

ХРИСТЭЧ ГЭР БҮЛ

Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй христитгэгч удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Курс хичээлийг боловсруулсан: Др. Стефен К. Гибсон

Зохиогчийн эрх © 2023 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх Эхний хувилбараас монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, О. Болормаа, А. Хүслэн

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Гуравдагч талын материалууд нь тус тусын зохиогчийн эрх болон зөвшөөрөлтэй.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2019 хувилбараас ашиглав.

Зөвшөөрөлтэй холбоотой заавар:

Дараах зааврын дагуу энэхүү курс хичээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1) Хичээлийн агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2) Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3) Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү хичээлийг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4) Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр хичээлийг орчуулж болохгүй.

Гарчиг

Курсын тойм.....	5
(1) Харилцахын тулд бүтээгдсэн	7
(2) Библийн дагуух гэр бүл	17
(3) Библи дэх гэрлэлтийн ойлголт	31
(4) Бэлгийн харилцааны асуудлууд	41
(5) Ганц бие байх	61
(6) Гэрлэлтэд бэлтгэх нь	73
(7) Бат бэх гэр бүлийг цогцлоох нь	85
(8) Хайрын таван хэл – 1-р хэсэг.....	97
(9) Хайрын таван хэл – 2-р хэсэг.....	111
(10) Үр хүүхэдгүй байх.....	127
(11) Хүүхдийн хөгжил ба хүмүүжил	139
(12) Хүүхдийг зорилготойгоор хүмүүжүүлэх нь.....	147
(13) Хүүхэд хүмүүжүүлэхэд тулгардаг асуудлууд.....	159
(14) Өсвөр насны хүүхдийг хүмүүжүүлэх нь.....	173
(15) Залуу нас	185
Эмэгтэйчүүдийг хүндлэх нь	197
Жирэмслэлтээс хамгаалах	201
Санал болгох эх сурвалжууд.....	205
Даалгаврын тэмдэглэл.....	207

Курсын тойм

Курсын агуулга

Энэхүү курс нь амьдралын үе шатууд болон гэр бүлийн харилцаа, ялангуяа гэрлэлт, хүүхэд хүмүүжлийн талаарх Бурханы зарчмуудыг заадаг. Энэхүү хичээлээр дамжуулан суралцагчид амьдралынхаа одоогийн үе шатанд болон харилцаандаа Бурханыг дээдлэн өргөмжлөхөд бэлтгэгдэх болно. Тэд бусдад Библийн зарчмууд болон эдгээр зарчмын практик хэрэглээг заахад сургагдана. Бурханлаг байдлын нөлөөг гэр бүл, нийгэм, хамт олныхоо дунд авчрахын тулд нутгийн чуулгантай холбогдох хэрэгтэйг суралцагчид ойлгуулж сэдэлжүүлнэ.

Суралцагчид хүүхэд, өсвөр насныхныг гэр бүлдээ дагалдуулах талаар бусад зүйлсэд мөн суралцах болно. Энэхүү курст хамрагдаж буй эцэг эхчүүд өдөр бүр гэр бүлийн мөргөлийн цагаа төлөвлөх талаар 12-р хичээлийн 3-р даалгавар дээр зааврыг танилцуулсан. Shepherds Global Classroom байгууллага нь "Гэр Бүлээрээ Суралцах Зааварчилгаа" нэртэй гэр бүлийн дагалдуулалтын номыг зохиосон бөгөөд эцэг эхчүүд гэр бүлийн мөргөлийн үеэрээ ашиглаж болно. Энэ номыг shepherdsglobal.org вебсайтаас татаж авах боломжтой.

Ангийн удирдагчдад зориулсан зөвлөмж

Хэлэлцүүлгийн асуултууд болон **ангийн үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Хэлэлцүүлгийн асуултуудын хувьд, ангийн удирдагч асуултыг асууж, суралцагчид хариулах боломжийг олгоно. Хэрэв нэг суралцагч л голдуу анхны хариултыг өгч, бусад нь ярьдаггүй бол удирдагч асуултыг өөр хүнээс асууж чиглүүлнэ: "Цэнгүүн, чи энэ асуултад юу гэж хариулмаар байна?" гэж хэлж болно.

Хичээл бүрийн төгсгөлд бүлгийн хэлэлцүүлэгт зориулсан хэд хэдэн нэмэлт асуулт багтсан байгаа. Ангийн удирдагч бүлэгтэй ямар асуултыг хэлэлцэхээ сонгож болно.

Энэхүү курст **Бичвэрийг** өргөн ашигласан. Ангид чангаар дуудан унших эшлэлүүдийг сумаар тэмдэглэсэн байгаа. Бүлгийн хүн бүр Бичвэрийг харж, нэг суралцагч чангаар уншина. Бусад тохиолдолд Бичвэрийн эшлэлийг хаалтанд тэмдэглэсэн. Жишээ нь: (Ефес 6:1). Эдгээр эшлэл нь текст дэх мэдэгдлүүдийг дэмжих зорилготой. Хаалтанд байгаа эшлэлийг байнга унших шаардлагагүй.

Энэхүү курсын төгсгөлд хоёр тусгай сэдвийн талаар товч хэлэлцүүлэг багтсан болно. Эдгээр сэдэв нь бусад хичээлтэй бүрэн холбоогүй бөгөөд бүрэн хэмжээний хичээл биш юм. Гэсэн хэдий ч эдгээр нь христитгэлийн үүднээс ойлгох ёстой чухал сэдвүүд юм. Анги нь 3-р хичээлийн дараа Хавсралт А-г судалж, хэлэлцэх ёстой бөгөөд 10-р хичээлийн дараа Хавсралт Б-г судлах ёстой. Эдгээр хоёр хичээлийн төгсгөлд санах зүйлсийг өгсөн байгаа.

Хичээл бүрийн төгсгөлд **даалгаврууд** өгөгдсөн. Даалгавруудыг дараагийн хичээлээс өмнө биелүүлж, тайлагнах ёстой. Хэрэв суралцагч даалгавраа биелүүлээгүй бол дараа нь хийх боломжтой. Гэсэн хэдий ч, удирдагч суралцагчдыг хуваарийн дагуу хийхэд урамшуулснаар тэд ангид суралцах хичээлээсээ ихийг сурах боломжтой болно. Хичээл бүрийн даалгаврыг хийхээс гадна суралцагчид дараагийн хичээлд бэлтгэж, дараагийн хичээлийг унших ёстой.

Хэрэв суралцагч нь Shepherds Global Classroom байгууллагаас **гэрчилгээ авахыг** хүсвэл тухайн хичээлүүдэд хамрагдаж, даалгавруудаа бүрэн хийсэн байх шаардлагатай. Курсын төгсгөлд даалгавруудаа бүрэн хийснийг тэмдэглэх маягт хавсаргасан байгаа.

1-р хичээл

Харилцахын тулд бүтээгдсэн

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Бурхан бидэнтэй ямар харилцаатай байхыг хүсэж байгааг ухамсарлаж, үнэлэх.
- (2) Хүн бүрийн дотор Бурханы дүр төрх байгааг ойлгож, үнэлэх.
- (3) Харилцаандаа гаргасан сонголтуудынхаа төлөө бид Бурханы өмнө хариуцлага хүлээдгийг ухамсарлах.
- (4) Библи бол бурханлаг харилцааны гарын авлага бөгөөд бид харилцаандаа Бурханыг дуурайх ёстойг мэдэх.

Бурхантай харилцах харилцаа

Бурхан бол бусадтай харилцаатай байж, харилцдаг бодгаль болохыг бид Бичвэрээс мэддэг (Еврей 1:1-2). Эцэг Бурхан, Хүү Бурхан, Ариун Сүнс Бурхан өнө мөнхөд хоорондоо харилцаатай байж ирснийг Бичвэрт харуулдаг.¹

Бурхан тэнгэр, газар, тэнгис болон тэдгээрт буй бүхнийг бүтээсэн (Гэтлэл 20:11). Дуулал 8:3-8-д хүн төрөлхтөн бол Түүний хамгийн сайн, хамгийн чухал бүтээл болохыг харуулдаг. Бурхан хүнийг өөртэйгөө адил харилцаатай байхаар бүтээсэн. Бичвэрийн туршид Бурхан хүмүүсийг өөртэйгөө харилцах амь өгөгч харилцаа руу урьсаар байдаг.²

Орчлон ертөнцийг Бүтээгч Бурхан тантай болон надтай харилцаатай байхыг хүсдэгийг ойлгож мэдэх нь үнэхээр гайхалтай!

► Нэг суралцагч Эхлэл 3:8-9 эшлэлийг уншина.

Хэсэг зуур нүдээ аниад, дөнгөж сая уншсан дүр зургийг төсөөлөөрэй. Эдгээр эшлэлийг ойлгохын тулд төсөөллөө ашиглана уу. Өдрийн сэрүүн үед хамгийн үзэсгэлэнтэй цэцэрлэгт зогсохдоо, нүүрийг илбэх таатай салхийг мэдрээрэй. Бурханы хөлийн чимээг болон Түүний хайртай хоёр бүтээл чимээгүй байхыг сонсоорой. Дараа нь Бурхан “Чи хаа байна вэ?” гэж асууж байна.

¹ Жишээ нь, эдгээр Библийн эшлэлд Эцэг, Хүү, Ариун Сүнсний хоорондын харилцааг харуулжээ: Иохан 17:22-24; Иохан 14:16, 26; Иохан 15:26. Эдгээр эшлэлд Ариун Сүнс хэрхэн мөнхөд байгаа талаар өгүүлдэггүй ч Еврей 9:14 гэх мэт бусад эшлэлээс Тэр мөнх болохыг бид мэддэг.

² Жишээ нь, Исаиа 55:3, Иохан 1:12-13, Иохан 3:36, Иохан 17:3, 2 Коринт 6:16-18, 1 Иохан 1:3, Илчлэл 3:20 эшлэлийг үзнэ үү.

Бурхан эрэгтэй, эмэгтэй хоёртой нөхөрлөхийг хүсэж дуудаж байсан тэр агшин ямар байсныг та төсөөлж байна уу? Дахин хэдэн хором Бурханы зүрх сэтгэлийг бодож үзээрэй. Бурхан Адам, Еватай, тантай, надтай нөхөрлөхийг хүсэж, эрэлхийлж байна!

Бид Бурханд дуулгаваргүй байснаараа Түүнээс өөрсдийгөө тусгаарласан ч (Исаиа 59:2) Бурхан амьд буй хүн болгонтой харилцаатай байхыг хүсдэг. Лук 19:10 эшлэлд Тэрээр нүгэлтэн бүрийг эрж хайж байгааг өгүүлдэг. Бурхан одоо ч гэсэн "Чи хаана байна вэ?" гэж асуусаар байна. Есүс бидний төлөө үхсэн учраас бид Түүнтэй зөв харилцаатай болж чадна (Ефес 2:13, 19). Та бид Бурхантай харилцахын тулд бүтээгдсэн.

Бүтээгчийн маань төлөвлөгөө

Бурхан бүтээлээ хайрлаж, зорилготойгоор бүтээсэн гэдгийг үгүйсгэдэг хүмүүс өөрсдийгөө хэн болох, юуны тулд оршин байгаагаа ойлгох гэж тэмцэлддэг. Бурхантай харилцах харилцаанаас ангид байдлаар хүн төрөлхтнийг зөвөөр ойлгох боломжгүй юм. Дэлхийн мэргэн ухааны зөвлөгөөгөөр амьдардаг хүн буюу хүн төвтэй аз жаргалыг эрэлхийлдэг нэгэн амьдралыг үнэхээр ойлгож чадахгүй.

Бид хэн болох (өөрийн уг чанар), ямар зорилготой (оршин буйн учир), хэрхэн бүтээгдсэнээ үнэн зөв ойлгохын тулд бид Бүтээгчийнхээ зорилгыг мэдэх ёстой бөгөөд энэ нь Ариун Библид бичигджээ. Бид хэн болохыг Бурхан аль хэдийн тогтоожээ. Энэ нь бидний зохион бүтээдэг зүйл биш юм. Тэрээр биднийг зорилготойгоор бүтээж, санаа бодолтойгоор урласан. Бидний амьдрал болон харилцааны талаарх Түүний төлөвлөгөөг ойлгосон цагт л бид хэн байх ёстойгоо, оршин буйнхаа төлөөх Түүний зорилгыг биелүүлж чадна.

Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдэг нь хүмүүс харилцахын тулд өвөрмөц байдлаар бүтээгдсэн гэсэн үг юм. Бурхан харилцаатай байдаг шигээ хүмүүсийг харилцаатай байхаар Тэр бүтээсэн. Бурхан хүн бүрийн сэтгэл, сүнс, бие махбодыг өөртэйгөө болон бусадтай харилцаатай байхаар төлөвлөжээ.

Хүн хоорондын харилцааны талаарх гарын авлага

Бурхан хүмүүсийг харилцаатай байхаар бүтээсэн гэдэг нь Тэрээр бидний харилцах зарчим, удирдамжийг тогтоосон гэсэн үг юм. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүтээгдэхүүнийхээ загвар болон үүнийг хэрхэн ашиглах талаар тайлбарласан гарын авлага гаргадаг. Үүнтэй адилаар Бурхан бидэнд өөрийн Үг болох Библийг өгсөн бөгөөд энэ нь бидний загвар, амьдрал харилцаа маань хэрхэн зөв явагдах талаар тайлбарладаг.

Хүн хоорондын харилцаанд Бурханы тогтоосон үүргийг Библид тодорхой дүрсэлсэн байдаг. Энэ нь нөхөр, эхнэр; эцэг, эх, хүүхдүүд; ах, эгч, дүү нар; өвөө, эмээ; найз нөхөд; дайсан; хөрш; засаг төр ба иргэд; ажил олгогч ба ажилчид зэрэг үүрэг, харилцааг хөнддөг. Бид ямар нөхцөл байдал, орчинд байгаагаас үл шалтгаалж, Бурханы Үгийн зарчмууд нь бидэнд хандсан Түүний төлөвлөгөөг заадаг. Библи нь амьдралын бүхий л үе шатанд бидний төлөөх Бурханы хүслийг заадаг.

Хүний нийгэм, соёл нь төгс бус хэдий ч Бурханы загвар төлөвлөгөөг тусгадаг. Соёл нь бүх харилцаа болон нөхцөл байдалд хандах хүний хэвийн зан байдлыг тодорхойлдог. Соёл болгонд хүүхэд хүмүүжүүлэх, гэрлэлтийн харилцааг хадгалах зэрэг өөрийн гэсэн арга замууд бий. Соёлууд нь уламжлал, орчин, генетик, гол үйл явдлуудаараа ихээхэн ялгаатай байдаг ч, соёл болгон үндсэн ёс суртахууныг агуулдаг. Жишээлбэл, соёл болгон гэрлэлтийн аливаа нэгэн хэлбэртэй. Гэсэн хэдий ч, бүх зан байдлыг соёлын хэм хэмжээгээр бус, Библийн зарчмаар үнэлж цэгнэх ёстой. Соёл биш, харин Библи бол бидний эрх мэдэл билээ (Ром 12:2).

Соёлын нарийн ширийн зүйлс нь заавал төвийг сахисан байх албагүй бөгөөд бид тэдгээрийг ийм байна гэж хүлээх ёсгүй юм (Ефес 2:2). Өөртөө төвлөрсөн, буруу хүслээр хэлбэржсэн унасан хүмүүс соёлыг хөгжүүлдэг. Нийгэм нь Библийн үнэний талаар ямар нэгэн мэдлэгтэй байж болох ч, ямар ч нийгэм Бурханы зөв, буруугийн хэм хэмжээнд тогтмол нийцдэггүй. Зөвхөн тогтсон соёл учраас хэмээн юуг ч зөвтгөх ёсгүй юм. Зөвхөн Библи л бидэнд Бурханы хэм хэмжээг төгс байдлаар харуулдаг (Дуулал 19:7-11).

Хэрэв та Ливи улсад зочилж, Ливийн иргэд аюулгүй байдлыг үл тоомсорлон машин жолоодож байгааг анзаарвал "Энэ нь тэдний соёл; тэдний жолоодлогын хэв маяг тэдэнд тохирч байна" гэж бодож болох юм. Тэд өөрсдийн жолоодлогын соёлын хэв маягийг хөгжүүлсэн нь үнэн. Гэсэн хэдий ч, Ливи улс дэлхийд авто замын ослын улмаас нас барагсдын тоогоор хамгийн өндөр үзүүлэлттэй байдаг. Тэдний энэ үзүүлэлт дэлхийд хоёрдугаарт ордог улсынхаас хоёр дахин өндөр юм. Эндээс харвал тэдний соёл жолоодлогын сайн хэв маягийг хөгжүүлээгүй нь илэрхий байна.

Амьдрал хэрхэн явагдах ёстойг Бурхан мэддэг бөгөөд Тэр бидэнд дүрмийг өгсөн. Бид зүгээр л туршилт хийж, судлах ёсгүй. Бид зүгээр л хүссэн зүйлийг маань өгч байна гэж санагдсан болгоныг хийх ёсгүй. Бид зүгээр л аз жаргалтай амьдрал байх болно гэж төсөөлсөн зүйлдээ хүрэхээр хичээх ёсгүй. Харин харилцааны талаарх Бурханы загвар төлөвлөгөөг бид дагах ёстой.

Хамгийн сайхан зүйл нь бидний сайн сайхны төлөө байгаа Бурханы зааврыг дагах явдал юм. Бурхан биднийг хайрладаг учраас бидэнд тушаал өгсөн (Дэд хууль 6:24). Тэдгээрийг сахиснаар бид сайн үр дүнд хүрч, олон муу үр дагавраас хамгаалагддаг. Биднийг бүтээгч бидэнд юу хамгийн сайн болохыг мэддэг бөгөөд Түүний төлөвлөгөөг дагахдаа бид ерөөгддөг.

Харилцаандаа Бурханы өмнө хүлээх хариуцлага

- ▶ Бусад хүмүүстэй хэрхэн харьцдаг нь Бурхантай харилцах харилцаанд маань хэрхэн нөлөөлдөг вэ?
- ▶ Суралцагчид дараах эшлэл тус бүрийг бүлэгт уншина. Эдгээр хүн хоорондын харилцаанд Бурхан юу шаарддаг, дуулгавартай байдал нь Бурхантай харилцах харилцаанд маань хэрхэн нөлөөлдөг талаар товч хэлэлц. Бурханы зааврыг зөрчих нь Бурхантай харилцах харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ?

Бусадтай харилцах харилцаа болон Бурхантай харилцах харилцаа			
Бичвэр	Хүн/ Үүрэг	Хүн хоорондын харилцаан дахь Бурханы шаардлага	Бурхантай харилцах харилцаанд үзүүлэх нөлөө
1 Петр 3:7	Нөхөр	Эхнэрээ ойлгож, хүндэтгэх.	Нөхрийн залбиралд саад тотгор болохгүй.
Ефес 5:22, 24, 33; 1 Петр 3:1-6	Эхнэр	Нөхөртөө захирагдах.	Энэ нь эхнэрийн Бурханд захирагдаж буй хэлбэр юм. Бурхан түүний энэ хандлага, зан үйлийг үнэлдэг.
Колоссай 3:20	Хүүхэд	Эцэг эхээ бүх зүйлд дуулгавартай дагах.	Энэхүү зан байдал нь Эзэнд таалагддаг.
Матай 6:12-15	Хүн бүр	Бидний эсрэг нүгэл үйлдсэн хүмүүсийг уучлах.	Бурхан биднийг уучилж чадна.
Ром 13:1-5	Хүн бүр	Дэлхий дээрх эрх мэдэлд захирагдах.	Энэ нь бидний Бурханд дуулгавартай байгаа хэлбэр юм.
1 Петр 2:18-20	Зарц үйлчлэгч	Шударга бус харьцааг тэвчээртэйгээр тэсвэрлэх.	Зарц үйлчлэгч нь Бурханы тааллыг олдог.

Бид ёс суртахуунтай бүтээлүүд бөгөөд энэ нь зарим үйлдэл буруу, зарим нь зөв гэдгийг ойлгож, сонголтоороо Бурханы өмнө хариуцлага хүлээдэг гэсэн үг юм. Энэ нь бидэнд асар том боломж болон асар их хариуцлагыг өгдөг. Бидний сонголт Бурхантай харилцах харилцаанд маань нөлөөлдөг. Харилцааны талаарх Бурханы зааврыг дагах нь зүгээр л аз жаргалтай байж, амьдралаас хамгийн сайныг авах практик асуудал биш юм. Бид харилцаан дахь шийдвэр, зан байдлынхаа төлөө Бурханы өмнө хариуцлага хүлээдэг (Ром 14:10, 12).

Бурхан биднийг бусадтай шударгаар харьцаж, хайр, энэрлээр үйлдэхэд уриалдаг (Мика 6:8). Асуудал нь Адамын нүглийн улмаас түүний бүх үр удам нүгэлт мөн чанартай төрдөг болсонтой холбоотой (Ром 5:12, 19). Үүнээс болж бид хайр, энэрэл, шударга ёсны дагуу тогтмол үйлдэж чаддаггүй (Ром 7:15-24). Гэхдээ бид дахин төрөхөд Бурханы нигүүлсэл биднийг өөрчилдөг. Ариун Сүнс бидэнд Бурханы шаардлагыг биелүүлэх боломжийг олгодог (Ром 8:3-4).

Хүн бүрийн үнэ цэн

► Суралцагчид Исаиа 44:24, Дуулал 139:13-16, Эхлэл 9:6, Иаков 3:9 эшлэлийг бүлэгт уншина. Амьдрал бүрийн үнэ цэнийн талаар эдгээр Бичвэр бидэнд юу хэлж байна вэ? Хүнийг юу үнэ цэнтэй болгодог вэ?

Бусадтай эрүүл харилцаатай байхын тулд бид хүмүүсийг Бурхан үнэ цэнтэйд тооцдог шиг үнэлэх ёстой. **Хүн бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд зөвхөн үүгээрээ л үнэ цэнтэй юм.** Эрэгтэй, эмэгтэй, эрүүл, өвчтэй, бүрэн бүтэн, хөгжлийн бэрхшээлтэй, хөгшин залуу, баян ядуу (Сургаалт үгс 14:31), эхийн хэвлийд байгаа эсэхээс үл хамааран хүн бүр Бурханы өвөрмөц бүтээл юм. Үүнд арьсны өнгө ямар байх, оюун санааны болон бие махбодын чадвар, хязгаарлалт ямар байх нь хамаагүй (Гэтлэл 4:11).

Ахмад настнуудыг мартаж, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс дорд үзэх, хүүхдүүдийг зовлон гэж үздэг соёлууд бий. Зарим соёлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хараагдсан гэж үзээд нийгмээс нуух, эсвэл гадуурхах тохиолдол байдаг. Дэлхий даяар арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл түгээмэл. Нэг овог эсвэл үндэстэн өөрийгөө бусдаас илүүд үзэж, бусдыг гутаадаг. Эдгээр үйлдэл бүр Бурханы бүх бүтээлээс хамгийн үнэ цэнтэй нь болох хүмүүсийг үнэгүйдүүлдэг. Бурханыг өргөмжилсөн эрүүл харилцаатай байхын тулд бид эхлээд бүх хүмүүс хэн болохыг бодож үзэх ёстой. Тэд бол Бурханы дүр төрхийг тээгчид юм.

Бурханы төлөө бүтээгдсэн, бусдын төлөө бүтээгдсэн

Илчлэл 4:11 эшлэлд Бурхан бүх зүйлийг өөрийнхөө төлөө бүтээсэн гэж өгүүлдэг. Үүнд хүн төрөлхтөн ч мөн адил хамаарна. Бид Бурханаар, Бурханы төлөө бүтээгдсэн. Бидний хийж буй бүхэн Бурханы алдрын төлөө байх ёстой (1 Коринт 10:31, 1 Петр 2:12). Бид бас бусад хүмүүсийн тусын тулд бүтээгдсэн.

Бурханы зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бид бусад хүмүүстэй хамтран ажиллахаар бүтээгдсэн. Хүмүүс хамтран ажиллах Бурханы загвар төлөвлөгөөний нэг жишээ нь гэрлэлт юм. Бурхан анхны эрэгтэй хүнийг бүтээсний дараа удалгүй "Хүн ганцаараа байх нь сайн биш. Би түүнд тохирох туслагчийг буй болгоё гэжээ" (Эхлэл 2:18). Эмэгтэй хүн чухал байдлаараа эрэгтэй хүнтэй төстэй боловч бусад чухал байдлын хувьд ялгаатай. Тэднийг оршин байлгаж буй Бурханы зорилгыг тэд хамтдаа биелүүлж чадна. Бурхан тэдэнд хамтдаа хийх ёстой ажлыг өгсөн (Эхлэл 1:26-28).

Чуулган бол хүмүүс хамтран ажиллах Бурханы загвар төлөвлөгөөний өөр нэг жишээ юм. Элч Паул биеийн эрхтнүүдийн талаар зүйрлэн хэлсэн байдаг (1 Коринт 12:12-26). Хүн ганцаараа Бурханы зорилгыг биелүүлж чадна гэж эсвэл бусад хүмүүс хэрэггүй гэж бодох ёсгүй. Хүмүүс хамтран ажиллах Бурханы загвар төлөвлөгөөний олон жишээний хоёр нь гэрлэлт болон чуулган юм.

Бид бусад хүмүүст үйлчлэхээр бүтээгдсэн (Галат 5:13-14). Бид бусдад өгч, бусдад тус хүргэх хайр дүүрэн харилцаатай байхаар бүтээгдсэн.

► Суралцагчид Сургаалт үгс 17:17, Галат 6:2, Филиппой 2:4 эшлэлийг бүлэгт уншина.

Бид Бурханы төлөө болон бусад хүмүүсийн төлөө бүтээгдсэн. Бурханы Үгэнд биднээс шаарддаг бүх зүйл нь Түүнтэй харилцах харилцаа, бусадтай харилцах харилцаанд эсвэл хоёуланд нь хамаатай байдаг. Үнэндээ биднээс шаарддаг бүх зүйлийг бүхий л зүрх сэтгэл, оюун ухаан, хүч чадлаараа Бурханыг хайрлах ба бусдыг өөрийн адил хайрлах гэсэн хоёр тушаалд нэгтгэн дүгнэх боломжтой гэдгийг Есүс хэлжээ.

► Нэг суралцагч Матай 22:36-39 эшлэлийг бүлэгт уншина.

Бид Бурханы төлөө мөн бусдын төлөө бүтээгдсэн. Эдгээр баримтууд нягт холбоотой. Бурханыг алдаршуулж, Түүний дүр төрхийг тусгадаг бидний анхдагч талбаруудын нэг бол бусадтай харилцах харилцаа юм. Бурханы зан чанар, үйлдэл биднийг Түүнтэй адил байхыг шаарддаг (1 Петр 1:16, Матай 5:48). Бүх хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн боловч бид Түүнтэй адил үйлдэхдээ Бурханы мөн чанар, зан чанарыг тусгадаг.

Хэн нэгэн гачигдалтай хүнд энэрэл үзүүлэхэд тэр хүний өрөвч сэтгэл нь Бурханы өрөвч сэтгэлийн тусгал бөгөөд түүний энэрэнгүй үйлдэл Бурханы ажлын дуурайл юм. Энэрэл үзүүлж буй хүн итгэгч эсэхээс үл хамааран энэ нь үнэн юм. Гэсэн хэдий ч, бид Түүнтэй эвлэрүүлэгдэж, Түүний Сүнс бидний дотор ажиллаж байх үед л бид Бурханыг хамгийн сайн дуурайдаг.

► Нэг суралцагч 2 Петр 1:2-11 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ багц эшлэлд Христийн дагалдагч бүрийн төлөөх Бурханы гайхалтай төлөвлөгөөг тайлбарладаг. Энэ хэсгээс бид дараах зүйлийг сурдаг:

1. Есүс өөрийн алдар, сайн сайхнаараа биднийг дуудаж, гайхалтай амлалтуудыг өгсөн (3-4-р эшлэл).
2. Эдгээр амлалтуудаар дамжуулан Христийг мэддэг бид Бурханы ариун мөн чанарыг өөртөө агуулж чадна (4-р эшлэл).
3. Эцэг Бурхан болон Есүстэй харилцах харилцаагаар дамжуулан бидэнд амьдрал болон бурханлаг байдалд хэрэгтэй бүх зүйл бий (3-р эшлэл).
4. Эдгээр зүйлсийн ачаар бид Есүстэй адил амьдралаар, Бурхан биднийг хэрхэн амьдрахыг дуудсан шиг тийм амьдралаар амьдарч чадна (5-8-р эшлэл).

► Бид харилцаандаа Бурханы зан чанар болон мөн чанарыг хэрхэн тусгаж чадах вэ?

► Нэг суралцагч 2 Коринт 4:4 эшлэлийг бүлэгт уншина. Бурханы төгс дүр хэн бэ?

► Нэг суралцагч 2 Коринт 3:18 эшлэлийг бүлэгт уншина.

Ариун Сүнс итгэгчдийг Эзэний алдрыг улам бүр тусгахын тулд өөрчилдөг. Есүсийг харах замаар бид хандлага, зан байдлаараа Түүнтэй улам бүр адил болдог. Энэ бол

сайнмэдээний гоо үзэсгэлэн юм. Эцэг Бурхан, Есүс, Ариун Сүнсний хүчээр бид Бурханы зан чанарыг тусгаж, дуурайж чадна.

Бурхан биднийг бусадтай харилцах харилцаандаа өөрийг нь дуурайхыг уриалдаг (Ефес 5:1). Хүүхэд эцэг эх эсвэл ах эгчээ ажиглаж, дуурайдаг шиг бид Есүсийн үлгэр жишээг харж, бусадтай харилцахдаа Түүний хандлага, үзэл бодол, үйлдлийг хуулбарладаг (Филиппой 2:5-7, Ефес 5:2).

► Суралцагчид дараах эшлэл тус бүрийг бүлэгт уншина. (1) Бурханы зан чанар эсвэл ажил, (2) Бурхан биднээс хүсэн хүлээдэг зүйлсийг тэмдэглээрэй (Эхний хоёр хэсгийн тэмдэглэлийг жишээ болгон бичсэн. Энэ хичээлийн төгсгөл дэх 2-р даалгавар нь энэ судалгааны үргэлжлэл юм).

Хүн хоорондын харилцаа Бурханы алдрыг хэрхэн тусгадаг вэ?		
Бичвэр	Бурханы хийдэг/Христийн хийсэн зүйл	Бурханыг тусган харуулдаг бидний үйлдэл
Филиппой 2:3-8	Өөрийн эрхээсээ татгалзсан. Зарц болсон. Бүрэн дүүрэн даруу, дуулгавартай байсан.	Өөрийн эрхээсээ татгалзах. Бусдын ашиг сонирхлыг анхаарах. Даруу байх.
Иохан 13:3-5, 12-15	Дагалдагч нартаа үйлчилж, практик хэрэгцээг нь хангасан.	Бусад итгэгчдэд үйлчлэх.
Ефес 4:32-5:2		

Бидний хэн нь ч Бурханы хайрыг төрөлх байдлаараа харуулж чадахгүй. Учир нь бид хувиа хичээсэн мөн чанартай төрдөг. Бурхан биднийг өөрийн загвар төлөвлөгөө рүү буцаан авчрахын тулд нигүүлслээ өгдөг. Түүнд буулт хийсэн даруу залбирал хүнийг энэхүү өөрчлөлтөөр алхуулдаг.

Дүгнэлт

Бурхан хүмүүсийг хайрлаж, харилцаатай байхаар бүтээснийг Библи илчлэн харуулдаг: Түүнтэй харилцах харилцаа болон бусадтай харилцах харилцаа.

Бурхан хүмүүсийг бүтээгч, харилцааг зохиогч тул бид:

1. Хүн хоорондын харилцааны талаарх Түүний үзэл бодлыг олж авах ёстой.
2. Харилцаандаа гаргасан сонголтоороо Түүний өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлах ёстой.

3. Харилцааны талаарх Түүний төлөвлөгөөг хүлээн авч, дагах ёстой.

Энэхүү курс хичээл нь эдгээр зүйлийг хийхэд тань тусалж, хүн хоорондын харилцааны талаарх Бурханы хүслийг бусдад заахад таныг бэлтгэх болно.

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Соёл нь хүний харилцааны удирдамж болоход яагаад хангалтгүй вэ?
- ▶ Энэ хичээлийн ямар ойлголт танд шинэлэг байсан бэ? Энэ нь яагаад чухал вэ? Үүнийг ойлгох нь таны харилцаанд хэрхэн туслах вэ? Үүнийг ойлгох нь таны үйлчлэлд хэрхэн нөлөөлөх вэ?
- ▶ Энэ курсыг судалснаар та хэрхэн өсөхийг хүсэж байна вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Намайг өөрийнхөө дүр төрхөөр, амьдралыг минь зорилготойгоор бүтээсэн танд талархаж байна.

Намайг тантай харилцаатай байхаар бүтээж, үүнийг миний нүглийн төлөөх Есүсийн үхлээр дамжуулан боломжтой болгож өгсөнд талархаж байна.

Тантай хэрхэн харилцах, бусадтай харилцах харилцаандаа таныг хэрхэн алдаршуулахыг заадаг эрдэнэс болох таны Үгийн төлөө талархаж байна.

Таны Үг болон Сүнсээр дамжуулан өөрт минь зориулагдсан амьдралаар амьдрахад намайг сургаач.

Миний эргэн тойронд буй хүмүүст таныг зөвөөр тусган харуулахад надад туслаач. Ингэснээр тэд таныг мэдэх болтугай.

Амен.

Хичээлийн даалгаврууд

(1) Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн тухай үнэн хүн бүрд хэрхэн үнэ цэн өгдөг, бүтээлийг үгүйсгэх нь хүний үнэ цэнийг хэрхэн бууруулдаг талаар тайлбарла.

(2) Доорх хүснэгт дэх Бичвэрийн эшлэлийг уншаад (а) Бурханы зан чанар эсвэл ажил, (б) Бурхан биднээс хүсэн хүлээдэг зүйлсийг тэмдэглээрэй.

(3) 2-р даалгаврын хүснэгт болон хичээлийн төгсгөлд өгөгдсөн хүснэгтийг хараад, амьдралаа хэсэг зуур эргэцүүлэн бодоорой:

- Та одоо Түүнийг өргөмжилж, алдаршуулах байдлаар Бурханы дүр төрхийг тусгаж байна уу?
- Бурхан таны амьдралд зориулсан зорилгод амьдралаа илүү тодорхой, хүчтэй нийцүүлэхийн тулд гэмших ёстой ямар нэгэн дуулгаваргүй байдал байна уу?
- Есүстэй улам бүр адил болохын тулд Бурхан танаас ямар алхам хийхийг хүсэж байна вэ?

Энэхүү суралцаж буй зүйлдээ хариулт болгон догол мөрөнд залбирлаа бичнэ үү (Та энэхүү бичсэн зүйлээ ангийн удирдагчтайгаа хуваалцах шаардлагагүй бөгөөд даалгавраа хийсэн гэдгээ л мэдэгдэхэд болно).

Хүн хоорондын харилцаа Бурханы алдрыг хэрхэн тусгадаг вэ?		
Бичвэр	Бурханы хийдэг/ Христийн хийсэн зүйл	Бурханыг тусган харуулдаг бидний үйлдэл
Дуулал 68:5; Иаков 1:27		
2 Петр 3:9; Тит 3:1-5		
Матай 5:43-48, 1 Тесалоник 5:14- 15		
Иохан 13:1, 34; 1 Иохан 4:7-8, 11- 12		

2-р хичээл

Библийн дагуух гэр бүл

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Гэрлэлт Гурвалын харилцааг хэрхэн тусгах ёстойг ойлгох.
- (2) Хүүхэдтэй байх талаарх Бурханы үзэл бодлыг хүлээн авах.
- (3) Уналт гэрлэлт болон гэр бүлийн харилцаанд хэрхэн нөлөөлснийг ойлгох.
- (4) Хүний алдаа дутагдал байсаар байхад ч Бурханы авралын зорилго хэрхэн биелэлээ олдгийг ойлгож талархах.
- (5) Бурханы төлөвлөгөөнд дуулгавартай байх нь ямар ч гэр бүлд Түүний нигүүлсэл ба эдгэрлийг мэдрэхэд тусалдаг гэдгийг ухаарах.

Гэр бүлийн харилцааны нөлөө

Энэхүү курсээр бид голчлон нэг орон байранд хамт амьдардаг гэр бүлийн талаар суралцах болно. Олон янзын хүмүүсийн нэгдэл гэр гэртээ хамт амьдарч, гэр бүл гэж нэрлэгддэг бүлгийг бүрдүүлдэг. Нэг эцэг эхтэй гэр бүл, салан тусгаарласан гэр бүл, дахин гэрлэснээр нэгдсэн гэр бүл, хүүхэд үрчилсэн гэр бүл, олон үеийнхнийг багтаасан гэр бүл, түр хугацаагаар нэмэлт хүүхэд эсвэл насанд хүрэгчдийг асрамжиндаа авсан гэр бүл гэх зэрэг.

Бидний хүн нэг бүрд *гэр бүл* гэж юу болох тухай өөрийн гэсэн ойлголт бий. Гэр бүлийн тухай яриа бидний хувийн туршлагаас хамааран янз бүрийн сэтгэл хөдлөлийг бидэнд төрүүлдэг.

Бага нас бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ?

Магадгүй та бага насны гайхалтай дурсамжуудтай эсвэл бага насандаа туулсан зүйлсийн улмаас уур уцаартай байдаг ч байж болно. Магадгүй танай гэр бүлийн гишүүд бие биенээ байнга дэмжиж, урамшуулдаг эсвэл бие биенээсээ зайлсхийж, хамтдаа байхдаа зөрчилддөг байж болох юм. Та гэр бүлээ амьдралынхаа гайхалтай суурь, туслах хүч гэж мэдэрдэг байж болох ч, магадгүй таны гэр орон зугтахыг хүссэн шорон мэт, өвдөлттэй орчин байсан ч байх боломжтой. Магадгүй та өөрийнхөөс илүү сайн гэр бүлтэй хүмүүсийг харахдаа танай гэр бүл таныг хангалттай дэмжээгүй гэж боддог байх.

Гэр бүлийнхээ талаарх бидний ойлголт чухал, учир нь энэ нь амьдралын тухай болон Бурхан хэн болох тухай бидний ойлголтод нөлөөлдөг. Библид Бурханыг өөрийн ард түмний Эцэг гэж хэлдэг. Эцэг эхтэйгээ, ялангуяа эцэгтэйгээ харилцах харилцаа бидний

тэнгэрлэг Эцэгийн тухай ойлголтыг хэлбэржүүлдэг. Хэрэв төрсөн эцэг маань байхгүй, эсвэр тэрээр хүчирхийлэгч, хайхрамжгүй, хэтэрхий шаардлагатай, хуурч мэхэлдэг, идэвхгүй, ямар нэгэн байдлаар таныг гомдоосон бол Эцэг Бурханы тухай бидний ойлголт гэмтэх магадлалтай. Бурханы Үгээр, Есүсийн амьдралаар болон Түүнтэй хувийн харилцаагаар дамжуулан Түүнтэй танилцах хүртлээ бид Түүнийг сайн Эцэг гэж харахад хэцүү байж болох юм. Тэр үнэхээр хүүхдүүдээ идэвхтэй хамгаалж, хангадаг **сайн** Эцэг мөн. Тэр хүүхдүүдээ сонсож, тэдэнтэй ярилцаж, тэднийг чиглүүлж, сайн сайхан амьдралд нь баярладаг. Бид Түүнийг таньж мэдсэнээр Түүний талаарх ойлголтоо өөрчлөхөд Бурхан тусалж чадна.³

Сүнслэг ялгаа бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ

Бидний зарим нь Христийг дагасны улмаас гэр бүлээсээ хөөгддөг. Есүс биднийг Түүнд үнэнч байсныхаа төлөө итгэгч биш гэр бүлийн гишүүдээсээ хавчлага ч амсах боломжтой гэдгийг хэлсэн. Олон газар оронд итгэгч хүмүүсийг Христийг үгүйсгэдэг гэр бүлийн гишүүд нь хуурч, гутааж, хайхрамжгүй хандаж, хүчирхийлж эсвэл хөнөөдөг.

► Нэг суралцагч Матай 10:21-22, 28, 32-39 эшлэлийг бүлэгт уншина. Эдгээр эшлэлийг уншсаны дараа дараах асуултуудыг хэлэлцээрэй:

- Энэ эшлэлд итгэгчид юу хүлээх ёстой гэж байна вэ?
- Энд ямар амлалтууд өгөгдсөн бэ?
- Итгэгчид хавчлагын талаар ямар бодолтой байх ёстой вэ?

Зарим нь гэр бүлээсээ хавчлага амсахгүй байж болох ч итгэлийнхээ улмаас харилцааны бэрхшээлтэй тулгарч болно. Магадгүй итгэгч бидний амьдрал гэр бүлийн гишүүдийн маань амьдралаас эрс ялгаатай учраас гэр бүлийн харилцаа маань хурцадмал, хөндий эсвэл хязгаарлагдмал байх боломжтой. Биднийг буруу ойлгож эсвэл хүндэтгэхгүй байж болно. Хамаатнууд маань бидний үйлчлэлийг саатуулахыг оролдож болно. Есүс хүртэл эдгээр бэрхшээлийг туулсан (Марк 3:21, Иохан 7:3, 5) тул бид ч бас тулгарвал гайхах хэрэггүй.

Та болон таны гэр бүл

Хэдэн минутад багтаан та ангийнхандаа өөрийгөө танилцуулна уу. Ингэхдээ зөвхөн нэрээ хэлээд зогсохгүй гэр бүлийнхээ хүрээнд та хэн болох тухайгаа хуваалцаж болно.

Эхлээд гэр бүлийнхээ хүрээнд таныг дууддаг янз бүрийн нэрийг бодоорой. Тухайлбал хүү эсвэл охин, нөхөр эсвэл эхнэр, аав эсвэл ээж, авга ах эсвэл авга эгч, өвөө эсвэл эмээ гэх мэт. Танд өөр нэр бодогдож байна уу? Та магадгүй хэд хэдэн нэрээр дуудуулдаг ч байж болно.

³ Бурхан хэн болох тухай ойлголтоо хэрхэн шинэчлэх талаар Shepherd's Global Classroom байгууллагын "*Spiritual Formation*" курсын 4-р хичээлээс үзнэ үү.

Та гэр бүлдээ өөр ямар үүрэг эсвэл байр суурьтай вэ? Та айлын том эсвэл хамгийн бага нь уу? Гэр бүлээ тэжээгч үү? Гэр орноо халамжилдаг хүн үү? Ахмад настан эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч буй хүн үү? Гэр бүлийнхээ хүрээнд гүйцэтгэдэг бусад үүрэг, хариуцлагын талаар бодоорой.

► Ангийнхандаа өөрийгөө танилцуулж, гэр бүлийнхээ хүрээнд дуудуулдаг хэд хэдэн нэр, үүргээ жагсаагаарай.

► Одоо хэсэг зуур бодоод, таны нэр, үүрэг (1) өөрийгөө хэрхэн хардаг, (2) гэр бүлийнхээ бусад гишүүдийг хэрхэн харах байдалд нөлөөлдөг талаар бодно уу.

Та ойрын болон холын хүрээний гэр бүлийн гишүүдийнхээ талаар ямар мэдрэмжтэй байхаас үл хамаарч тэд таны л хүмүүс байх болно. Магадгүй танай гэр бүл эвдэрсэн, өвдөлттэй, зовлон туулсан шарх сорвитой ч байж болно. Эсвэл таны гэр бүлд хүмүүс атаархдаг байж магадгүй. Учир нь таны гэрлэлт амжилттай, хүүхдүүд нь ухаантай, эрүүл чийрэг, орон гэр нь хайр, амар тайван, инээд хөөр дүүрэн төгс харагддаг байх.

Танай гэр бүл сул эсвэл хүчтэй мэт санагдаж байсан ч Бурхан танай гэр бүлийг сонирхож, оролцоотой байдаг. Түүнд танай гэр бүлд зориулсан төлөвлөгөө бий.

► Гэр бүлийнхээ гишүүдийн нэрийг (дор хаяж 3-4 үеийн) бичээрэй. Жишээлбэл, эмээ өвөөгийнхөө нэрийг (1-р үе), эцэг эхийнхээ нэрийг (2-р үе), өөрийнхөө болон ах эгч дүү нарынхаа нэрийг (3-р үе), хүүхдүүд эсвэл ач зээ нарынхаа нэрийг (4-р үе) г.м.

Дотно, сайн харилцаатай хүмүүсийнхээ нэрийн дэргэд од зураарай. Хязгаарлагдмал харилцаатай хүмүүсийнхээ нэрийн дэргэд гурвалжин зураарай. Ямар нэгэн шалтгаанаар холбоогүй болсон хүмүүсийнхээ нэрийг дөрвөлжин дотор хийгээрэй.

Таны гэр бүлийн гишүүн биш ч гэсэн гэр бүлийн нэгэн адил бүх цугларалт, баяр ёслолд оролцдог хүмүүс бий юу? Тэдний нэрийг бичиж дугуйлаарай.

Хүн төрөлхтний анхны гэр бүл

► Бид Адам, Ева, Абрахам, Сара нарын амьдралыг судлахын тулд Библиэ Эхлэл ном дээр нээлттэй байлгацгаая.

Анхны хурим

Адам, Ева хоёр бол хүн төрөлхтний анхны гэр бүл байсан. Нэг нөхөр, нэг эхнэр, гэрлэлтээр холбогдсон нэг эрэгтэй, нэг эмэгтэй. Анхны хурим дээр Адам: "Энэ чинь л яснаас минь авсан яс магнаас минь авсан мах юм. Эр хүнээс авагдсан тул эм хүн гэж нэрлэгдэг гэжээ" (Эхлэл 2:23).

Дараагийн эшлэлд гэрлэлтийн талаарх Библийн тодорхойлолтыг өгүүлдэг: "Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болдог" (Эхлэл 2:24). Энэ хэллэг Шинэ гэрээнд Матай 19:5 болон Ефес 5:31-д давтагддаг. **Эрэгтэй, эмэгтэй**

хоёрын нэг махбод болох нэгдэл нь насан туршид үргэлжлэх Бурхан болон хүний өмнө өгсөн болзолгүй үүрэг, амлалт юм.

Гэрлэлт бол гурван талт гайхамшиг юм. Энэ нь хоёр хүнийг нэг махбод болгодог биологийн гайхамшиг; хоёр гэр бүлийг хооронд нь холбодог нийгмийн гайхамшиг; гэрлэлтийн харилцаа нь Христ болон Түүний сүйт бүсгүй болох чуулганы нэгдлийг дүрсэлдэг сүнслэг гайхамшиг юм.⁴

Гэрлэлт нь Гурвалын харилцааг тусган харуулдаг

Гэрлэлт нь Бурханы зан чанар болон Түүний харилцааг тусгахаар бүтээгдсэн. Эцэг Бурхан, Хүү Бурхан, Ариун Сүнс Бурхан гурав үргэлж хоорондоо харилцаатай байсан бөгөөд цаашид ч тийм байх болно. Тэдний үүрэг тус бүрдээ өвөрмөц боловч Гурвалын бүх бодгаль нь мөнхөд Нэг бөгөөд Нэг мөн чанартай. Гурвалын бодгаль хоорондын харилцаанаас бид эв нэгдэл, дотно байдал, үнэнч байдал, тогтвортой хайрыг олж хардаг. Библийн дагуух гэрлэлт энэхүү гайхалтай харилцааны загвараар бүтээгдсэн. Бурханы төлөвлөгөө бол нөхөр эхнэр бүр хайрандаа цэвэр ариун байж, насан туршдаа бие биедээ үнэнч байх явдал юм.

“Гэрлэлт бол... агуу гэрээ байгуулагч, гэрээгээ сахигч Бурханы зан чанарыг харуулдаг илэрхийлэл юм. Гэрээн дэх чухал элементүүд нь үнэнч байдал, шударга ёс бөгөөд сэтгэл хөдлөл биш юм.”

- Robertson McQuilkin, *An Introduction to Biblical Ethics*

Хүний гэрлэлтийн харилцаа нь Гурвалын доторх харилцааг дараах байдлаар тусгах ёстой:

1. Гэрлэлт нь нөгөө хүндээ өгсөн болзолгүй, онцгой үүрэг зориулалт байх ёстой.
2. Гэрлэлт нь өөрийгөө зориулсан хайрын харилцаа байх ёстой.
3. Гэрлэлт нь үр жимстэй харилцаа байх ёстой.

Анхны тушаал

Бурхан өөрөө анхны хуримыг адислахдаа,

Бурхан тэднийг ерөөж —Үржиж, олширцгоог! Газар дэлхийг дүүргэж, түүнийг эзэмшицгээг! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дээр хөлхөгч амьтан бүхнийг захирцгааг! гэв (Эхлэл 1:28).

Үржиж, олшрох нь Библид Бурханы өгсөн анхны тушаал юм. **Гэрлэлт нь өөрийгөө зориулсан хайрын үр жимстэй харилцаа байхаар бүтээгдсэн.** Гэрлэлт доторх үржил нь Бүтээгчийг алдаршуулдаг. Учир нь нөхөр эхнэр хоёр *хамтдаа* Бурханы бүтээлч ажлыг үргэлжлүүлж, гэр бүлийн харилцаанд илүү олон хүнийг авчирдаг. Ямар их аз завшаан бөгөөд хариуцлага вэ!

⁴ *The Woman's Study Bible*, (Thomas Nelson, Inc., 1995), 9.

► Нэг суралцагч Дуулал 127:3-5 эшлэлийг бүлэгт уншина. Энэ эшлэлд хүүхдүүдийг дүрслэхийн тулд үгээр зураглажээ. Ямар үгсээр зурагласан бэ? Эдгээрийг үндэслэн бид хүүхдүүдийнхээ талаар хэрхэн бодох ёстой вэ?

Библи бидэнд хүүхдүүд бол бэлэг, үнэт эрдэнэ гэдгийг харуулдаг. Тэднийг зөвхөн бэлгийн харилцааны үр дүн гэж бодох ёсгүй. Хүүхэд бүрэлдэх нөхцөл байдал хүсүүштэй эсвэл зөв эсэхээс үл хамааран Амийг Өгөгч та биднийг оролцуулан хүүхэд бүрийг бүрэлдүүлж, санаа зорилготойгоор төрүүлдэг. Хүний төрөлтийн нөхцөл байдал ямар байсан ч хамаагүй Бурхан хүн бүрд зориулсан зорилго бий.

Тийм ээ, хүүхдүүд бол Бурханы өгсөн бэлэг, гэхдээ тэд бас эцэг эхийн Бурханд өгсөн бэлэг юм.

Гэвч өчүүхэн ч гэсэн Сүнстэй хэн нь ч тэгэхгүй. Бурханлаг үр удмыг Бурхан эрэлхийлж байхад тэр хүн юу хийж байгаа нь тэр вэ? Тиймээс сэтгэлээ анхаар. Хэн ч залуу насныхаа эхнэрээс бүү урваг (Малахи 2:15).

Хүүхдүүд бол ариун итгэл найдвар юм. Эцэг эхчүүд хүүхдүүдээ Түүний зорилгыг биелүүлэхээр өсгөхийг Бурхан хүсэн хүлээдэг. Бурхан хүүхдүүдийг маань өөрийн хаанчлалыг түгээхэд ашиглахыг хүсдэг (Эхлэл 18:19). Бурхан бидэнд хүүхдүүдээ Түүнд үйлчлэх амьдралд бэлтгэх итгэлийг өгсөн (Дэд хууль 6:2). Бид тэднийг бидэнд үйлчлэх эсвэл бидний мөрөөдлийг биелүүлэхийн тулд өсгөдөггүй. Бид тэднийг Бурханы тэдэнд зориулсан байг онох сүм гэж харах ёстой юм.

Хүн төрөлхтний гэр бүлийн уналт ба эвдрэл

Эхлэл 3-р бүлэгт хэзээ нэгэн цагт оршин байсан цорын ганц төгс гэр бүл эвдэрч, Аврагч туйлын хэрэгтэй болсон тухай өгүүлдэг. Адам, Ева хоёр нүгэл үйлдсэн бөгөөд үхлийн хараал бүх хүн төрөлхтний дээр буусан. Адам, Ева хоёрын хоорондын харилцаа эргэлт буцалтгүйгээр эвдэрч, тэд Бурханаас тусгаарлагдсан.

Эр, эм хоёул нэмэлт хараалаас болж зовох болсон:

- Хүүхэд төрүүлэх нь өвдөлттэй байх болно.
- Нөхрүүд эрх мэдлээ буруугаар ашиглах болно.
- Эхнэрүүд дуулгаваргүй, хүндэтгэлгүй байх болно.
- Ажил нь цөхөрмөөр хэцүү хүнд байх болно.⁵

Сатан худал хэлсэнд хүмүүс итгэсэн учраас гэр бүлд зориулсан Бурханы төгс төлөвлөгөөнд гажуудал бий болсон.

⁵ **Хүүхэд төрүүлэх** нь хараалын нэг хэсэг биш гэдгийг онцлон тэмдэглэх нь чухал юм. Хүүхэд төрүүлэх үеийн **өвдөлт** нь хараалын үр дагавар боловч хүүхэд төрүүлэх нь өөрөө үргэлж дараагийн үеийг бий болгох Бурханы гайхалтай төлөвлөгөө байсан. Ажил ч бас хараал биш, харин ажлын **хүндрэл** нь хараал байсан юм. Үнэндээ Эхлэл 1:28-д Бурханы Адам, Ева хоёрт өгсөн бусад тушаалууд нь бид ажиллахаар бүтээгдсэн гэдгийг харуулдаг! Ажил бол Бурханы дүр төрхийг тусган харуулдаг арга замуудын нэг юм.

Эхлэл 4-р бүлэгт унасан хүн төрөлхтний гэр бүл хэрхэн эвдэрч сүйдэж буйг үргэлжлүүлэн харуулдаг.

Эхлэл 4:1-д анхны жирэмслэлт, төрөлт тэмдэглэгдсэнийг анзаараарай. Энэ эшлэл хүүхэд бүрэлдсэнээс төрөх хүртэлх есөн сарын хугацааг хамруулдаг. Ева Адамтай айдас болон баяр хөөрөө хуваалцахыг хичээж байсан тэрхүү есөн сарын тээлт ямар байсныг төсөөлөөд үзээрэй. Түүнд зөвлөгөө өгөх хэн ч, асуултад нь хариулах хэн ч байгаагүй. Түүний томрох гэдэс, хүүхдийн хөдөлгөөн, агшилт, өвдөлттэй төрөх үйл явц нь хүн төрөлхтний эх болох түүнд анх удаа тохиолдсон зүйл байв. Ева Каиныг төрүүлэхдөө "ЭЗЭНий ерөөлөөр би хүүтэй боллоо" (Эхлэл 4:1) гэж хэлсэн нь гайхах зүйл биш юм.

Цаг хугацаа өнгөрч, хоёр дахь жирэмслэлт, төрөлт болсон талаар дараагийн эшлэлээс бид хардаг. Одоо Адам, Евагийн гэр бүл ам бүл дөрвүүл болжээ. Мөн эшлэлийн хоёр дахь хэсэгт тэдний хөвгүүдийн ажил мэргэжлийн талаар хураангуйлсан байна. 3-р эшлэлд хөвгүүд өсөж том болсон тухай, дараагийн эшлэлүүдээс анхны аллагын эмгэнэлт түүхийг бид уншдаг. Адам, Ева хоёрын ууган хүү уур уцаар, атаархлын улмаас дүүгээ хөнөөжээ. Цочрол, харуусал, асуултууд, гомдол, өвдөлтийг та төсөөлж байна уу?

Эдгээр асуултад та "Тийм ээ! Би төсөөлж чадна. Үнэндээ би үүнтэй төстэй зүйлийг туулсан!" гэж хариулж магадгүй юм. Би таныг урамшуулахыг хүсэж байна. Та ганцаараа биш. Танай гэр бүл аврагдах боломжтой! Гэр бүл болгонд зориулсан сайн мэдээ бий.

Гордон Венхэм бичихдээ,

... Эхлэл номын утга санаа бол хүний нүгэл хэдий их байсан ч нигүүлсэл ялж, нүглийн улмаас эвдэрсэн гэр бүлд ч нигүүлсэл ялсан түүх юм. Ном дэлхийг бүтээснээр эхэлж, Бурханы дүр төрхөөр хүн төрөлхтнийг бүтээснээр оргилдоо хүрч, Бурхан өөрийн бүтээсэн бүхнийг маш сайн гэж тунхагладаг... Зөвхөн 3-р бүлэгт дуулгаваргүй байдал [зөрчил], үхэл дуулгавартай байдал, энх тунх амьдралыг орлосноор бүх зүйл буруу тийшээ эргэж эхэлсэн. 4-р бүлэгт байдал улам дордож... 6-р бүлэгт [хамгийн доод цэгтээ] хүрч, дэлхий хүчирхийллээр дүүрсэн гэж хэлдэг (Эхлэл 6:11, 13).⁶

Абрахамын гэр бүлийн эвдрэл

Эхлэл номоос бид Еврей үндэстний эцэг Абрахамын тухай уншдаг (Эхлэл 11:27-25:11).⁷ Бурхан Абрахамын гэр бүлээр дамжуулан, Аврагчийг хүн төрөлхтний гэр бүлд авчрахаар төлөвлөжээ.

⁶ Gordon Wenham, writing in *Family in the Bible*, edited by Richard S. Hess and M. Daniel Carroll R., Grand Rapids, MI: Baker Academic, 2003, 29

⁷ Бурхан Эхлэл 17:5, 15-д Абрам, Сарагийн нэрийг Абрахам, Сара болгон өөрчилсөн.

Үргүйдэл⁸

Эхлэл 11-р бүлэгт Ноагийн хүү Шемээс гаралтай Абрамын угсаа гарлыг жагсаасан байна. Эхлэл 11:30-д Абрамын эхнэр Сараи хүүхэд төрүүлж чадахгүй байсан тухай өгүүлдэг. Энэ нь уншиж буй олон хүний хувьд нулимс, зовлон, сэтгэлийн шарх, цөхрөл, хоосрол, уур, гашуудлын эшлэл юм. Хэрэв та Сараигийн оронд өөрийнхөө нэрийг тавиад энэ эшлэлийг уншвал та ганцаараа биш гэдгээ мэдэх болно.

Хүүхэдтэй болохыг хүсдэг ч үргүйдэлтэй тулгарч буй хүмүүсийн хувьд Эхлэл 1:28, Дуулал 127:3-5 зэрэг эшлэлүүдийг унших нь асар их өвдөлт, гуниг төрүүлдэг. Хүүхэдгүй байх нь шийтгэл эсвэл хараал мэт санагдах нь жам ёсны зүйл юм.

Үнэн хэрэгтээ та хүүхэдгүй учраас Бурханы хувьд доогуур, чухал биш гэсэн үг биш. Та мартагдаагүй. Таны үргүйдлээс болж танай гэр бүл хэвийн бус гажигтай гэр бүл болохгүй. Бусад хүмүүс ч бас энэхүү гүн харууслыг амсаж туулсан байдаг.

Хосууд үргүйдлийг хамтдаа болон хувь хүнийхээ хувьд хэрхэн даван туулах нь маш чухал юм. Ухаалаг бус сонголтууд цаашдын асуудалд хүргэж болдгийг Абрахам, Сараи нарын амьдралаас харах боломжтой.

Амлалтыг хүлээх нь

Эцэг нь нас барсны дараа Абрам гэр бүлийнхээ хүндэт эцэг болжээ. Бурхан Абрамыг агуу үндэстэн болгоно (Эхлэл 12:2) хэмээн амлаж, Абрамын үр удамд Канаан нутгийг өгөхөөр амласан (Эхлэл 12:7). Тэр үед Абрам 75 настай (Эхлэл 12:4), Сараи 10 насаар дүү (Эхлэл 17:17) байв. Сараи 65 настай, ер бусын үзэсгэлэнтэй эмэгтэй (Эхлэл 12:11) байсан бөгөөд хүүхэдгүй, жирэмслэх нас нь аль хэдийн өнгөрсөн байв.

Он жилүүд улиран өнгөрсөөр, Бурханы амлалт Эхлэл 13:14-17-д тодорхой шинэчлэгдсэн хэдий ч хүүхэд төрөөгүй л байв. Эхлэл 15:2-3-д Абрам Бурханд хандан зарц нь өв залгамжлагч гэж хэлснээс харвал тэрээр хүүхэдтэй болох нь нэгэнт боломжгүй гэж бодсоных болов уу. Харин Эзэн хариуд нь “Тэр хүн чиний өв залгамжлагч болохгүй, харин өөрийн чинь биеэс төрөх хүн л өв залгамжлагч болно гээд” (Эхлэл 15:4) гэж айлджээ. Дараа нь Бурхан Абрамд тоолж баршгүй олон үр удмын талаарх хоёр дахь амлалтаа зураглан өгсөн бөгөөд Абрам Эзэнд итгэжээ (Эхлэл 15:6).

Бурхан биднийг Есүстэй адил болгохоор ажиллаж байна. Заримдаа Бурхан биднийг хүлээлгэдэг. Учир нь хүлээлтийн хугацаанд бидний зүрх сэтгэлд өөрөөр хийх боломжгүй ажлыг Тэр хийж чаддаг.

Сараи эдгээр хүлээлтийн жилүүдийг хэрхэн туулсныг бодож үзээрэй:

Бусдын шүүлт Сараиг хэчнээн өвтгөж байсан ч өөрийнх нь [хурц] цөхрөл хамгийн их өвдөлт авчирсан байх. Тэр зөвхөн эх хүн болохын утга учрыг биелүүлэхийг

⁸ Уг агуулгатай холбогдуулан 10-р хичээлээс дэлгэрүүлж үзнэ үү.

хүсээгүй, бас эмэгтэйчүүдийг төдийлөн их тоодоггүй нийгэмд эхчүүдэд олгодог хүндэтгэл, эрхэмлэлийг хүсэж байсан болов уу. Эрэгтэй хүний үргүйдэл жирэмслэхгүй байх шалтгаан болдог гэдгийг бид мэднэ. Гэхдээ Сараигийн цаг үед ийм биологийн мэдлэг байгаагүй юм. Сараи эмэгтэй хүний хувьд, зүй ёсоор үнэлэгдэхийн тулд хүүхэд төрүүлж, хөхүүлж байж л өөрийн хэн болохыг тодорхойлох байв. Тэр зөв шударга, итгэмжтэй байснаараа бус, харин нөхөртөө эрэгтэй өв залгамжлагч төрүүлж өгснөөрөө эрчүүдийн нүдэнд үнэ цэнтэй болох ёстой байв. Хоосон хэвлий гэдэг нь хоосон амьдрал гэсэн утгатай байжээ.⁹

Хүмүүний шийдэл ба эмгэнэлт үр дагавар

Абрамыг 85 настай байхад Сараи хүүхэдтэй болох арга замын талаар нэгэн санааг олжээ. Сараигийн шивэгчин түүний хүүхдийн эх байж болох юм! (Эхлэл 16:1-4). Гэвч Абрам, Сараи хоёрын төгс шийдэл гэж найдсан зүйл Хагар жирэмсэн болох үед гэрийнх нь амар амгаланг сүйтгэж орхив. Зөв мэт санагдсан зүйл нь үнэндээ буруу байлаа. Бурханы амлалтыг биелүүлэхэд Түүнд туслах гэсэн оролдлого нь зөвхөн хэрүүл маргаан, зөрчилдөөнд хүргэсэн юм. Хүмүүс Бурханы төлөвлөгөө, цаг хугацаанд итгэхгүй байх үед харилцаа эвдэрч, өвдөлтийг мэдрэх зэрэг жам ёсны үр дагаврууд бий болдог.

Дараагийн жилүүдэд Абрам, Сараигийн гэр бүлд төдийгүй тэдний үеэл Лотын гэр бүлд ч бас хурцадмал байдал, гомдол, үл ойлголцол, харилцааны асуудал, уур уцаар, орхигдол, цөхрөл улам бүр нэмэгдсэн (Эхлэл 16-21).

“Бурхан бидний гуйлт хүсэлтийг хүлээлгэх ариун шалтгаантай. Елизабетад тохиолдсон шиг (Лук 1:7, 13), мөн Мариад тохиолдсон шиг (Лук 1:34) биднийг бэлэн болохоос ч өмнө урагшлах ариун шалтгаантай. Бид Түүнд дуулгавартай байж, мөргөн хүндлэх үед Тэр чиглүүлж, сургаж, бидний төсөөлж чадахгүй зүйлээр үл хязгаарлагдан, өөрийн төлөвлөгөөг гүйцэлдүүлдэг.

Shauna Letellier,
Remarkable Advent номоос авсан

Сэвтсэн гэр бүлүүд

Абрамыг Бурхан агуу үндэстний эцэг, Есүсийн төрөх угсаа болгон сонгосон! Абрам болон түүний гэр бүлийн бусад гишүүд Бурханы төлөвлөгөөг сүйтгэж байгаа мэт санагдаж болох юм! Тэд маш их алдаа дутагдалтай гэр бүлийн жишээ юм.

Эхлэл 49:33 хэсэгт ирэхэд Абрахам, Сара, Исаак, Ребека, Иаков болон түүний эхнэрүүд бүгд нас барсан байв. Иаковын хүүхдүүд бүгдээрээ сүйрэл бүтэлгүйтэл, алдаа дутагдлаар дүүрэн гэр бүл байлаа. Хэрүүл тэмцэл, маргаан, ялгаварлан гадуурхалт, хууран мэхлэлт, орхигдолт, ах дүүгийн өрсөлдөөн, хүчингийн хэрэг, цус холилдолт бүгд тэдний гэр бүлийн түүхийн нэг хэсэг юм. Эдгээр үгсээр хөгжин дэвжих, амар амгалан гэр бүлийг дүрслэх боломжгүй!

⁹ David and Diana Garland, *Flawed Families of the Bible*, Grand Rapids, MI: Brazos Press, 2007, 21-22

Харамсалтай нь энэ түүхийг Библийн туршид болон үүнээс хойших олон зууны туршид дэлхий даяар давтах болжээ. Мэдээж хэрэг, эдгээр гэр бүлүүдэд ч баяр хөөртэй цаг үе, сэтгэл булаам хайрын түүхүүд, мөн цөөн тооны зөвт хүмүүс байсан юм.

Энэ бүхнийг үл харгалзан, Бурхан хүн төрөлхтнийг аврах төлөвлөгөөгөө хэзээ ч орхигдуулаагүй. Тэрээр гэр бүлд зориулсан зорилгоо ч өөрчлөөгүй. Хэрэв та Хуучин гэрээг үргэлжлүүлэн уншвал Еврей гэр бүлийн түүхээр дамжих авралын гайхамшигтай сэдвийг олж мэдэх болно. Олон үйл явдал Есүсийг урьдаас заан өгүүлсэн байдаг. Абрахам Исаакийг өргөл болгон өргөсөн; Египет дэх боолчлолоос Израилын ард түмнийг чөлөөлсөн Алгасал баяр; Рахабыг шүүлтээс аварч, Бурханы ард түмний нэг хэсэг болгосон болон бусад олон үйл явдал Аврагч ирж, хүн төрөлхтнийг золин аварна гэсэн амлалтыг гайхалтайгаар дүрсэлдэг .

Гэр бүл дэх Бурханы авралын ажил

Ефес 5–р бүлэгт Бурхан гэрлэлтийг Христ болон Түүний сүйт бүсгүй Чуулгантай харилцах харилцааны дүр зураг байхаар төлөвлөсөн гэдгийг өгүүлсэн. Тэргүүн болох Христ өөрийгөө Чуулганы төлөө өгдөг шиг нөхөр бүр эхнэрийнхээ тэргүүн болохын хувьд өөрийгөө түүний төлөө өгөх ёстой аж. Үүний нэгэн адил эхнэр бүр Чуулганы жишээг дагах ёстой юм. Чуулган Христэд захирагддаг шиг эхнэр бүр нөхөртөө захирагдах ёстой.

Хүн төрөлхтний уналт гэр бүлд зориулсан Бурханы анхны загвар төлөвлөгөөг гажуудуулж, гэрлэлтийн харилцаанд гамшигт үр дагаврыг авчирчээ. Хүн төрөлхтөн нүгэлд унасны үр дагаврыг гэр бүл болгон амсдаг. Гэсэн хэдий ч,

Есүс бүх зүйлийг, түүний дотор гэрлэлтийг золин аврахаар ирсэн юм. Тэрээр нүглээс болж эвдэрч, гутаагдсан бүхнийг аварч, сэргээхээр ирсэн. Гэрлэлтэд зориулсан Бурханы төлөвлөгөөг бид хэрэгжүүлэх чадахгүй байхад Есүс Бурханы хэм хэмжээг төгс биелүүлсэн билээ. Есүс чуулганыг хайрлаж, түүний төлөө амиа өгсөн. Тэр Эцэг Бурханы төлөвлөгөөнд төгс захирагдсан юм. Бурханы төлөвлөгөө болон бидний гэрлэлт гүйцэлдүүлж чадахгүй зүйл буюу хайрлах ба захирагдахын төгс, бүрэн дүүрэн биелэл нь Есүс байв.¹⁰

► Гэрлэсэн хүнд байх ёстой хандлагын жишээг Есүсээс хэрхэн харж болох вэ?

Есүс өөрийн бүрэн захирагдах байдал, төгс хайраараа Бурханы хүслийг биелүүлээд зогсохгүй, унасан хүн төрөлхтний нэг хэсэг болсон сүйтгэгч хандлагыг давж туулахад нөхөр эхнэрүүдэд тусалдаг. Түүний нигүүлслээр нөхөр эхнэрүүд Ариун Сүнсний хүчээр амьдрахдаа гэрлэлтэд зориулсан Бурханы төлөвлөгөөг биелүүлж чадна (Ефес 5:18).

¹⁰ Christina Fox, “Redeeming Marriage.” 2022 оны 11 сарын 29-нд <https://cbmw.org/2013/08/29/redeeming-marriage/> вебсайтад хандсан.

Төгс гэр бүл гэж байхгүй ч Бурхан гэр бүл болгоныг золин аврахыг хүсдэг. Бурханы нигүүлсэл гэр бүлийн дотор ажиллаж, хүн нэг бүрийг Бурхан анхнаасаа хэн байгаасай гэж хүссэн тийм хүн болоход нь тусалдаг. Гэр бүлийн доторх хүн нэг бүр Бурханы зааврыг дагахаар сонгосноор тэдний дуулгавартай байдал гэр бүл болгонд байдаг төрөлхийн гажуудал, дутагдлыг даван туулахад нь тус дэм болдог. Бид Бурханы хүсэлд захирагдах үед хүн хоорондын харилцаанд нөлөөлдөг уналтын үр дагавар багасаж байдаг.

Жишээлбэл, бурханлаг нөхөр Ефес 5-р бүлэгт Бурханы өөрт нь өгсөн зааврыг дагах үедээ хувиа хичээсэн, эрх мэдлээ эхнэртээ буруугаар ашиглах төрөлхийн хандлагаа даван туулдаг. Бурханд захирагдах түүний дуулгавартай байдал нь уналтын хор хөнөөлтэй үр дагаврыг багасгаж, эдгэрлийг авчирдаг. Энэхүү дуулгавартай байдал нь эхнэр нь түүнд захирагдахад ч бас түлхэц болдог.

Эхнэр хүн Бурханы зааврыг дагаж, нөхөртөө захирагдах үедээ (Ефес 5:24) нөхрийнхөө эрх мэдлийг эсэргүүцэх төрөлхийн нүгэлт хандлагаа даван туулж байдаг. Бурханд захирагдах түүний дуулгавартай байдал нь Бурхан гэрлэлтийг нь ямар байлгахыг хүссэн тийм харилцаанд илүү ойртоход нь тусалж, эдгэрлийг авчирдаг (1 Коринт 11:3, 1 Петр 3:1-7).

Бурханы хувьд гэр бүлийн харилцаа маш чухал болохыг итгэлийн гэр бүлүүд харуулахын тулд Тэрээр гэр бүлийг эдгээх, аврах заавруудыг өгсөн.

Библийн дагуух гэр бүлийн хариуцлага

Эцэг эх ба өвөө эмээгийн үүрэг хариуцлага

Эцэг эх, өвөө эмээ нар хүүхэд, ач зээ нартаа Бурханы замыг заах хэрэгтэйг Библийн олон эшлэлд дурдсан байдаг. Бид гурвыг товчхон авч үзэх болно.

► Нэг суралцагч Ефес 6:4 эшлэлийг бүлэгт уншина. Энэ эшлэл юу гэсэн утгатай вэ?

Эцэг эхчүүд хүүхдүүдээ Бурханыг мэдэж, Түүнд дуулгавартай байхад сургах нь Бурханы төлөвлөгөө юм. Эцэг эхчүүд хүүхдүүдээ удирдаж, зааварчилж, залруулж, сургадаг арга барил нь Бурхан өөрийн хүүхдүүдэд эдгээр зүйлийг хийдэг арга барилын тусгал байх ёстой.

► Нэг суралцагч Дуулал 78:1-8 эшлэлийг бүлэгт уншина. Дараах асуултуудад хариулаарай:

- Энэ хэсэгт гэр бүлийн хэдэн үеийг дурдсан байна вэ?
- Үе бүрийн хариуцлага юу вэ?
- Ахмад үе залуу үедээ юу заах ёстой вэ?

Дуулал 78 нь Бурханы гайхалтай нигүүлсэл, өршөөлийг харуулдаг. Энэ нь Египетээс гарсан цагаас Давидын хаанчлал хүртэл Израилын гэр бүлд Түүний хийсэн ажлын тухай өгүүлдэг. Энэ Дуулал уншигчдад тэдний гэр бүлийн нөхцөл байдалд найдварыг өгдөг.

► Нэг суралцагч Дэд хууль 6:1-9 эшлэлийг бүлэгт уншина. Энэ хэсгийг харвал, Бурханы ард түмэн болох биднээс Тэр юу шаарддаг вэ?

Энэ эшлэлд Бурханы амласан нутагт израилчууд орохын өмнөхөн Мосегийн тэдэнд хэлсэн үгсийн нэг хэсгийг өгүүлжээ. Тэд Бурханы ард түмэн хэрхэн байх тухай, Бурханд харьяалагдах гэж юу гэсэн үг болохыг суралцжээ. Эдгээр эшлэлд өгүүлсэн үнэнүүд нь Бурханы ард түмэн байж амьдрахын үндэс суурь болдог.

Бурхан биднийг өөрийнх нь Үгийг дуулгавартай сонсож, Түүний биднээс шаарддаг зүйлийг хийхийг тушаасан! (3-4-р эшлэл).

Биднээс шаарддаг зүйлс:

1. Бүх зүрх, сэтгэл, хүч чадлаараа Эзэнийг хайрлах (5-р эшлэл).
2. Бурханы Үгийг зүрх сэтгэлдээ хадгалах (6-р эшлэл).
3. Хүүхдүүддээ Бурханы Үгийг хэрхэн дагахыг хичээнгүйлэн заах (7-р эшлэл).
4. Бурханы Үгийг оюун бодолдоо хадгалж, байнга өмнөө байлгах (8-9-р эшлэл).

Эдгээр тушаал нь бүх үеийнхэнд зориулагдсан болохыг анзаараарай (2-р эшлэл). Бурхан эцэг эх, өвөө эмээ нарыг хүүхэд, ач зээ нараа Түүний төлөө амьдрахад сургах хариуцлагатай гэж үздэг. Хэр удаан хугацаанд вэ? Амьдралынх нь бүх өдрүүдэд (2-р эшлэл). Бурхан эцэг эхчүүд бидэнд хүүхдүүддээ Түүний замыг өдөр бүр, хаа сайгүй, явсан газар, хийсэн бүх зүйлдээ заах ёстой гэж хэлдэг (7-9-р эшлэл).

Хүүхдүүдийн сүнслэг боловсрол нь эцэг эхийн хариуцлага байсан. Сургалт нь эцэг эхийн үлгэр жишээгээр болон Хуулийг давтах замаар өдөр бүр явагддаг байжээ. Эцэг эхчүүд хүүхдүүддээ заахын тулд ямар их хүчин чармайлт гаргадаг байснаас энэ тушаал ямар чухал болохыг харж болно. Энэ нь зөвхөн Хуулийн баримтуудыг заахаас илүү, өдөр тутмын амьдралыг хивс нэхэхийн адил амьдралын хэв маяг болгон харуулах ёстой байжээ. Өрх гэрийн энгийн ажлуудыг хийж байхдаа Бурханы заавар журмуудыг заахад бүтээлч байдал шаардагддаг.¹¹

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ оюун ухааныг төдийгүй зүрх сэтгэлийг нь бас сургах ёстой. Тэд хүүхдүүддээ зөвхөн Бурханы тухай баримтуудыг төдийгүй Бурхантай харилцаатай амьдрах болон Түүнд дуулгавартай байх практик хэрэглээг бас заах ёстой. Эцэг эхчүүд хүүхдүүддээ үгээр зааварчлах болон амьдралын жишээгээр сургадаг. Энэ хоёул чухал.

Энэ эшлэл энгийн мэт санагдаж болох ч маш чухал юм. Эдгээр үнэнүүд болон тушаалууд нь хувь хүмүүс болон гэр бүлд зорилго, чиглэлийг өгдөг. Эцэг эхчүүд Бурханыг улам ихээр мэдэхийг байнга эрэлхийлж, бүх зүйлд Түүнд бүрэн дуулгавартай байхын хэрээр тэд хүүхдүүддээ үүнийг хийхийг зааж байдаг. Эцэг эхчүүд насан туршдаа суралцах, дуулгавартай байх хандлагатай байх ёстой. Энэ нь тэдний хүүхдүүдэд үлгэр жишээ болж, тэдэнд Бурханыг эрэлхийлэх хүслийг төрүүлдэг.

¹¹ *The Woman's Study Bible*, Thomas Nelson, Inc. 1995, 292

► Эцэг эхчүүд хүүхдүүдээ өдөр бүр дагалдуулах ямар практик аргууд байдаг вэ?

Гэр бүл - бусдыг хайрлах сургалтын талбар

► Нэг суралцагч 1 Иохан 4:7-13, 19 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ хэсгийн гол сэдэв бол хайр юм. Бурхан хэн болохыг бялхам дүүрнээр мэдэхийн тулд бид *бие биенээ* хайрлах ёстой. "Бие биенээ" гэдэгт гэр бүл маань багтана. Бурхан бидэнд гэр бүлийг өгсөн нэг шалтгаан нь бид бусдыг хэрхэн хайрлахыг сурахын тулд юм. Бид гэр бүлийнхээ гишүүдэд хайраа харуулж сурахын хэрээр (хэцүү байсан ч) Бурхантай улам бүр адил болдог. Учир нь Бурхан бол хайр юм! (8-р эшлэл).

Сүнслэг эсвэл биеийн гэр бүлийн гишүүд бие биенээ хайрласнаар тэд Бурханаас төрсөн гэдгээ баталдаг (7-р эшлэл). Тэд бие биенээ хайрлах тусам Бурханы хайр тэдний дотор төгс болдог (12-р эшлэл).

Бурхан биднээс зөвхөн бусдыг хайрлахыг шаардаагүй, харин эхлээд биднийг Тэр хайрласан (9-11, 19-р эшлэл). Тэр бидний нүглийн төлөө Есүсийг илгээж, биднийг хайрласан (10-р эшлэл). Биднийг хайрласан Бурханы хайр нь бусдыг хайрлах бидний сэдэл юм (11-р эшлэл).

Гэр бүлээ хайрлах нь зарим хүмүүст амархан, бусдынх нь хувьд маш хэцүү ч байж болох юм. Харин Түүний тушаалыг дагахад бидэнд бүгдэд маань хэрэгтэй зүйл нь Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор оршдог Бурхан билээ (12-13-р эшлэл).

Бурхан биднийг эцэг эх, хань ижил, үр хүүхдүүдээ оролцуулаад бие биенээ хайрлахад уриалдаг. Гэр бүлээ хайрлах нь буруу эсвэл муу зүйлийг зөвшөөрнө гэсэн үг биш. Энэ нь биднээс хариуцлага шаардахгүй ч гэсэн үг биш. Харин энэ нь бид гэр бүлийнхээ гишүүдэд хамгийн сайн сайхныг хүсэж, тэдний сайн сайхны төлөө өөрийгөө зориулахад бэлэн байна гэсэн үг юм.

Хэлэлцүүлгийн асуултууд

- Гэрлэлт Гурвалын харилцааг хэрхэн тусгадаг талаар өөрийн үгээр тайлбарлаарай.
- Нүглийн улмаас эвдэрсэн гэрлэлтийг Бурхан хэрхэн эдгээн авардаг тухай ярина уу.
- Гэрлэлт дэх Бурханы зааврыг дагах нь яагаад гэр бүлийг шинэчлэн эдгээдэг болохыг тайлбарлана уу.

Залбирал

Хэсэг зуур залбирч, гэр бүлийнхээ төлөө Бурханд талархал илэрхийлээрэй. Гэр бүлийнхээ төлөө залбираарай. Өвдөлт, бүтэлгүйтэл, баяр ёслол, баяр хөөртэй нөхцөл байдлынхаа талаар залбираарай. Дэд хууль 6:4-9 эшлэлийн үгсийг өөртөө тусгаж, тэдгээрийг дуулгавартай байдал, хүсэлт болгон залбираарай.

Хичээлийн даалгаврууд

(1) Дэд хууль 6:4-9 эшлэлийг цээжил. Дараагийн хичээлийн эхэнд цээжилснээ бичгээр эсвэл аман хэлбэрээр уншаарай.

(2) Дэд хууль 6:1-9-д Бурхан биднээс дөрвөн зүйлийг шаардсан. Эдгээр дөрвөн чиглэлийн дагуу залбирч, өөрийгөө шударгаар үнэлээрэй.

Биднээс шаарддаг зүйлс:

- Бүх зүрх, сэтгэл, хүч чадлаараа Эзэнийг хайрлах (5-р эшлэл).
- Бурханы Үгийг зүрх сэтгэлдээ хадгалах (6-р эшлэл).
- Хүүхдүүддээ Бурханы Үгийг дагахыг хичээнгүйлэн заах (7-р эшлэл).
- Бурханы Үгийг оюун бодолдоо хадгалж, байнга өмнөө байлгах (8-9-р эшлэл).

Эдгээрийн талаар тус бүр нэг догол мөрөнд залбирал болгон бичээрэй (Та энэ бичсэн зүйлээ ангийн удирдагчтайгаа хуваалцах шаардлагагүй бөгөөд даалгавраа хийсэн гэдгээ л мэдэгдэхэд болно).

(3) Абрахам, Сара нарын амьдралаас бид урт удаан хүлээлтийн талаар сурдаг. Дараах асуултуудын дагуу бодож үзнэ үү:

- Та хэзээ Бурханы цаг хугацааг хүлээх шаардлагатай болсон бэ? Эдгээр хүлээлтийн цаг үеэс та юу сурсан бэ?
- Та Бурханы Үгийн амлалтад хэр их итгэдэг вэ? Та одоо ямар нэгэн амлалттай холбоотой бэрхшээлийг туулж байна уу? Энэ бэрхшээл танай гэр бүлд хэрхэн нөлөөлж байна вэ?
- Та Бурханд итгэж найдахгүйгээр өөртөө эсвэл гэр бүлдээ зориулж ямар нэгэн зүйлийг шийдвэрлэхийг оролдож байсан уу? Үр дүн нь юу байсан бэ?
- Тэвчээргүй байдал, итгэлгүй байдал гэр бүлд хэрхэн сөргөөр нөлөөлдөг вэ?

Энэ сэдвээр нийт гурван догол мөрөнд багтаан хариулт бичээрэй (Та энэ бичсэн зүйлээ ангийн удирдагчтайгаа хуваалцах шаардлагагүй бөгөөд даалгавраа хийсэн гэдгээ л мэдэгдэхэд болно).

3-р хичээл

Библи дэх гэрлэлтийн ойлголт

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Гэрлэлтийн төлөөх Бурханы төлөвлөгөө болон зорилгод өөрийгөө зориулах.
- (2) Христиг гэлт гэрлэлтийн төлөөх Бурханы зарчмуудад дуулгавартай байх.
- (3) Библийн дагуух гэрлэлтийг бусдад заахад бэлтгэгдэх.

Амлалтаа сахигч Робертсон МакКуилкин

Др. Робертсон МакКуилкин 12 жилийн турш Японд илгээлтийн ажлыг хийжээ. Хожим нь Колумбиа Олон Улсын Их Сургуулийн ерөнхийлөгч болсон. Тэрээр зохиолч, илтгэгч, сурган хүмүүжүүлэгч гэдгээрээ олонд танигдсан хүн юм. Түүний эхнэр Мюриел хүний бодох, санах, харилцах чадварт нөлөөлдөг тархины өвчтэй байв. Өвчин нь улам хүндэрч Мюриелд байнгын асаргаа сувилгаа шаардлагатай болсон тул Др. МакКуилкин эхнэрийнхээ төлөө их сургуулийн ерөнхийлөгчийн албан тушаалаасаа огцорчээ. Тэрбээр энэ тухайгаа гэрлэхдээ эхнэртээ өгсөн амлалтаа биелүүлж байна хэмээн хэлсэн юм. Түүний хувьд эхнэрээ асрах нь их сургуулийн ерөнхийлөгчийн албан тушаалаас илүү чухал гэдэгт тэр итгэж байв.

Гэрлэлтийг Бурхан үндэслэсэн

Бурхан өөрийн бүтээсэн анхны эрэгтэй, эмэгтэй хоёрт зориулан гэрлэлтийг эхлүүлсэн. Бурхан хүмүүсийн мөн чанарт тохируулан гэрлэлтийг санаачилсан. Энэ нь хүний мөн чанарт яг тохирсон байхаар бүтээгдсэн. Бурханы бүтээсэн бүх зүйл ба түүний шалгуур нь үргэлж бидний сайн сайхны төлөө байдаг (Дэд хууль 6:24). Гэрлэлтийн талаарх Бурханы төлөвлөгөө нь эхнэр, нөхрийн аль алиныг сэтгэл санаа, харилцаа болон сүнслэг байдлын хувьд хамгийн сайн байхад зориулагдсан юм.

Бурхан гэрлэлтээр эрэгтэй, эмэгтэй хүн эцэг эхээ орхиж, нэг болдог гэж хэлсэн. Гэрлэлт нь хоёр хүнийг бусад харилцаанаас илүү дотно нөхөрлөл, хамтын ажиллагааны хувьд хүчтэй, мөн дотно байхаар бүтээгдсэн байдаг. Гэрлэлт бол зөвхөн хязгаарлагдмал харилцаанд байгаа хоёр хүний тухай ойлголт биш юм. Тэдний амьдрал нэгдсэн нь, нэг хүн шиг болсон гэсэн утгатай. Энэ нь хувь хүний онцлог байдлыг устгаж буй хэрэг биш бөгөөд харин онцгой нэгдмэл байдлын тухай юм.

Библийн дагуу гэрлэлт

Библийн дагуу гэрлэлт бол маш сайхан зүйл юм. Харин гэрлэлтийн сайхныг мэдэрч, амтлахыг хүсэж буй хосууд Библид энэ тухай юу заадгийг сурч, дуулгавартай хэрэгжүүлэх хэрэгтэй. Сэтгэл хангалуун гэрлэлт нь хүчин чармайлт, золиос шаарддаг.

Библийн дагуу гэрлэлт бол нөхөрлөл юм

Эхлэл номд Бурхан гэрлэлтийг бүтээсэн тухай өгүүлдэг. Тодорхойлолтын хэсэг бүр нь гэрлэлтийн мөн чанарын тухай юм.

ЭЗЭН Бурхан —Хүн ганцаараа байх нь сайн биш. Би түүнд тохирох туслагчийг буй болгоё гэжээ (Эхлэл 2:18).

Бурхан Эцэг, Хүү, Ариун Сүнс хэмээх нөхөрлөлд оршдог шиг Бурхан биднийг нийгмийн нэг хэсэг байхаар бүтээсэн. Бид бусадтай ярилцаж байхаар бүтээгдсэн. Бид дотно байдал, нөхөрлөлд зориулагдан бүтээгджээ. Бурхан ганцаараа байх нь сайн биш хэмээн айлдсан!

Бурхан эрэгтэй хүний хавирганаас үзэсгэлэнтэй эмэгтэй хүнийг бүтээсэн нь Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, үнэ цэн ижил, үзэгдэх байдлын хувьд өөр ч, эрэгтэй хүнийг төгс болгохоор бүтээгдсэн бие хүн юм. Эмэгтэй хүн нь "Бүтээгчийн сүүлчийн бөгөөд хамгийн төгс бүтээл болохын хувьд эрэгтэй хүнд онцгой хүндэтгэлтэйгээр ирсэн юм."¹²

Гэрлэлт бол баяр хөөртэй нэгдмэл байдал юм.

Адам "Энэ чинь л яснаас минь авсан яс" (Эхлэл 2:23) гэж хэлэхдээ хүндэтгэл, баяр баясгалангаа илэрхийлж байсан. Адам "Зарцтай боллоо! Одоо миний хувцсыг угааж, хоол хийж, нурууг минь барьж, гэрийн ажил хийлцэх хүнтэй боллоо!" гэж хэлээгүй. Харин Адам "Эцэст нь намайг төгс болгох туслагчтай боллоо!" гэж хэлсэн.

Гэрлэлт бол эрх тэгш хүмүүсийн нэгдэл юм.

... түүнд тохирох туслагчийг (Эхлэл 2:18).

Бурхан эмэгтэй хүнийг эрэгтэй хүнтэй зохицож, түүнийг төгс болгохоор бүтээсэн.

Мэтью Хенри бидэнд сануулахдаа: "Эмэгтэй хүнийг Адамын хавирганаас бүтээсэн гэдэг нь; түүнийг захирах толгой байхаар биш, түүний хөлд дэвслэгдэх нэгэн байхаар биш, харин түүнтэй түүний хажууд эрх тэгш байхаар, түүний гар дор хамгаалагдахаар, хайрлуулахын тулд зүрхнийх нь ойр бүтээсэн."¹³ гэжээ. Эмэгтэй хүн эрэгтэй хүнээс дорд эсвэл дээгүүр ч биш, харин түүнтэй эрх тэгш байхаар бүтээгдсэн.

¹² Charles Ellicot, ed., *Ellicot's Commentary for English Readers*. (Эхлэл 2:22-ын тэмдэглэлд). 2020 оны 12 сарын 29-нд <https://biblehub.com/genesis/2-22.htm#commentary> вебсайтад хандсан.

¹³ Matthew Henry, *Matthew Henry's Commentary on the Whole Bible*. (Эхлэл 2:21-25-ын тэмдэглэлд). 2023 оны 7 сарын 31-нд <https://studylight.org/commentaries/eng/mhm/genesis-2.html> вебсайтад хандсан.

Гэрлэлт бол гэрээний нэгдэл байх ёстой.

Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болдог (Эхлэл 2:24).

Бат бэх гэрлэлт нь тасралтгүй үргэлжлэх романтик мэдрэмж (мэдрэмж байнга өөрчлөгддөг), таашаал (эрүүл гэрлэлт баяр баясгалан авчирдаг хэдий ч), эсвэл хувийн сэтгэл ханамж (бат бэх гэрлэлт сэтгэл ханамж өгдөг хэдий ч) зэргээс шууд хамаардаггүй. Гэрлэлтийн гайхалтай ашиг тус нь бат бэх гэрлэлтийн *шалтгаан* биш; харин бат бэх гэрлэлтийн *үр дүн* юм. Гэрлэлт нь гэрээний бат бэх суурин дээр үндэслэгдсэн, насан туршдаа үнэнч байх нэг эрэгтэй, нэг эмэгтэй хүний зориулалт юм.

Гэрлэлт бол ил тод, найдвартай, хүлээн зөвшөөрөгдсөн харилцаа байх ёстой - "Тэр хүн, бас эхнэр нь хоёулаа нүцгэн байсан бөгөөд тэд ичсэнгүй" (Эхлэл 2:25). Нүгэл анхны хосын гэм зэмгүй байдлыг хараахан гажуудуулаагүй байсан учраас тэдний гэрлэлт шүүлтгүй, ичих зүйлгүй, айдасгүй байжээ. Шинэ гэрээнд бидэнд "Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр чинь бүү бузартаг..." (Еврей 13:4) гэж хэлсэн байдаг.

Аюултай, үл итгэлцэл, хардалт, айдас болон бие биенийхээ үнэнч байдалд эргэлзэж буй газарт бат бэх гэрлэлт орших боломжгүй. Бат бэх гэрлэлт нь хосын нэг нь нас барж, амлалтын харилцаа дуусахад л төгсгөл болдог (Ром 7:1-2).

Гэрлэлтийн талаарх Бурханы зорилго нь нэг эрэгтэй, нэг эмэгтэй хүний хоорондох насан туршийн гэрээ юм (Матай 19:3-6). Паул итгэгч хүний итгэгч биш хань ижил нь салах үед тэд боолчлолд байдаггүй гэж Паул хэлсэн (1 Коринт 7:15). Гэвч итгэгч хүн итгэгч биш хань ижлээсээ өөрөө салахыг хүсэх ёсгүй (1 Коринт 7:12-14, 16) гэжээ. Паул өмнө нь бичихдээ Эзэн ч мөн адил ийнхүү хэлсэн гэж өгүүлсэн байдаг: итгэгчид ханиа орхих/салах шийдвэр гаргах ёсгүй, харин салсан бол өөр хэн нэгэнтэй гэрлэж болохгүй (1 Коринт 7:10-11, Матай 5:31-32, Матай 19:9) гэжээ.

Гэрээний хайр нь хоорондын харилцаа хэцүү үед ч өөрийгөө бүрэн зориулсан, хүндэтгэлтэй, үзэсгэлэнтэй харилцаа юм (1 Коринт 13). Сул зориулалт нь тодорхойгүй хүчин чармайлт, сэтгэл санаа үл холбогдох, хөндий харилцаа, уруу таталтыг бий болгодог.

Гэрээний дагуу хайрлаж буй нөхөр хүн эхнэрээ хариу үйлдэл үзүүлэхгүй, хүндэтгэлгүй, өвчтэй байсан ч, түүнийг хэзээ ч орхихгүй. Гэрээний дагуу хайрлаж буй эхнэр хүн нөхөр нь түүнийг хайрлахгүй байх үед ч Христийн төлөө түүнийг хүндэтгэж, дуулгавартай байхыг сонгодог.

Эр нөхрийнх нь хайр эхнэрээсээ хүндэтгэл олж, эхнэрийнх хүндэтгэл эр нөхрөөсөө хайрыг олж авдаг. Ингэж тэдний харилцаа өссөөр байдаг!

► Хүмүүс гэрлэлтдээ сэтгэл хангалуун бус байвал шийдвэрээ өөрчилж болно гэсэн бодолтой гэрлэлт эхлүүлбэл ямар асуудлууд үүсэх вэ? Хүн гэрлэлтээ үүрд хэмээн итгэж, бүрэн зориулалт гаргавал гэрлэлтэд чинь ямар өөрчлөлт гарах вэ?

Библийн дагуух гэрлэлт бол бэлгийн таашаал ба нөхөн үржихүйн талбар юм.

Бурхан бэлгийн харилцааг бүрэн таашаал болон онцгой хүчтэй байхаар бүтээсэн. Энэ нь бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлын хувьд нэгдмэл болох зорилготой үйлдэл юм. Эрүүл бэлгийн амьдрал нь зөвхөн баяр баясгалантай нэгдмэл байдлыг авчирдаг төдийгүй гэрлэлтийн харилцааг ундаалж байдаг. Библийн дагуух бэлгийн харилцааны ёс зүйг дагахыг хүсдэг хүмүүсийн хувьд бэлгийн харилцаа бол гэрлэлт дотроо бүрэн таашаал авахын тулд өгөгдсөн Бурханы бэлэг юм.¹⁴

► Суралцагчид 1 Коринт 7:1-5 ба Еврей 13:4 эшлэлийг бүлэгт уншина.

1 Коринт номын эшлэлүүд гэрлэлтийн нэг зорилго нь бэлгийн дур хүслийг хангахад оршдог гэдгийг бидэнд хэлдэг. Нөхөр эхнэр хоёр бие биедээ өөрсдийгөө өгч, өөрсдийн бие махбодыг эзэмших эрхээсээ татгалзсан. Энэ нь гэрлэсэн хүн зөвхөн өөрийн хүссэн үедээ бэлгийн харилцаанд орох ёсгүй, харин ханийнхаа хүсэлд ч мөн адил хариу үйлдэл үзүүлэх ёстой гэсэн утгатай. Эдгээр эшлэл нь хосууд өөрийнхөө хүслийн төлөө сэтгэл ханамж шаардах эрхтэй гэж хэлээгүй. Харин, бие биенийхээ хэрэгцээнд хариу үйлдэл үзүүлэхийг сануулдаг.

Энэ хэсэгт гэрлэсэн хүмүүс дээрх давуу байдлаа бие биенээсээ харамлах ёсгүй гэж хэлдэг. Мацаг барих үедээ бэлгийн харилцаанд богино хугацаагаар орохгүй байж болох ч, удаан хугацаагаар харилцаанд орохгүй байх нь бие сэтгэл ханаагүй хүслээс болж уруу таталтад орох нөхцлийг бүрдүүлнэ. Заримдаа хосууд хэдэн сараар эсвэл түүнээс дээш хугацаагаар нэг нь алс хол ажиллах эсвэл суралцах болсноос үүдэн тусгаарлагддаг. Ийм шийдвэр гаргахаасаа өмнө хосууд энэхүү төлөвлөгөө нь тэдэнд тохирч байгаа эсэхийг, мөн Бурханы төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг бодох хэрэгтэй. Урт хугацааны тусдаа байдлаас болж тэд асуудалтай тулгарч болно.

Зарим хүмүүс хүүхэдгүй амьдралын хэв маягийг илүүд үздэг боловч эцэг эхчүүд бурханлаг хүүхэдтэй байх үед Бурхан баярладаг хэмээн Библид хэлдэг (Малахи 2:15). Бурхан зөвхөн нөхөн үржихүйг хүсдэггүй, харин бурханлаг үр хүүхдийг хүсдэгийг анхаарах нь чухал юм. Бурханаар дуудагдсан эцэг эхчүүдээс хүүхдээ Христийг дагахад сургахыг уриалсан байдаг.

Библийн дагуух гэрлэлт нь Христийн төлөө юм

► Суралцагчид 1 Петр 3:1-7 ба Ефес 5:22-33 эшлэлийг бүлэгт уншина. Бүлэг хэлэлцүүлгийн үеэр эдгээр эшлэлийг нягтлахын тулд нээлттэй үлдээх хэрэгтэй.

¹⁴ “Spiritual Health and Porn Addiction,” 2023 оны 7 сарын 31-нд <https://thefreedomfight.org/health/porn-addiction-and-spiritual-health/> вебсайтад хандсан.

Ефес 5:30-32 эшлэлд Есүсийг ирэх хүртэл нууцлаг байсаар байгаа, гэрлэлтийн гүн гүнзгий утга учрыг Ариун Сүнс илчилдэг. Гэрлэлт бол Есүс Христ болон Түүний чуулган хоорондын харилцааны дэлхий дээрх зураглал бөгөөд тусгал юм.

Паул энэ хэсэгт итгэгчдийг Сүнсээр дүүрэн байхыг уриалж (Ефес 5:18) эхэлдэг. Энэ хэсэгт тэрбээр гэрлэлтийн талаар дараах зааврыг өгсөн.

Сүнсээр дүүрэн сүйт бүсгүй Эзэний дотор болзоот залуудаа (өөрийн "Тэргүүн") захирагдах болно, итгэгч нар Есүст захирагддаг шиг (Ефес 5:24, 32; мөн 1 Петр 3:1-ийг үзнэ үү). Энэ нь эхнэр нь Есүс болон нөхөртөө хүндэтгэл үзүүлж буй хэлбэр юм. Эхнэрийн хувьд түүний нөхөр нь итгэгч биш байсан ч түүний удирдлагад байх ёстой. Хэрэв тэр ийнхүү үйлдвэл түүний аврагдаагүй нөхөр нь итгэгч болох боломжтой.

Эхнэрүүд нөхөртөө захирагдах бүрдээ Эзэнийг санаж байх нь чухал. Учир нь энэ нь зөвхөн нөхөртөө захирагдаж буй хэрэг биш, харин Бурханы төлөө юм. Эхнэр нь цорын ганц гэм буруугүй Есүсийг ширтэн харж, төвлөрөхийн тулд юм. Эхнэрийн нөхөртөө дуулгавартай захирагдаж буй нь нөгөө талаар Есүсийг мөргөн хүндэтгэж буй үйлдэл юм.

Библийн дагуу захирагдах байдал нь хайрлахтай адил албадлагын байж таарахгүй. Библийн дагуу захирагдах нь эхнэрүүдийн Христэд хүндэтгэлтэй хандсанаар нөхөртөө өгч буй бэлэг юм (Ефес 5:22-24). Захирагдах нь Есүсийг мөргөн хүндэтгэж буй үйлдэл билээ.¹⁵

Эхнэр нь нөхөртөө захирагдах нь түүнийг хүндэтгэж буй үйлдэл (Ефес 5:33) бөгөөд Сүнсээр дүүрэн амьдралын нэг хэсэг юм (Ефес 5:18-21). Эелдэг, дөлгөөн сэтгэлээс ирэх энэ хүндэтгэл Бурханы нүдэнд маш үнэ цэнтэй (1 Петр 3:4).

Сүнсээр дүүрэн болзоот залуу нь Есүс чуулганаа хайрласан шиг сүйт бүсгүйгээ хайрлах болно (Ефес 5:25). Болзоот залуу өөрийн биеэ хайрладаг шиг сүйт бүсгүйгээ хайрлах ёстой (Ефес 5:28-29). Сүнсээр дүүрэн Есүс өөрийгөө золиос болгон өөрийн сүйт бүсгүй болох чуулганд зориулсны адил болзоот залуу нь өөрийгөө сүйт бүсгүйдээ бүрэн зориулах ёстой. Энэ нь түүний хувьд Бурханд захирагдаж буй үйлдэл юм (Ефес 5:21). Нэгэн Библийн тайлбарлагч үүнийг ингэж хэлсэн байна:

Тэрээр (Есүс) чуулганаа аврахын тулд загалмай дээр зовж, өөрийгөө өгсөн шиг бид эхнэртээ аз жаргал өгөхийн тулд өөрийгөө үгүйсгэж [хүнд хөдөлмөр, бэрхшээлийг], ачаа үүрэхэд бэлэн байх ёстой. Нөхрийн үүрэг бол түүнийг тэжээн тэтгэхийн төлөө [хичээнгүйлэн ажиллах]; түүний хэрэгцээг хангах; өвчтэй үед нь түүнийг асран халамжлахын тулд шаардлагатай бол өөрийн амралт, тав тухтай байдлаас татгалзах; аюулд орох үед нь өмгөөлөх, хамгаалах; [аюултай нөхцөл байдалд]; уурлах үед нь тэвчих; түлхэж байгаа үед нь түүнд улам ойртох;

¹⁵ Библийн дагуу захирагдах байдлын талаар дараах хичээлийг дэлгэрүүлж үзнэ үү. *Spiritual Formation*, 10-р хичээл, Shepherds Global Classroom.

сүнслэг асуудалтай байх үед нь түүнтэй хамт залбирах; түүнийг аврахын тулд үхэхэд бэлэн байх юм. Яагаад ингэх ёстой гэж? Хэрэв тэд хамтдаа усан онгоцны сүйрэлд орж, амьд үлдэх ганцхан тавцан хэлтэрхий олдвол эр нөхөр нь түүнийг эхнэртээ өгөхөд бэлэн байх ёсгүй гэж үү? Гэхдээ үүнээс ч илүү зүйл гэж бий... Нөхөр нь эхнэрээ сүнслэг авралыг олоход туслах нь түүний амьдралынх нь гол зорилго байх ёстой. Тэрээр энэ бүхнийг зориулахдаа эхнэрийнхээ сүнсний төлөө л зөвхөн үйлдэж байж ч магадгүй юм... Мөн тэрбээр үлгэр дуурайл үзүүлэх ёстой; хэрэв эхнэрт нь зөвлөгөө хэрэгтэй бол түүнд зөвлөгөө өгөх; энэ нь аврагдах боломжийг эхнэртээ хялбар байлгахын төлөө юм. Хэрэв нөхөрт нь Аврагчийн Сүнс болон өөрийгөө үгүйсгэх зориулалт байгаа бол гэр бүлийнхээ авралын төлөө ямар ч золиосыг төлөхөд бэлэн байдаг.¹⁶

Болзоот залуу сүйт бүсгүйгээ Христ өөрийн чуулганыг цэвэрлэсэн шиг цэвэр ариун байлгахыг эрмэлзэх ёстой (Ефес 5:26-27).

1 Петр 3:7-д нөхөр нь эхнэрээ ойлгож амьдрах ёстой гэж хэлсэн нь эхнэрээ ойлгохын тулд чадах бүхнээ хийх ёстой гэсэн утгатай юм. Тэрээр эхнэрийнхээ хэрэгцээг ойлгохын тулд түүний тухай мэдэх ёстой. Энэ эшлэлд эмэгтэй хүнийг "хэврэгхэн сав" гэж нэрлэсэн байдаг. Эхнэрт нөхрийнх нь анхаарал халамж хэрэгтэй. Нөхөр нь эхнэрээ зөвхөн бие махбодын хор хөнөөлөөс хамгаалах төдийгүй санаа зовнил, сэтгэл санааны дарамтаас хамгаалах ёстой.

Нөхөр эхнэрийнхээ сайн сайхны төлөө шаардлагатай бүхий л зүйлээр хангах ёстой: итгэмжит байдал, болзолгүй хайр, ойлголцол, залбирал, зөвлөгөө, заах, эелдэг байдал зэрэг юм.

Нөхөр нь эхнэрээ ингэж хайрлах үед тэрээр эргүүлээд аз жаргалаар шагнагдах болно. Паул "Эхнэрээ хайрлагч нь өөрийгөө хайрладаг" (Ефес 5:28) гэж хэлсэн. Эхнэрээ ийнхүү өөрийгөө золиослон хайрладаг нөхрүүд Эзэнээр илүү ихээр шагнагдах бөгөөд хүндэтгэл, хайр, итгэмжит байдлыг эхнэрээсээ авдаг.

► Нөхөр нь эхнэртээ сүнслэг дэмжлэг өгөхдөө ямар тодорхой зүйлсийг хийх ёстой вэ?

Эдгээр эшлэл дэх тушаалууд хэрхэн өгөгдсөнийг санах нь чухал. Нөхөр нь эхнэрээ эрх мэдлээрээ албадан харилцах тухай энд хэлээгүй. Эхнэр нь нөхөртөө дуулгавартай байх тухай хэлсэн боловч нөхөр нь эхнэрээ дуулгавартай байлгах тухай хэлээгүй. Эхнэрээ хайрлаж, түүнийг асран халамжлахын тулд шаардлагатай бол өөрийгөө золиослох тухай нөхөрт сануулж хэлсэн. Үүний нэгэн адил эхнэр нь нөхрөөсөө халамж шаардах тухай яриагүй; харин эхнэрийг эр нөхрөө хүндэтгэ хэмээн хэлжээ.

¹⁶ Albert Barnes, *Barnes' Notes on the Whole Bible*. (Ефес 5:25-ын тэмдэглэлд). 2023 оны 7 сарын 31-нд <https://studylight.org/commentaries/eng/bnb/ephesians-5.html> вебсайтад хандсан.

Нөхрийн зорилго бол эрх мэдлээ хадгалах тухай биш, эхнэртээ хайр халамж үзүүлэх явдал юм. Эхнэрийн зорилго бол өөрийгөө халамжлахыг шаардах биш, харин нөхрөө хүндэтгэх явдал юм.

Элч Петр хэлэхдээ нөхөр нь эхнэрээ зохих ёсоор халамжлахгүй бол түүний залбиралд саад тотгор учирна гэж анхааруулдаг. Паул, Петр нарын үгнээс харвал эхнэрээ зохих ёсоор халамжлахгүй байгаа нөхөр Бурханыг ч зохих ёсоор хайрлахгүй байна гэжээ. Нөхрөө үл хүндэтгэж буй эмэгтэй ч Бурханыг зохих ёсоор хүндэтгэхгүй байгаа хэрэг. **Гэрлэлт дэх бидний зан байдал Бурхантай харилцах харилцаанд маань нөлөөлдөг.**

Гэрлэлтийн хувиршгүй чанар

Бурхан гэрлэлтийг байнгын, хувиршгүй байхаар бүтээсэн. Гэрлэсэн хосууд амьд байх хугацаандаа хоёр биедээ үнэнч байна гэж амладаг.

Гэрлэлтийн талаар фарисайчуудтай ярилцсан Есүсийн үгсийг Библид тэмдэглэсэн байдаг.

► Нэг суралцагч Матай 19:3-8 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан гэрлэлтийг хувиршгүй байхаар бүтээсэн хэмээн Есүс хэлсэн. Тэрээр салалтыг Бурханыг дагадаггүй хүмүүст зориулагдсан гэжээ.

Бурхан гэрлэлтийг байнгын, хувиршгүй байхаар бүтээсэн олон шалтгаан бий бөгөөд заримыг нь бид өмнөх хэсэгт ярилцсан. Гэрлэлт байнгын, хувиршгүй байх ёстой өөр нэг шалтгаан бол хүүхдүүдийн төлөө юм. Гэрлэлтийн төлөөх Бурханы зарчмуудыг дагаснаар хүүхдээ өсгөх хамгийн сайхан орчныг бүрдүүлж буй хэрэг юм. Эцэг эхчүүд гэрлэлт, гэр бүлдээ Бурханы зарчмуудыг дагаснаар бурханлаг хүүхдүүдийг өсгөж чадна (Малахи 2:15).

Бурхан хүний амьдралыг хүүхдүүд нь насанд хүртлээ хэдэн жил хамт амьдрах шаардлагатайгаар бүтээсэн. Энэ хугацаанд хүүхдүүд нь хамгаалалт, хангамж, сурах үйл явцын хувьд эцэг эхээсээ хамааралтай байдаг. Хүүхэд бол нэг, хоёр жилийн дотор насанд хүрдэг амьтны үр төлөөс ялгаатай. Хүмүүс төлөвшсөн зан чанартай болох хүртлээ тодорхой цаг хугацаа шаардагддаг. Бурхан гэр бүлийг хүүхэд өсгөх газар байхаар бүтээсэн. Нийгэмд тулгарч буй олон асуудал нь үнэнч гэр бүл дутагдсанаас үүдэлтэй.

Гэрлэлт нь хосууд бүхий л амьдралаа бие биедээ зориулах амлалт өгөхийг шаарддаг. Ахуй соёл бүрд гэрлэлтийг маш чухал зориулалт гэдгийг илтгэх өөрийн гэсэн ёслолууд байдаг. Эдгээр ёслол нь хосуудыг олон нийтийн өмнө насан туршийн зориулалт гаргалаа гэдгийг харуулах арга юм.

Ихэнх засгийн газар гэрлэлтийн бүртгэл хөтөлдөг. Гэрлэлтийн тухай хуулиуд эд хөрөнгийн өмчлөл, хүүхдийн асрамж, өв залгамжлалд нөлөөлдөг.

Гэрлэх ёслолд ашигладаг тангаргын жишээг энд оруулав:

Би таныг өөрийн хууль ёсны [нөхөр/эхнэр] болгон авч, өнөөдрөөс эхлэн сайн үед ч, муу үед ч, баян үед ч, ядуу үед ч, өвчтэй үедээ ч, эрүүл үедээ ч хайрлан энхрийлж, үхэл биднийг салгах хүртэл Бурханы ариун ёс журмын дагуу танд өөрийгөө зориулахаа амлаж байна.

Романтик мэдрэмж тасралтгүй үргэлжлэх боломжгүй. Гэрлэлт нь байнга өөрчлөгдөж байдаг хувийн мэдрэмжид тулгуурлаж болохгүй. Хуримын тангараг гэдэг нь амьд байх хугацаандаа эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь ямар ч нөхцөлгүйгээр нэг нэгэндээ үнэнч байхаа амлаж байгаа утга санааг илэрхийлдэг.

Гэрлэлтийн хувиршгүй чанарын улмаас Христэд итгэгч хүмүүс харилцааны асуудлаас болж гэрлэлтээ цуцлуулж болохгүй. "Би чамтай гэрлээгүй байсан бол" эсвэл "Магадгүй бид салах ёстой байсан байх" гэж хэзээ ч хэлэх ёсгүй. Заримдаа ингэж хэлэх нь гэрлэлтдээ анхаарч байгаа мэт дүр үзүүлж буй нэг төрлийн заль юм. Хүмүүс иймэрхүү хатуу үг хэлэхдээ нөгөө хүнээ илүү их хичээх байх гэж боддог ч энэ нь бараг л боломжгүй байдаг. Харин ч үүнийг сонссон нөгөө тал "За, чи хүсвэл бид салж болно" гэж хэлэн өөрийгөө хамгаалдаг. Ингэснээр хосууд өөрсдийн хүслээр гэрлэлтээ цуцлахад бэлэн байгаагаа илэрхийлсэн болохоор тэдний цаашдын харилцаа улам дорддог.

► Гэрлэлт яагаад зөвхөн хайраа илчилсэн үгсээр биш, харин тангараг өргөснөөр эхэлдэг вэ?

► Ашиг тусыг нь харснаас биш, үүрэг амлалтаа ухамсарлаагүй гэрлэлтийн талаар ямар нэг зүйлийг хуваалцах хүн байна уу?

Гэрлэлт нь христитгэлийн хамтрагч болох нь

► Нэг суралцагч 2 Коринт 6:14-18 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэл нь итгэгч биш хүмүүстэй хэтэрхий ойр дотно байвал итгэгч хүмүүсийн зориулалтад саад учирна гэдгийг бидэнд хэлдэг. Сатанд мөргөдөг хүнтэй итгэгч нар хамт мөргөл хүндэтгэл хийж чадахгүйтэй адил тэдний амьдралын хэв маягийг даган дуурайх боломжгүй. Энэ анхааруулга нь бизнесийн болон бусад олон төрлийн харилцаанд сэрэмжлүүлэг болдог.

Гэрлэлт бол хүмүүсийн хоорондын хамгийн ойр түншлэл юм. Итгэгч хүн итгэгч биш хүнтэй гэрлэх талаар бодох ч ёсгүй (1 Коринт 7:39). Итгэгч биш хүнтэй гэрлэсэн итгэгч нь хүүхэд өсгөх, амьдралын олон шийдвэрүүдэд ихээхэн гуниг, олон саад бэрхшээлтэй тулгарах болно.

Хэрэв эхнэр нөхөр хоёулаа итгэгч боловч өөр өөр чуулганд харьяалагддаг бол чухал сүнслэг асуудлуудын талаар санал нэг байгаа эсэхээ шалгах ёстой. Тэд гэрлэснийхээ дараа нэг чуулганд хамрагдахаар төлөвлөх хэрэгтэй юм.

Хосууд гэрлэлтээ бэхжүүлэх арга замууд

(1) Тэд Бурханы анхны төлөвлөгөөнд талархаж, гэрлэлт доторх өөрсдийн өвөрмөц үүргийг үнэлэх ёстой.

Нөхөр нь эхнэрээ Бурханы өгсөн бэлэг бөгөөд түүний дутууг гүйцээх туслагч гэдгийг санах ёстой. Тэрээр эхнэрийнхээ аюулгүй байдал буюу сэтгэл санаа, сүнслэг байдал болон бие махбодын сайн сайхны төлөө амьдралаа зориулах ёстой. Тэрбээр эхнэрээ бага хэмжээний хайр халамж үзүүлж байсан ч талархаж, хайрлахыг сонгох ёстой бөгөөд түүнийг зөвхөн Бурхан л өөрчилж чадна гэдгийг ухамсарлах ёстой. Бурхан нөхрийн дуулгавартай байдал, итгэлийг шагнах болно.

Эхнэр нь нөхрөө өөрийн тэргүүнээр сонгосон Бурханы сонголтыг хүндэтгэж, чадах бүхий л аргаар түүнд хүндэтгэл үзүүлж, түүний удирдлагыг бүх талаар дагаж байгаагаа харуулах ёстой. Тэрбээр нөхрөө алдаа гаргаж, хамгийн бага хайр халамж үзүүлж байсан ч хүндэтгэхийг сонгож, түүнийг зөвхөн Бурхан өөрчлөх болно хэмээн хэрэгцээнийх нь төлөө залбирах ёстой. Бурхан эхнэрийн дуулгавартай байдал, итгэлийг шагнах болно.

(2) Гэрлэсэн хосууд жинхэнэ сүнслэг болон бие махбодын дотно байдлыг хөгжүүлэх ёстой.

Хосууд нь айдасгүйгээр, шүүмжлэлгүйгээр, бусадтай харьцуулахгүйгээр, хүчирхийлэлгүйгээр, хувиа хичээлгүйгээр, доромжлолгүйгээр бие биенээ таньж мэдэхийг эрмэлзэх ёстой. Тэд Бурханы өмнө болон бие биенийхээ өмнө ил тод, үнэнчээр амьдрах ёстой.

(3) Гэрлэсэн хосууд үүргээ биелүүлж чадахгүй үедээ Бурханы нигүүлслийн жишээг дагах ёстой.

Адам, Ева хоёр нүгэл үйлдэн, ичиж харамсах үед Бурхан тэднийг уналтаас золин аврах өөрийн хүч чадлыг илчилсэн юм. Бурхан Адам, Ева хоёрын нүцгэн биеийг халхлах дээл хийхийн тулд амьтны амийг золиосолсон (Эхлэл 3:21). Бурханы хайрыг харуулсан энэ үйлдэл нь Христээр дамжуулан золин аврах Бурханы амлалт болон нигүүлслийн дүр зураг байсан юм. Христ биднийг уучлагдаж, сэргээгдэхэд тусалдаг. Гэрлэсэн хосууд нь дотно харилцаандаа бүтэлгүйтсэн ч, Христээр дамжуулан ичих зүйлгүйгээр эргэн нийлж чадна.

Дүгнэлт

Гэрлэлт бол хүний бус, Бурханы бүтээл юм. Тиймээс бид зааварчилгаа авахын тулд дэлхийн соёл руу биш, Бурхан руу очих ёстой. Тэр л зөвхөн бидний гэрлэлтийг хэрхэн хүчтэй, бат бэх, үр шимтэй болгохыг мэддэг. Гэхдээ Ариун Сүнсний тусламжгүйгээр бид хэзээ ч зүй ёсны хань ижил байж чадахгүй!

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Олон хүмүүсийн хувьд мартсан мэт санагддаг гэрлэлтийн тухай үнэн юу вэ?
- ▶ Гэрлэлтийг бэхжүүлэхийн тулд чуулган ямар зарчмуудыг заах ёстойг тайлбарла. Та нарын эргэн тойронд ямар ойлголт дутагдалтай байна вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Гэрлэлтийн гайхалтай бэлгийг бидэнд өгсөн таньд баярлалаа. Гэрлэлтийг ямар үзэсгэлэнтэйгээр бүтээсний тань төлөө талархаж байна. Таны төлөвлөсөн гэрлэлтийг бид амсаж мэдрэхийн тулд шаардлагатай зориулалт гаргахад бидэнд туслаач.

Христ чуулганаа хайрладаг шиг хайрыг харуулахад бидэнд туслаач.

Бие биенээ хүндэтгэхдээ өөрсдийн ахуй соёлын нөлөөнөөс ч илүү хандахад бидэнд туслаач.

Баяр хөөртэй, бат бэх харилцааг боломжтой болгодог Ариун Сүнсний ажилд талархаж байна. Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Танд энэ хичээлээс шинэлэг санагдсан хоёр зарчмыг сонгоорой. Эдгээрийг нэг догол мөрөнд өөрийн үгээр тайлбарлан бичнэ үү.

(2) Доорх сэдвүүдийн аль нэгээр товч танилцуулга бэлдээрэй (Ангийн удирдагч суралцагч бүрд сэдвийг хуваарилна). Дараагийн хичээлийн эхэнд танилцуулгаа хийнэ.

- Гэрлэлт дэх нэгдмэл байдлын талаарх Бурханы төлөвлөгөө
- Гэрлэлтийн төлөөх Библийн зорилго
- Гэрлэлт дэх Бурханы өгсөн үүрэг болон эдгээр үүргийг биелүүлэхийн тулд Ариун Сүнсээр дүүрэн байхын ач холбогдол
- Гэрлэлтийн хувиршгүй чанар

(3) Хэрэв та гэрлээгүй, ирээдүйд гэрлэхээр төлөвлөж байгаа бол ирээдүйн гэрлэлтдээ Бурханы зарчмуудыг дагахаа амлаж, хоёр догол мөрөнд багтаан бичнэ үү. Хэрэв та гэрлэсэн бол гэрлэлтдээ Бурханы зарчмуудыг дагахаа амлаж, хоёр догол мөрөнд багтаан бичээрэй.

Эмэгтэйчүүдийг хүндэтгэх нь

4-р хичээлийг үргэлжлүүлэхээс өмнө анги **Хавсралт А-г судалж, хэлэлцэх** ёстой. Энэ нь гэрлэлт, гэр бүлтэй холбоотой чухал сэдэв болох эмэгтэйчүүдийг хүндэтгэх тухай товч хэлэлцүүлэг юм.

4-р хичээл

Бэлгийн харилцааны асуудлууд

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Уналт нь хүний мөн чанар болон бэлгийн дур хүсэлд хэрхэн нөлөөлснийг тайлбарлах.
- (2) Хувь хүн өөрийгөө тодорхойлох байдал болон энэ нь тухайн хүний ёс зүйтэй хэрхэн холбогддог талаар тайлбарлах.
- (3) Бэлгийн харилцаа болон бэлгийн ёс бус байдлын талаарх Библийн үзэл баримтлалыг ойлгох.
- (4) Бэлгийн ёс бус байдлын уруу таталтыг ялан дийлж, нүглээс салж, эрх чөлөөг олох.
- (5) Тусламж, ялалт хэрэгтэй хүмүүст үйлчлэхэд бэлтгэгдсэн байх.

Кристофер Юан

Кристофер нь АНУ-д Ази-Америк гаралтай гэр бүлд төрж өсчээ. Өсвөр наснаасаа эхлэн тэр эмэгтэйчүүдээс илүү эр хүнд татагддаг байв. Түүний эцэг эх хүүгийнхээ сонирхлыг мэдэж ичиж, цочирдов. Тэрээр өсвөр насандаа хэд хэдэн удаа эрэгтэйчүүдтэй гүнзгий харилцаанд орж үзсэн байв. Жинхэнэ хайр, үнэнч байдлыг эрэлхийлж байсан боловч бүх харилцаа нь эцэстээ бүтэлгүйтсэн. Тиймээс ч олон эрэгтэйтэй болгоомжгүй, зүй бус харилцаанд ордог байв. Кристоферийн ээж Христэд итгэгч болсноор тэрээр өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй хайрыг амсаж, хүлээн зөвшөөрөгдөж, бүх зүйл нь өөрчлөгдөж эхэлсэн. Тэрбээр өөрийнх нь анхдагч мөн чанар нь Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүн гэдгээ ухаарч эхэлсэн. Тэр гэмшиж, амьдралынхаа бүхий л талбарыг Бурханд даатгасан. Тэр Бурхантай харилцах харилцаагаар дамжуулан бүрэн сэтгэл ханамж, зорилгоо олсон юм.

Хүний унасан мөн чанар ба нүгэлт хүслүүд

Бурхан Адам, Ева хоёрыг бүтээхдээ тэднийг бүх талаараа төгс, ямар ч өө сэв, дутах зүйлгүй бүтээсэн (Эхлэл 1:31). Тэдний мөн чанар нь зөвхөн зөв, сайн зүйлийг хүсдэг байв. Тэдний оюун ухаан, бие махбод төгс ажиллаж байв. Гэтэл Адам Бурханы тушаалыг зөрчих сонголт гаргасан. Ийнхүү үйлдсэний дараа хүний мөн чанар гажуудсан (Ром 8:20-23). Хүний бие, оюун ухаан нүгэлд өртсөн. Хамгийн эрүүл, хамгийн ухаантай хүн ч нүглийн үр дагаврыг амсах болсон. Нүгэл нь анхны төгс бүтээлийг үүрд мөнхөд гэмтээсэн. Христ эргэж ирэх хүртэл Бүтээл бүрэн эдгэрэхгүй (1 Коринт 15).

Хүний мөн чанар, бие махбодод учирсан энэхүү хохирлоос үүдэж, бидний махбодын төрөлх хүсэл үргэлж зөв, тэнцвэртэй байх боломжгүй болсон. Үнэндээ бидний хүслийн олонх нь тэнцвэрээ алдсан байдаг. Хүмүүс төрөлхийн буруу зүйлийг хүсдэг. Есүс хүний зүрх сэтгэлээс гардаг олон төрлийн нүглүүдийг тоочихдоо хүмүүний төрөлхийн нүгэлт байдлыг ажиглажээ (Марк 7:21-22).

Энэ хичээлээр бид бэлгийн харилцааны асуудлуудын талаар ярилцаж байна. Хүний бүх хүслийн дотор бэлгийн дур хүсэл хамгийн хүчтэй нь юм.

Бэлгийн буруу хүсэл нь түүнийг мэдэрч буй хүний хувьд өөрийнх нь төрөлх чанар шиг санагддаг. Энэхүү төрөлх хүслээ биелүүлснийхээ төлөө буруутгагдах ёсгүй гэж тэрээр бодож магадгүй. Гэсэн хэдий ч ямар ч хүн гаж хүслээ зөв болгохын тулд эсэргүүцэх ёстой. Хүнд худал хэлэх, хулгайлах, хүчирхийлэх, залхуурах, тэвчээргүй байх төрөлхийн мөн чанар бий. Хүмүүс өөрийнхөө төрөлх байдалдаа хариуцлага хүлээхгүй ч төрөлх хүслээ дагаж нүгэл үйлдвэл гэм буруутай болдог.

Заримдаа хүүхэд насандаа амссан хүчирхийлэл эсвэл бусад нөхцлөөс шалтгаалан ижил хүйстэнээ сонирхох эсвэл бусад бэлгийн буруу хүсэлд уруу татагддаг. Гэсэн хэдий ч бэлгийн буруу хүсэл нь бусад нүглээс ялгаатай гэж хандах нь буруу юм. Ямар ч шалтгаантай байсан хүнд Бурханы аврал, ариусгал хэрэгтэй.

Буруу хүсэл зарим хүмүүсийн хувьд хэвийн мэт санагддаг гайхах зүйлгүй юм. Нүгэл нь нүгэлт хүслийг мэдэрч буй хүнд хэвийн, төрөлхийн зүйл мэт санагддаг.

Бид төрөлхийн уур хилэнгийн хүүхдүүд юм (Ефес 2:3). Бид төрөлхийн нүгэл үйлдэхээр гажуудсан бөгөөд төрөлх мэт санагддаг нүгэл үйлдсэнээрээ өөрсдийгөө шийтгэлд авчирдаг. Хүн тодорхой нүгэлт хүсэлтэй төрдөг ч гэсэн энэ нь нүгэл үйлдэх ёстой гэсэн үг биш юм.

► Яагаад бид бүх төрөлх хүслээ дагах ёсгүй вэ?

Библид биднийг Христтэй адилхан болох ёстой гэж хэлдэг (Ром 8:29). Бид Эзэн Есүс Христийг өмсөх ёстой. Бидний махан биеийн хүсэл амьдралын үндэс болох ёсгүй. Харин бид буруу өдөөгч хүслээ Бурханы эрх мэдэлд захируулах ёстой (Ром 13:14).

► Буруу өдөөгч хүслээ Бурханы эрх мэдэлд захируулах гэдэг нь юу гэсэн үг вэ?

Та бэлгийн дур хүслээ таны туйлын зорилгод (Бурханы дүр төрхийг харуулж Бурханыг алдаршуулах) захируулах ёстой. Христийг дагах амьдрал бол танд байгаа Бурханы дүр төрхтэй нийцэх амьдрал юм.

Хүн өөрийгөө тодорхойлох нь

Хүн өөрийнхөө талаар зөв ойлголттой байх нь

Олон хүн хүний төрөлх чанар нь тэднийг зөв замд хөтөлнө гэж буруугаар итгэдэг. Өөрийнх нь төрөлх чанараас гарч буй хүсэл нь тэднийг сэтгэл хангалуун байдал руу хөтөлнө гэж үзэх нь боломжтой мэт. Тэд хүний мөн чанар нь нүглийн улмаас гэмтсэн

тул бүрэн найдах боломжгүй гэдгийг ухаардаггүй. Хүний төрөлх хүсэл гажсан байдаг тул сэтгэл хангалуун байдалд хүргэхгүй. Бурхангүйгээр хүний төрөлхийн хүсэл түүнийг ёс суртахууны хувьд зөв зүйл рүү ч хөтлөх боломжгүй.

Хүмүүс амьдралынхаа зорилгыг өөрсдөө бий болгодог учраас өөрийн хүсэл, мэдрэмжийг дагах ёстой гэж үздэг. Тэд ямар нэгэн эрх мэдэл эсвэл ёс суртахууны шаардлагад хязгаарлагдахгүйгээр өөрийгөө тодорхойлсон байх нь чухал хэмээн итгэдэг. Юу зөв, үнэ цэнтэй болохыг хувь хүн өөрөө шийдэх ёстой гэж боддог. Тэд өөрсдийн мөн чанарыг зөв зам руу хөтөлнө хэмээн итгэдэг. Тэдний үйлдлийг нь хязгаарладаг байгууллага, дүрэм журамд тэд таагүй ханддаг. Хүний гажуудсан мөн чанар нь Бурханы Үгийн оронд ёс зүйн хэм хэмжээ болдог.

Бэлгийн харилцаа нь хүний төрөлх чанарын хүчирхэг хэсэг учраас олон хүмүүс бэлгийн хүсэл нь өөрсдийг нь хэн болохыг тодорхойлдог гэж үздэг. Өөрсдийгөө хэн гэдгээ танин мэдэхийн тулд бэлгийн хүслээ дагах ёстой гэж боддог. Хүмүүс бэлгийн харилцааг зөвхөн **хүсдэг** эсвэл **хийдэг** зүйл биш, харин тэд хэн **байгааг** тодорхойлох зүйл гэж үздэг. Тэд үүгээр өөрийгөө тодорхойлдог.

Дэлхийн үзэл бодлоос ялгаатай нь **Библи биднийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, Бурхантай харилцах зорилготойгоор бүтээгдсэн гэж хэлдэг. Энэ бол хүн болохын хувьд бид хэн бэ гэдгийн жинхэнэ тодорхойлолт юм.**

Дэлхий дээрх ямар ч зүйл бидний жинхэнэ хэн болохыг тодорхойлж чадахгүй. Дэлхий дээрх бидний шинж чанарууд бол одоо байгаа нөхцөл байдал маань л юм. Эдгээр нь бидний хэн болохыг тодорхойлдоггүй. Бидний угсаа гарвал, нийгмийн байр суурь, эдийн засгийн байдлын аль нь ч бидний хэн болохыг **тодорхойлдоггүй**, энэ бол зөвхөн бидний **нөхцөл байдал** юм. Эмч, шоу бизнесийн од эсвэл үндэсний хэмжээний удирдагч хэн ч байсан тэр хүн бол Бурханы өмнө Түүний дүр төрхөөр бүтээгдсэн бүтээл бөгөөд энэ тодорхойлолт л хамгийн чухал нь юм.

Бэлгийн харилцаа бол бидний нөхцөл байдлын хүчирхэг тал юм. Бидэнд бэлгийн гажуудал, дур хүсэл, сэтгэл дундуур байдал бий. Гэхдээ эдгээр нь бидний хэн болохыг тодорхойлдоггүй; харин нөхцөл байдлын нэг тал юм.

Адамын нүгэл хүн төрөлхтнийг Бурханаас салгасан учраас бид нүгэлт мөн чанартай төрдөг (Ром 5:18). Гэвч бидний нүгэлт байдал ч бидний хэн болохыг тодорхойлдоггүй; энэ нь бидний нөхцөл байдал бөгөөд Бурханы нигүүлсэл ба хүчээр өөрчлөгдөх боломжтой юм (Ром 5:19).

► Хүний өөрийн *тодорхойлолт* болон *нөхцөл байдлын* ялгаа юу вэ?

Хүний өөрийн тодорхойлолт ба хувийн ёс зүй

Ёс зүй нь үүн дээр суурилдаг учраас хүний өөрийн тодорхойлолт, тухайн хүн өөрийгөө хэн гэж тодорхойлох нь чухал юм. Ёс зүй гэдэг нь зөв эсвэл буруу зан байдлыг

тодорхойлдог зарчмууд юм. Хэрэв хүн бэлгийн харилцаа нь түүний хэн болохыг тодорхойлдог гэж итгэвэл бэлгийн чиг хандлагаа дагах нь зөв гэж үзэх болно.

Заримдаа хүн "Би ингэж төрсөн; ийм зүйл хийх нь миний хувьд төрөлхийн; тиймээс миний буруу биш" гэж хэлдэг. Гэвч биднийг нүгэлт мөн чанартай төрсөн гэж Библи заадаг (Ром 5:12, Ефес 2:3). Бид төрөлхийн ингэж төрсөн хэмээн нүгэлт чанараа дагах нь зөв биш юм.

Бидний нүгэлт байдал нь бидний өөрийн тодорхойлолт биш юм. Бидний нүгэлт чанар бол нөхцөл байдал. Бид бэлгийн харилцаагаар тодорхойлогдохгүй. Харин Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн нь бидний хэн болохыг тодорхойлдог. Хэрэв бид энэхүү бодит байдлыг ойлгож чадвал, юу нь зөв ба буруу болохыг Бурхан шийддэг гэдгийг бид ухаарна. Бидний өөрийн тодорхойлолт нь ариун зан байдлын зөв хэм хэмжээг ойлгоход тусалдаг.

► Хүн хэн болохоо ойлгож мэдэх нь түүний ёс зүйд хэрхэн нөлөөлдөг вэ?

Хүйсийн талаарх зөв ойлголт

Хүн болон олон амьтад эрэгтэй, эмэгтэй хүйсээр ялгаатай болохыг бид мэднэ. Бид Бурханыг эрэгтэй эсвэл эмэгтэй байх боломжтой гэж хэлж болох ч энэ нь буруу юм. Бурхан бол хүйс бий болохоос өмнө оршиж байсан, агуу мөн чанартай оршихуй юм. Хүн хоёр хүйстэйгээр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн (Эхлэл 1:27). Эр, эм хүйсийн аль аль нь Бурханы дүр төрхийг илэрхийлдэг.

Бурханы дүр төрх бол зөвхөн хүний мөн чанарын нэг хэсэг биш юм. Бурханы дүр төрх бол бидэнд өгөгдсөн хайрлах чадвар, гоо үзэсгэлэнг үнэлэх чадвар, зөв бурууг ойлгох чадвар зэрэг тодорхой шинж чанарууд төдий зүйл биш юм. Хүний бүхий л мөн чанар Бурханы дүр төрхийг харуулдаг. Бурханы дүр төрхөөс өөр юу ч бидний оршихуйн мөн чанар биш юм. Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн анхны бүтээлүүд юм. Хүний нөхцөл байдлын ямар ч нарийн ширийн зүйлс бидний хэн болохыг тодорхойлох ёсгүй бөгөөд бидний ёс зүйн үндэс суурь байж чадахгүй.

Бурхан хүйсийг сонгосон явдал нь хүн бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдгийг харуулахын тулд юм. Зарим хүмүүс Бурханы оноосон хүйсийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэд эсрэг хүйсийн хүний амьдралаар амьдрахыг оролддог. Зарим хүмүүс мэс заслын аргаар бие махбодоо өөрчлөхийг ч хүсдэг. Хүн бие махбодоо өөрчилснөөр хүйсээ өөрчилж чадахгүй тул энэ нь Бурханы бүтээлийг эмгэнэлтэйгээр гэмтээж буй хэрэг юм. Хүн зөвхөн бие махбодоор бус, харин хүн бүр бодгаль чанараараа эрэгтэй, эмэгтэй хүн байдаг. Бурхан бидэнд оноосон хүйсээр дамжуулан Түүнийг алдаршуулж, дүр төрхийг нь тусган харуулахыг Тэр биднээс хүсдэг.

Бурханы ёс суртахууны хэм хэмжээ

► Нэг суралцагч Еврей 13:4 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэл гэрлэлтийг бид маш их хүндэтгэх ёстой гэдгийг сануулдаг. Бэлгийн нүгэл бол гэрлэлтийг үл хүндэтгэж буй хэрэг юм. Бурхан бэлгийн ёс бус байдлыг шүүх болно.

► Нэг суралцагч 1 Коринт 6:18 эшлэлийг бүлэгт уншина.

Бэлгийн нүгэлд тачаангуй хүсэл, садар самуун байдал, завхайрал, цус ойртолт, хүчиндэлт, хүүхэд хүчирхийлэх, ижил хүйстний бэлгийн харилцаа, порнографийн хэрэглээ зэрэг багтана.

- **Тачаангуй хүсэл:** Ханьтайгаа биш хэн нэгэнтэй бэлгийн харилцаанд орохыг санаатайгаар төсөөлөх.
- **Садар самуун байдал:** Гэрлээгүй хүмүүсийн хоорондох бэлгийн харилцаа.
- **Завхайрал:** Гэрлэсэн хүнтэй бэлгийн харилцаанд орох.
- **Цус ойртолт:** Ойрын төрөл, хамаатан садантайгаа бэлгийн харилцаанд орох.
- **Хүчиндэлт:** Бэлгийн хүчирхийлэл, хэн нэгнийг хүсээгүй байхад нь бэлгийн харилцаанд оруулах.
- **Хүүхэд хүчирхийлэх:** Шийдвэр гаргах чадамжгүй, бэлгийн хүслээ удирдах хэмжээнд төлөвшөөгүй хүнтэй бэлгийн харилцаанд орох.
- **Ижил хүйстний бэлгийн харилцаа:** Ижил хүйстэй хүмүүсийн хоорондох бэлгийн харилцаа.
- **Порнограф:** Бэлгийн харилцаа үүсгэх зорилготой нүцгэн эсвэл сексийн үйлдлүүд харуулсан бичвэр, зураг, видео зэрэг.

Эдгээр нь бүгд гэрлэлтийн харилцааг зөрчиж буй хэрэг юм.

Санах—махан биед биднийг уруу татаж буй хүслүүд нь Бурхантай уулзсанаар бүрэн хангагдаж болох хэрэгцээнүүд юм. Бурханлаг бэлгийн харилцаа зөвшөөрөгдөх цорын ганц нөхцөл нь гэрлэлт дэх бэлгийн харилцаа юм. Ёс бус бэлгийн харилцаа нь... түрхэн зуурын таашаал өгч болох ч бид үүнийг амсахыг улам их хүсэх бөгөөд эцэстээ бидний сүнслэг хүслийг хордуулж үгүй хийнэ. Ёс бус бэлгийн харилцаа нь бидний ариун байдал, зөв шударга байдал, Бурханы оршихуйд мэдрэг байдлыг хоослохоос өөр юу ч өгөхгүй.¹⁷

¹⁷ Gary Thomas, *Sacred Marriage* (Grand Rapids, MI: Zondervan, 2000), 210.

Сургаалт үгс номын олон эшлэлд бэлгийн ёс бус байдал нь хүний амьдралыг сүйтгэж, үхэлд хүргэдэг гэдгийг анхааруулдаг (жишээлбэл, Сургаалт үгс 2:16-19 ба Сургаалт үгс 6:24-29, 32-33).

Робертсон МакКуилкин бичихдээ,

[Бэлгийн харилцааны талаарх Бурханы зорилго] нь тухайн үйлдлээс оюун санааны хувьд ч ижил хэмжээгээр хохирдог. Бурхан зүгээр л эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээгээгүй; өөрийн мөн чанартай адил дотно, байнгын хувиршгүй гэрлэлт, нэгдмэл байдлыг тэдэнд зориулан бүтээсэн. Энэхүү тэргүүн зорилгыг биелүүлэхийн тулд дотно байдал нь маш онцгой, тууштай зориулалт эсвэл нэгдмэл байхыг шаарддаг. Оюун бодолдоо үнэнч итгэмжит байх нь хамгийн чухал юм. Онцгой дотно байдал, тууштай зориулалт, харилцан итгэлцэл нь хамгийн түрүүнд оюун бодолд зөрчигддөг.¹⁸

► Суралцагчид 1 Коринт 6:9-11, 15-20 ба Матай 5:27-30 эшлэлийг бүлэгт уншина.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох харилцааны талаар ахуй соёлын ялгаатай ойлголтууд бий. Эдгээр соёл нь Библийн ёс суртахууны хэм хэмжээнээс доогуур жишигт байдаг. Олон соёлд зөвхөн дэг журамтай нийгмийг хадгалахад зориулагдсан дүрэм бий. Тэд бэлгийн нүглээс үүдсэн муу үр дагавар эсвэл түүнтэй холбоотой дуулиан шуугианаас зайлсхийж болгоомжтой ханддаг. Библийн ёс суртахууны хэм хэмжээ нь бусдаас ялгаатай.

Харамсалтай нь зарим чуулган Библийн ёс суртахууны оронд өөрийн чуулганд тогтсон соёлыг дагадаг. Тэд нүгэл нь олны өмнө ил болсон, үүндээ хайхрамжгүй хандсан хүмүүсийг шийтгэдэг боловч, тэдэнтэй адил нүгэл үйлдсэн ч илүү болгоомжтой, нүгэл болон үүнээс үүдэн гарах үр дагаврыг нуун дарагдуулдаг хүмүүст хүлцэнгүй ханддаг.

Дээрх эшлэл нь эдгээр нүглийг үйлдэж буй хүмүүс бол итгэгч биш бөгөөд тэнгэрийн улсад очихгүй хэмээн бидэнд хэлдэг. Коринтын зарим итгэгчид эдгээр нүглийг өнгөрсөнд үйлдэж байсан боловч тэдгээрээс чөлөөлөгджээ.

Өөрийгөө итгэгч хүн гэж зарлаад эдгээр нүглүүдийг зөвтгөх ямар ч онол сургаал заасан бай тэр бол хуурамч сургаал юм. Хэрэв хүн Христийн дагалдагч гэж өөрийгөө хэлдэг хэдий ч бэлгийн нүгэл үйлддэг бол түүнийг чуулганаас зайлуулж, итгэгч гэж үзэхгүй байхыг Библи шаарддаг (1 Коринт 5:11-13).

Чуулганы удирдагчид сайн үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Чуулганы магтаалын удирдагчаа зохисгүй хувцаслахыг зөвшөөрөх эсвэл зүй бус бүжгийн хэлбэрийг зөвшөөрөх үед тэр нь ёс бус бэлгийн хүслийг хэвийн хэмээн үзэж буйг илэрхийлдэг. Тэд бэлгийн нүглийг ноцтой биш хэмээн үзэж буй хэрэг юм.

¹⁸ Robertson McQuillkin, *An Introduction to Biblical Ethics*, 2nd ed. (Wheaton, IL: Tyndale House Publishers, Inc., 1995), 216.

Нийгэм нь бэлгийн дур хүсэл өдөөхүйц задгай хувцаслаагүй нэгнийг гоё сайхан хувцасласан гэж үзэхгүй байж болно. Ялангуяа баяр наадмын зарим үйл ажиллагаанд оролцох үедээ чуулганы гишүүд энэ занганд ордог. Тэд нийгмийн чиг хандлагыг дагахгүй бол гоё хувцасласангүй гэж боддог. Чуулган үүнийг буруу гэж заах ёстой. Итгэгч хүн бусдад буруу хүсэл төрүүлэхүйц хувцас өмсөх ёсгүй. 1 Тимот 2:9-10-д хэн ч харсан итгэгч хүн болгоомжтой, цэвэр амьдралаар амьдарч, нүгэл үйлдэх эсвэл бусдыг нүгэл үйлдэхэд уруу татахыг хүсдэггүй нэгэн хэмээн мэдэгдэхээр хувцаслаж, үйлдэх ёстой гэж хэлдэг.

Порнограф

Порнограф гэдэг нь бэлгийн харилцаа үүсгэх зорилготой нүцгэн эсвэл сексийн үйлдлүүд харуулсан бичвэр, зураг, видео зэрэг юм.

Интернет нь порнографийг дэлхий нийтээр хялбархан хүртээмжтэй зүйл болгож байна. Интернет байгаагүй учраас ахмад пастор, удирдагчдын хувьд ийм уруу таталтад өртөөгүй байж магадгүй юм. Тэд залуу үеийнхэн ямар бэрхшээлтэй тулгарч байгааг бараг ойлгохгүй байж магадгүй. Гэхдээ хүмүүст чөлөөт цагаа өнгөрөөх сонголтод Библийн зарчмууд хэрхэн хэрэгждэгийг зааж сургах ёстой.

Порнограф бол буруу юм. Учир нь энэ нь хүнийг садар самуун, завхайрал, бэлгийн гаж буруу үйлдлүүдийг төсөөлөхөд хүргэх зорилгоор бүтээгдсэн юм. Энэ нь хүний нүгэлт хүслийг өдөөх зорилготой. Порнограф нь Бурханы жигшдэг ёс бус үйлдлүүдэд оролцох боломжийг хүнд олгодог. Есүс хэлэхдээ эдгээр зүйлийг төсөөлөхөөр сонгож буй нь ч нүгэл гэжээ (Матай 5:28).

Порнограф нь хүмүүс болон тэдний харилцааг үнэ цэнгүй болгодог тул буруу юм. Энэ нь бэлгийн харилцааг хувиа хичээсэн үйлдэл болгон хувиргадаг. Энэ нь хүмүүсийг эрүүл харилцаанд зориулагдан Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн үнэ цэнтэй гэж үзэхийн оронд таашаал авахын тулд ашиглах хэрэгсэл гэж хандахад хүргэдэг.

Порнограф бол донтуулагч юм. Порнограф нь ерөнхийдөө нүглээр боолчлогч (Иохан 8:24, 2 Петр 2:19). Порнограф хэрэглэдэг хүн үүнээс хүчтэй хэрэгцээг мэдэрч байдаг. Тэрээр үүнгүйгээр амьдрахыг төсөөлж ч чаддаггүй. Порнографтаас авдаг төсөөллүүдгүйгээр амьдрал нь хоосон, сонирхолгүй мэт санагддаг. Бусад бүх донтолтын нэгэн адил түүний хүсэл нь бүх зүйл болдог бөгөөд хэрэглэгч нь үүний төлөө амьдралынхаа сайн сайхан зүйлсийг золиосолж эхэлдэг.

Порнограф бол үйл явц юм. Хэрэглэгч нарт улам бүр ил тод, гаж буруу материал хэрэгтэй болдог. Тэд өмнө нь жигшиж, айж байсан зүйлсээсээ сайхан зүйлсийг мэдэрч эхэлнэ.

Порнограф бол хортой. Хэрэглэгч хэвийн харилцаанд орох чадваргүй болдог. Түүний хүсэл гаж болж хэзээ ч ханаж чадахгүй. Тэр бусдыг хүчирхийлж байгаагаа ч мэдэхээ больж, өөрийн таашаалын төлөө бусдыг зовооход бэлэн болдог.

Порнографийн зарим үр дагавар

Порнографид дүрслэгдсэн үйлдлүүдийг төсөөлөх нь үзэгчдийн оюун ухаан, биед өөрсдөө эдгээр үйлдлийг биечлэн хийж байгаа мэт нөлөөлдөг.

Сатан таны бэлгийн ханамжийг "хулгайлж, алж, устгахыг" (Иохан 10:10) хүсдэг бөгөөд порно бол түүний сонгосон зэвсэг юм. Порнограф бэлгийн ханамжийг амладаг боловч үнэн хэрэгтээ жинхэнэ зүйлийг эдлэх чадварыг маань булаадаг."
- Эрх чөлөөний тэмцэл

Порнограф нь тархинд ямар ч бэлгийн харилцаанд орохоос илүү хүчтэй таашаал өгч, бодит бус нөхцөл байдлыг мэдрүүлдэг.¹⁹ Тархи нь таашаалын энэ хэт өндөр түвшинд дасан зохицдог. Үүнээс болж тархи нь порнографийн хэмжээг байнга нэмэгдүүлэхийг шаарддаг бөгөөд таашаалын мэдрэмжээ үргэлжлүүлэхийн тулд улам бүр гаж буруу порнограф шаарддаг. Тархины химийн өөрчлөлт нь эцэстээ хүнийг бодит амьдрал дээрх бэлгийн харилцаанд орох эсвэл таашаал авах чадваргүй болгодог. Таашаалын бодис хэт ихэссэний улмаас шийдвэр гаргах чадвартай тархины хэсэг бас гэмтдэг.

Бурхан бэлгийн харилцааг хосуудын харилцааг бэхжүүлэх зорилготойгоор бүтээсэн. Бэлгийн харилцааны үед тархинд ялгардаг гормон нь хосуудыг бие биетэйгээ сэтгэл санааны хувьд холбож, харилцааг нь бэхжүүлэх үүрэгтэй. Энэ бол гэрлэлт доторх гайхалтай бэлэг юм. Гэсэн хэдий ч порнограф үзэх нь үзэгчийг порнографтайгаа сэтгэл санааны хувьд холбогдоход хүргэдэг.

Порнограф хэрэглэсний дараах гэмшил, ичгүүр нь хүмүүсийн харилцааг тусгаарлаж, эрүүлээр бусадтай харилцах чадамжгүй болгодог. Энэ нь гэрлэлт доторх итгэлцлийг бас устгадаг.

Тархинд ялгарах бодисын тэнцвэргүй байдал үүсгэдэг учраас порнограф хэрэглэх нь сэтгэл гутралд оруулж болно.

Порнографид дүрслэгдсэн дүр зураг заримдаа бодит амьдрал дахь бэлгийн харилцаанд хүчирхийлэл, зүй бус үйлдэл хийхэд хүргэдэг.

Пасторууд, эцэг эхчүүд залуу үеийнхэнд порнографийн аюулыг анхааруулах ёстой. Эцэг, эхчүүд уруу таталтыг эсэргүүцэх хангалттай төлөвшөөгүй хүүхдүүддээ интернетийг хязгааргүй ашиглах эрх өгөх ёсгүй. Порнографийн уруу таталттай тэмцэж буй хүн ялалт, бүтэлгүйтлээ итгэж болох, бурханлаг нэгэнд тогтмол мэдээлэх ёстой.

¹⁹ Энэ догол мөр болон дараах дөрвөн догол мөрөнд байгаа мэдээллийг <https://thefreedomfight.org> вебсайтаас авсан бөгөөд энэ нь порнографийн донтолоос чөлөөлөгдөхийг хүсэж буй нэгэнд зориулагдсан Библи суурьтай эх сурвалж юм.

Төлөвшсөн итгэгчтэй тогтмол уулзах нь ариун байдалд үнэнч байж, тогтмол ялалт байгуулахад нь донтолттой тэмцэж буй нэгэнд тусална.

► Порнографийн донтолтоос хамгаалахын тулд хүмүүст ямар дадлуудыг зөвлөх вэ? Чуулган хэрхэн тусалж чадах вэ?

Хүүхэд хүчирхийлэх / Хүчиндэх

Хүүхэд хүчирхийлэх гэдэг нь хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох явдал юм. Үүнийг бэлгийн харилцааны гаж хэлбэр гэж үзнэ. Энэхүү үйлдэл бузар зүйл бөгөөд олон шалтгаантай. Үүнд:

- Гэрлэлтийн гэрээн дэх бэлгийн харилцааны талаарх Бурханы сайн сайхан төлөвлөгөөг үгүйсгэдэг (Еврей 13:4).
- Хүүхдийн цэвэр ариун байдлыг хулгайлдаг – ингэснээр хүүхэд мэдэж болохгүй зүйлсийн талаар ойлголттой болдог.
- Хүүхдийг онгон байдлаас нь салгадаг (1 Тесалоник 4:3-7).
- Хүүхдэд гэм буруугийн мэдрэмж төрүүлдэг; хүүхэд буруу үйл ажиллагаанд оролцож байгаа боловч жинхэнэ сонголт хийх чадваргүй эсвэл зөвшөөрөгдөөгүй байдаг.
- Хүүхдийг төлөвшөөгүй бэлгийн харицааны талаар буруу цагт нь шийдвэр гаргахад хүргэдэг.
- Хүүхдийг ирээдүйд ёс зүйгүй үйлдэл хийх магадлалыг нэмэгдүүлдэг, учир нь тэд өөрсдийгөө буруутай эсвэл үнэ цэнгүй гэж мэдэрдэг (Матай 18:6).
- Хүүхдийг ирээдүйд гаж буруу эсвэл хүчирхийллийн үйл ажиллагаанд оролцох уруу таталт болдог.
- Өөрийгөө хамгаалж чадахгүй, сул дорой хүмүүсийг хүчирхийлдэг.
- Хязгааргүй үнэ цэнтэй Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн нэгнийг гэмтээдэг (Эхлэл 1:27).

Хүүхэд хүчирхийлэх явдал гэр бүл болон найз нөхдийн дунд тохиолддог. Гэр бүлийн гишүүд болон найз нөхөд нь итгэж болох хүмүүс гэж үзэгддэг учраас хүүхэд болсон явдлын талаар хүнд хэлэхээс айдаг тул тэднийг сэжиглэдэггүй.

Хүчиндэх гэдэг нь хүнийг (хүүхэд эсвэл насанд хүрсэн хүн) өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр бэлгийн харилцаанд албадан оруулах явдал юм. Хүүхэд хүчирхийлэхтэй ижил олон шалтгааны улмаас үүсдэг бузар үйл бол хүчиндэх юм (Дэд хууль 22:25-27).

Бэлгийн хүчирхийллийн өөр нэг хэлбэр бол бэлгийн мөлжлөг/хүн худалдаалах юм. Дэлхий даяар хүүхэд, залуучуудыг танихгүй хүмүүс хулгайлж, эсвэл гэр бүлийн гишүүд

нь худалдаж, садар самуун порнографид ашигладаг. Ядуу амьдралтай гэр бүлүүд мөнгөний шалтгаанаар хүүхдүүдээ энэ бузар бизнесд татан оролцуулдаг. Үүнээс хэн нэгэн ашиг олдог боловч хүүхдүүд зөвхөн бие махбодын хувьд хохироод зогсохгүй сэтгэцийн болон сэтгэл санааны хувьд аймшигтайгаар гэмтдэг. Энэ бол ядуу, сул дорой хүмүүсийг гэм нүглээр дарлаж буй хэрэг бөгөөд Бурхан үүнийг шүүх болно (Сургаалт үгс 14:31).

Хүүхдийн эсрэг эдгээр нүгэл Бурханы зүрхийг шархлуулдаг (Матай 18:10-14, Дуулал 146:7-9). Эдгээр нүглийг үйлдсэн хүмүүс шийтгэлгүй өнгөрөхгүй (1 Тесалоник 4:6, Езекиел 7:8-9). Итгэгчид Бурханы зүрхнээс гарах хайр, энэрэлийг хуваалцаж, боолчлогдсон хүмүүсийг хамгаалах, аврах, эдгээхийн төлөө ажиллах ёстой (Сургаалт үгс 24:11-12, Иов 29:12-16, Дуулал 72:12-14).

Гар хангалга

Гар хангалга гэдэг нь бэлгийн таашаал авах эсвэл бэлгийн дур хүслээ тайлахын тулд өөрийн бэлэг эрхтнээ өдөөх үйлдэл юм.

Библид гар хангалгыг ёс бус гэж тодорхойлсон зүйл байхгүй. Гэсэн хэдий ч гар хангалга нь тачаангуй бодол, порнографийн хэрэглээ, садар самуун нүгэл рүү уруу татах боломжтой (Матай 5:27-28, Матай 15:19-20).

Гар хангалга нь хүнийг донтуулдаг бөгөөд үүнийг хийх нь ухаалаг хэрэг биш. Та үүнийг хийх тусам улам их хүсдэг.

Хүчээр гар хангалга хийж буй нь заримдаа тухайн хүнд сэтгэл санаа, харилцааны асуудал, эсвэл өнгөрсөнд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийлэл зэрэг гүн гүнзгий асуудал байсныг илтгэдэг.

► Суралцагчид 1 Коринт 6:12-13, 18-20 ба 1 Тесалоник 4:1-8 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан эхнэр, нөхөр хоёрыг сэтгэл санаа, сүнслэг байдалд нэгдмэл байлгахын тулд гэрлэлт доторх бие махбодын нэгдлийг бүтээсэн (1 Коринт 6:16-20, Малахи 2:15).

Олон хүмүүс... гэрлэх хүртлээ ганц бие байхдаа гар хангалга хийх нь тэдэнд тустай гэж үздэг. Гэсэн хэдий ч энэ нь дадал зуршил болж хувирвал ирээдүйд гэрлэлт дэх бэлгийн харилцааны сайхан, дотно байдалд хор хөнөөлтэй гэдгийг тэд ухаардаггүй.

Гар хангалга нь бэлгийн харилцааны үндсэн зорилго болох хосыг бие махбод, сэтгэл санааны хувьд нэг болгох гэдгийг үгүйсгэдэг.... Гар хангалгыг гэрлэлт дэх эрүүл, хэвийн бэлгийн харилцаанд орлуулагч болгон ашиглаж болохгүй.²⁰

²⁰ Dr. Tim Clinton and Dr. Diane Langberg, *The Quick-Reference Guide to Counseling Women*, (Grand Rapids, MI: Baker Books, 2011), 185.

Хэрэв гар хангалга нь асуудалтай бол гэрлээгүй хүн юу хийх ёстой вэ? Хэрэв хэн нэгэн зөвхөн бэлгийн дур хүслээ хангах зорилгоор гар хангалга хийж байсан ч, өдөр тутам уруу таталтыг эсэргүүцэж татгалзах нь л сайн хэрэг бөгөөд гар хангалга нь хэзээ ч бэлгийн харилцааны талаарх Бурханы зорилгыг биелүүлэхгүй.

Хэрэв хэн нэгэний амьдралд ямар нэгэн ёс бус зүйл байгаа бол нүглээ гэмшиж, орхих ёстой. Тэд өөрсдийнх нь төлөө залбирч, зөвлөгөө өгөх бурханлаг халамжлагч нарт ялалт, бүтэлгүйтлийнхээ талаар байнга тайлагнах ёстой.

Хэрэв гар хангалга нь сэтгэл зүйн, харилцааны асуудал, эсвэл өнгөрсөн бэлгийн хүчирхийллээс улбаатай бол мэргэжлийн христитгэгч зөвлөгч нараас тусламж авах хэрэгтэй.

Библи ижил хүйстний бэлгийн харилцааны талаар юу хэлдэг вэ?

Бурхан гэрлэлтийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох насан туршийн, үнэнч харилцаа байхаар бүтээсэн. Бурхан Адамд туслагч хэрэгтэйг харсан (Эхлэл 2:18). Туслагч гэдэг үг нь бусадтай таарч тохирох, олон аргаар бусдад туслахыг хэлнэ. Бурхан Адамын туслагчаар эрэгтэй хүнийг биш, харин эмэгтэй хүн бүтээсэн (Эхлэл 2:22). Бүтээлийн эцсийн зорилго нь хүн төрөлхтний төлөөх гэрлэлтийн зарчмууд бөгөөд гэрлэлтээр дамжуулан эрэгтэй, эмэгтэй хоёр нэгдмэл болдог (Эхлэл 2:24).

Есүс гэрлэлтийг Бурхан ямар загвараар бүтээснийг хэлсэн (Матай 19:4-6). Тэрээр Эхлэл номоос эш татаж, эрэгтэй, эмэгтэй хоёр хүн нэгдэж онцгой, хувиршгүй харилцааг бий болгодог талаар өгүүлдэг.

Элч Паул гэрлэлтийн талаар олонтоо тайлбарласан байдаг. Тэр гэрлэлт бол Христ болон чуулганы харилцааг бидэнд зааж буй дүрслэл гэж хэлсэн (Ефес 5:22-33). Ефес номд эрчүүдэд хандан эхнэртэйгээ хэрхэн харилцахыг зааварласан. Тэрээр Эхлэл болон Матай номоос эр хүн, эхнэртэйгээ харилцах онцгой харилцааны талаар эш татсан байдаг (Ефес 5:31). Эндээс гэрлэлт бол эрэгтэй, эмэгтэй хоёр хүний хоорондох харилцаа гэдэг нь тодорхой харагдаж байна.

Леви номд Израилд зориулсан Бурханы хуулийг хэрхэн хэрэглэх талаар өгүүлдэг. Энд эрэгтэй хүн нь эмэгтэй хүнтэй адил өөр эрэгтэйтэй хэвтэх нь жигшил зэвүүцэлтэй хэрэг гэж тэмдэглэсэн байдаг (Леви 18:22). Ижил хүйстний бэлгийн харилцаа нь үүнийг үйлдэгчдийн хувьд үхлийн шийтгэлтэй бөгөөд учир нь хоёул жигшил зэвүүцэлтэй хэрэг үйлдсэний тул юм (Леви 20:13).

Зарим хүмүүс Леви номыг орчин үеийн хүмүүст хамааралгүй гэж хэлдэг. Леви номын зарим тушаалууд нь ёслолд зориулагдсан байсан нь үнэн. Гэсэн хэдий ч Леви 18-20-р бүлгийн тушаалууд нь ойрын төрөл нэгэнтэйгээ болон амьтантай бэлгийн харилцаа үйлдэх, охиноо садар самуунд уруу татах зэрэг бэлгийн гаж буруу үйлдлийг хориглосон байдаг. Эдгээр бүлэгт мөн хүүхдээр тахил өргөх, хулгайлах, шүтээн шүтэх, дүлий эсвэл сохор хүмүүстэй зүй бусаар харьцах, ядуусыг дарлах, харийн хүмүүстэй зүй бусаар харьцах, хуурамч жин хэрэглэхийг хориглосон тушаалууд бий. Эдгээр тушаалууд нь

Бурханы ёс суртахууны болон шударга ёсны хэм хэмжээг зааж, бүх цаг үе, бүх газар орны хүмүүст хамаатай болох нь тодорхой байна.

► Нэг суралцагч Ром 1:18-32 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд Бурханыг санаатайгаар эсэргүүцдэг хүмүүсийн дээр Бурханы шүүлт ирнэ гэдгийг хэлдэг. Энд хэлэхдээ цорын ганц үнэн Бурхан, Бүтээгчийн тухай мэдлэгийг үгүйсгэснийхээ дараа хүн төрөлхтөн хуурамч шүтээн шүтэгч нар болж, бүтээгдсэн зүйлд мөргөж эхэлсэн гэж өгүүлдэг. Тэд үнэнийг үгүйсгэж, энэ нь бэлгийн ёс бус байдалд хүргэсэн бөгөөд улмаар ижил хүйстний бэлгийн харилцаа руу тэднийг аваачсан. Энд ижил хүйстний бэлгийн харилцаа нь төрөлх мөн чанарын эсрэг зүйл хэмээжээ. Зарим хүмүүс энэ хэсэгт ижил хүйстний хүчирхийллийн талаар өгүүлсэн гэж тайлбарладаг боловч үнэндээ хүмүүс хамтдаа буруу зүйл хийхийг сайн дураараа үйлдэж, үүнийхээ төлөө шүүгдсэн тухай бичжээ. Олон төрлийн нүглийг энд жагсааж, Бурханыг эсэргүүцэх хандлагын талаар дүрсэлсэн.

Элч Паул Бурханы буруушаадаг бусад нүглийн хамт ижил хүйстний бэлгийн харилцааг бичсэн байдаг (1 Коринт 6:9-10, 1 Тимот 1:9-10).

Чуулганы үүрэг хариуцлага

Зарим чуулган бэлгийн нүгэл үйлдсэн хүмүүст хэрхэн хайр энэрэл үзүүлэх талаар бэрхшээлтэй тулгардаг. Зарим чуулган бэлгийн нүглийн янз бүрийн хэлбэрийг хэвийн, төрөлхийн, зайлшгүй хэмээн зөвтгөдөг.

► Бэлгийн ёс суртахууны асуудлын талаар чуулганы үүрэг хариуцлага юу вэ?

Зөв шударга байдлыг зааж, хайрлах нь

Заримдаа чуулган хор хөнөөл болон гаж буруу талыг нь бага гэж үздэгээс үүдэн бэлгийн ёс бус хэлбэрүүдэд төдийлөн анхаарал хандуулдаггүй. Жишээлбэл, залуу, гэрлээгүй хүмүүст уруу таталтыг ялж амьдрах талаар заадаггүй учраас тэд бэлгийн харилцаанд орж байна гэж таамагладаг. Итгэгчид ариун амьдралын тухай Бурханы хэм хэмжээг дагаснаар, бэлгийн харилцааг зөвхөн гэрлэлтдээ зориулах ёстой.

Чуулганы зарчмууд нь Библид заасан шиг тодорхой байх ёстой. Гэрлэлтээс гадуур бэлгийн харилцаанд орсон хүмүүсийг Бурхан шүүх болно (Еврей 13:4). Итгэгчид ёс бус бэлгийн харилцаатай хүнийг шүтэн бишрэх ёсгүй. Христэд итгэгч нар бэлгийн ёс бус байдлын талаар хошигнох ёсгүй. Жирэмслэлт, өвчнөөс зайлсхийхийн тулд бэлгийн харилцаанд болгоомжтой хандахыг дэлхий дахин зааж буй ч, чуулганы байр суурь үүнээс ч илүү чухал юм. Чуулган бэлгийн нүгэл нь гуниг харуусал, эвдэрсэн гэр бүл, уруу таталт, сэтгэл ханамжгүй байдал, өөрийгөө буруутгах мэдрэмжид хүргэдэг гэдгийг заах ёстой.

Сайнмэдээг хуваалцах нь

Чуулган бүх нүгэлтнийг хайрлаж, Христийн нигүүлсэл, уучлалыг тэдэнд үзүүлэх ёстой.

Уруу таталтыг мэдрэх нь нүгэл биш юм. Христ хүртэл уруу татагдаж байсан боловч нүгэл үйлдээгүй (Еврей 4:15). Чуулган уруу таталтад орсон хэн нэгэнд, тэр ч байтугай ёс бус бэлгийн үйлдэлд уруу татагдсан ч байсан түүнд ялтай, итгэл найдвараа алдсан мэт хандах ёсгүй. Хүн бүрд байх буруу хүсэл нь өөр өөр боловч үүний шалтгаан нь хүн бүр төрөлхийн нүгэлт мөн чанартай, сүнслэг гажуудалд унасан учраас юм.

Пастор нь гаж буруу хүсэлтэй хүнд заахад тусгайлан бэлтгэгдээгүй хэдий ч тэрээр нүгэл үйлдсэн хүмүүсийн адил тэдэнд зөвлөгөө өгч, тусалж чадна (Энэ хичээлийн дараагийн хоёр хэсэгт бэлгийн ёс бус байдалд уруу татагдахдаа хэрхэн даван туулах талаар илүү нарийвчилсан зөвлөгөө бий).

► Чуулганы гишүүн бэлгийн ёс бус зүйл хийсэн үед чуулган хэрхэн хариу үйлдэл үзүүлэх вэ?

Нүгэлтнийг шинэчлэх нь

Галат 6:1-д нүгэл үйлдсэн итгэгчийг чуулган шинэчлэн өөрчлөх ёстой гэж хэлсэн байдаг. Энэ нь нүгэл үйлдсэнийхээ дараа итгэгч хүн үйлчлэлээ хадгалж үлдэх эсвэл хурдан хугацаанд үйлчлэлдээ эргэн орох гэсэн үг биш юм. Дахин шинэчлэх гэдэг нь чуулганы нөхөрлөл, халамжинд эргэн хүлээн зөвшөөрөгдөх гэсэн утгатай. Хэрэв итгэгч хүн үнэн сэтгэлээсээ гэмшвэл Бурхан болон чуулган түүнийг уучилна. Чуулган түүнийг нүглээ даван дийлсэн ялалтаа хадгалахад нь тусалж, сүнслэг дэмжлэг үзүүлэх ёстой. Шинэчлэгдсэн итгэгч нь хариуцлагатай амьдарснаар сүнслэг гэр бүлийнхээ итгэлийг аажмаар олж авах боломжтой.

Хэрэв гэрлээгүй эмэгтэй жирэмсэлсэн бол чуулган түүнийг сүнслэг шинэчлэл хийлгүйгээр чуулганы нөхөрлөл, халамжаас хасах ёсгүй. Хэрэв гэмшиж, сүнслэг хариуцлагад захирагдвал түүнийг уучилна. Түүний үйлдсэн нүгэл нь түүнтэй холбогдсон эрэгтэй хүнийхээс илүү биш. Заримдаа эмэгтэйн үйлдсэн гэм буруугийн үр дагавар ил байдаг учраас түүнд хатуу хандах тохиолдол бий.

Зарим чуулган гэрлэлтээс гадуур төрсөн хүүхдэд өөрөөр ханддаг нь буруу бөгөөд учир нь үүнд хүүхдийн буруу байхгүй. Чуулган хүүхдийг хайрлаж, хүлээн зөвшөөрснөөрөө нүглийг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг биш.

Сул дорой хүмүүсийг хамгаалах нь

Зарим нийгмийн бүлэгт гэрлээгүй охиныхоо жирэмслэлтээс ичсэн эцэг эхчүүд гэр бүлийнхээ нэр хүндийг аврахын тулд төрөөгүй хүүхдийг хөнөөх үйлдэл гаргадаг. Гэвч аллага хийх сайн шалтгаан гэж байдаггүй (Гэтлэл 20:13). Төрөөгүй хүүхэд бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн (Эхлэл 9:6, Дуулал 139:13-14). Тэр охины нялх хүүхэд хайрлагдаж, асран хамгаалагдах ёстой.

Ядуурлын эсрэг боломжоор хангах нь

Чуулган бол итгэлийн гэр бүл юм. Чуулган зөвхөн нүглийг буруушаах нь хангалттай биш. Чуулган өөрийн гишүүдээ халамжлах ёстой. Жишээлбэл, нүглийн шалтгаанаар

санхүүгийн дэмжлэг авч буй хэн нэгэнд өөр арга замаар орлого олох боломжийг харахад нь туслах хэн нэгэн хэрэгтэй.

Жишээлбэл, хэсэг охид нэлээн том хэмжээний чуулганд хамрагддаг бөгөөд найрал дуунд үйлчилдэг байв. Тэд ядуу гэр бүлээс гаралтай байжээ. Охид гэр бүлдээ туслахын тулд эрчүүдтэй ёс бус харилцаанд ордог байв. Ийм тохиолдолд чуулган юу хийх ёстой вэ?

► Танай чуулган хүмүүсийг нүгэлт амьдралаас нь салахад хэрхэн туслах вэ?

Сорилтыг даван туулж буй нэгэнд туслах нь

Бид энэ хичээлээр олон хүнд сэдвүүдийг хэлэлцлээ. Энэ хичээлийг уншиж буй олон хүн эдгээр асуудлуудтай тэмцэж байсан байх. Зарим уншигчдын хувьд уруу таталтад орж буй итгэгчдэд хэрхэн зөвлөхийг суралцах шаардлагатай чуулганы ахлагч, удирдагчид ч байж болох юм.

Ямар ч төрлийн уруу таталт байсан, даван туулахад нь туслах тодорхой үйлдэл, оюун бодолд хандсан загвар арга бий.

Христэд итгэгч нар дараах зүйлсээр тусламж авах шаардлагатай:

- 1. Христтэй харилцах харилцаандаа үнэнч байх (Матай 16:24-27).** Бэлгийн ёс бус байдалд уруу татагдах нь, бусад уруу таталтын нэгэн адил таны сүнс сэтгэл рүү дайрч буй Сатаны довтолгоо юм (1 Петр 2:11). Тэр зөвхөн хулгайлах, алж, сүйтгэхээр (Иохан 10:10) байгаа. Та амийнхаа төлөө зугтах ёстой (2 Тимот 2:22).
- 2. Есүс санаа тавьдаг гэдэгт итгэх (Дуулал 139:1-3, 1 Петр 5:6-10).** Тэр таны итгэл, бие махбодын хэрэгцээ, ариун байдалд санаа тавьдаг. Тэр хүний амьдралыг туулахдаа бие махбодын болон оюун санааны уруу таталтыг ялан дийлсэн бөгөөд бидэнд ялалт байгуулахад хэрэгтэй нигүүлслийг өгдөг (Еврей 4:14-16).
- 3. Чөтгөрийн худал үгэнд үл итгэх (Иохан 8:44).** Чөтгөр танд "Есүс чамд санаа тавьдаггүй болохоороо чамайг маш ихээр шаналгаж буй бэлгийн ёс бус хүслийг чинь арилгахгүй байна" гэж хэлж болно. 1 Петр 5:7-8-д Есүс чамд үнэхээр санаа тавьдаг, харин чөтгөр биднийг устгахыг хүсдэг гэж хэлсэн байдаг. Чөтгөр таныг бэлгийн ёс бус хүслээсээ болж нүгэлтэн хэмээн худал хуурмагаар буруутгаж болно (Илчлэл 12:10).
- 4. Есүст төвлөрч, Түүний хэн болохыг магтан алдаршуулаарай (Дуулал 105:3-4).** Чөтгөр энэхүү сорилтыг ашиглан таны итгэл болон Бурхантай харилцах харилцааг устгахыг маш их хүснэ (Иохан 10:10). Харин Есүсийн энэхүү сорилтын зорилго нь таны итгэлийг бэхжүүлж, түүнийг илүү ихээр алдаршуулах явдал юм (1 Петр 1:5-9). Та Есүсийг мөргөн хүндлэхэд төвлөрвөл Тэр танд тусалж, хамт байх болно (Дуулал 46:1).

5. **Бурханы Үгийг тунгаан бодох (Дуулал 119:9).** Бурханы Үгийг унших, сонсох, тунгаан бодох нь сорилттой үед ялалт байгуулахад тань тусална. Есүс уруу татагдах үедээ Библийн Үгийг ашиглан ялалт байгуулсан (Матай 4-р бүлэг). Бид ч мөн адил үйлдэх ёстой.
6. **Бэлгийн хүслийнхээ төлөө Есүст талархах, уруу таталтыг даван туулах хүчийг гуйн залбирах (2 Коринт 12:7-9).** Та өөрийн төрөлх хүсэлдээ талархаж болно. Учир нь тэдгээр нь Бурхан хүнийг бүтээсэн төлөвлөгөөнийх нь нэг хэсэг бөгөөд Есүст хамаатай байх, Түүнээс тусламж авахад тусалдаг. Түүнтэй хамт алхах үедээ та сул талаа Түүний тусламжтайгаар хүчирхэгжүүлэх боломжтой болдог.
7. **Төлөвшсөн, бурханлаг нэг хүнийн өмнө хариуцлагатай байх (Галат 6:2).** Итгэлийн замд илүү хол явсан хэн нэгэнтэй (адил хүйсийн) нээлттэй, шударга байх нь тустай. Тэр таны төлөө залбирч, зөвлөгөө өгөх болно. Түүнтэй өөрт тулгарч буй бэрхшээлийн талаар ярилцах нь ариун байдлаа хадгалахад болон итгэлээрээ урам зоригтой байхад тань тусална.
8. **Бусдад үйлчилж, тэдний хэрэгцээнд анхаарлаа хандуулах (Филиппой 2:3-5).** Өөрийн хэрэгцээ, хүсэлд хэт их санаа зоволгүйгээр харин бусдад үйлчлэх хүсэлтэй байгаарай.
9. **Бурханы цаг хугацаанд зөв хүнтэй гэрлэх (Сургаалт үгс 5:15, 18-19).** (Дараагийн хичээлүүдээр гэрлэлтийн ухаалаг сонголтын талаар хэлэлцэх болно)

► Эдгээр санаануудын аль нь танд шинэлэг байсан бэ? Таны амьдралд аль нь тустай вэ?

► Өөр ямар үйлдэл эсвэл оюун бодлын загвар танд тустай вэ?

Гэрлэхээс өмнөх ёс суртахууны цэвэр байдал

Залуу хүмүүс гэрлэхээсээ өмнө хүчтэй сорилтод ордог. Тэдний амьдралын хань нь үнэнч нэгэн байх хэрэгтэй гэдгийг санах нь чухал.²¹ Тэд гэрлээгүй мөртлөө богино хугацааны таашаал хүсдэг хүнтэй харилцаа үүсгэх талаар бодох ч ёсгүй. Мөн итгэгч бус хүнтэй харилцаатай байх талаар бодох ч ёсгүй (1 Коринт 7:39). Харин итгэлийн гэр бүлийн хань, сайн эцэг эх байж чадах хүнийг олох ёстой.

Сайн гэр бүлтэй болохыг хүсдэг хүн нь өөрөө Христийн үнэнч, тууштай дагалдагч байх ёстой бөгөөд ингэснээр мөн ийм зөв хүн түүнд татагдах болно (Сургаалт үгс 3:4-8). Хүн зохистой зан ааль, даруу хувцаслалтаар сайн зан чанараа харуулдаг (1 Тимот 2:9-10). Эсрэг хүйсийн хүмүүстэй хайхрамжгүй харьцдаг хүмүүс буруу хүсэлд суурилсан харилцаатай байхад бэлэн гэдгээ илэрхийлдэг (1 Тесалоник 4:1-7). Буруу хүслийг

²¹ Сургаалт үгс 31:11-12, 1 Тимот 3:11-12, Малахи 2:14-16 ба Сургаалт үгс 2:16-17 эшлэлүүдийг үз.

өдөөхүйц байдлаар хувцасладаг хүн ч бас үнэнч бус, зөвхөн таашаал хүсдэг хүнийг татдаг (Сургаалт үгс 7-р бүлэг).

Бурхан эцэг эх, пастор болон ахлагч нарт зан ааш, хувцаслалт, харилцаандаа сонголт хийх боломжийг өгсөн. Залуучууд нь Бурханд дуулгавартай байж, эдгээр хүмүүсээс зөвлөгөө авах үедээ Бурханы ерөөлийг авч, хор хөнөөл, уруу таталтаас хамгаалагдах болно.

► Суралцагчид 1 Петр 5:5 ба Еврей 13:17 эшлэлийг бүлэгт уншина.

Хүүхэд залуучууд эцэг эх болон сүнслэг удирдагчдынхаа мэргэн ухаан, удирдамжийг дуулгавартай дагах нь тэдний үүрэг хариуцлага юм. Эдгээр удирдагчид нь залуучуудыг сорилтоо даван гарахад туслах үүрэгтэй.

► Суралцагчид Ром 13:14 ба 1 Коринт 10:13 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан итгэгч нарыг **хэрэв** тэд хүсвэл зугтаж чадах болон дааж давшгүй сорилтод оруулахгүй. Залуучууд уруу таталтаас зугтах ёстой (2 Тимот 2:22). Эцэг эхчүүд үр хүүхдээ шаардлагагүй уруу таталтад өртөхөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Үүнийг эцэг эхчүүд дараах гурван аргаар хийж болно:

- 1. Тодорхой зааварчилгаа өгөх:** Хүүхдүүд юу хийх ёстой, юу хийх ёсгүй, хэнтэй хамт байх ёстой, хаашаа явах ёстой талаар заах (Ефес 6:1-4). Эцэг эхчүүд төлөвшсөн байдал нь уруу таталтад нөлөөлж чадахгүй нөхцөл байдалд хүүхдүүдээ оруулах ёсгүй. Жишээлбэл, хэрэв залуу эрэгтэй, эмэгтэй хоёр нэг газар хамтдаа байвал тэд буруу үйлдэлд уруу татагдах магадлалтай.
- 2. Залуусыг сорилттой тулгарах үед нь хамт байж, хариуцлагатай байх:** Эцэг эх хүүхдүүдтэйгээ хамт залбирч, өдөр тутмын амьдралынх нь талаар асуулт асуух хэрэгтэй. Хариуцлагатай байхын үр дүн нь эцэг эх болон хүүхдийн хоорондох харилцаанаас ихээхэн хамаарна. Хэрэв хүүхэд нь эцэг эхээ өөрийг нь хайрладаг, хүлээн зөвшөөрдөг, дэмждэг гэж итгэхгүй бол тэдний өмнө алдаагаа хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй.
- 3. Залуу хүмүүст Библийн дагуу зөвлөгөө өгөх:** Эцэг эхчүүд хүүхдүүдээ Библийн зарчмуудыг тунгаан бодож нөхцөл байдалд хэрхэн хандахыг зааж сургах хэрэгтэй (Сургаалт үгс 4:1-9, Сургаалт үгс 7:1, 4-5). Тэд хүүхдүүдтэйгээ аюултай гэж үзэж байгаа өөрсдийн бодлыг ярилцах хэрэгтэй. Хүүхдүүддээ шаардлагатай янз бүрийн сонголтуудыг гаргахад нь туслах хэрэгтэй. Тэд хүүхдүүддээ уруу таталтыг урьдчилан харж, хэрхэн зайлсхийх, уруу таталтад өртөх үедээ юу хийх талаар нь ярилцаж туслах ёстой.

Чуулган нь Библийн ёс суртахууныг хамгаалах хэрэгцээ шаардлагатай тулгарч байгаа бол зарим ахуй соёлоос тусгаарлах ёстой. Олон соёлын хувьд бэлгийн нүгэл ноцтой зүйлд тооцогддоггүй. Тэд гэрлээгүй залуусыг гэрлэхээсээ өмнө бэлгийн харилцаанд орохыг хэвийн зүйл гэж үздэг. Чуулган нүгэлд буулт хийх ёсгүй. Чуулган нь

залуучуудын дундах бэлгийн ёс бус байдлыг хэвийн гэж үзэх ёсгүй. Бурхан ёс суртахуунгүй нэгэн нь Христийн хаанчлалыг өвлөхгүй гэж айлдсан (Ефес 5:5).

- ▶ Чуулган нь дэлхийн уруу таталттай тэмцэж буй залууст хэрхэн тусалж чадах вэ?
- ▶ Суралцагчид Ефес 5:3-7 ба Еврей 13:4 эшлэлийг бүлэгт уншина.

Бэлгийн харилцаа нь гэрлэлтээс өмнөх харилцаанд эхлэх ёсгүй. Харин энэ нь эрэгтэй, эмэгтэй хоёр нь сүнслэг болон Библийн дагуу гэдгээ баталгаажуулж нэгдсэний дараа эхлэх ёстой харилцаа юм. Энэ бол тэд бие биедээ үүрдийн амлалт өгөх хангалттай итгэлцлийг бий болгосны дараа буюу бие биенийхээ тухай бүрэн ойлголттой болох үе юм. Хэрэв тэд энэ итгэлцэлд хүрч чадахгүй бол харилцаагаа дуусгаж, гэрлэх ёсгүй.

Зарим нийгэмд хүмүүс гэрлэлтийг төвөгтэй, үнэтэй ёслол гэж үздэг учраас гэрлэлтээ хойшлуулдаг. Ингэж гэрлэлтээ олонтоо хойшлуулж байх үедээ хосууд хамт амьдарч, хүүхэдтэй болдог. Зарим хосуудын хувьд хуримын зардал нь тэднийг удаан хугацаанд санхүүгийн хувьд хохироодог бөгөөд тэд хуримын арга хэмжээндээ бүх зүйлээ зарцуулж, мөнгө ч зээлдэг. Чуулган нь гэрлэлтийн өөр хувилбарыг санал болгодог итгэлийн бүлэг байх ёстой. Христэд итгэгчдийн гэрлэлт нь бие биедээ болон Бурханд үнэнч эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулагдах бөгөөд энэ нь хуримыг хойшлуулах эсвэл хосуудын ирээдүйг хохироох хэмжээний зардал шаардах учиргүй.

- ▶ Итгэгч хүмүүсийн гэрлэлт нийгэмд тогтсон гэрлэлтээс ямар ялгаатай байх ёстой вэ?

Хүүхдүүдэд бэлгийн харилцааны талаарх Бурханы зорилго ба дүрмийг заах

Бэлгийн харилцааны талаарх мэдээлэл хүүхдүүдийн чихэнд сонсогдож, нүдэнд өртөж байдаг. Тэд буруу, зөвийн талаар янз бүрийн хүмүүсийн бодлыг сонсож байдаг. Хүүхдүүд эрт орой хэзээ нэгэн цагт бэлгийн мэдрэмж, хүсэл, уруу таталттай тулгардаг тул итгэгч эцэг эхчүүд тэдэнд Бурхан бэлгийн харилцааны талаар юу хэлснийг тайлбарлаж өгөх нь чухал. Хүүхдүүд бэлгийн харилцааны талаарх нарийн зүйлсийг мэдэх шаардлагагүй, учир нь тэд гэрлэх насанд хүрээгүй бөгөөд тэднийг сорилтонд оруулах боломжтой.

Хүүхдүүд Бурханы төлөвлөгөөг болон дуулгавартай байх үүргээ мэдэх хэрэгтэй. Тэд уруу таталттай тулгарах болно гэдгийг мэдэх хэрэгтэй. Тэд Бурханд дуулгавартай байж, гэрлэх хүртлээ бэлгийн хүслээ хянах хэрэгтэй.

Дараах материал нь хүүхдүүдэд бэлгийн харилцааг нарийвчлан ярихгүйгээр христэд үзэл баримтлалыг заахад хэрэгтэй. Энэ нь хүүхдүүдтэй ярилцаж буй мэт энгийн байдлаар бичигдсэн.

Хүүхэдтэй ярилцах нь

- ▶ Эхлэл 2:7, 18-24 эшлэлийг хүүхэдтэйгээ хамт уншаарай.

Энэ хэсэгт Бурхан анхны эрэгтэй, эмэгтэй хүнийг хэрхэн бүтээж, онцгой харилцаатай болгосон тухай өгүүлдэг.

Бурхан гэрлэлтийг эрэгтэй, эмэгтэй хүний хоорондох онцгой харилцаа болгон бүтээсэн. Гэрлэсэн хосууд бие биедээ онцгой хайртай байдаг. Тэдний харилцааны нэг хэсэг нь зөвхөн хоёулханаа бие биеэ нэгтгэх буюу бэлгийн харилцаанд орох онцгой таашаал амсах юм. Бурхан бэлгийн харилцааг нөхөр, эхнэрт таашаал өгөх, заримдаа эхнэрийг жирэмсэн болгох зорилгоор бүтээсэн.

Бэлгийн харилцаа нь ийм онцгой таашаал өгдөг учраас эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биенийхээ биеийг харах, хүрэх, бие биедээ анхаарал тавих гэсэн төрөлхийн хүсэлтэй байдаг.

Библид Бурхан, бэлгийн харилцаа нь нөхөр, эхнэрийн хувьд зөв бөгөөд сайн зүйл гэж хэлсэн. Бурхан мөн гэрлээгүй хүмүүс хоорондоо бэлгийн харилцаатай байх нь маш буруу гэж хэлсэн. Бурхан бидэнд дараах дөрвөн шалтгааны улмаас бэлгийн харилцааны талаар дүрмийг өгчээ:

(1) Бэлгийн таашаал нь гэрлэлтэд зориулагдсан.

Бурхан бэлгийн харилцааг гэрлэлтийн онцгой хэсэг болгон бүтээсэн. Хэдийгээр ямар ч эрэгтэй, эмэгтэй хүн иймэрхүү байдлаар таашаал авах боломжтой боловч, энэ таашаал нь гэрлэлт дунд маш онцгой байдаг, учир нь нэг нь нөгөө хүндээ бүрэн зориулагдсан байдаг. Гэрлээгүй хүмүүсийн хувьд бэлгийн харилцаа нь Бурханы төлөвлөсөн харилцаа биш учраас утга байхгүй. Иймд гэрлэх нас болоогүй хүн бэлгийн харилцаанд орох ёсгүй. Хүмүүс гэрлэх амлалт өгч, олон нийтийн өмнө гэрлэх ёслол хийх хүртлээ бэлгийн харилцаанд орох ёсгүй. Хүн зөвхөн өөрийнхөө хостойгоо л бэлгийн харилцаанд орох учиртай.

(2) Бэлгийн дур хүслүүд маш хүчтэй байдаг.

Бэлгийн дур хүсэлтэй байх нь буруу биш, учир нь Бурхан тэдгээрийг бүтээсэн. Гэхдээ Бурханы хүсдэггүй зүйлд дур хүслээ зориудаар өдөөх нь буруу. Үүнээс болж:

- Гэрлэлтээс бусад тохиолдолд хүн бэлгийн дур хүслийг хүчтэй болгох зүйлсийг хийх ёсгүй, тухайлбал бусдын биеийг зориудаар харах эсвэл бодох гэх мэт.
- Гэрлэлтээс бусад тохиолдолд хүн бэлгийн дур хүслээ нэмэгдүүлэхийн тулд бусдад хүрэх ёсгүй.
- Хүн буруу зүйл хийхийг төсөөлөх ёсгүй.
- Хүн буруу зүйл хийж буй хүмүүсийг харах, таашаал авахын тулд зураг эсвэл видео үзэх ёсгүй.
- Хүн бусдыг буруу зүйл хийхийг хүсэх эсвэл буруу зүйл хийхээр төсөөлөх боломжтой байдлаар хувцаслах ёсгүй.
- Хүн буруу зүйл хийхийг хүссэн зан авир гаргах эсвэл тийм үгээр ярих ёсгүй.

(3) Бидний хүслүүд биднийг удирдаж чадахгүй.

Амьтад өөрсдийн мэдрэмж, хүслээрээ удирдуулдаг. Бид амьтан биш; бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс. Иймээс бид юу хийх ёстойгоо бодож, дараа нь зөв сонголт хийх ёстой. Бид өөрсдийн мэдрэмж, хүслээр удирдуулж болохгүй. Заримдаа бид хүссэн зүйлээ хийх нь зөв байдаг ч, заримдаа үгүй. Бидний хүсэл нь бэлгийн харилцаа зөв гэж хэлж чадахгүй. Бид өөрсдийн мэдрэмжээ дагахын оронд Бурханы Сүнсний тусламжтайгаар Библиэс Бурханы зааврыг харж, дагах ёстой.

(4) Бэлгийн харилцаа нь заримдаа хүүхэдтэй болгодог.

Хүүхдүүд хайрын харилцаанаас ирдэг байхаар Бурхан бүтээжээ. Тэрээр хүүхдүүдийг өөрсдийг нь хайрлаж, халамжилдаг гэр бүлд өсөж торнихоор бүтээсэн. Эцэг, эх нь гэрлээгүй хүмүүсийн хүүхэд нь насанд хүртлээ эцэг эхтэйгээ хоёулантай нь байж чаддаггүй.

Дээр дурдсан дөрвөн баримтыг ойлгосноор Бурханыг дагах хүсэлтэй, хамгийн сайхан амьдралыг хүсдэг хүмүүс Бурханы зааврыг дагах болно. Ингэснээр тэд уруу татлагыг эсэргүүцэх чадвартай дадлуудыг Бурханд дуулгавартай байхын тулд өөрсөддөө бий болгоно.

Хүүхдийн залбирал

Хайртай Бурхан минь,

Намайг (хүү эсвэл охин байлгаж) бүтээсэнд баярлалаа. Гэрлэлтийн төлөөх таны онцгой, сайн төлөвлөгөөнд баярлалаа. Намайг насан туршдаа танд хайртай, дуулгавартай байхад туслаач. Та миний хийж буй бүхнийг хардаг, миний бодож буй бүхнийг мэддэг. Амьдралын талаарх таны зааврыг үргэлж дагаж мөрдөхөд надад туслаач. Би бодол болон үйлдлээрээ таныг баярлуулахыг хүсэж байна. Найзууддаа сайн үлгэр дуурайл болж, танд дуулгавартай байхад надад туслаач. Зөв цагтаа, намайг том болоход, таны хүссэн (нөхөр эсвэл эхнэр) хүн байхад надад туслаач. Би танд хайртай, Бурхан минь!

Амен

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Биднийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээж, амьдралд утга учир, зорилго өгсөнд талархья. Таны дүр төрхийг харуулахын тулд хүйсийг бүтээсэнд баярлалаа.

Гэрлэлт дэх бэлгийн харилцааны талаарх таны сайн загвар болон зорилгод талархья.

Бид таны Үгийг үл дагасныхаа төлөө гэмшиж байна. Есүсийн нэрээр биднийг угааж, уучилж, ариусгаач (1 Коринт 6:11). Биднийг нүглийн боолчлолоос чөлөөлөөч (Ром 6:6-7). Бид одоо биеэ танд өргөж, таны нүдэнд зөв зүйлийг хийхээ амлаж байна (Ром 6:13-14).

Зөв бодож, зөвийг үйлдэх дадлыг хэвшүүлэхэд бидэнд туслаач (1 Тимот 4:7, Дуулал 23:3). Бидний бодол, үйлдэл үргэлж таны нүдэнд тааламжтай байг (Дуулал 19:14). Сорилт ирэх бүрд бидэнд ялалтыг өгөхөө амласан танд талархья (1 Коринт 10:13).

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Дараах асуултуудад хариулахын тулд Галат 5:16-6:9 эшлэлийг энэ хичээлээр хэлэлцсэн сэдвүүдийг харгалзан уншина уу. Дараах асуултуудад бичгээр хариул:

- Махбодын хүсэл (5:16) болон махбодын үйлдэл (5:19) хоёрын ялгаа юу вэ?
- Махбодын үйлдлийг үйлдсэн хүмүүст ямар хоёр зүйлийг амласан бэ? (5:19-21, 6:7-8)
- Итгэгч хүн махбодын хүсэл тачаалд үл захирагдах хүчийг хэрхэн олж авах вэ? (5:16, 22-23, 25)
- Сорилтын үед итгэгчид ямар үнэнүүдийг санах ёстой вэ, энэ нь хэрхэн даван туулахад тусалдаг вэ? (Энэ хэсгээс хамгийн багадаа дөрвийг нэрлэнэ үү)
- Энэ хэсэгт итгэгчдэд юу хийхийг зааварчилсан бэ? (Энэ хэсгээс хамгийн багадаа дөрвийг нэрлэнэ үү)
- Итгэгчид бие биеийнхээ өмнө ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ? (Галат 6:1-2, 6)

(2) Ром 6:1-23-ыг уншина уу. Дараах асуултуудад хариул:

- Энэ хэсэгт итгэгч бүрийн тухай ямар үнэнүүд бичигдсэн бэ? (6-8 зүйлийг жагсаана уу)
- Итгэгчид өөрсдийн талаарх үнэнээс болж ямар сонголтуудыг хийх ёстой вэ? (6-8 зүйлийг жагсаана уу)
- Итгэгч хүн нүгэл үйлдэх сорилтын үед яагаад ялалт байгуулна гэж найдаж болох вэ? (Нэг догол мөрөөр бичнэ үү)

(3) Ром 8:1-14-г уншина уу. Энэ хэсэгт буй үнэнүүд дээр үндэслэн залбирлаа бичээрэй.

(4) Ром 6:11-14 ба Колоссай 3:5-7 эшлэлийг цээжилнэ үү. Дараагийн хичээлийн эхэнд эдгээр эшлэлийг цээжээр бичих болон уншина уу.

5-р хичээл

Ганц бие байх

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Ганц бие байх талаарх Библийн ойлголтийг таньж мэдэх.
- (2) Гэрлэлт болон ганц бие байхтай холбоотой сонголтын хувьд Библи юуг чухалчилдаг болохыг тодорхойлох.
- (3) Амьдралынхаа энэ үед ёс суртахууны цэвэр ариун байдал, бурханлаг зан чанар, үр бүтээлтэй үйлчлэлд өөрийгөө зориулах.
- (4) Есүс Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрч захирагдах, Түүний дотор бүрэн дүүрэн байх.

Гэрлэсэн, гэрлээгүй эсэхээс үл хамаарч Есүсийг дээдлэн хүндлэх

Стивен, Сара хоёр гэрлэх нь Бурханы хүсэл мөн үү гэдгийг тодорхойлохыг хичээж байв. Хэрэв Стивентэй (илгээлтийн эзэн байв) гэрлэвэл амьдрал нь олон талаар өөрчлөгдөнө гэдгийг Сара мэдэж байв. Тэр шинэ газар орон руу нүүж, шинэ хэл сурч, шинэ соёлд дасан зохицох болно.

Тэрээр дассан, таатай байсан бүхнээ орхих болно гэдгээ мэдэж байлаа. Урам хугарах, золиос гаргах зүйлс тохиолдох болно. Гэрлэлт нь нөхөртөө хайртай байх үүрэг төдийгүй, Есүсийн төлөөх итгэл, хайрын үйлдэл юм. Цаг хугацаа өнгөрөхөд Стивен, Сара хоёр бие биетэйгээ тохирохгүй, гэрлэх ёсгүй гэдгийг ойлгожээ. Сара урам хугарав. Тэр урам хугаралтынхаа төлөө ч залбирсан. Тэрээр Бурханаас энэ амьдралынхаа хугацаанд Түүнд үр бүтээлтэй байхад нь туслахыг гуйсан юм. Тэр залбирахдаа Бурханы хүсэлд өөрийгөө өгөх нь гэрлэлтийн адил Есүсийн төлөөх итгэл, хайрын үйлдэл байсныг ойлгожээ.

Ганц бие байх

Энэ курсээр гэрлэлтэд зориулсан Бурханы загвар төлөвлөгөөнд бид суралцаж байна. Гэрлэлтийн төлөөх Бурханы зорилгыг бид Бичвэрээс сурч мэддэг. Бид Бурханы гэрлэлтэд зориулсан зааварчилгаа, мөн гэрлэлтээ сайжруулах практик аргуудыг хэлэлцэнэ. Мөн Бурханы гэрлэлтэд зориулсан төлөвлөгөөний сайн сайхан талыг харах болно.

Ихэнх хүмүүс гэрлэхийг Бурханы хүсэл гэж ойлгодог. Хэдий тийм боловч олон хүн гэрлэхээсээ өмнө тодорхой он жилүүдийг ганц бие байж туулдаг. Заримдаа энэхүү ганц бие байх хугацаа нь урт удаан үргэлжилдэг. Зарим хүмүүс гэрлэсний дараа хань ижлээ

алдах, эсвэл салалт зэргээс болж ганц бие амьдрах өөр он жилүүдийг туулдаг бол зарим хүмүүс хэзээ ч гэрлэдэггүй.

Хүн дараах нэг буюу хэд хэдэн шалтгааны улмаас гэрлээгүй байж болно:

- Тэд гэрлэхээс илүү ганц бие байхын давуу талыг илүүд үздэг.
- Тэд сайн гэр бүлийн харилцааг хараагүй учраас гэрлэлтийн талаар санаа зовдог.
- Тэд одоогоор боловсрол эсвэл карьер зэрэг зорилгодоо төвлөрч байна.
- Тэдэнд гэрлэх сэтгэл зүйн эсвэл бие махбодын хэрэгцээ байдаггүй.
- Тэдэнд сайн гэрлэлттэй учрах боломж олдоогүй. Учир нь хүний ганц бие амьдрах сонголт нь Бурхантай болон бусадтай харилцах харилцаанд асар том нөлөө үзүүлдэг. Энэ хичээл нь гэрлээгүй итгэгч хүний амьдралд төвлөрч бичигдсэн.

Ганц бие байх талаар Есүс болон Паулын хэлсэн үгс

Фарисайчууд Есүсээс гэр бүл салалтын талаар асуусны дараа Есүсийн хариултыг сонсоод дагалдагч нар нь гэрлэхгүй байсан нь дээр юм (Матай 19:10) гэж дүгнэсэн байдаг. Есүс дэлхий дээрх амьдралынхаа туршид гэрлээгүй бөгөөд ганц бие амьдарсан. Тэрээр ихэнх хүмүүсийн хувьд гэрлэх шаардлагатай байдаг ч цөөн тооны хүмүүсийн хувьд урт удаан хугацаанд ганц бие байх чадвар өгөгдсөн байдаг гэж хариулжээ (Матай 19:11-12).

Коринт дахь гэрлээгүй итгэгчдэд элч Паул (хэзээ ч гэрлэж байгаагүй эсвэл бэлэвсэрч үзээгүй) үүнтэй төстэй зөвлөгөө өгсөн байдаг. Харин бэлгийн ёс бус явдалд уруу татагдах аюулаас болж ихэнх хүмүүс гэрлэх ёстой гэжээ (1 Коринт 7:2, 8-9). Гэрлэлт дэх бэлгийн харилцааны дотно байдлыг Бурхан сайн бэлэг болгон бүтээснийг Паул мэдэж байсан (1 Коринт 7:7, 1 Тимот 4:1-5, Еврей 13:4). Тэрээр бэлгийн харилцаа нь гэрлэлтээс гадуур байх ёсгүй гэж хэлсэн (1 Тесалоник 4:3-4).

Паул гэрлээгүй амьдралын нэгэн давуу талыг ч дурдсан байдаг. Гэрлээгүй итгэгчид цаг хугацаа, эрч хүч, хүчин чармайлтаа Эзэнд таалагдах, үйлчлэлд зориулахад төвлөрүүлж чаддаг ажээ (1 Коринт 7:32-35).

Паул ч гэрлээгүй, ганц биеэр амьдарсан (1 Коринт 9:5) бөгөөд Бурханы түүнд даалгасан илгээлтийн ажилд анхаарлаа хандуулахын тулд гэрлэхгүй байхыг сонгожээ. Тэрээр ганц бие байхыг билэг авьяас гэж үздэг байв (1 Коринт 7:7-8). Тэрээр үйлчлэлдээ маш их зовлон бэрхшээлийг тэвчсэн (2 Коринт 11:23-28). Эхнэр, хүүхдийн хариуцлага хүлээгээгүй учраас энэ зовлонг даван туулахад илүү хялбар байсан болов уу (1 Тимот 5:8).

Хэдийгээр Паул ганц бие байх нь түүний үйлчлэлд давуу талтай гэж үзсэн ч, гэрлэлт нь үйлчлэлд давуу тал болдог арга замуудын талаар ч мөн өгүүлсэн байдаг.

► Та ганц бие байх нь үйлчлэлд хэрхэн давуу тал болж болдгийг харж байсан уу? Та гэрлэлтийг үйлчлэлд хэрхэн давуу тал болж байгааг харсан уу?

Хүмүүс гэрлэх эсэхээ шийдэхдээ хэд хэдэн зүйлийг харгалзан үзэх ёстой гэж Паул хэлсэн:

- Насан турш ганц бие амьдарч чадах хувийн чадвар эсвэл чадамжгүй байдал (1 Коринт 7:9, 36-37)
- Хавчлага гэх мэт одоогийн хүнд хэцүү нөхцөл байдлууд (1 Коринт 7:26)
- Гэрлэлтийн үүрэг хариуцлагууд (1 Коринт 7:27-28, 32-35)

Зөв эрэмбэ дараалал

Ганц бие байх, гэрлэх нь нэг нь нөгөөгөөсөө илүү дээр эсвэл илүү сүнслэг зүйл биш юм. **Аль алинд нь өвөрмөц бэрхшээл, уруу таталт, ерөөл, боломжууд байдаг.** Аль аль нь өөр өөр цаг үед, өөр өөр хүмүүст тохиромжтой байдаг.

Эцсийн дүндээ, хувь хүний сэтгэл ханамж, бүрэн бүтэн байдал нь тухайн хүн гэрлэсэн эсэхээс үл хамааран Бурхантай харилцах харилцаанаас нь ирэх ёстой (Дуулал 73:25, Дуулал 107:8-9). Цаашилбал, гэрлэсэн болон гэрлээгүй бүх итгэгчид анхаарлаа өнө мөнхийн зүйлсэд хандуулах учиртай. Учир нь энэ амьдрал богинохон бөгөөд өнө мөнх биднийг баттай хүлээж байна (1 Коринт 7:31).

► Нэг суралцагч Матай 6:26-33 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ хэсэгт Есүс дэлхийн үнэт зүйлс, эрэмбэ дараалал нь итгэгчдийнхээс тэс өөр болохыг тайлбарладаг. Итгэгч хүний хамгийн дээд зорилго бол Бурханы хаанчлалд оролцох явдал юм. Итгэгч хүний нэн түрүүнд чухалчлах зүйл бол Бурханы нигүүлслээр зөвт амьдралаар амьдрах юм. Матай 6:33-д Есүсийн үгийг дагаж буй хүүхдүүдийнхээ бие махбодын болон материаллаг хэрэгцээг хангана гэдгээ Бурхан амлажээ.

Христэд итгэгч хүн хэзээ гэрлэх ёстой вэ? Гэрлэлт нь түүнд Бурханы хаанчлалд илүү сайн үйлчлэхэд туслах тэр цаг үед. Гэрлэлт нь түүнд илүү үр жимстэй, ялалттай, зөвт амьдралаар амьдрахад туслах тийм цаг үед.

Гэрлээгүй Христэд итгэгч хүн хэзээ ганц бие хэвээр үлдэх ёстой вэ? Гэрлэлтийг эрэлхийлэх эсвэл гэрлэлт нь өөрөө Бурханы хаанчлал дахь үүрэг оролцоонд нь саад тотгор болох үед. Тэрээр ганц бие хүний хувьд сүнслэг талаараа илүү үр жимстэй байж чадах үед. Тэрээр гэрлэлтэд олгогддог бэлгийн дотно харилцаагүйгээр сүнслэг байдлын хувьд ялалттай, ёс суртахууны цэвэр байдлыг хадгалж чадах тийм цаг үед.

► Хэрэв та ганц бие бол түр завсарлаад өөрийгөө шударгаар эргэцүүлэн бодоорой.

- Та Бурханы Үгийг дуулгавартай даган амьдарч байна уу?
- Бурхан яг одоо өөрийнхөө хаанчлалд юу хийхийг танд даалгасан бэ?
- Бурхан таныг урт хугацаанд амьдралаараа юу хийгээсэй гэж дуудсан гэж та боддог вэ?

- Энэ дэлхий дээрх амьдралд гэрлэлт таныг Бурхантай харилцах харилцаа болон Бурханы төлөөх ажилд илүү сайн эсвэл муу болгоно гэж та боддог уу?

Бурханы хувьд юу чухал болохыг хүлээн зөвшөөрөх нь гэрлээгүй итгэгчдэд гэрлэлтийг эрэлхийлэх эсэхээ шийдэхэд тусалдаг. Энэ нь мөн бидний ирээдүйн ханиасаа юу хайх ёстой талаарх ойлголтыг маань төлөвшүүлдэг. Гэрлэхийг хүсдэг итгэгч бүр Бурханыг нэгдүгээрт тавьдаг, Бурханы Үгийг дуулгавартай даган амьдардаг, Бурханы хаанчлалыг өргөжүүлэхийг эрмэлздэг нэгнийг хайх ёстой.

► Суралцагчид Ефес 4:17-24 ба 1 Иохан 2:15-17 эшлэлийг бүлэгт уншина.

Дэлхийн хүмүүс өөрсдийнхөө төлөө амьдардаг. Тэд бие махбод, оюун бодолдоо хүссэн зүйлээ хийхийг сонгодог (Ефес 2:3). Мөн тэд Бурханы Үгийг дагахгүй байхад бэлэн байдаг. Нүгэлт хүмүүс ихэвчлэн өөрт нь таатай санагддаг, хамгийн тохиромжтой эсвэл бусад хүмүүсийн анхаарлыг татдаг зүйлийг хийдэг. Тэдний нэн тэргүүнд тавьдаг зүйл нь өөрсдийгөө баясгах явдал юм. Тэд зөвхөн тухайн хүнд бие махбодын хувьд татагдсан учраас л романтик харилцаа үүсгэдэг. Тэд зөвхөн тухайн хүнтэй хамт байхдаа сэтгэл хөдөлгөм мэдрэмж төрдөг учраас л хэн нэгэнтэй харилцаатай болдог.

Хувиа хичээсэн хүмүүс гэрлэлт дэх өөрийгөө зориулах харилцаанд орохыг хүсэхгүй байж магадгүй. Хэдийгээр Бурхан ийм харилцааг буруу гэж хэлдэг ч гэсэн тэд гэрлэлтгүйгээр бэлгийн харилцаанд ороход бэлэн байдаг (1 Коринт 6:9-11).

Гэрлэсэн хувиа хичээсэн хүмүүс гэрлэлт нь хэцүү болох үед ханиа орхиж магадгүй. Тэд ханиасаа салж, өөр хэн нэгэнтэй шинэ харилцаа эхлүүлж чадна. Үг зааврыг нь дагадаг хүмүүст Бурхан үүнээс хавьгүй дээр зүйлийг бэлдсэн байдаг (Дуулал 19:8, 11, Дэд хууль 6:24).

Бүх зүйлээрээ Бурханыг баярлуулахыг Есүс бидэнд уриалсан (Матай 16:24, 2 Коринт 5:9, Колоссай 1:10). Бид Христийн дагалдагчид учраас хувийн амьдралдаа чухалчлах зүйлс маань Бурханы хаанчлал ба зөвт байдал байх учиртай. Цаашилбал, бидний гэрлэлтийг эрэлхийлэх эрэмбэ дараалал ч Бурханы хаанчлал ба зөвт байдал байх ёстой. Бид гэрлэх болсон шалтгаандаа болон гэрлэлтийг эрэлхийлэх арга замдаа Бурханыг дээдлэн хүндэтгэх учиртай. Бид Есүсийн үнэлдэг зүйлсийг сонсож, Түүний зөв бөгөөд сайн гэж хэлсэн зүйлийг дагах ёстой. Тэгээд бид нөхөр, эхнэрийн хувьд биднээс хүлээж буй Түүний хүлээлтийг дагаж Бурханыг дээдлэх учиртай.

Аливаа зүйлд цаг хугацаа бий

Нас биенд хүрээд удаагүй байгаа үе бол ихэнх хүмүүсийн хувьд гэрлэхэд хамгийн тохиромжтой цаг байдаг (Сургаалт үгс 5:18, Малахи 2:15, Тит 2:4). Залуу насандаа хүн аль хэдийн амьдралд бэлтгэгдэж, бэлэн болсон байх учиртай. Эрэгтэй, эмэгтэй хүн төлөвшсөн, хариуцлага хүлээх чадвартай, ухаалаг шийдвэр гаргах чадвартай байх ёстой (1 Тимот 4:12). Хамгийн тохиромжтой нь, залуучууд гэрлэлт болон хүүхэд өсгөх хариуцлагад бэлэн болсон байх үе юм. Тэдний бие махбод нь мөн хүүхэд төрүүлэхэд

бэлэн байдаг бөгөөд ихэнх тохиолдолд бэлгийн дур хүсэл ихтэй, гэр бүлийн дотно харилцааны хэрэгцээ шаардлага өндөр байдаг.

Өнөөдөр олон соёлд залуучууд дээд боловсрол эзэмшсэний дараа эсвэл карьертаа байр сууриа олсны дараа хэмээн гэрлэлтээ хойшлуулах нь түгээмэл болж байна. Бусад залуучуудын хувьд хариуцлагаас ангид амьдрахыг хүсдэг учраас гэрлэлтийг сонирхдоггүй.

Олон залуучууд гэрлэхээсээ өмнө бэлгийн харилцааны ёс суртахуунгүй амьдардаг. Тэдний бэлгийн дур хүсэл их бөгөөд сэтгэл хөдлөлийн хувьд дотно нөхөрлөлийг хүсдэг. Гэсэн хэдий ч тэд амьдралын зорилгогүй эсвэл хариуцлага хүлээх хүсэлгүйгээсээ болж гэрлэх, гэр бүл зохиох үүрэг хүлээхийг хүсдэггүй.

Гэрлэлтээ хойшлуулж буй христитгэлт залуучууд өөрсдийн чухалчилдаг зүйлсээ сайтар бодож үзэх хэрэгтэй. Тэд бурханлаг, ариун, Бурханы хүслийг дагаж амьдарч байгаа эсэхээ баталгаажуулах ёстой. Түүнчлэн гэрлэхэд болон үр хүүхдээ бурханлаг хүн болгон өсгөхөд Бурхан хандуулж буй чухал ач холбогдлыг анхаарч үзэх хэрэгтэй.

Гэрлээгүй ч хамт амьдардаг хосууд

Заримдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүс дотно харилцаанд орж, хамт амьдардаг боловч гэрлэлтээ хойшлуулдаг. Тэд бие биедээ үнэнч байж болох ч гэрлэлтийн гэрээ байгуулаагүй байдаг. Хүмүүст өөр өөр шалтгаан байж болох юм:

1. Заримдаа ахуй соёлоос үүдэлтэй сүржин, үнэтэй хуримын ёслол нь тарчиг хосыг хүлээн зөвшөөрөгдөхүйц хурим хийхэд нь саад болдог.
2. Заримдаа хосууд гэрлэлт нь бүтэлгүйтэх вий гэсэн айдсаас болж гэрлэхээс татгалздаг. Хэрэв салалт тохиолдвол гэрлээгүй байсан нь гарз хохирол багатай гэж бодох нь ч бий. Тэд хамт амьдарч байхдаа харилцаа нь илүү бат бөх болно гэж найдаж ч болох юм.

Бурхан бэлгийн дотно харилцааг гэрлэлтэд зориулсан юм (Еврей 13:4). Гэрлээгүй хэрнээ хамт амьдарч байгаа хосууд Бурханы Үгэнд дуулгаваргүй хандсан гэм буруутай. Тэдний дотно харилцаа нь насан турш бие биедээ өөрсдийгөө үнэнчээр зориулах болон харилцан итгэлцэлгүй байдал зэргээс болж хэзээ ч байх ёстой шигээ байж чадахгүй.

Итгэгч хүн итгэгч бус хүмүүсийн жишээг дагах ёсгүй. Харин Бурханы Үгийг дагах ёстой. Чуулган ёс суртахууны талаарх Бурханы хүлээлтийг дэмжиж, хосуудад гэрлэлтийн талаарх Бичвэрийн төлөвлөгөөг дагахад нь практик тусламж үзүүлэх ёстой. Жишээлбэл, хосууд үнэтэй хурим хийх боломжгүй үед чуулганы гэр бүл энгийн хурим хийхэд нь тэднийг дэмжиж болох юм. Энэ нь гэрлэлтээр дамжуулан хосууд ёс суртахууны талаарх Бурханы хэм хэмжээг дагахад нь тусалж буй хэрэг юм. Энэ нь мөн хосуудад гэрлэлтээ санхүүгийн өргүй эхлэхэд нь туслах болно. Христэд итгэгчдийн гэрлэлт нь хуримын ёслолоос хавьгүй чухал боловч, гэрлэлтийн тодорхой амлалт үүнд байх ёстойг санаж байх хэрэгтэй.

► Суралцагчид Ром 12:2 ба Филиппой 2:15-16 эшлэлийг бүлэгт уншина. Итгэгч хүн ёс суртахуунтай байснаар эргэн тойрондоо ахуй соёлдоо хэрхэн нөлөөлж, өөрчилдөг талаар ярилцаарай.

Зөв эрүүлээр ганц бие байх нь

Захирагдах (Буулт хийх нь)

Бурханы хүүхэд бүр өөрийн хүсэл тэмүүллээ Есүст даатгах ёстой. Есүс бол Эзэн. Итгэгч нэг бүр амьдралынхаа туршид Есүст хэр зэрэг үнэнч байгаагаараа шалгагддаг. Хэцүү зүйл тохиолдох үед... эсвэл бидний хүссэн сайн зүйл биелэхгүй байх үед... Есүс биднээс, дагалдагчдаасаа: "Би та нарын Эзэн мөн үү? Та нар миний сайн сайханд итгэж найддаг уу? Миний төгс төлөвлөгөөнд итгэх үү? Та нар надад дуулгавартай байх уу? Миний хүсэлд буулт хийх үү? Миний хийж буй зүйлд захирагдах уу? Та нар үүгээр дамжуулан намайг алдаршуулах уу?" гэж асуудаг.

"Сэтгэл хангалуун байдал нь Бурхан миний бүх нөхцөл байдлын дээгүүр бүрэн эрх мэдэлтэй бөгөөд надад хамгийн сайн зүйлийг өгч байгаа гэдгийг мэдэх үед ирдэг сэтгэл ханамж юм."

- Phil Brown

Зарим ганц бие хүмүүс ганц бие хэвээр үлдэхдээ баяртай байдаг. Гэхдээ гэрлэхийг хүсдэг боловч сайн боломж олдоогүй хүмүүсийн хувьд гэрлэлтийг нь хойшлуулж буй Бурханы сонголтыг даруухнаар хүлээн авах учиртай.

Христитгэлт эрэгтэй, эмэгтэй хүмүүс... Бурхан тэднийг гэрлүүлэхийг хүсвэл, Тэрээр өөрийн төгс цаг хугацаа, арга замаар үүнийг тодорхой болгоно гэдгийг ухаарах ёстой. Гэхдээ Тэр үргэлж эхэнд байх ёстой бөгөөд Түүнд үргэлж [бүрэн итгэх] ёстой.²²

Бурхан бол итгэлтэй бөгөөд сайн. Гэрлээгүй итгэгчийн зүрх сэтгэл, амьдралд хийхийг хүсдэг ажил Түүнд бий. Бурхан өөрийн хүүхдүүдэд үргэлж хамгийн сайн сайхныг зөвшөөрдөг бөгөөд хамгийн чухал нь, Есүсийг хамгийн ихээр алдаршуулах зүйлийг зөвшөөрдөг. Биднийг зан чанараараа Есүстэй адилхан болгохын тулд бүх зүйлийн дотор Бурхан ажилладаг (Ром 8:28-29) бөгөөд бид Есүсийг өнө мөнхөд мөргөн хүндлэх боломжтой байхын тулд аж (1 Петр 1:6-7).

Бурхан хүүхдүүдийнхээ нэгэнд бурханлаг хань өгөх бүрэн чадвартай. Тэр Христэд итгэгч эр хүнд бурханлаг эхнэр олоход нь тусалж чадна. Учир нь эр хүн амьдралаараа Бурханыг өргөмжилдөг үнэнч эмэгтэйг хайж байдаг (Сургаалт үгс 18:22, Сургаалт үгс 19:14, Сургаалт үгс 31:10).

Христийн төлөө амьдарч буй гэрлээгүй эмэгтэйн хувьд Бурхан түүнийг эрэгтэй хүнтэй учруулах үгүй эсэхээс үл хамааран, Тэр түүний хэрэгцээг хамгийн сайн байдлаар

²² Leslie Ludy, *Sacred Singleness* (Eugene, OR: Harvest House Publishers, 2009), 24 -аас авсан.

хангах болно гэдэгт итгэж болно. Бурханы хангамж ба итгэмжит байдлын ачаар тэр бүрэн дүүрэн, сүнслэг үр жимстэй амьдралаар амьдарч чаддаг.

Хэрэв ганц бие байх нь түүний төлөөх Бурханы сонголт бол, тэрээр Бурханыг төгс хайрлагч, хангагч, хамгаалагч, удирдагч гэдгийг олж мэдэх болно. Есүс түүний зүрх сэтгэлийн хань байх болно (Исаиа 54:5). Тэрээр дэлхийн нөхрийн оронд Түүнийг хайрлаж, хүндэтгэж, захирагдаж, дуулгавартай байж чадна.

Хэрэв гэрлэлт нь эмэгтэйн төлөөх Бурханы сонголт бол, түүний ганц бие байсан цаг хугацаа нь Бурханд (*цорын ганц* төгс хайрлагч, хангагч, хамгаалагч, удирдагч) итгэж найдахыг түүнд заасан бөгөөд улмаар тэр төгс бус, нөхөр хүнийг хайрлаж, хүндэтгэж, захирагдахад суралцдаг.

Христ доторх бүрэн дүүрэн байдал

Итгэгч хүн бүрийн бүрэн дүүрэн байдал нь хүмүүн хамтрагчаас биш, харин Христ дотор байдаг. Хэдийгээр хэн нэгэн гэрлэхийг илүүд үздэг байсан ч, удаан хугацаанд ганц бие байх нь түүнийг Есүс дотор үнэхээр сэтгэл хангалуун байгаа эсэхээ батлах боломжийг олгодог. Ганц бие байх нь Есүс хангалттай гэдгийг батлах боломжийг олгодог (Филиппой 4:11-13).

Бурхан гэрлэлтийг бүтээсэн бөгөөд бид үүнийг ариун нэгдэл гэж хүндэтгэх ёстой нь Бичвэрээр дамжуулан тодорхой харагддаг... Адам ганцаараа байх нь сайн биш байсан, гэхдээ энэ нь Бурхан өөрөө Адамын хэрэгцээг хангахад хангалтгүй байсан гэсэн үг үү? Мэдээж үгүй! Библид тайлбарласны дагуу, Бурхан Еваг бүтээсэн нь Адамд *туслагч*, Бурханы түүнд хийхээр дуудсан дэлхий дээрх ажлыг хийх хамтрагч хэрэгтэй байсан учраас тэр юм. Тийм ээ, Адам болон Ева хоёуланд нь бие биетэйгээ хамт байхын олон ерөөл, ашиг тус ирсэн боловч тэдний гэрлэлт хэзээ ч Бурханыг орлох ёсгүй байсан. Тэрээр үргэлж Бурхан хэвээрээ байсан бөгөөд тэдний хайр, мөргөлийнх нь анхдагч, үндсэн объект байх ёстой байв.²³

Залбирал

“Эзэн минь, би Таных. Энэ бол миний үнэ цэн, миний дуудлага, миний аюулгүй байдал, миний тайтгарал, миний зорилго, миний баяр хөөр, мөн миний шагнал. Надад Та хэрэгтэй. Та л хангалттай. Та намайг дүүргэнэ. Та бол миний эх сурвалж. Та намайг бүрэн дүүрэн болгодог.”

Хүн бие махбодын болон сэтгэлзүйн хэрэгцээг нь хангах гэр бүл, хань ижилгүй үед Бурханы хайрыг илүү ихээр мэдрэх боломжтой байдаг. Дуулал 73:25-26 зэрэг Бичвэрүүд нь сэтгэл санааны зовлон, бие махбодын уруу таталтын үед урам зориг өгдөг:

²³ Leslie Ludy, *Sacred Singleness*, 66-67.

Тэнгэрт Танаас гадна Хэн надад байгаа вэ? Танаас өөр юуг ч газар дээр би үл хүснэ. Бие махбод хийгээд зүрх минь бүтэлгүйтэж болох хэдий ч, Бурхан мөнхөд зүрхний минь хад хувь ногдол минь юм.

Лесли Лудигийн бичсэнээр,

Дуулаач Давид амьдралдаа олон эмэгтэй хамтрагчидтай байсан. Гэхдээ эдгээр шүлэгт дүрсэлсэн төгс сэтгэл ханамжийг түүнд *Бурхантай* харилцах дотно харилцаа нь авчирсан.²⁴

Ганц бие итгэгчийн хувьд Есүс хангалттай гэдгийг олж мэдэх болно. Бурхантай харилцах нь сэтгэл хангалуун байдлыг авчирдаг.

Үйлчлэх боломжууд

Гэрлээгүй итгэгчид Христ дотор сэтгэл хангалуун байдлаа олох үед, Тэр тэдний ганц бие байх амьдралыг бусдад үйлчлэх боломж болгодог. Өөрийн хэрэгцээнд анхаарлаа төвлөрүүлж, сэтгэл дундуур байхын оронд тэд бусдын хэрэгцээг анзаарч, хангахад суралцаж чадна. Бусдад туслах нь үр бүтээлтэй бөгөөд сэтгэл хангалуун амьдрах хамгийн сайн арга замуудын нэг юм. Амьдралын тухайн цаг хугацаанд хөгжсөн зан чанар нь тэднийг амьдралынхаа туршид сайн үр жимс ургуулахад туслах болно.

“Хэрэв та ганц бие бол, таны цаг хугацаа, эрх чөлөөтэй байдал нь өөртөө төвлөрсөн зорилгод бус, харин чуулган болон дэлхийд үйлчлэхэд зориулагдсан гэдгээ санаарай.”

- Paul Lamicela

► Суралцагчид Филиппой 2:3-4 ба Тит 3:8, 14 эшлэлийг бүлэгт уншина.

Өмнө дурдсанчлан, ялгаатай амьдралын нөхцөл байдлууд нь өвөрмөц боломжуудыг олгож байдаг. Амьдралын үе шат болгонд хүн хийж чадах зүйлс, хийж чадахгүй зүйлс гэж бий. Нэгэн ганц бие залуу эмэгтэй ганц бие амьдарсан учраас онцгойлон хийж чадах зүйлсийн жагсаалт гаргажээ. Бусад ганц бие эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд өөрсдийн жагсаалтад өөр зүйлсийг оруулах боломжтой.

Би ганц бие залуу эмэгтэй учраас дараах зүйлсийг хийх нь надад хамаагүй хялбар байдаг:

- Ахмад настай хүмүүсийнд зочилж, тэдэнтэй цагийг өнгөрүүлэх.
- Орон гэргүй хүмүүст хоол хийж үйлчлэх.
- Библийг гүнзгий судалж, хүүхдүүдэд Библийн хичээл бэлтгэх.
- Гэртээ эмэгтэйчүүд болон охидод үйлчлэх.
- Завсарлагагүйгээр зуучлан залбирал хийх.
- Шинэ ур чадварт суралцах.

²⁴ Leslie Ludy, *Sacred Singleness*, 67. Leslie Ludy was referring to Дуулал 16:11, Дуулал 73:25, and Дуулал 107:9.

- Урам зориг өгөх захидал, карт бичих.
- Бусад хүмүүсийн төсөлд сайн дураараа туслах.
- Онцгой хэрэгцээ, гэнэтийн зүйлс тохиолдоход хуваариа тэр дор нь зохицуулах.

Хүн бүр амьдралынхаа нөхцөл байдлаас шалтгаалан тодорхой боломж эсвэл үүрэг хариуцлагыг тээдэг. Бага насны хүүхдүүдтэй ээж хүний бичих жагсаалтад өөрийн хүүхдүүддээ зааж буй зүйлс эсвэл тэднийг хүмүүжүүлж буй аргуудын талаарх жишээнүүд багтаж болох юм. Тэдний ээж учраас Бурхан түүнд ийм байдлаар үйлчлэх боломж, хариуцлагыг өгсөн (Энэ хичээлийн төгсгөлд та өөрийн хувийн жагсаалтыг гаргах болно).

Нөхөрлөл

Гэрлээгүй хүмүүс бусадтай эрүүл харилцаа тогтоох нь маш чухал. Өмнөх хичээлүүдэд Бурхан хүмүүсийг өөртэй нь болон бусад хүмүүстэй харилцахын тулд бүтээсэн гэж бид сурсан.

- Ганц бие хүмүүст хүүхдүүд, залуучууд эсвэл ахмадуудад үйлчилж, мөн тэдэнтэй харилцах харилцаа хэрэгтэй.
- Ганц бие хүмүүст зөвлөгөө өгч, хариуцлагатай байх үүднээс ахимаг насны төлөвшсөн халамжлагчид хэрэгтэй.
- Ганц бие хүмүүст амьдралын ижил төстэй байдалд байгаа найзууд хэрэгтэй. Ингэснээр тэд Эзэн дотор бие биенээ урамшуулж, хамтдаа нөхөрлөж чадна.
- Ганц бие хүмүүс гэрлэсэн хосууд болон гэр бүлүүдтэй найз байх хэрэгтэй. Ийм нөхөрлөл дотор тэд харилцан бие биедээ ерөөл болдог.

Бусадтай олон төрлийн харилцаатай байх нь ганц бие хүнд үйлчлэх олон боломжийг олгодог. Нөхөрлөл нь ганц бие хүнд хэрэгтэй сэтгэл санааны болон сүнслэг дэмжлэгийн зарим талыг хангадаг. Нөхөрлөл нь тэдний гэр бүлийн хэрэгцээг нөхөхөд тусалдаг. Ялангуяа өөрийн гэр бүлийнхэнтэйгээ ойр амьдардаггүй хүмүүсийн хувьд тус дэм болдог.

Хоёр анхааруулгыг нэмэх ёстой:

1. Гэрлээгүй хүн сэтгэл санааны болон бие махбодын хэрэгцээнээс болж ухаалаг бус эсвэл ёс суртахуунгүй харилцаа тогтоохоос зайлсхийхэд анхаарах ёстой.
2. Ганц бие хүн Бурхантай харилцах харилцаагаа аливаа хүний харилцаанаас илүүд үзэх ёстой.

Бодлын амьдрал

Бүх итгэгчид Бурханы нигүүлслээр (Сургаалт үгс 4:23) өөрсдийн бодлын амьдралыг ариун байлгахын тулд хичээх ёстой. Дуулал 19:14 нь Бурханаас биднийг үг яриа, бодол санаагаар дамжуулан Түүний төлөө хэрхэн зөв болгоомжтой амьдрахад туслахыг гуйсан

залбирал юм. Энэ залбирал нь бид санаа зорилготой үг яриа, бодлынхоо төлөө Бурханы өмнө хариуцлагатай гэдгийг сануулдаг.

Бид оюун бодолдоо юу оруулах талаар (юу үзэх, сонсох, эсвэл унших) сонголт хийдэг (Филиппой 4:8). Хэрэв бид Бурханыг өргөмжлөхийг хүсвэл, ариун бөгөөд биднийг Түүнд ойртуулж, Түүнд дуулгавартай байхад туслах оюун бодлын хоол хүнсийг сонгох ёстой (Ром 12:2, Ром 13:14).

Христийн дагалдагчид бусдын адил нүгэлт зүйлсээр зугаацах ёсгүй (Дуулал 101:3, 1 Коринт 15:33). Ёс суртахуунгүй үйлдлийг үзэж зугаацах нь хэн нэгний нүгэлд оролцож буй явдал юм (Ром 1:32). Ийм зүйлийг үзэж, сонсох нь итгэгчийг нүгэлд мэдрэмжгүй болгож, Эзэнийг баярлуулах зорилгоо алдахад хүргэдэг (Сургаалт үгс 13:20). Бурханы Үг биднийг үргэлж Эзэнийг хүндлэх (Сургаалт үгс 23:17), мөн Түүнтэй адил хорон мууг үзэн ядах зэрэг хэрэгцээг онцолдог (Сургаалт үгс 8:13). Бид Эзэнээс эмээж, хорон муугаас эргэх үедээ ерөөгддөг (Дуулал 111:10).

Бид оюун бодолдоо юу оруулах, юуг бясалгах тухай Бурханы зааврыг зөрчсөн үедээ нүглээ хүлээж, эдгээр зүйлсийг хийхээ болих ёстой. Санамсаргүйгээр муу зүйл сонсох эсвэл харсан тохиолдолд ч, бид эдгээр зүйлсийн тухай бодлоо сайн, бурханлаг бодлуудаар зориуд орлуулах учиртай.

► Суралцагчид Дуулал 19:14, Дуулал 1:1-2, Филиппой 4:6-8, болон Ефес 5:25-27 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан бидний зүрх сэтгэл, оюун бодлыг хамгаалахыг хүсдэг бөгөөд харин бид зөв зүйлсийг зориуд бясалгах замаар Түүнтэй хамтран ажиллах ёстой талаар Филиппойн эшлэлүүд хэлдэг. Бичвэрийг бясалгах нь эрүүл, цэвэр ариун бодлын амьдралд маш чухал юм. Бурханы Үг биднийг цэвэрлэдэг хэмээн Ефес захидалд хэлсэн байдаг. Үүнд мэдээж бидний оюун санаа, бодлууд багтана.

► Бурханыг өргөмжилсөн бодол санаатай амьдрахад ямар үйл ажиллагаанууд танд тусалдаг вэ? Бодлын амьдралд тань тусалсан өөр ямар эшлэлүүд байдаг вэ?

Ганц бие байх болон бэлгийн харилцаа

*Хэрэв та энэ хичээлийг бүтэн курсээр бие даан судалж байгаа бол, бэлгийн цэвэр байдал болон ёс суртахууны асуудлуудыг агуулсан **4-р хичээлийг** мөн судлаарай.*

Дүгнэлт

Ганц бие байх нь итгэгчдэд Христтэй харилцах харилцаагаа өсгөх болон бусдад үйлчлэх өвөрмөц боломжуудыг олгодог. Гэрлээгүй хүмүүс бусадтай эрүүл харилцаа тогтоож байхдаа Христ дотор бүрэн дүүрэн байдлаа олж авдаг. Тэд ганц бие байх боломжуудыг Бурханы алдар ба Түүний хаанчлалын сайн сайхны төлөө ашиглах ёстой. Бурханы чухалчилдаг зүйлс итгэгчдэд гэрлэх боломжийн тал дээр сайн сонголт гаргахад нь тусалдаг.

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Амьдралын ганц бие он жилүүд, гэрлэх сонголт, болон гэрлэлтийг эрэлхийлэхтэй холбоотой шийдвэрүүдийг удирдан чиглүүлэх ёстой хэд хэдэн эрэмбэ дарааллыг нэрлэж, хэлэлцээрэй.
- ▶ Танай чуулган ганц бие гишүүддээ хэрхэн илүү үр дүнтэй үйлчилж чадах вэ?
- ▶ Танай гэр бүл ганц бие хүнтэй хэрхэн найзалж чадах вэ?
- ▶ Хэрэв та ганц бие бол, чуулганы гэр бүлдээ хэрхэн хувь нэмэр оруулж чадах вэ? Амьдралын үе шат, янз бүрийн настай бусад хүмүүст хэрхэн ерөөл болж чадах вэ?
- ▶ Энэ хичээлийн ямар санаанууд танд шинэлэг байсан бэ?
- ▶ Энэ хичээл дээр өөр юуг хэлэлцээсэй гэж та хүссэн бэ?
- ▶ Энэ хичээлийн ойлголтуудыг амьдралын бусад үе шатанд хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцээрэй.

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Амьдралын үе шат бүрд бидэнд итгэмжит байсанд талархъя. Таны оршихуйд амьдарч, ганц бие он жилүүддээ таныг алдаршуулсан хүмүүсийн үлгэр дуурайлыг өгдөгт баярлалаа.

Амьдралынхаа туршид танд бүрэн буулт хийж, захирагдахад туслаач. Тантай харилцах харилцаанаас ирэх бүрэн дүүрэн байдлыг эрэлхийлж, олоход бидэнд туслаач. Амьдралынхаа энэ цаг хугацаанд таны өгсөн боломжуудыг ашиглахад бидэнд туслаач.

Сонголт, бодол санаа, бусадтай харилцах харилцаа, үйлчлэлээрээ таныг үргэлж өргөмжилж чадахад бидэнд туслаач. Таны алдрын төлөө биднийг үр жимстэй байлгаач.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Есүс танаас өөрийн төлөвлөгөөнд нь буулт хийхийг хүссэн нөхцөл байдлын талаар бодож үзнэ үү. Хамгийн багадаа хоёр догол мөрөнд нөхцөл байдал болон түүнд хандах хариу үйлдлээ тодорхойлж бич (Энэ нь одоогийн эсвэл таны өнгөрсөн үеийн нөхцөл байдал байж болно). Таны итгэл хэрхэн шалгагдсан бэ? Эзэн таныг хэрхэн удирдсан бэ? Та Түүний төлөвлөгөөнд буулт хийсэн үү? Та Түүнд юу гэж хэлсэн бэ? Энэ нөхцөл байдалд таны дуулгавартай байдал хэрхэн харагдсан бэ?

(2) Гэр бүлийн байдал, хүйс, амьдралын нөхцөл байдлын **улмаас** танд ямар боломжууд байна вэ? Одоохондоо хийж **чадахгүй** зүйлсийн талаар битгий бодоорой. Харин Бурхан таныг одоо хаана байлгаж байгаагаас шалтгаалж, хийж чадах зүйлсээ жагсаахад хэдэн минут зарцуулаарай. "Би _____ учраас надад... хийх боломж байна" гэж бичээрэй.

(3) Хичээлийн сүүлийн хэсэгт дурдагдсан доорх Бичвэрүүд тус бүрийг уншиж, бясалгаарай. Таны бодлын амьдралыг цэвэр, Түүнд таалагдсан байлгахын тулд өөрчлөх шаардлагатай аливаа зүйлийг Бурхан харуулахыг гуйгаарай. Гэмшлийн залбирал болон дуулгавартай байх амлалтаа бичнэ үү.

- Дуулал 1:1-2
- Дуулал 19:14
- Дуулал 101:3
- Дуулал 111:10
- Сургаалт үгс 4:23
- Сургаалт үгс 8:13
- Сургаалт үгс 13:20
- Сургаалт үгс 23:17
- Ром 1:32
- Ром 12:2
- Ром 13:14
- 1 Коринт 15:33
- Филиппой 4:6-8

(4) 3-р даалгавраас гурван эшлэлийг сонгож цээжлээрэй. Дараагийн хичээлийн эхэнд эшлэлүүдээ цээжээр унших эсвэл бичээрэй.

6-р хичээл

Гэрлэлтэд бэлтгэх нь

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Хань ижлээ ухаалгаар сонгохын ач холбогдлыг ойлгох.
- (2) Библийн эрэмбэ дараалал болон зарчмуудад тулгуурлан, итгэгч хүн хань болоход тохирох хүнээ тодорхойлох.
- (3) Хүүхдүүдээ гэрлэхээс өмнө Библийн зарчмуудыг эцэг эхийн үүрэг, оролцоондоо хэрэгжүүлэх.
- (4) Гэрлэхээс өмнөх нөхөрлөлдөө ухаалаг шийдвэр гаргах.

Рут ба Самуел

Рут Энэтхэг улсын Христэд итгэгч гэр бүлд өсөж торнижээ. Нэгэн өдөр гэр бүлийнхэн нь түүнд эхнэр хайж байгаа залуу номлогч Самуелын талаар ярихад тэд мөн Самуелтай түүний талаар ярилцжээ. Рут түүнтэй уулзахыг хүсэхгүй байгаагаа хэлэв. Нэгэн орой тэр гэртээ ирэхэд Самуел түүнтэй уулзахаар хэдэн цаг хүлээж байсныг олж харав. Рут түүнийг хараад таагүй байсан ч, түүнийг яриулахын тулд суув. Самуел: "Би Библийн сургуулийн багш. Надад их цалин төлдөггүй. Би мөн хүнд хэцүү газруудаар явж сайнмэдээ номлодог, заримдаа гадаа хоноглодог. Чи надтай хамт зовоход бэлэн үү?" гэж хэлэв. Рут түүнийг ярихад үйлж эхлэв. Учир нь Бурхан түүнд энэ бол түүний гэрлэх ёстой хүн гэдгийг хэлж байгаа мэт санагджээ. Энэ ярианаас хойш тэд хуримаа хийх хүртэл ховорхон уулзсан бөгөөд ганц ганцаараа уулзаагүй юм. Харин тэд одоо олон жил хамтдаа үйлчилсээр байна.

Ханиа сонгох

Няхуур сонго!

Есүс гэрлэлтийг Бурханы тогтоосон насан туршийн зориулалт гэж хэлсэн байдаг (Матай 19:6-8). Та зөвхөн энэ цаг мөчийн төлөө л хэн нэгэнтэй гэрлэж байгаа хэрэг биш. Та хоёрын хэн нэг нь нас барах хүртэл насан туршийн хамтрагчаа сонгож байгаа юм (Ром 7:2). Ухаалаг сонголт хийгээрэй!

Та хоёр зөвхөн амьдралын сайхан цаг үе, баяр баясгалангаа хуваалцахгүй. Харин хамтдаа амьдралын бэрхшээл, зовлон, хямрал, хагацлыг ч хуваалцах болно. Та ямар төрлийн уй гашуутай тулгарахыг мэдэхгүй. Хүнд хэцүү цаг үед сайн, бурханлаг ханьтай байх нь маш их ерөөл юм. Гэхдээ Эзэн дотор бат зогсдоггүй ханьтай байвал хэцүү цаг

үе илүү хүнд болдог. Та бүх амьдралынхаа туршид, бүхий л нөхцөл байдалд хамт байх нэгэнтэй гэрлэж байгаа юм. Ханиа няхуур сонгоорой!

Та хамтдаа гэр бүлээ босгох хүнтэй гэрлэж байна. Та хүүхдүүдийнхээ эцэг эхийг, мөн үр удмынхаа өвөө эмээг сонгож байна. Таны сонгох хүний сүнслэг амьдрал таны хүүхдүүдийн сүнслэг амьдралд маш ихээр нөлөөлөх болно. Таны хүүхдүүд зан чанар, дадал зуршил, үйлдлүүдийг нь даган дуурайх хүнийг сонгож байна (Ефес 5:1). Таны хүүхдүүдийг үлгэр дуурайл, үг яриагаар хэлбэржүүлж, сургах нэгнийг та сонгож байна (Сургаалт үгс 23:26). Хүүхдүүдээ хайрлаж, эрхэмлэх, анхааралтай, хичээнгүй, хайраар удирдан, сахилга батыг заах нэгнийг та сонгоорой. Та үе дамжин нөлөөлөх (сайн эсвэл муугаар) хүнийг сонгож байна. Сонголт тань мэргэн байх болтугай!

“Та гэр бүлээ сонгож төрөөгүй. Харин дараагийн гэр бүлээ бүтээх хүнийг сонгох боломжтой.”

- Gary Thomas, *The Sacred Search*

► Суралцагчид Сургаалт үгс 14:1, Сургаалт үгс 24:3-4 болон Сургаалт үгс 31:10-12, 30 эшлэлийг бүлэгт уншина.

Гэр бүлийн хүнээ сонгох нь амьдралдаа хийх таны хоёр дахь чухал шийдвэр юм. Эхнийх нь Есүсийг өөрийн Эзэн, Аврагчаар хүлээн авах сонголт юм. Таны сонголт амьдралын тань зам харгуйг өөрчлөхөөс гадна бусад олон хүнд нөлөөлдөг. Ухаалаг сонголт нь таныг болон бусад олон хүнийг ерөөх болно. Ухаангүй сонголт нь танд болон бусад олон хүмүүст хор хөнөөл учруулна. Залбиралтайгаар сонгоорой!

Дэлхий дээр төгс хүн гэж байдаггүй. Та ч гэсэн асуудал, сул тал, алдаа дутагдалтай. Таны хань мөн төгс бус байх бөгөөд амьдралын туршид төгс бус хэвээр байх болно. Тиймээс төгс хань хайх хэрэггүй. Харин Бурханыг болзолгүй хайрладаг хань хайгаарай. Алдаагаа хүлээн зөвшөөрч, засаж чадахуйц хангалттай даруу хүнийг хайгаарай. Ийм хань танд ерөөл байх болно. Мөн та хоёр бие биенийхээ сул талыг нөхөж, дэмжин тусалж чадна.

► Суралцагчид Сургаалт үгс 11:14, Сургаалт үгс 12:15, Сургаалт үгс 13:18 болон Сургаалт үгс 23:22 эшлэлийг бүлэгт уншина.

Ухаалгаар сонго. Насан туршид хамт байх нэгнийг сонго. Бурханлаг хүмүүс болон эцэг эхээсээ зөвлөгөө ав. Тэдний анхааруулгыг сонсоорой. Зөвхөн өөрийн сэтгэл хөдлөлийг бүү сонс. Энэхүү сонголт таны хайхрамжгүй байдалтай зүйрлэшгүй чухал юм.

Итгэгч биш хүнтэй бүү гэрлэ

Бурханы хувьд маш чухал зүйлсийн нэг бол Түүний хүмүүс зөвхөн итгэл нэгтэй хүмүүстэй гэрлэх явдал юм. Учир нь Бурхантай харилцах харилцаа нь бүх амьдралын туршид болон мөнхөд хамгийн чухал нь юм. Хүмүүний бүх харилцаануудаас хамгийн ойр дотно нь гэрлэлт бөгөөд энэ нь хүний Бурхантай харилцах харилцаанд нөлөөлдөг. Итгэгч хүн итгэгч биш ханьтай бол Бурхантай ойр, нягт харилцаагаа хадгалахад илүү хэцүү болдог.

Цаашилбал, эцэг эхийн үл итгэх байдал нь хүүхдүүд нь Христийн эсрэг байхад ихээхэн нөлөөлдөг. Эцэг эхийн нэг нь итгэгч бус гэр бүлд бүх хүүхдүүд нь Эзэнд үйлчлэх тохиолдол маш ховор байдаг. Бурхан биднийг өөрт нь үйлчлэхийг хүсдэг бөгөөд Тэр биднийг хүүхдүүдээ өөрт нь үйлчлэгч байхаар өсгөхийг сануулж хэлсэн байдаг (Эхлэл 18:19; Дэд хууль 6:2, 7; Малахи 2:15).

Хуучин гэрээнд израилчуудыг итгэлийн гэр бүлээс гадуур хэнтэй ч гэрлэхийг зөвшөөрдөггүй байсан.²⁵ Бурхан итгэгч биш хүмүүстэй гэрлэх нь хүмүүсийг өөр бурхдыг шүтэхэд хүргэж, цорын ганц үнэн Бурхантай харилцах харилцааг нь сүйрүүлнэ гэдгийг мэдэж байсан! Хуучин гэрээнд Израилд яг тийм зүйл тохиолдсоныг бид хардаг.²⁶

Өнөө цагт ч гэсэн итгэгч хүн зөвхөн итгэгч хүнтэй л гэрлэх ёстой. Энэ тал дээр бүү буулт хий. Итгэгч биш хүнтэй байгаа романтик харилцаагаа бүү өмөөр.

► Суралцагчид 2 Коринт 6:14-18 болон 1 Коринт 7:39 эшлэлийг бүлэгт уншина.

Хань нь итгэгч биш бол

Бурхан гэрлээгүй итгэгчийг итгэгч биш хүнтэй гэрлэхийг хүсдэггүй. Энэ нь тодорхой. Гэхдээ итгэгч биш гэр бүлийн хэн нэг нь авралын төлөө Христ дээр ирэх үед, хань нь түүнтэй үлдэхээс татгалзахгүй л бол тэр хүн аврагдаагүй ханьтайгаа гэрлэсэн хэвээр үлдэх ёстой (1 Коринт 7:12-16). Зарим тохиолдолд, итгэгч биш хань нь Христэд итгэсэн нөхөр эсвэл эхнэрийнхээ итгэлийн улмаас аврагдсан байдаг (1 Коринт 7:14, 16; 1 Петр 3:1-2). Гэхдээ Христэд итгэгч ганц бие хүмүүс итгэгч биш хүнтэй гэрлэх тухай хэзээ ч бодож болохгүй.

Ирээдүйн ханийнхаа талаар бодолцох зан чанарууд

Гэрлэлтэд бэлтгэхдээ хувь хүмүүс сайн хань байхад туслах зан чанаруудыг хөгжүүлэх ёстой. Гэрлэх хүнээ хайхдаа тэдгээр ижил төстэй зан чанарууд дээр өсөж буй хүнийг хайх учиртай.

1. Түүний Христтэй харилцах харилцаа нь таны Христтэй харилцах харилцааг урамшуулж, сүнслэгээр өсөхөд тань туслах тийм хүнтэй гэрлэ (2 Петр 1:5-9, 2 Петр 3:18).

2. Сайн зан чанартай хүнтэй гэрлэ. Ефес 5:33 эшлэлд эхнэрүүд нөхрийнхөө зан чанараас үл хамааран түүнийг хүндлэхийг тушаасан байдаг. Гэхдээ хүндлэхүйц эрэгтэйтэй гэрлэсэн үед үүнийг хийх нь хамаагүй хялбар юм. Сайн зан чанар нь уучлах чадвар, өөрийгөө хянах чадвар, даруу байдал, хичээнгүй,

Эрэгтэй болон эмэгтэй хүн аль аль нь чин сэтгэлээсээ "Ганц бие байснаас илүү чамтай гэрлэснээр Эзэнд илүү сайн үйлчлэх болно" гэж хэлж чадах хүртлээ бие биедээ гэрлэлтийн амлалт бүү өг."

²⁵ Гэтлэл 34:11-16, Дэд хууль 7:1-6, Иошуа 23:11-13, Езра 9-10

²⁶ Шүүгчид 3:5-7, 1 Хаад 11:1-6, Езра 9:10-15

хариуцлагатай байх, суралцах хүсэлтэй байх зэрэг үйлдлүүдийг агуулдаг. Таны гэрлэх хүн төгс биш ч эдгээр үйлдлүүдээр өссөөр байх ёстой. Бурхан чуулганы удирдагчид болон тэдний эхнэрүүдэд өндөр шаардлага тавьдаг (1 Тимот 3:2-4, 8-9, 11-12; Тит 1:6-8). Хэрэв чуулганы удирдагч муу зан чанартай хань ижилтэй бол, үйлчлэлд нь ихээхэн саад болдог.

3. **Цэвэр ариун ба сайн зан байдлын төлөө нэр хүндээ бүтээж буй хүнтэй гэрлэ** (1 Тимот 2:9-10, 1 Тимот 3:7, 2 Тимот 2:19, Тит 1:15, Тит 2:4-5).
4. **Библийн дагуу бодоход суралцаж буй хүнтэй гэрлэ** (Дуулал 119:66). Уруу таталт, айдас, буруу хандлага эсвэл буруу сэдэл зэрэг тулгарах үед тэд Бурханы Үгийг санаж, итгэж, дуулгавартай байхад суралцаж байдаг (Сургаалт үгс 4:4-6, Иошуа 1:7-8). Хэрэгцээ, аюул, зовлон, эсвэл аливаа төрлийн бэрхшээлтэй тулгарах үед тэд Бурханд төвлөрч, Түүний Үгээс хэрэгтэй тусламжаа олоход суралцсаар байдаг (Дуулал 119:50, 92, 114).
5. **Таны хүүхдүүдэд сайн эцэг эсвэл эх болох хүнтэй гэрлэ:** хүүхдүүддээ Бурханы замуудыг зааж, тэдний өмнө тогтвортой христитгэлийн амьдралаар амьдрах хүн (Сургаалт үгс 6:20-23, Ефес 6:4, 2 Тимот 1:5, 2 Тимот 3:14-15).
6. **Бурханлаг найз нөхөд, халамжлагчдаар хүрээлүүлэхийг сонгодог хүнтэй гэрлэ** (Дуулал 119:63, 2 Тимот 2:22).
7. **Эрх мэдэлд захирагддаг хүнтэй гэрлэ.** Эр хүн өөрт нь захирагддаг эмэгтэйг эхнэрээ болгохоор хайх нь ухаалаг хэрэг юм (Ефес 5:22). Эмэгтэй хүн мөн адил Бурханд болон Бурхан түүнийг захирагдахаар чуулганд, ажилд, засгийн газарт тавьсан эрх мэдэлтнүүдэд захирагддаг хүнтэй гэрлэх ёстой (Ром 13:1, Ефес 6:5-8, Еврей 13:17, 1 Петр 5:5). Нөхөр нь Бурханд захирагдах үед тэрээр хамгаалагдаж, ерөөгдөх болно.

► Дээр дурдсан шинж чанаруудаас аль нь танд хамгийн чухал санагдаж байна вэ? Эдгээр шинж чанаруудын ач холбогдлыг харуулсан ямар жишээг та харж байсан бэ?

Эцэг эх нь зуучлах гэрлэлт

Олон соёлд эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ гэрлэлтийг зуучилж зохион байгуулдаг нь хэвийн үзэгдэл юм. Жишээлбэл, аль нэг улс оронд эцэг эхчүүд хүүхдэдээ боломжит хань сонгохоор, нөгөө талын эцэг эхтэй нь ярилцаж тохирдог. Үүнийхээ дараа тэд ихэвчлэн хүү, охин хоёрыг уулзуулах ажлыг зохион байгуулдаг. Залуучууд гэрлэх эсэх талаар шийдвэр гаргахаасаа өмнө нэг, эсвэл хоёр, гурван удаа уулздаг. Хүүхдүүдийнх нь хувьд эцэг эхийн сонгосон хүнийг хүлээн авах эсэхээ сонгох боломж олгогддог ч, тэд бие биенээ сайн таньж мэдэх цаг хугацаа олддоггүй.

Эдгээр соёлд амьдардаг христитгэлт эцэг эхчүүд хүүхдүүддээ ирээдүйн хань хайхдаа Библийн үнэт зүйлсийг дагах ёстой. Тэд хүүхдүүддээ бурханлаг, ухаалаг, төлөвшсөн хань хайх учиртай. Тэд амьдралдаа Бурханыг нэгдүгээрт тавьж буй хүнийг хайх ёстой.

Эдгээр зүйлс нь эцэг эхийн сонголтод хэн нэгний боловсрол, мэргэжил, нийгмийн байдал, эсвэл санхүүгийн түвшнээс илүү нөлөөлөх ёстой.

Бие даан шийдвэрлэх гэрлэлт

Эцэг эхчүүд хүүхдүүддээ ханиа сонгоход нь туслах ухаалаг зөвлөгөө

Зарим нийгэм, соёлд, түүний дотор Европ, Хойд Америкийн соёлд залуучууд эцэг эхийнхээ чиглүүлэггүйгээр өөрсдөө ханиа сонгох нь түгээмэл байдаг.

Эдгээр соёлд амьдардаг христитгэлт эцэг эхчүүд нас биенд хүрсэн, хань ижлээ хайж буй хүүхдэдээ нөлөөлөх боломжгүй эсвэл нөлөөлөх ёсгүй гэж бодож болох юм. Эцэг эхчүүд хүүхдийнхээ гэрлэхээр тооцож буй хүнийг зөвшөөрөхгүй байсан ч эсэргүүцэх ёсгүй гэж бодож магадгүй. Тэдний шүүмжлэл нь ирээдүйд хүүхэд болон бэр/хүргэнтэйгээ харилцахад асуудал үүсгэнэ гэж болгоомжилж ч байж болох юм.

Хэдийгээр христитгэлт эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ гэрлэлтийг зуучилж зохион байгуулдаггүй ч, хүүхдүүд нь ханиа сонгоход тэд нөлөөлөх учиртай. Эцэг эхчүүд эдгээр зүйлсийн талаар хүүхдүүддээ бага байхад нь ярилцах хэрэгтэй. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сэтгэлгээ болон үнэт зүйлсийг зорилготойгоор чиглүүлж хэлбэржүүлэх ёстой (Дэд хууль 6:5-9). Эцэг эхийн хувьд та үүнийг хэрхэн хийх вэ?

- 1. Өөрөө бурханлаг хань, эцэг эхийн сайн үлгэр дуурайл байгаарай.** Хэрэв та өөрөө Бурханы зарчмуудыг амьдралдаа дагаж мөрдөхгүй бол, хүүхдүүддээ хэлэх үгэн заавар тань юу ч биш болно. Хэрэв таны үлгэр дуурайл хэлсэн үгтэй нь таарахгүй бол, таны хүүхдүүд үгийг тань бус, харин үлгэр дуурайлыг нь сонсох болно.
- 2. Амьдралын зорилго, гэрлэлтийн зорилго ба утга учир, мөн ханиа сонгох шалгуур зэрэгт Бурханы хэм хэмжээг онцол** (Дуулал 34:11-12). Бид дэлхийн хэм хэмжээг үзэж, сонсож, уншиж, эсвэл харахдаа, Бурханы Үг бидний үлгэр дуурайл байхын оронд дэлхий бидний үлгэр дуурайл гэдгийг хүүхдүүддээ зааж байдаг. Үүний оронд бид Бурханы сайн төлөвлөгөөг дагадаг хүмүүст анхаарлаа хандуулж, хүүхдүүддээ бурханлаг хүсэл тэмүүллийг төлөвшүүлэх ёстой. Ийм хүмүүсийн Бурханд дуулгавартай байсны улмаас эдэлдэг сайн үр дагавруудыг бид зааж өгөх учиртай.
- 3. Ханиа сонгохдоо зан чанар нь юу юунаас илүү чухал гэдгийг хүүхдүүддээ заа.** Бага наснаас нь эхлэн хүүхдүүддээ бусдын гадаад төрх эсвэл хувийн араншингаас илүүтэйгээр сайн зан чанарыг анзаарч, үнэлэхийг заагаарай. Тэдний үе тэнгийнхэн хариуцлагатай эсвэл залхуу, дуулгавартай эсвэл тэрслүү, шударга эсвэл мэхлэгч эсэхийг анзаарч сургаарай. Гадаад төрхөөсөө илүү өөрсдийн зан чанартаа анхаарахыг тэдэнд зааж өг.

Хэрэв эцэг эхчүүд хүүхдүүд нь нас биенд хүрээд амьдралын ханиа сонгох үедээ өөрсдийг нь хүлээн зөвшөөрөхийг хүсвэл, хүүхдүүддээ бага байхад нь эцэг эхээ сонсох

нь ухаалаг хэрэг гэдгийг заах ёстой! (Сургаалт үгс 1:8.) Өсвөр нас эсвэл насанд хүрэх үе нь үүнийг заахад хэтэрхий оройтсон байдаг. Эцэг эхчүүд хүүхдүүдээ бага байхад нь үүнийг заах хэрэгтэй (Сургаалт үгс 4:3-9). Бурханлаг эцэг эхээ сонсох нь хүүхдүүдийн хувьд хамгаалагдаж, ерөөгдөх Бурханы арга зам юм.

4-р хичээл дээр үзсэнчлэн, хүүхдүүд нь харилцаандаа ёс суртахууны цэвэр байдлыг хадгалахад эцэг эхчүүд тусалж, Бурханы өмнө хариуцлага хүлээдэг. Үүнийг хийхийн тулд та хүүхэдтэйгээ хэдийн сайн, нээлттэй харилцааг тогтоосон байх хэрэгтэй бөгөөд тэд сайн дураараа танд хариуцлагатай байж, зөвлөгөөг тань хүлээн авдаг. Ийм төрлийн харилцааг хүүхдээ бага байхаас нь та өдөр бүр нягт нямбайгаар зааж, сургаж, удирдаж, сахилгажуулснаар бий болгодог.

Залуу хүн ханиа сонгох мэргэн ухаан

Гэрлэлтийн тал дээр өөрсдөө шийдвэр гаргах ёстой залуу итгэгчдэд Бурхан мэргэн ухааныг зөвлөдөг. Сайн шийдвэр гаргахад туслах ухаалаг зөвлөгөө энд байна:

(1) Библийн дагуу биш сонголтуудаас татгалз.

Жишээлбэл, итгэгчид итгэгч биш хүмүүстэй гэрлэх нь Бурханы хүсэл биш гэдгийг бид мэднэ. Тиймээс бид итгэгч биш хүнтэй романтик харилцаа тогтоох талаар бодох ч ёсгүй.

(2) Мэргэн ухааны төлөө залбир (Сургаалт үгс 2; Иаков 3:13, 17).

Бид Бурханы ойлголтыг бүх зүрхээрээ эрэлхийлэх үед Тэр бидэнд мэргэн ухааныг баяртайгаар өгдөг. Бурханы Үгийг няхуур судалж, дуулгавартай байснаар мэргэн ухааныг олж авдаг. Түүнчлэн бурханлаг хүмүүсийн зөвлөгөөгөөр дамжуулан Бурхан бидэнд мэргэн ухааныг өгдөг. Бурханы мэргэн ухааныг хүлээн авах нь биднийг нүгэл болон хор хөнөөлөөс хамгаалдаг. Түүний мэргэн ухаан биднийг ерөөж, бидний амьдралд зориулсан Бурханы хамгийн сайн төлөвлөгөөг мэдэж амсах боломжийг олгодог. Хамгийн чухал нь, бид мэргэн шийдвэр гаргах үедээ тэнгэрлэг Эцэгээ алдаршуулдаг.

(3) Ариун Сүнсний удирдамжийг дага (Дуулал 119:133, Сургаалт үгс 3:5-7, Иеремиа 10:23).

Ариун Сүнс биднийг Бурханы Үгэнд дуулгаваргүй байхад хэзээ ч удирдахгүй. Харин ч Тэр бидэнд үүнийг итгэмжтэйгээр сануулсаар байдаг (Иохан 14:26, Иохан 16:13-14). Тэрээр Бурханд дуулгавартай хүүхдүүдийг нүглээс хамгаалж, тэднийг амь ба амар тайвнаар шагнадаг (Ром 8:5-6, 13-14; Галат 5:16, 22-25). Та нөхцөл байдал болгон дээрх Бурханы хүслийн нарийн ширийн зүйлсийг үргэлж мэдэхгүй байж болно. Гэхдээ та тодорхой мэддэг зүйлээ дагах ёстой. Бурхан таныг сүнслэг байдал болон ёс суртахууны хувьд итгэмжит байхыг хүсдэг гэдгийг та мэддэг. Тэр таныг тодорхой зүйлсээс зайлсхийж, тодорхой зүйлсийг дагахыг хүсдэг гэдгийг та мэднэ. Бурханаас удирдамжийг асуун залбирахдаа зөв гэж мэддэг зүйлээ хийгээрэй.

(4) Бурханлаг хүмүүсийн зөвлөгөөг анхааралтай сонс.

Бурханлаг эцэг эхтэй залуучууд тэдний мэргэн ухааныг эрэлхийлэх ёстой. Тэд гэрлэлтийн талаарх бодлоо эцэг эхтэйгээ илэн далангүй, үнэнчээр хуваалцах хэрэгтэй. Тэд эцэг эхийнхээ санааг зовоосон аливаа асуудалд анхааралтай хандах ёстой. Бурхан тэднийг хор хөнөөлөөс хамгаалж, сайн сайхныг өгөхөөр эцэг эх заяасан юм. Залуучууд эдгээр арга замаар ерөөгдөх боломжоо бүү орхигдуулаарай.

Олон христитгэлт залуучууд гэр бүлийнхээ ахимаг насны бурханлаг хүмүүсийн зөвлөгөөг сонсдоггүй. Мэдээж, бурханлаг зан чанартай, сайн үр дүнтэй ухаалаг шийдвэр гаргах чадвараа харуулсан хүмүүсээс зөвлөгөө авах ёстой нь үнэн.

Гэсэн хэдий ч, эцэг эх нь Эзэнд үйлчилдэггүй байлаа ч залуучууд тэдний зөвлөгөөг үл тоомсорлож болохгүй. Зарим тохиолдолд залуу хүн Бурханд дуулгавартай байхын тулд аврагдаагүй эцэг эхийнхээ хүслийн эсрэг явах шаардлагатай болдог. Гэхдээ үүнийг хэзээ ч тэрслэл (1 Самуел 15:23) эсвэл үл хүндэтгэх (Гэтлэл 20:12) байдлаар хийх ёсгүй юм.

Эцэг эхийн Бурханд зориулсан амьдралаас үл хамааран, Бурхан тэдний зүрх сэтгэлийг зөөлрүүлж, хүүхдийнхээ гэрлэлтийг ерөөх чадвартай болгодог. Эцэг эхийнхээ зүрх сэтгэлийг өөрчлөхийг Бурханаас гуйж, хүлээх нь тэрхүү хүү эсвэл охины итгэлийг шалгаж, бэхжүүлдэг.

► Гэрлэх шийдвэрт эцэг эхийн оролцооны талаарх Бичвэрийн зарчим, жишээг хэлэлцээрэй. Эцэг эхчүүд хүүхдийнхээ ханиа сонгох үйл явцад нөлөөлөхийн тулд юу хийх ёстой вэ? Итгэгч нас биенд хүрсэн хүн гэрлэх шийдвэрийнхээ тал дээр эцэг эхтэйгээ харилцах хандлага нь ямар байх ёстой вэ?

Гэрлэхээс өмнөх хосуудын нөхөрлөл

Хэрэв гэрлэхээс өмнө хугацаа байгаа бол, эрэгтэй, эмэгтэй хүн янз бүрийн орчинд бие биетэйгээ цагийг өнгөрөөх нь хамгийн сайн юм. Энэ нь тэдэнд нөгөө хүн хэрхэн биеэ авч явдаг, бусадтай хэрхэн харилцдаг, гэнэтийн нөхцөл байдалд хэрхэн ханддаг, өөр өөр нөхцөл байдлыг хэрхэн зохицуулдаг талаар таньж мэдэхэд нь тусалдаг. Хамтдаа өнгөрөөх энэ хугацаа тэдэнд гэр бүл байхад тохиромжтой эсэхээ ойлгоход тусална.

Цэвэр ариун байдлын төлөөх үүрэг амлалт

► Суралцагчид 1 Тесалоник 4:1-8 болон 2 Тимот 2:19-22 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан эрэгтэй, эмэгтэйчүүдийг бие махбодын болон сэтгэл санааны дотно харилцааны хүсэл, чадавхтайгаар хайрлан бүтээсэн. Эдгээр хүсэл тэмүүллийн улмаас, ирээдүйд гэрлэхээр ярьж буй найзуудын хувьд бие биетэйгээ харилцах харилцаандаа болгоомжтой хандах ёстой. Бурхан эдгээр хүсэл тэмүүллийг онцгой, насан туршийн гэрлэлтийн гэрээний хүрээнд биелүүлэхийг зорьдог.

Хэрэв эрэгтэй, эмэгтэй хүн зориудаар өөрсдийгөө болгоомжтой, цэвэр ариун байх шийдвэртэй байлгахгүй бол тэд уруу таталтын үед өөрсдийн сэтгэл хөдлөлөө дагаж, Бурханд дуулгаваргүй байх боломжтой. Ёс суртахууны цэвэр байдлын талаарх Бурханы шаардлагыг үл биелүүлэх нь олон талаараа хор хөнөөлтэй бөгөөд зөвхөн эр, эм хоёрт төдийгүй олон хүнд нөлөөлдөг. Дуулгаваргүй байдал нь харамсал, хүлээс, гэм буруу, ичгүүр, айдас, үл итгэлцэл, эвдэрсэн харилцаанд хүргэдэг.

Цэвэр ариун байдлын талаарх Бурханы төлөвлөгөөг дагадаг хүмүүст олон ерөөл бий. Дуулгавартай байдлаараа Бурханыг өргөмжилдөг хүмүүс Түүний тэдэнд зориулж төлөвлөсөн бүх сайн сайхныг амсаж туулах боломжтой. Дуулгаваргүй байдлын үр дагаврын оронд тэд баяр хөөр, амар тайвныг хүлээн авдаг. Тэд бие биедээ итгэж чадна. Тэд Эзэнтэй болон бие биетэйгээ баялаг харилцаанд байх болно.

Бурханд дуулгавартай байна гэдэг нь Тэр таны төлөө хамгийн сайныг хүсдэг бөгөөд түүнийг мэддэг гэдэгт нь итгэж найдахыг хэлнэ.
(Сургаалт үгс 3-р бүлгийг үз)

Эдгээр ерөөлүүд нь цэвэр ариун байдлын талаарх Бурханы төлөвлөгөөг дагах хүчтэй сэдэл болдог. Гэсэн хэдий ч, энэ тал дээр болгоомжтой байх итгэгчдийн хамгийн том сэдэл нь амьдралынхаа бүх талбарт Эзэн Есүсийг дээдлэх хүсэл байх ёстой. Үерхэж буй хосууд "Бид харилцаандаа Бурханыг хэрхэн **хамгийн сайнаар** дээдэлж чадах вэ? Бид Есүсийг хэрхэн **хамгийн ихээр** алдаршуулж чадах вэ?" гэж асуух учиртай.

Цэвэр бус үйлдлээс зайлсхийхийн тулд үерхэж буй хосууд биеэр ойртох харилцаандаа болгоомжтой байх ёстой. Юу хийж байгааг чинь мэдэх боломжгүй газар, удаан хугацаагаар хоёулхнаа хамт цагийг өнгөрөөхөөс зайлсхийх ёстой. Биеэр ойртож дотносох нь ердийн харилцаанаас нь илүү чухал болох үед хосууд уруу татагдаж эхэлдэг. Тэдний бодол санаа, зүрх сэтгэл нь бие махбодын хүслээр давамгайлж байгаа учраас сүнслэг болон харилцааны асуудлуудыг сайн шийдвэрлэх чадваргүй болж болох юм. Гэрлэлтээс өмнөх харилцаандаа юу хийх (мөн юу хийхгүй) талаар тодорхой зүйлсийг хамтдаа шийдээрэй. Таны төлөвлөгөө нь та хоёрыг нүглээс хамгаалж, ирээдүйн ханиа хайрлахад тусалж, Бурханыг дээдлэх боломжийг олгох ёстой. Төлөвлөгөөндөө үнэнч байгаарай. Бурханлаг халамжлагч нарын өмнө хариуцлагатай байж, тэдний зөвлөгөө, анхааруулгыг сонсоорой. Бурханлаг найз нөхөд, гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа цагийг өнгөрөө.

Өнөөдөр таны өөрийгөө хянах чадвар ирээдүйн ханьдаа өгөх бэлэг юм. Таны хань Бурханд дуулгавартай байх таны сонголтоос болж хамгаалагдаж, хүндлэгдсэнээ мэдэрдэг. Хань тань маш их хайрлагдсанаа мэдэрдэг.

Өсөлтийг дэмжих үйл ажиллагаанууд

Үерхэх үе бол бие биенээ таньж мэдэх цаг үе боловч, энэ нь мөн өсөлтийн цаг үе байх ёстой. Үерхэж буй хосын хамтдаа хийж болох үйл ажиллагааны зарим санаа энд байна:

- Ажлын төслүүд хийх.
- Хэн хэнийх нь хувьд шинэ ур чадварт суралцах.

- Сайн ном уншиж, хэлэлцэх.
- Библийн эшлэлүүдийг зэрэг судлах эсвэл цээжлэх, дараа нь хэлэлцэх.
- Үйлчлэлийн үйл ажиллагааг хамтдаа төлөвлөж, гүйцэтгэх.
- Хамт жаахан хүүхдүүдийг харалцах.
- Бие биенийхээ гэр бүлтэй цагийг хамт өнгөрөөх.

Эдгээр үйл ажиллагаанууд нь:

- Эрэгтэй, эмэгтэй хүн бие биенээ таньж мэдэхэд тусална.
- Тэднийг бие биедээ тохирох хань мөн эсэхийг мэдэхэд тусална.
- Бие биетэйгээ сайн харилцах чадварыг нэмэгдүүлнэ.
- Тэднийг өсөхөд тусална.

► Үерхлийн талаарх эдгээр зарчим, санаануудаас аль нь танд шинэлэг байна вэ? Танай нөхцөл байдалд итгэгчид гэрлэхээс өмнө харилцаандаа цэвэр ариун байдал болон Бурханыг дээдлэх Библийн зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх ёстой вэ?

Гэрлэхээсээ өмнө хэлэлцэх сэдвүүд

Хосууд гэрлэх шийдвэр гаргах үйл явцынхаа нэг хэсэг болгон бие биенээ таньж мэддэг ахуй соёлд хуримын өмнө хэлэлцэх ёстой чухал асуудлууд байдаг.

Гэрлэлтийг нь эцэг эх зуучлан зохион байгуулдаг зарим соёлд хосууд бие биенээ сайн таньж мэдэх боломжгүй байдаг. Тэдэнд хуримын өмнө чухал асуудал бүрийг хэлэлцэх боломж олддоггүй. Энэ нөхцөл байдалд, эрэгтэй, эмэгтэй хоёрын эцэг эхчүүд бие биетэйгээ мэдээлэл хуваалцаж, залуу хос бие биедээ сайн тохирох эсэхийг шалгах нь хамгийн сайн арга юм.

Бие биенээ бага мэддэг хүмүүсийн хувьд, тэд эдгээр асуудлуудыг гэрлэснийхээ дараа шийдвэрлэдэг. Гэхдээ эдгээр асуудлууд тэдний сонголтод нөлөөлж чадахгүй, учир нь тэд бие биедээ болон Эзэндээ аль хэдийн амлалт өгч шийдвэр гаргасан байдаг.

Эрэгтэй, эмэгтэй хүний итгэл үнэмшил, гарал үүсэл, соёл, амьдралын зорилго, үнэт зүйлс нь хэдий чинээ ижил төстэй байна, төдий чинээ гэрлэлтэд илүү тохиромжтой байх боломжтой. Хэрэв боломжтой бол, гэрлэхээр төлөвлөж буй хосууд дараах зүйлсийг хэлэлцэхэд цаг гаргаарай:

- Тэдний амьдралын зорилго
- Тэдний хувьд чухал үнэт зүйлс
- Тэдний бага нас болон хэрхэн өсөж торнисон түүх
- Эцэг эх болон бусад хамаатан садантайгаа харилцах харилцаа

- Тэдний хувийн онол сургаалын итгэл үнэмшил болон итгэлийн хэрэгжүүлэлт, тухайлбал хувийн сүнслэг сахилга бат, чуулганд хамрагдах байдал, үйлчлэл болон сайн дурын үйл хэрэг
- Хүүхэд өсгөх, түүний дотор хүүхдүүдэд заах, сургах, сахилга батыг заах, мөн тэдэнд Христийг таньж, дуулгавартай байхад сургах талаарх тэдний ойлголт, итгэл үнэмшил
- Санхүүгийн талаарх тэдний үзэл бодол, түүний дотор зарцуулалт, хуримтлал, хүнд хэцүү цаг үеийг даван туулах талаар
- Тэдэнд байгаа аливаа бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудал эсвэл хөгжлийн бэрхшээл, мөн тэдний гэр бүлд нийтлэг тохиолддог эрүүл мэндийн асуудлууд

Харилцааны энэ хэсэгт та амьдралын хэцүү, төвөгтэй сэдвүүдийн талаар ярилцах ёстой. Та нэгэнт Бурханд болон бие биедээ амлалт өгч үүрэг хүлээсэн л бол та хоёр гэрлэсэн бөгөөд нэг бол илүү дээр эсвэл бүр муу гэрлэлтийг эхлүүлсэн гэсэн үг. Гэрлэлтэд нөхөр, эхнэр хоёр бие биетэйгээ бүх зүйлээ хуваалцдаг тул илэн далангүй шударгаар ярилцах нь маш чухал юм. Энэхүү яриа улам нээлттэй, гүн гүнзгий байх ёстой. Хэрэв таны гэрлэхээр зорьж буй хүн эдгээр чухал асуудлуудын талаар ярилцахыг хүсэхгүй байвал, энэ нь ноцтой аюулын дохио юм.

Хуримынхаа өмнө хосууд гэрлэлт дэх бэлгийн харилцааны талаарх итгэл үнэмшил, хүлээлт, хүсэл тэмүүлээ ярилцах ёстой. Харилцааны эхэн үед бэлгийн харилцааны талаар ярилцах нь шаардлагагүй уруу таталт үүсгэж болох ч, үүнийг гэрлэхээс өмнө ярилцах нь чухал юм.

Гэрлэх гэж буй эрэгтэй, эмэгтэй хүн дараах зүйлс дээр ижил төстэй байх нь тустай:

- Оюун ухааны хувьд ижил төстэй байх.
- Гэрлэсэн амьдралын талаар ижил төстэй хүлээлттэй байх.
- Ижил төстэй онол сургаалын итгэл үнэмшил, сүнслэг дадал хэвшил.
- Мөнгө болон цагийг ашиглах талаар ижил төстэй үнэт зүйл, дадал хэвшилтэй байх.
- Амьдрал болон хүүхэд өсгөх нарийн ширийн зүйлсийн талаар нэгдмэл ойлголттой байх.

Үерхэх үеийн аюулын шинж тэмдгүүд

Жон Дрешер үерхэж байгаа хос харилцаагаа зогсоох талаар нухацтай бодох шалтгаан, найман асуудлыг жагсаажээ:²⁷

- 1. Та хоёр байнга маргалддаг.**
- 2. Та эмзэг сэдвүүдийг ярихаас зайлсхийдэг.** Учир нь найздаа сэтгэл санааны хувьд хохирол учруулахаас айдаг. Хэрэв та өөртөө "Би энэ тухай ярихгүй байсан нь дээр" гэж хэлж байвал энэ нь аюулын дохио юм. Гэрлэлт гэдэг нь та олон зүйлийн талаар итгэлтэйгээр, хайраар ярилцах шаардлагатай болно гэсэн үг.
- 3. Таны харилцаа бие махбодын хувьд улам бүр дотно болж байна.** Та хоёр гэрлээгүй байхдаа бие махбодын хувьд хэдий чинээ их харилцаанд орно, төдий чинээ хэл яриа, дууны өнгө, нүүрний хувирал, биеийн хэлэмжээр харилцаж сурах нь багасдаг. Илүү их хүрэлцэж, харин бага ярих нь жинхэнэ аюулын дохио байж болно.
- 4. Та ямар нэг айдсаас болж харилцаагаа авч үлдэж байгаагаа мэдэрдэг.** Жишээлбэл, "Би харилцаагаа зогсоохыг хүсэж байна, гэхдээ хэнийг ч гомдоохыг хүсэхгүй байна."
- 5. Таны найз бүтээлч шүүмжлэлийг хүлээж авч чаддаггүй.** Таны найз буруу байх үедээ уучлалт гуйхаас татгалздаг уу? Энэ нь одоо ч хор хөнөөлтэй бөгөөд хэрэв та хоёр гэрлэсэн бол бүр ч их хор хөнөөлтэй байх болно.
- 6. Эцэг эх тань эсвэл таныг сайн мэддэг найз нөхөд таны харилцаа болон ирээдүйн гэрлэлтийг нь эсэргүүцдэг.** Энэ нь мэдээж аюулын шинж тэмдэг байж болох бөгөөд таныг харилцаагаа зогсоох талаар бодоход хүргэх ёстой. Та зөвхөн хувь хүнтэй гэрлэдэггүй, харин гэр бүлд нэгддэг бөгөөд энэ нь таны гэрлэлтийн аюулгүй байдал, амжилтад ихээхэн нөлөөлөх нь үнэн юм.
- 7. Таны найз хэтэрхий хартай эсвэл сэжигтэй байдаг.** Жишээлбэл, хэрэв таны найз үгэнд чинь эргэлзэж, эсвэл өөр байдлаар танд итгэхгүй байвал энэ нь аюулын дохио юм. Үл итгэлцэл нь ямар ч гэр бүлийн харилцааг устгах болно. Тиймээс, хэрэв таны найз хэтэрхий хартай эсвэл үл итгэмтгий бол харилцаагаа боломжтой дээр нь зогсоо.
- 8. Та харилцахдаа тавгүй мэдрэмжтэй байдаг.** Ялангуяа найзтайгаа ганцаараа байх үед. Танд "Ямар нэг зүйл буруу байна" гэсэн бодол эсвэл сэтгэгдэл төрдөг. Энэхүү дотоод амар тайван байхгүй байдалд анхаарах цаг болсон!

²⁷ John Drescher, *For Better, For Worse: A Premarital Checklist*, (Morgantown, PA: Masthof Press, 1999), 30-31 номоос ашиглав.

Дүгнэлт

Сургаалт үгс 24:3-4, “Мэргэн ухаанаар гэр орон сүндэрлэж бодол ухаанаар тэр чухамдаа тогтдог. Мэдлэг нь өрөөнүүдийг чинь тааламжит үнэт баялгаар дүүргэнэ.”

Ханиа сонгох нь хэн нэгний хийж болох хамгийн чухал сонголтуудын нэг юм. Бурхан өөрийн хүүхдүүдэд ирээдүйн ханиа бодож, танилцах үедээ ухаалаг сонголт хийхэд нь туслах дуртай байдаг.

Хэлэлцүүлгийн асуултууд

► Энэ хичээлийн ямар ойлголт танд шинэлэг байсан бэ? Энэ нь яагаад чухал вэ? Үүнийг ойлгох нь таны харилцаанд хэрхэн туслах вэ? Үүнийг ойлгох нь бусдын төлөөх таны үйлчлэлд хэрхэн нөлөөлөх вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Биднийг удирдан, хангаж байдагт талархъя. Амьдралын чухал шийдвэрийг ухаалгаар гаргахад тусалдаг зарчмуудыг өөрийн Үгээр дамжуулан өгсөнд баярлалаа.

Ханиа сонгохдоо таны чухалчилдаг зүйлсийг баримтлахад бидэнд туслаач. Таны хүссэн эрэгтэй, эмэгтэй хүн байхад бидэнд туслаач. Даруу байж, бурханлаг хүмүүсийн зөвлөгөөг сонсоход бидэнд туслаач.

Бид таныг алдаршуулсан цэвэр ариун, үр жимстэй амьдралаар амьдрахыг хүсэж байна.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Энэ хичээлийн нэг хэсгийг өөрийн үйлчлэлийн нөхцөл байдалд тохируулан заахаар сонгоорой. Та хувь хүнд эсвэл залуучуудын бүлэгт зааж болно. Хичээлээс гадуур зааж дуусгаад ангийн удирдагчдаа мэдэгдээрэй.

(2) Танай ахуй соёлд, гэрлэхээр төлөвлөж буй эсвэл гэрлэхээр шийдсэн бурханлаг эрэгтэй, эмэгтэй хоёрын харилцааны шинж чанаруудыг тодорхойлж бичнэ үү.

(3) Та (гэрлэх ч бай, гэрлэхгүй ч бай) ирээдүйн ханийнхаа талаарх шинж чанаруудын жагсаалт гаргаарай. Өгөгдсөн Бичвэр бүрийг унш. Таны бодлын амьдралыг цэвэр, Түүнд таалагдсан байлгахын тулд хэрхэн өсөх ёстойг Бурханаас харуулахыг гуйгаарай.

(4) Хэрэв та ганц бие бөгөөд ирээдүйд гэрлэхээр төлөвлөж байгаа бол, ханийнхаа талаар тодорхойлсон жагсаалт бичээрэй. Та үүнийг ангийн удирдагчтайгаа хуваалцах шаардлагагүй, зүгээр л даалгавраа гүйцэтгэсэн тухайгаа мэдэгдэхэд болно.

7-р хичээл

Бат бэх гэр бүлийг цогцлоох нь

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

(1) Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг онцлогтойгоор бүтээсэн тухай болон гэрлэлтийн харилцаанд өгсөн Түүний заавруудыг ойлгох.

(2) Эхнэр, нөхөр хоёр Библийн зарчмуудад дуулгавартай байснаар бие биенийхээ хэрэгцээг хангадаг талаар суралцах.

Хувь хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нь

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс олон талаараа ялгаатай байдаг нь нууц биш. Олон эрчүүд сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг бол олон эмэгтэйчүүд сэтгэл хөдлөлөө илэрхийлэхийг жинхэнэ харилцааны нэг хэсэг гэж үздэг. Эрчүүд илүү их эрсдэл хүлээх хандлагатай байдаг бол эмэгтэйчүүд ихэвчлэн аюулгүй байдалд санаа тавьдаг. Эрчүүд төрөлхийн бие махбодын гоо үзэсгэлэнд илүү татагддаг бол ихэнх эмэгтэйчүүд төрөлхийн сэтгэл хөдлөлийн дотно харилцаанд илүү татагддаг. Өөр олон ялгааг дурдаж болно.

Хүйсийн ердийн ялгаанаас гадна эхнэр, нөхөр хоёр хувь хүнийхээ хувьд ялгаатай. Магадгүй нэг нь хүмүүстэй хамт байх дуртай байхад, нөгөө нь ганцаараа байх дуртай байж болно. Мөн гэр орны гэрэлтүүлэг ямар байх ёстой эсвэл өрөөний хэм хэр зэрэг байх ёстой зэрэг дээр жижиг ялгааг ч анзаарах болно. Гэрлэсэн олон хүмүүс мөнгөө зарцуулах тал дээр санал зөрөлдсөнөөс болж хүндрэл үүсдэг. Эдгээр ялгаа нь заавал зан чанартай холбоотой байх албагүй. Харин зүгээр л хувь хүний онцлог, үзэл бодлын ялгаа байх боломжтой.

Зарим хүмүүс гэрлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүнийг нэгтгэдэг учраас ялгаатай байдал нь арилах ёстой гэж боддог. Аль нэг нь хань ижлийнхээ ялгаатай байдлыг өөрчлөх ёстой дутагдал ч гэж бодож болох юм. Хоёр тал бие биенийхээ үзэл бодол, дадал хэвшил, сонголтыг өөрчлөхийг тууштай оролдож ч магадагүй.

Харилцааны улмаас хүн бүр хөгжиж, сайжрах ёстой нь үнэн. Гэсэн хэдий ч заримдаа хүнийг өөрчлөх гэсэн бидний оролдлого тухайн хүний хувийн онцлогт халдаж байдаг. Эрүүл гэрлэлтэд эхнэр нөхөр хоёр бие биенийгээ хайрлах, хүндлэх, үнэлэх, үйлчлэх сахилга батыг хөгжүүлдэг.

► Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бусад ялгаатай талууд юу вэ? Бие биеэ хүлээн зөвшөөрөх ёстой бусад хувийн онцлог шинжүүд юу вэ?

Үйлчлэхийг сонгох нь

Гари Томасын, *Sacred Marriage* (Ариун нандин гэрлэлт), номд дурдсанчлан,

*Сайн гэрлэлт бол олж авдаг зүйл биш, харин түүний төлөө ажиллах ёстой зүйл юм. Энэ нь хичээл зүтгэлийг шаарддаг. Та өөрийн аминч чанараа цовдлох ёстой. Та заримдаа нүүр тулж, заримдаа нүглээ улайх шаардлагатай болно. Уучлахыг дадал болгох нь чухал. Энэ бол гарцаагүй хүнд хөдөлмөр боловч эцэстээ үр өгөөжөө өгдөг. Эцэстээ энэ нь гоо үзэсгэлэн, итгэлцэл, харилцан дэмжлэг бүхий харилцааг бий болгодог.*²⁸

Томас Отто Пайперын үгийг эш татахдаа:

Хэрэв гэрлэлт... олон хүний хувьд бүтэлгүйтлийн туршлага болсон бол үүний шалтгаан нь тэдний итгэлийн [идэвхгүй байдалд] оршино. Бурханы ерөөлийг тууштай эрэлхийлж байж л олж, эдлэх боломжтой гэдгийг хүмүүс таашаадаггүй (Матай 7:7; Лук 11:9). Иймээс гэрлэлт бол бэлэг болоод биелүүлэх ёстой үүрэг юм.²⁹

Эхнэр нөхөр хоёр бие биенийхээ хэрэгцээг хангахыг хичээхийн оронд өөрсдийнхөө хэрэгцээг боддог учраас гэрлэлтүүд ихэвчлэн цэцэглэн хөгжиж чаддаггүй.

Бид бие биенийхээ **гүн гүнзгий** хэрэгцээг хангаж **чадахгүй**. Зөвхөн бидний тэнгэрлэг Эцэг л бидний хүсэл тэмүүллийг бүрэн дүүрэн хангаж чадна. Тийм ч учраас Есүс ирсэн юм. Түүний зорилго бол биднийг аврах, өөрийн Сүнсээр буюу Ариун Сүнсээр дүүргэх, мөн "Ааба аа! Аав минь!" гэж хэлэх (Ром 8:14-15; Галат 4:6) гүн гүнзгий, сэтгэл хангалуун байх харилцаанд авчрах юм.

Гэсэн хэдий ч Бурханы гэрлэлт дэх зорилгуудын нэг нь үйлчлэгч байхад суралцах талбар юм. Үүнийг бид Есүсийн дотроос олж хардаг (Иохан 13:14). Бурхан эхнэр нөхөр хоёрын хэн хэнд нь бие биедээ санаа тавьдаг, даруу үйлчлэгчийн зүрх сэтгэлийг төлөвшүүлэхийг хүсдэг (Филиппой 2:3-8).

Хамгийн үзэсгэлэнтэй, аз жаргалтай зарим гэрлэлтүүд нь эхнэр нөхрийн хэн нэг нь өвчин, бүтэлгүйтэл, хагацал эсвэл уй гашуу зэрэг хэвийн биш хүнд нөхцөл байдал дунд өөрийгөө умартаж, нөгөөдөө үйлчилсэн учраас л оршин тогтнодог. Зарим нөхрүүд өөрсдийг нь хайрлахын аргагүй байх үед нь эхнэрүүд нь тэдний төлөө залбирч, уучилж, санаа тавьж, болзолгүй хайрласан учраас л амьдрал нь сүйрэлгүй найдвар бий болсон гэж гэрчлэн ярьдаг. Түүнчлэн зарим эхнэрүүд хүчирхийлэгч эцэг эсвэл бусад гэмтлээс үүдсэн сэтгэл санааны хохирлыг даван туулахад нөхрийнх нь тэвчээр, ойлголт тусалсан гэж гэрчилдэг. Бид унасан, нүгэлт ертөнцөд амьдарч байгаа бөгөөд бүх бүтээл ёолж байдаг учраас (Ром 8:22), гэрлэсэн хүн бүр шарх, сорвийг тээж явдаг. Гэхдээ Бурханы

²⁸ Gary Thomas, *Sacred Marriage*, (Grand Rapids: Zondervan, 2000), 133.

²⁹ Ibid.

нигүүлсэл биднийг бие биедээ санаа тавьж, бие биенийхээ шархыг бооход туслах болно!

Бидний хүн нэг бүр төрөлхийн хувиа хичээсэн байдаг. Бид төрөлхийн бусдын хэрэгцээнээс илүүтэй өөрсдийн хэрэгцээнд санаа тавьдаг. Бурханы аврах ба ариусгагч нигүүлсэл нь бидний дотор орших Ариун Сүнсээр дамжуулан өөрсдийн хэрэгцээнээс илүү бусдын хэрэгцээг өмнөө тавьдаг хүмүүс болгон өөрчилж чадна. Эхнэр нөхөр хоёр бие биенийхээ хэрэгцээ, хүсэлд анхааралтай хандах үед гэрлэлт цэцэглэн хөгждөг.

► Үйлчлэхийг сонгоно гэдэг нь юу гэсэн үг вэ?

Эхнэр, нөхрийн үндсэн хэрэгцээ

Бурхан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөр өөр хэрэгцээ, хүсэл сонирхолтойгоор бүтээсэн. Энэ нь эрэгтэй хүний хувьд өөрийг нь баярлуулдаг зүйлс эхнэрийг нь ч баярлуулна гэж бодох ёсгүй гэсэн үг. Эхнэр ч гэсэн нөхрөө өөртэйгөө адилхан хандаасай гэж бодох ёсгүй. Мэдээж хэрэг, зарим талаар өгөөмөр хандах, эелдэг харилцаа хоёуланд нь адил байх ёстой ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тус бүрдээ өөрийн гэсэн онцгой хэрэгцээтэй байдаг.

Хэрэв бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцгой хэрэгцээг ойлгох юм бол хань ижлээ хэрхэн хангахыг ойлгох боломжтой. Эхнэр нөхөр хоёрын хоорондох олон маргаан, яриа нь асуудлын шийдэл болдоггүй нь харамсалтай. Учир нь хэн хэн нь нөгөөгийнхөө хэрэгцээг ойлгож чаддаггүй. Хэн хэн нь нөгөөгөө ойлгохгүй байгаа учраас уурлаж, гоморхдог.

Бүх хүн хайрлагдах, хүндлэгдэх хэрэгцээтэй байдаг. Гэхдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ялгаа бий. Эмэгтэй хүний үндсэн хэрэгцээ бол хайр, харин эрэгтэй хүний үндсэн хэрэгцээ бол хүндлэл юм.³⁰

► Та эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээний энэ ялгааг хэрхэн ажигласан бэ?

Нөхөр нь эхнэрээ хайрлаж байгаагаа хэрхэн харуулах вэ?

Ефес 5:25, 28-д хэлэхдээ, “Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла... Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие шиг хайрлах ёстой...”

Нөхөр нь эхнэрээ хайрлаж буйгаа байнга хэлж байх ёстой бөгөөд тэр үүнийг мэдэж байгаа гэж бодох ёсгүй юм. Мөн үг ярианаас илүүтэйгээр хайраа илэрхийлэх ёстой. Эхнэрийнх нь хувьд чухал байдлаар тэр хайраа харуулах ёстой. Нөхөр нь өөрийнхөө хувьд чухал байдлаар хайраа илэрхийлсэн учраас эхнэр нь хайрлагдсанаа мэдрэх байх гэж бодох ёсгүй. Учир нь эхнэрийнх нь хэрэгцээ түүнийхээс өөр юм.

³⁰ Dr. Emerson Eggerich, *Love and Respect* ном нь энэ сэдвийг ойлгоход тустай.

(1) Нөхөр нь аюулгүй байдлыг хангах замаар эхнэрээ хайрладаг.³¹

Эхнэр хүн нөхөр нь түүнийг бие махбодын болон сэтгэл санааны хувьд хамгаалдаг гэдгийг мэдэхийг хүсдэг. Нөхөр нь хөршүүдтэйгээ үүссэн аливаа зөрчилдөөнийг шийдвэрлэх ёстой. Нөхөр хүн гэр нь аюулгүй газар гэдгийг баталгаажуулах ёстой. Эхнэрийг нь хүмүүс (тэр байтугай хамаатан садан нь) шүүмжлэх үед тэр түүнийг өмгөөлөн ярих ёстой. Эхнэрээ өөртөө захируулахын тулд нөхөр хүн цохих эсвэл ямар нэгэн байдлаар бие махбодын хохирол учруулах ёсгүй. Тэрээр гэр бүлийнхээ материаллаг хэрэгцээг хангахын тулд чадах бүхнээ хийх ёстой. Хэрэв нөхөр нь мөнгө санхүүгийн асуудалд хайнга ханддаг бол эхнэр нь түүнийг гэр бүлийнхээ хэрэгцээг анхаардаггүй гэж мэдэрдэг.

Нөхрүүдэд зориулсан санхүүгийн зөвлөгөө:

Мөнгөний асуудал бол гэрлэлтийн хамгийн том зөрчилдөөний нэг шалтгаан юм. Нөхрүүд ээ,

- Ашиг олохын тулд ямар нэгэн хууль бус, ёс суртахуунгүй зүйл хийхээс татгалз. Та Бурханы эрх мэдэл дор байгаа гэдгээ санаарай.
- Аравны нэгээ чуулганд өгөөрэй. Бурхан таныг хангана гэдэгт та итгэж байгаа учраас тэр юм.
- Ажил эрхлэх хамгийн сайн сонголтыг хайгаарай. Гэхдээ одоохондоо тааламжгүй ажил хийхэд ч бэлэн байх хэрэгтэй.
- Ажил эрхэлж байгаа эсэхээс үл хамааран, өдөр бүр өөртөө болон бусдад туслах ажил олж хийгээрэй.
- Өнөөдөр мөнгө зээлж, маргаашийн мөнгөө бүү зарцуул.
- Таашаал авахын тулд мөнгө зарцуулахдаа эхнэр, хүүхдүүдээ хамруулж байгаарай.
- Байрны түрээс гэх мэт ердийн зардлуудад зориулж тогтмол хуримтлал үүсгээрэй.
- Тав тухтай байдалд мөнгө зарцуулахын оронд нөхцөл байдлаа сайжруулахын тулд хөрөнгө оруулалт хий.

(2) Нөхөр нь өөрийгөө эхнэртээ үнэнчээр зориулж хайрладаг.

Нөхөр хүн өөрийгөө ёс суртахууны хувьд цэвэр байлгаж, эхнэртээ хангалуун байх ёстой. “Энхрийхэн марал, гоолигхон согоон адил эхнэрийн чинь хөх чамайг ямагт хангалуун байлгаж, эгнэгт түүний хайранд чи хөлчүүрэх болтугай!” (Сургаалт үгс 5:19).

³¹ Энэхүү үнэнтэй холбоотой Библийн олон эшлэл бий. Ефес 5:28-31, Колоссай 3:19 (сэтгэл санааны хамгаалалт), 1 Тимот 5:8 (бие махбодын хангамж), Нехемиа 4:13-14 (бие махбодын хамгаалалт) болон 1 Тимот 2:14 (сүнслэг хамгаалалт).

Хэрэв нөхөр нь өөр эмэгтэйчүүдтэй зохисгүй, ёс бус харилцаатай байвал эсвэл бусармаг зугаа цэнгэлд оролцдог бол эхнэр нь хайрлагдахгүй байгаагаа мэдэрдэг.

(3) Нөхөр нь эхнэрээ ойлгохыг хичээх замаар хайрладаг.

Нөхөр нь эхнэрээ үргэлж ойлгож чадахгүй байж болох ч тэрээр түүнийг сонсож, танихад цаг гаргах ёстой. Бичвэр нөхрүүдэд хандан, “Нөхрүүд ээ... мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар... Амийн нигүүлслийг хамтран өвлөгчийнх нь хувьд...” (1 Петр 3:7) гэж хэлдэг. Хэрэв нөхөр нь эхнэрийнхээ мэдрэмж, үзэл бодлыг дорд үзвэл тэрээр хайрлагдахгүй байгаагаар мэдэрдэг. Нөхрийнх нь хэлсэн үгс логикгүй санагдаж байсан ч хамаагүй, тэрээр санааг нь зовоосон асуудлыг ойлгохоор хичээхийг нөхрөөсөө хүсдэг.

Учир нь Бурхан эр нөхрийг өрх гэрийн тэргүүн байхаар бүтээсэн (Ефес 5:23) бөгөөд орон гэрээ удирдах хариуцлага нь түүнийх юм (1 Тимот 3:4-5). Гэсэн хэдий ч нөхөр, эхнэр хоёр ихэнх шийдвэр дээр санал нийлэх хүртлээ ярилцаж хэлэлцэх цаг гаргах ёстой. Нөхөр нь эхнэрийнхээ мэдрэмж, үзэл бодлыг харгалзан үзэхгүйгээр ямар нэгэн зүйлийг хурдан шийдэх учиргүй. Хэрэв тэд ямар нэг асуудал дээр санал нийлж чадахгүй бол нөхөр нь шийдвэр гаргах шаардлагатай болж болох ч нэгдмэл байж чадаагүйд нөхөр нь харамсах ёстой. Ихэвчлэн нэгдмэл биш байдал нь нөхөрт өгөх сэрэмжлүүлэг болдог. Ихэвчлэн эмэгтэйчүүд илүү ялгах чадвар, мэргэн ухаантай байдаг бөгөөд эрчүүдийг сайн шийдвэр гаргахад энэ нь хэрэгтэй юм.

► Нэг суралцагч Ефес 4:2-3, 15-16 эшлэлийг бүлэгт уншина. Эдгээр эшлэл нөхөр, эхнэрийн харилцаанд хэрхэн хэрэгжих боломжтой вэ?

(4) Нөхөр нь эхнэрээ үнэлж хайрладаг.³²

Олон эхнэрүүд нөхрүүд нь тэдний хийж буй ажлыг үнэлдэггүй гэж мэдэрдэг. Нөхөр нь эхнэртээ талархлаа илэрхийлэх ёстой. Гэр бүлийнхээ төлөө гаргаж буй түүний хүчин чармайлтыг нөхөр хүлээн зөвшөөрөх ёстой. Тэр бусад хүмүүсийн дэргэд эхнэрээ хэзээ ч шүүмжлэх ёсгүй.³³ Нөхөр эхнэрийнхээ зан чанар, сэтгэл татам байдал, чадварыг магтах ёстой. Тэрээр эхнэрээ гоё хувцаслахад нь чадах чинээгээрээ туслах ёстой. Нөхөр нь түүний гадаад төрхөд санаа тавихгүй байх үед эхнэр нь хайрлагдахгүй байгаагаар мэдэрдэг.

Нөхөр нь эхнэрээ шүүмжлэх үедээ түүнийг хувь хүн талаасаа хангалтгүй гэж бодоход хүргэж, урмыг нь хугалдаг. Паул итгэгчдэд “хэнийг ч муулахгүй, хэрүүлч биш, дөлгөөн байж, бүх талаар даруу байдлыг бүх хүнд харуулахыг” (Тит 3:2) хэлсэн байдаг. Хэрэв шүүмжлэх шаардлагатай бол эхнэрээ үнэлэх үнэлэмж нь шүүмжлэлээс нь илүү их гэдгийг нөхөр маш болгоомжтойгоор батлах ёстой. Нөхөр эхнэрээсээ илүү сайн эмэгтэйчүүдийн жишээг дурдахаас зайлсхийх ёстой.

³² Сургаалт үгс 31:28-31

³³ Гэрлэлтийн хам сэдэвт энэ нь Ефес 4:29-32, Ефес 5:25-29 ба Матай 7:12 эшлэлийн бидэнд хэлсэн зааврын хэрэгжүүлэлт болдог.

(5) Гэр бүлийн харилцаандаа цаг гаргаснаар нөхөр нь эхнэрээ хайрладаг.

Хамтдаа амьдралыг хуваалцах нь ярилцах цагийг шаарддаг. Харилцаа нь үгээр гүнзгийрдэг (Сургаалт үгс 16:24, Сургаалт үгс 20:5). Эхнэр нөхөр хоёр өдөр тутмын амьдралаа дүүргэдэг зүйлсийн талаар ярилцах ёстой. Тэд нөхөрлөл, мэдрэмж, хүсэл, санаа зовоосон асуудлуудынхаа талаар ярилцах учиртай. Нөхөр нь ярилцаж, сонсоход цаг гаргах үед эхнэр хайрлагдаж байгаага мэдэрдэг. Нөхөр ажлаасаа ядарч ирэхдээ ярилцах эсвэл гэрийн асуудлын талаар сонсох хүсэлгүй байж болох ч энэ хэрэгцээг үл тоомсорлож болохгүй. Хэрэв нөхөр нь бие махбодын дотно харилцааг хүсдэг ч, сэтгэл санааны дотно харилцаанд бэлэн биш бол эхнэр өөрийгөө ашиглагдсан, хайрлагдахгүй байгаагаар мэдэрдэг.

(6) Нөхөр нь эхнэрийнхээ сул талуудад тэвчээртэй хандсанаар хайрладаг.

1 Петр 3:7-д “Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг хэврэгхэн сав мэт үзэн, та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар...” Ихэнх эмэгтэйчүүд ихэнх эрчүүд шиг бие махбодын хувьд хүчтэй биш байдаг. Мөн ихэнх эмэгтэйчүүд ихэнх эрчүүдээс илүү сэтгэл санааны зовиур, дарамтад өртөмтгий байдаг. Эр нөхөр эхнэрээ тайтгаруулж, урамшуулдаг байх учиртай. Тэрээр эхнэрийнхээ стрессийг хэрхэн тайлахад суралцах хэрэгтэй. Эхнэр нь ядарсан, стресстэй эсвэл санаа зовсон үед түүнд шаардлага тавихаас зайлсхийх ёстой.

(7) Нөхөр нь эхнэрийнхээ практик хэрэгцээг хангаснаар хайрладаг.

Яг л эрэгтэй хүн ажилдаа зориулсан хамгийн сайн хэрэгсэл, ажил хийх сайн газартай байхыг хүсдэг шиг, эхнэртээ сайн орчинг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Гэр оронд нь засаж янзлах зүйл, эхнэрийнх нь хэрэглэдэг зүйлс хангагдсан байгаа эсэхийг нөхөр шалгах ёстой.

Нөхрүүд эхнэрүүдээ хайрлах үед гарах үр дүн

Ихэнх нөхрүүд эхнэрээ хайрлах үед эхнэрүүд нь баяр хөөр, хамтын ажиллах хариу үйлдэл үзүүлдгийг олж мэддэг. Эмэгтэйчүүд нөхөр нь өөрт нь үнэнч байж, дээр дурдсан арга замуудаар хайраа илэрхийлэх үед аз жаргалтай болдог. Нөхрүүд эхнэрээ хайрлах үедээ гэрлэлтээсээ хамгийн их зүйлийг хүлээн авдаг (Ефес 5:28). Гэсэн хэдий ч эрчүүдэд үр дүн баталгаа болохгүй. Үүнд хамаарахгүй тохиолдлууд бий. Эрэгтэй хүн хүссэн зүйлээ авахын тулд хайраа харуулах ёсгүй. Тэрээр өөрийнхөө хэрэгцээнд санаа тавихын оронд Бурханыг баярлуулах, эхнэрийнхээ хэрэгцээг хангахын тулд хайраа илэрхийлэх учиртай.

Зарим эхнэрүүд өнгөрсөн туршлагаасаа болж сэтгэл санааны хохирол амссан байж болох бөгөөд нөхрийнхөө хайранд хурдан хариу үйлдэл үзүүлэхгүй байж болно. Хайрыг илэрхийлэх эдгээр дадал нь хэдхэн өдөрт турших техник биш юм. Нөхөр нь Бурханд болон эхнэртээ өөрийн зүрх сэтгэлд буй хайрын улмаас эдгээр арга замуудаар хайраа тууштай илэрхийлсээр байх ёстой. Христ чуулганыг өөрийгөө зориулсан шийдвэр ба итгэмжит байдлаараа хайрласан юм.

Эхнэр нь нөхрөө хэрхэн хүндлэх вэ?

Ефес 5:33-д "Гэхдээ хэн чинь ч өөрийгөө хайрладгийн адил эхнэрээ **хайрла**. Эхнэр нь нөхрөөсөө **эмээж бай**" хэмээн тушаасан.

Эр хүн хүндлэгдэх хэрэгцээтэй байдаг. Ихэнх эрчүүд бусдад таалагдахаас илүүтэй тэднээр хүндлүүлэхийг хүсдэг. Бурхан эрчүүдийг гэр бүлээ хамгаалах, хангах, удирдах чадвартайгаар бүтээсэн. Эцэг, нөхрийн байр суурь нь тэрхүү хүндлэлийг олохоос ч өмнө байх ёстой хүндэтгэл байдаг. Эхнэр нь нөхрийнхөө үйлдэл буруу байсан ч түүнд хүндэтгэлтэй хандах ёстой. Түүнийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, эрх мэдлээ төгс ашиглаагүй байхдаа ч эрхэм чухал хүн гэж эхнэр тооцох ёстой (Ефес 5:23). Энэ нь түүний үйлдэл эсвэл шийдвэртэй санал нийлэхгүй гэдгээ хэлж болохгүй гэсэн үг биш, харин эхнэр нь түүнд үл хүндэтгэсэн байдлаар хандах ёсгүй гэсэн үг юм.

Эхнэр нь нөхрийнхөө эрх мэдэлд сайн дураараа захирагдаж хүндлэх үедээ Есүст хайртайгаа илэрхийлж байдаг (Ефес 5:22, 31-33).

Зарим эхнэрүүд нөхрийнхөө талаар найзууддаа шүүмжлэн ярьж, нууцаар үйлдэх, гомдоох үг хэрэглэх зэргээр нөхөртөө үл хүндэтгэсэн байдлаар ханддаг хэрнээ тэд нөхрөө хайрладаг гэж боддог. Тэдний санаа тавилт нь үл хүндэтгэлийг нь нөхөж чадахгүй гэдгийг ойлгох ёстой.

Ихэнх эмэгтэйчүүдэд бяцхан хүүхдийг анхаарч халамжлах эх хүний хүчтэй чанар байдаг. Нялх хүүхдийн хэрэгцээг хангах төрөлхийн чадвар, хүсэл эмэгтэй хүнд бий. Хэрэв хэн нэгэн "Та нялх хүүхдийг асрах чадваргүй" гэж хэлвэл эмэгтэй хүн хэрхэн мэдрэхийг төсөөлөөд үз. Үүнтэй адилаар эрчүүд хамгаалах, хангах, удирдах хүчирхэг чанартай. Эхнэр нь түүнд эдгээр зүйлсийг хийх чадваргүй гэж хэлвэл нөхөр нь эр хүн байж чадахгүй бүтэлгүйтжээ гэж мэдэрдэг.

Нөхрөөс нь илүү хүчтэй зан чанартай, илүү их мөнгө олдог, эсвэл илүү өндөр албан тушаалтай бусад эрчүүд байсаар байх болно гэдгийг эхнэр хүн ойлгох ёстой. Тэрээр нөхрөө бусадтай харьцуулж, бүтэлгүй мэтээр мэдрүүлэх ёсгүй. Ефес 5:21-33 эшлэлээс бид сурсанчлан, эхнэр нь нөхөртэйгөө нэг юм. Эхнэр нь нөхрөө шүүмжлэх эсвэл бусадтай харьцуулах үедээ өөрсдийгөө *хамтад* нь болон харилцаагаа хохироож байдаг.

► Нэг суралцагч Сургаалт үгс 31:11-12, 26 эшлэлийг бүлэгт уншина. Эдгээр эшлэл бурханлаг эхнэр хүн нөхөртөө зан байдал, үг яриагаараа хэрхэн ханддаг тухай бидэнд юуг сургаж байна вэ?

(1) Эхнэр нь урмын үгсээр нөхрөө хүндэлдэг.

Эхнэр нь нөхрийнхөө боломжит чадварыг үнэлж батлах ёстой. Эхнэрийн хүндлэл нөхөртөө хэлэх урмын үгсээс нь илэрхий харагддаг. Ихэнх эрчүүдэд үгс хүчтэй нөлөө үзүүлдэг. Тэдгээр нь босгон байгуулж эсвэл нураадаг (Сургаалт үгс 14:1). Тэдгээр нь урамшуулж эсвэл сул дорой болгодог. Үгс нь түүнийг өөртөө итгэлтэй болгож эсвэл сэтгэлийг нь мохоодог (Сургаалт үгс 18:21). Эр хүн бүх оролдлогодоо амжилт олохгүй, эсвэл зарим албан тушаалд байж чадахгүй байж болох ч, гэр бүлийнхээ аюулгүй байдал, орон гэрээ хангах түүний хүчин чармайлтыг эхнэр нь баталгаажуулах ёстой. Нөхөр нь шинэ санаа гаргах, шинэ зүйлсийг оролдох үед эхнэр урмыг нь хугалж болохгүй.

► Суралцагчид Сургаалт үгс 15:4 ба Сургаалт үгс 16:24 эшлэлийг бүлэгт уншина.

(2) Эхнэр нь захирагдах байдлаар нөхрөө хүндэлдэг (1 Петр 3:5).

Нөхөртөө захирагдах нь эхнэр нь нөхрөөсөө доогуур гэсэн үг биш. Харин тэдний үүрэг роль нь өөр гэсэн үг юм. Ариун Гурвалд ч Хүү нь Эцэгээсээ мөн чанар, хүч чадал эсвэл алив шинж байдлаараа доогуур биш хэдий ч Эцэгтээ захирагддагийг бид хардаг.

Энэ зарчим зарим эхнэрүүдийн хувьд амар биш байдаг. Ялангуяа нөхөр нь Бурханы Үгээр амьдардаггүй эсвэл тэдэнд эелдэг бус ханддаг бол. Зарим эхнэрүүд өөрсдөө эсвэл гэр бүлдээ нөхрөөсөө илүү сайн шийдвэр гаргаж чадна гэж боддог. Заримдаа эхнэрийн зөв, нөхрийн буруу байдаг. Гэсэн хэдий ч хэрэв эхнэр нь нөхөртэйгөө санал нийлэх үедээ л захирагддаг бол тэр эрх мэдлийг авч байгаа бөгөөд үнэхээр захирагдаж байгаа хэрэг биш юм. Захирагдах гэдэг нь нөгөө хүндээ шийдвэр гаргахыг зөвшөөрөх гэсэн утгатай.

Петр эхнэрүүдэд хандан,

та нар нөхөртөө захирагд. Тэгвэл зарим нөхрүүд үгийг дагадаггүй боловч, үг яриагаар бус журамт явдлаар чинь Эзэн рүү ирнэ.... Гоёл чинь үс сүлжилт, алтан эдлэл зүүх, эсвэл хувцаслалт гэх мэт гадна талынх бүү байг. Харин нуугдмал дотоод хүнээ дөлгөөн ба даруу сэтгэл бүхий мөхөшгүй чанараар гоё. Энэ нь Бурханы өмнө асар үнэтэй болой (1 Петр 3:1, 3-4).

Олон хүнд хэцүү нөхцөл байдлууд тохиолддог. Олон эхнэрүүд "Хэрэв тэр намайг _____ хий гэвэл би заавал хийх ёстой юу?" гэж асуудаг. Энэхүү хичээлээр амьдралд тохиолддог бүх төрлийн нөхцөл байдлыг авч үзэх боломжгүй. Гэсэн хэдий ч захирагдах асуудал ихэвчлэн нөхөр эхнэрээс хийх ёсгүй зүйлийг шаарддаг учраас үүсдэггүй. Эхнэр нь түүнд захирагдвал нөхрийнх нь хувьд үндэслэлгүй болох учраас тэрээр захирагдахыг хүсэхгүй ч байж болох юм. Магадгүй нөхөр нь хайргүй, эелдэг бус байж болно. Эхнэр нь шийдвэр гаргах эрх чөлөөгөө алдахыг хүсэхгүй ч байж болно. Эхнэр нь эсэргүүцсэн хандлагатай байж болно. Эхнэр нь нөхрийнхөө эелдэг бус үйлдэл эсвэл алдааны жишээг ерөнхийдөө түүний эрх мэдлийг үгүйсгэх шалтаг болгон ашигладаг ч

байх боломжтой. Гэхдээ эдгээр нь Бурханы тушаасан Үгэнд дуулгаваргүй байгаа хэрэг юм.

Библи бидэнд бурханлаг, захирагддаг эхнэр нөхрөө Эзэн дээр авчирч чадна гэж хэлдэг. Нөхөр нь сайн эхнэрийн улмаас итгэгч болно гэсэн баталгаа байхгүй ч, хэрэв түүний Христэд итгэгч эхнэр нь түүнд үл захирагддаг бол итгэгч болох магадлал хамаагүй бага байх болно. Эхнэр нь хүндэтгэлтэй хандсанаар нөхрөөсөө ихээхэн таашаал хүртэж болох ч, энэ нь түүнийг хийх үндсэн шалтгаан биш юм. Харин эхнэр нь нөхөртөө хүндэтгэл үзүүлэх ёстой бөгөөд Бурханыг ийнхүү баярлуулахыг хүсдэг учраас тэр үүнийг хийдэг.

Сургаалт үгс 12:4-д “Зохистой сайн эхнэр эр нөхрийн титэм. Гутамшигт эхнэр ясанд нь буглах идээ бээр.” гэж хэлсэн. Хэрэв эхнэр нь нөхрөө найзуудынх нь дэргэд үл хүндэтгэсэн байдлаар хандвал дахин буцаах боломжгүйгээр нэр төрийг нь сэвтүүлж орхидог. Эрчүүд үнэнч эхнэртэй бусад эрчүүдийг биширдэг. Эрчүүд үл хүндэтгэсэн эхнэртэй бусад эрчүүдийг өрөвддөг.

(3) Эхнэр нь нөхрийнхөө хэрэгцээнд анхаарал хандуулснаар хүндэлдэг (Сургаалт үгс 31:15, 21, 25, 27).

Эхнэр нь унд хоол бэлтгэх болон гэр орноо нөхөртөө таалагдахуйц байдлаар арчлах талаар тусгай нарийн ширийн зүйлийг сурах үед нөхөр нь хүндлэгдэж байгаагаа мэдэрдэг. Хэрэв эхнэр нь нөхрийнхөө төлөө зуршлаа өөрчлөхөөс татгалзвал, нөхөр нь эхнэрийнхээ хувьд чухал биш болжээ гэж мэдэрдэг.

Хэрэв эхнэр нь ажил, найз нөхөд, чуулган эсвэл зугаацдаг зүйлдээ завгүй болоод нөхрөө ярих үед сонсохгүй, түүний хэрэгцээг анзаарахад цаг гаргахгүй бол нөхөр нь эхнэрийнхээ хувьд чухал биш гэж мэдэрдэг.

Эхлэл 2:18-д “ЭЗЭН Бурхан—Хүн ганцаараа байх нь сайн биш. Би түүнд тохирох туслагчийг буй болгоё гэжээ” хэмээн заасан байдаг.

(4) Эхнэр нь нөхрөө бие махбодын дотно байдлаар хүндэлдэг.

Бэлгийн ханамж ихэнх эрчүүдэд зарим эмэгтэйчүүдийнхээс илүү чухал мэт санагддаг. Эмэгтэй хүн тухайн нөхцөл, сэтгэл санааны байдлаас болоод бэлгийн харилцаанд орох дур хүсэл төрөхгүй байж болно. Энэ нь эрэгтэй хүний хүсдэгээс бага байдаг. Хэрэв эхнэр нь нөхрийнхөө хэрэгцээг ойлгохгүй бол тэр ихэвчлэн сэтгэл дундуур байх боломжтой. Эхнэр нь өмнө нь харсан болон амсаж туулсан хүчирхийллээс болж нөхрийнхөө бэлгийн хүслийг үл тоомсорлож ч болох юм. Энэ тохиолдолд нөхөр нь эхнэртээ тэвчээртэй, ойлгож хандахыг хичээх ёстой. Харин эхнэр нь өөрөө тийм хэрэгцээг мэдрэхгүй байсан ч нөхрийнхөө бэлгийн хэрэгцээг хангах нь өөрт нь сайн гэдгийг ойлгох хэрэгтэй. Хэрэв нөхөр нь эхнэртээ үнэнч, итгэмжтэй ханддаг, өөр эмэгтэйчүүдтэй буруу харилцаанд байдаггүй бол эхнэр нь түүний хэрэгцээг анхаарахгүй байх үед гомддог. Нөхрийн хувьд гэрлэлтийн амлалтдаа үнэнч байх нь түүний бие махбодын ханамжаас хэзээ ч хамаарах ёсгүй юм. Харин эхнэр нь түүний

бэлгийн хэрэгцээнд анхаарал хандуулснаар нөхрийнхөө уруу татагдах нөхцлийг багасгаж чадна.

Соломоны дуун номд “Хайрт минь минийх харин би түүнийх... **Хүрээд ир хайрт минь** хөдөө тийш одоцгооё өнөө шөнийг тосгонд үдэцгээе... **Амраглал юугаа тэнд чамдаа өгье**” (Соломоны дуун 2:16; Соломоны дуун 7:11-12 нэмж тодруулсан, мөн 1 Коринт 7:3-5 эшлэлийг үз) гэж тэмдэглэжээ.

Бурханы зааварт дуулгаваргүй байхын үр дагавар

Дараах догол мөрөнд байгаа тодорхойлолт нь гэрлэлт дэх бүх зөрчилдөөнд хамаарахгүй ч түгээмэл тохиолддог. Эдгээр тодорхойлолт нь эхнэр нөхөр хоёр мэдэрч байгаа зүйлдээ сүнслэг *биш* байдлаар хариу үйлдэх үед тохиолддог төрөлхийн шалтгаан-үр дагавартай холбоотой зан байдлыг харуулдаг. Энэ нь (1) өөрсдөө юу мэдэрч байгаагаа танихгүй байх үед, (2) Бурханы үнэнийг болон Тэр тэднээс хүсэж буй зүйлийг санахгүй байх үед, (3) Библийн арга замаар хариу үйлдэхэд тусалдаг Сүнсэнд найдаж түшихгүй байх үед тохиолддог.

Хэрэв эхнэр нь Сүнсээр алхаж, Бурханы хайрыг өөрөөрөө дамжуулахгүй бол гэрлэлтэд хор хөнөөл учруулдаг төрөлх арга барилаар хариу үйлдэл үзүүлж болох юм. Хэрэв эхнэр нь хайрлуулж байгаагаа мэдрэхгүй бол тэрээр аюулгүй байдлыг ч мэдэрч чаддаггүй. Улмаар тэр өөрийгөө хамгаалж, нөхрийнхөө эрх мэдлийг эсэргүүцэж эхэлдэг. Учир нь нөхөр нь өөрт нь санаа тавина гэдэгт тэр итгэдэггүй. Эхнэр нь ийм байх үед нөхөр үл хүндлэгдэх байдлыг мэдэрдэг. Энэ үедээ хэрэв нөхөр нь эрх мэдлээ хамгаалж, хүндлэхийг шаардаж эхлэвэл эхнэр нь түүнийг өөрт нь хайргүй гэж улам ихээр мэдэрдэг.

Хэрэв нөхөр нь Сүнсээр алхаж, Бурханы хайрыг өөрөөрөө дамжуулахгүй бол гэрлэлтээ бат бэх болгох хандлагаа гээх болно. Нөхөр нь үл хүндлэлийг мэдрэх үедээ өвдөлт, уур уцаарыг мэдэрдэг. Тэр энэ үедээ эхнэрээ өвтгөх үгийг хэлэх боломжтой. Тэрээр сэтгэл хөдлөлөө хянахыг хичээснээр чимээгүй болж болох юм. Тэрбээр эхнэрийнхээ дэргэд байхыг хүсэхгүй эсвэл сэтгэлээ түүнд нээхийг хүсэхгүй болдог. Учир нь нөхөр нь эхнэртэйгээ хамт биш, холбоогүй гэж мэдэрдэг. Энэ үед эхнэр нь яагаад ийм байгааг тэр ойлгодоггүй. Магадгүй эхнэр нь аз жаргалгүй байгаагаа болон нөхөр нь өөрчлөгдөх ёстойг ойлгуулахын тулд түүнийг үл хүндэтгэсэн ч байж болно. Нөхөр нь уурлаж эсвэл хөндийрөх үед тэр өөрийнх нь мэдрэмжинд санаа тавихгүй байгаагаа баталлаа гэж эхнэр нь боддог. Тэгээд тэр бүр ч илүү үл хүндэтгэх байдлыг гаргадаг.

Гэрлэлтийн харилцаа гэмтсэн үед хүн уруу таталтад илүү өртөмтгий болдог. Эхнэр нь нөхрийнхөө удирдлагыг эсэргүүцэх байдалд илүү уруу татагддаг. Бусдад нөхрийнхөө талаар үл хүндэтгэсэн байдлаар ярих зэргээр уруу татагддаг. Тэр өөрийг нь үнэлдэг мэт санагдах өөр нэг эрэгтэйн анхаарлыг таашааж уруу татагдаж болно. Эхнэрийнх нь зан байдал түүнийг гомдоож байгаа учраас нөхөр нь түүнээс хол байхаар уруу татагддаг. Улмаар тэр эхнэрээ хайрлах үйлдэл хийх хүсэлгүй болдог. Тэрээр мөн өөрийг нь биширдэг өөр нэг эмэгтэйн анхаарлыг таашааж уруу татагдаж болно.

Хүн бүр сонголтынхоо төлөө Бурханы өмнө хариуцлагатай. Бурхан хүний нүглийг ханийнх нь хийсэн зүйлээр өршөөхгүй. Биднийг хэрхэн амьдрахад туслах хүчийг Бурхан амладаг. Энд өгүүлж буй санаа нь хүн ханиасаа хэрэгтэй зүйлээ шаардах эсвэл өөрийн нүглийг ханьдаа тохохын аль аль нь биш юм. Зорилго нь хүн Бурханыг баярлуулах, ханийнхаа хэрэгцээг хангах хариуцлагаа ухамсарлах явдал юм.

Буруу зорилго

Заримдаа хүн амьдралаа амар хялбар байлгах арга замыг хайдаг. Нөхөр нь эхнэрээ өөрчлөх замаар амьдралаа амар хялбар болгохыг хүсдэг. Үүнтэй адилаар эхнэр нь нөхрөө өөрчилбөл амьдрал нь илүү дээр байна гэж бодож магадгүй. Зөвлөгч, пастор эсвэл найзуудаасаа нөгөө хүнээ хэрхэн өөрчлөх талаар асуудаг. Хань ижлээ өөрчлөх нь зөв зорилго биш. Харилцааны техникийг ашиглан амьдралаа амар хялбар болгохыг хичээх нь Бурханыг болон нөгөө хүнээ хайрлах сэдлийн улмаас биш юм.

Заримдаа хүн нөгөө хүнийхээ алдааг засах гэж олон жил хичээдэг. Тэд нэг ижил алдааг шүүмжлэхээ хэзээ ч зогсоодоггүй. Хэдийгээр хүн бүр жинхэнээсээ алдаа дутагдалтай ч эхнэр нөхөр хоёр бие биенээ алдаатай нь хамт хүлээн зөвшөөрөх ёстой. Алдаа нь хувийн шинж байдал, зан чанар эсвэл сүнслэг (тэр ч байтугай нүгэл) алдаа дутагдал байж болно. Харилцаа нь нөгөө хүний өөрчлөгдөх хүсэл эрмэлзлээс хамаарах ёсгүй. Тэр өөрчлөгдөх боломжгүй гэж мэдэрч болно. Өөрчлөгдөхгүй байгаа шалтгаан нь юу ч байсан, эхнэр нөхөр хоёр хайр, хүндэтгэлийг үзүүлж, бие биенээ алдаатай нь хамт үнэлдэг байх учиртай.

Дүгнэлт

Бурхан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг онцлогтойгоор бүтээсэн бөгөөд хүний хэрэгцээг хангахын тулд гэрлэлтийг бий болгожээ. Гэсэн хэдий ч гэрлэлт, гэр бүл нүгэлд гүн гүнзгийгээр өртөж гэмтсэн ертөнцөд бид амьдарч байна. Бидний хүн нэг бүр өөрийн болон бидэнд нөлөөлсөн бусдын нүглээс болж гэмтсэн. Биднийг өөрчилж, бусдад нигүүлсэл үзүүлэхэд тусалдаг нигүүлсэлгүйгээр Бурханы зорьж буй гэрлэлтийг бид амсаж туулах боломжгүй. Сэдэл маань цэвэр ариун, хайр маань хүчтэй, үйлчлэл маань даруу байхын тулд бидэнд Бурханы Сүнсний цэвэрлэгээ хэрэгтэй.

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Энэ хичээлээр үзсэн ямар ойлголтууд таны хувьд шинэлэг байсан бэ? Та өөрийн хандлага, зан байдалдаа хэрхэн өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна вэ?
- ▶ Гэрлэлтүүдийг бат бэх болгохын тулд чуулган юу хийж чадах вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Олон онцгой хэрэгцээг хангахын тулд гэрлэлтийн харилцааг бүтээсэн танд талархъя. Бидэнд гэрлэлтийн талаарх зааврыг өгсөнд баярлалаа.

Бидэнд зохих ёсоор халамжлах хайр, ойлголтыг өгөөч. Таны хайрыг ертөнцөд харуулдаг гэр бүлтэй байхад бидэнд туслаач.

Таны адил хайрлахад тусалдаг нигүүлсэлд тань баярлалаа.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) 1 Коринт 13:4-8 эшлэлийг цээжил. Дараагийн хичээлийн эхэнд уг эшлэлийг цээжээр унших эсвэл бичнэ үү.

(2) Нөхөр эсвэл эхнэрийн хэрэгцээг тодорхойлсон хоёр хуудас эргэцүүлэл бич. Эдгээр хэрэгцээг хангахад туслах гэр бүлийн хүний зан байдлын жишээг өгнө үү. Таны хэлэлцсэн хэрэгцээ бүрд тохирох Бичвэрийн эшлэлийг ашиглаарай.

8-р хичээл

Хайрын таван хэл – 1-р хэсэг

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Жинхэнэ хайрын шинж чанар, зан байдлыг тодорхойлох.
- (2) Хэн нэгнийг болзолгүйгээр хайрлана гэдэг нь ямар утгатай болохыг тайлбарлах.
- (3) Хайрыг тухайн хүний хайрын үндсэн хэлээр илэрхийлэхийн чухал ач холбогдлыг хэлэлцэх.
- (4) Гэр бүлийн гишүүний хувийн зан чанар, хувийн онцлог чанарыг үнэлж хайраа илэрхийлэхдээ урмын үгсийг ашиглах.

Иосеф ба Ханна – Өсөж хөгжиж буй гэрлэлт

Эхнэр нь аз жаргалгүй байгаагаас болж Иосеф бүхимдаж байлаа. Тэр эхнэрийнхээ юу хүсээд байгааг ойлгосонгүй. Иосеф шаргуу ажиллаж, эхнэр, хүүхдүүдээ гэр орон, хоол хүнс болон амьдралд шаардлагатай бүх зүйлээр хангадаг байв. Тэрээр эхнэртээ хүссэн бүхнээ худалдаж авахыг зөвшөөрдөг бөгөөд эхнэр нь юунд ч санаа зовох шаардлагагүй байлаа. Эхнэр хүнд өөр хүсэх зүйл байдаг болов уу? Харин эхнэр нь түүний ажлыг үнэлэхгүй байгааг Иосеф мэдэрчээ.

Ханна Иосефыг өөрт нь зориулж онцгой зүйлсийг бодож хийж, хайраа илэрхийлэхийг нь хүсэж байсан учраас үүндээ сэтгэл дундуур байв. Нөхрөөсөө авсан түүний хамгийн дуртай бэлэг нь Иосеф өөрийнхөө мужааны цехэд хийсэн, Ханнагийн нэрийг сийлсэн жижиг модон хавтан байжээ. Нөхөр нь Ханнад хүссэн бүхнээ худалдаж ав гэж хэлэхийн оронд заримдаа өөрт нь цэцэг худалдаж авч өгөөсэй гэж тэр хүсдэг байв.

Иосеф, Ханна хоёр сэтгэл мэдрэмжээ хуваалцаж, бие биенийхээ хэрэгцээг ойлгож эхлэв.

Жинхэнэ хайр гэж юу вэ?

- ▶ Хэн нэгнийг жинхэнээсээ хайрлана гэж юу гэсэн үг вэ?
- ▶ Нэг суралцагч 1 Коринт 13:4-8 эшлэлийг бүлэгт уншина. Энэ эшлэлээс хайрын шинж чанар, үйлдлүүдийг жагсаан бичээрэй. Хайр нь юу биш, мөн хайр юу хийдэггүйг жагсаана уу.

1 Коринт 13-р бүлэг Хайр	
Хайр ямар байдаг вэ?	Хайр юу хийдэг вэ?
Хайр ямар байдаггүй вэ?	Хайр юуг хийдэггүй вэ?

Энэ эшлэлд хайр нь **юу вэ** гэдгээс илүү энэ нь **юу биш** вэ гэдгийг тодорхойлсон мэт харагдаж байна. Гэхдээ **хайр ямар байдаггүй вэ** гэсэн тодорхойлолт нь бидэнд хайр **ямар байдаг вэ** гэдгийг заадаг. Хэрэв хайр нь бардамнадаггүй бол энэ нь ямар байх вэ? Энэ нь эсрэгээрээ юм. Хайр бол даруу төлөв.

► Одоо 1 Коринт 13:4-8 эшлэлд дурдсан болон дээрх хүснэгтэд бичигдсэн, хайрын эсрэг шинжүүдийг жагсаан бич.

Хайр ямар байдаг вэ?	Хайр юу хийдэг вэ?

Жинхэнэ хайр:

- Зүгээр нэг мэдрэмж биш (хэдийгээр мэдрэмж ихэвчлэн хайрыг дагалддаг ч)
- Шаардлагаар биш, сонголтоор өгөгддөг.
- Зориулалт юм.
- Золиос шаарддаг.
- Болзолгүй бөгөөд энэ нь нөгөө хүнийхээ үйлдлээс хамаардаггүй.
- Санамсаргүй бус, зорилготой юм.
- Үнэ өртөгтэй.
- Нөгөө хүнийхээ хувьд хамгийн сайн зүйлийг эрэлхийлдэг.
- Өгөх замаар өөрийгөө илэрхийлдэг.

Та хайрлахгүйгээр өгч чадна, гэхдээ өгөхгүйгээр хайрлах боломжгүй. Хайр танаас ямар нэг өртгийг шаарддаг.

"Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан учраас цорын ганц Хүүгээ өгсөн..." (Иохан 3:16). Жинхэнэ хайр өгөх замаар өөрийгөө илэрхийлдэг. Энэ нь үргэлж бодит, материаллаг бэлэг өгнө гэсэн үг биш. Заримдаа бэлэг нь хайрын үгс байж болно. Заримдаа бэлэг нь хэн нэгэнтэй хамт байх, түүнд зориулсан цаг хугацаа байх боломжтой. Заримдаа хайрыг тусламж үзүүлэх эсвэл хайрлаж биеэр хүрэлцэх байдлаар дамжуулан өгдөг. Эцэг Бурхан биднийг маш их хайрласан учраас биднийг өөрийн хүүхдүүд болгохын тулд өөрт байсан хамгийн сайн зүйл буюу өөрийн цорын ганц Хүүгээ өгсөн юм. Бид бусдыг жинхэнээсээ хайрлах үедээ тийнхүү өгч зориулдаг.

Жинхэнэ хайр бол болзолгүй. Энэ нь хайрыг хүлээн авч байгаа хүний зан байдал эсвэл үнэ цэнээс хамаардаггүй. Энэ нь "Хэрэв та үүнийг хийж, намайг ингэж баярлуулвал би таныг хайрлана; харин хэрэв та ингэж хийж, намайг гомдоох юм бол би таныг хайрлахгүй" гэж хэлдэггүй.

Болзолтой хайр нь: "Хэрэв таны зан байдал намайг баярлуулвал, би таны хувьд утга учиртай хайрын илэрхийллээр шагнаа. Гэхдээ хэрэв та миний хүссэнийг хийхгүй бол би хайрынхаа утга учиртай илэрхийллээс татгалзах болно" гэж хэлдэг.

Жинхэнэ хайр бол болзолгүй. Энэ нь хайрлаж буй нэгэн нь юу хийсэн эсвэл хийгээгүйгээс үл хамааран өөрийгөө илэрхийлдэг. Хүлээн авагч хайраар хариу үйлдэл үзүүлж чадахгүй байсан ч, хариуд нь юу ч өгөхгүй байсан ч өөрийгөө илэрхийлдэг.

Хэн нэгнийг болзолгүйгээр хайрлана гэдэг нь тухайн хүнд хүссэн зүйлийг нь заавал өгнө гэсэн үг биш гэдгийг ойлгох нь чухал. Энэ нь тэр хүний буруу үйлдлийн үр дагаврыг арилгана гэсэн ч үг биш. Энэ нь түүний хувьд үргэлж хамгийн сайн зүйлийг хийхийг хичээнэ гэсэн үг юм. Хайртай хүмүүсээ зовж байгааг харах нь хэцүү ч, хэрэв тэд буруу зүйл хийсэн бол зовлонгийн туршлага нь тэднийг ихэвчлэн хортой зан

байдлаас нь холдуулах цорын ганц арга зам байдаг. Заримдаа хайртай хүмүүсийнхээ төлөөх хамгийн сайн зүйл нь тэднийг тэмцэлддэг зүйлд нь үлдээж, үүнтэйгээ нүүр тулах боломжийг олгох явдал юм. Харин бусад үед бид тэднийг тэмцэлддэг зүйлээсээ салахад туслах нь хамгийн сайн байдаг. Эдгээр нөхцөл байдалд юу хийхээ мэдэхийн тулд бидэнд ихэвчлэн бурханлаг зөвлөгөө болон Ариун Сүнсний тусламж хэрэгтэй байдаг.

► Бусдыг болзолгүйгээр хайрлахад юу биднийг өдөөдөг вэ?

► Нэг суралцагч Ром 5:8 эшлэлийг бүлэгт уншина.

Олон хүн Бурханы хайр нь тэдний гүйцэтгэлд суурилдаг гэж боддог. Үүнээс болж тэд бусад хүмүүсийг яагаад болзолгүйгээр хайрлах ёстойгоо ойлгодоггүй. Гэхдээ Ром 5:8 бидэнд Бурхан биднийг өөрийнх нь дайсан байхад ч хайрласан гэдгийг хэлдэг. Тэрээр биднийг нүгэлтэн байхад Аврагчийг өгсөн. Түүний бүх хүмүүсийн төлөөх хайр нь болзолгүй юм. Түүний хайр нь таны зан байдал эсвэл төгс төгөлдөр байдалд суурилдаггүй. Бурхан таныг өөрийнх нь дүр төрхөөр бүтээгдсэн хүн гэдгээр хайрладаг.

Тэр өөрөө биднийг хайрладагтай адил биднийг ч бас тийнхүү бусдыг хайрлахыг хүсдэг (Иохан 15:12, Ефес 5:2, 1 Иохан 4:11). Бид бусдыг болзолгүйгээр хайрлах хамгийн чухал шалтгаан бол Бурхан биднийг ингэж хайрлахаар дуудсан явдал юм (Матай 5:43-48, 1 Петр 4:8).

Хүмүүс өөр өөрөөр хайрыг мэдэрдэг

Бурхан олон төрөл зүйлд дуртай. Тэр хүмүүст бусдаас ялгаатай хувийн онцлог байдлыг өгдөг. Яг ижилхэн боддог, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг хүмүүс гэж байхгүй. Хувийн онцлог байдлаасаа болж, гэр бүлийн гишүүд маань биднээс арай өөр хэрэгцээтэй байдаг. Бидний ялгаатай байдал өдөр тутмын гэр бүлийн харилцаанд маань нөлөөлдөг.

Хувь хүний онцлог байдлын нэг нь тэд хайрыг хэрхэн илэрхийлдэг, мөн юу нь тэднийг бусадтай харилцах харилцаандаа хайрлагдсан, үнэлэгдсэн, аюулгүй гэж мэдэрдэг тэр зүйл юм.

Хайрыг илэрхийлэх болон хүмүүс хайрлагдсан гэдгээ мэдэрдэг олон арга зам бий. Гари Чапмен хайрын илэрхийлэл болох таван ерөнхий ангиллыг дурджээ.³⁴ Тэрээр эдгээрийг Хайрын таван хэл гэж нэрлэсэн. Хайрыг илэрхийлэх эдгээр аргууд тус бүр нь зөвхөн дан ганц үйлдэл биш, харин зан байдлын бүхэл бүтэн систем юм.

Хүн бүр энэхүү таван аргаар хайрлагдах хэрэгцээтэй байдаг ч, ихэнх хүмүүс эдгээрээс нэг төрлийн илэрхийллээр нь илүү хайрлагдсан мэдрэмжийг авдаг бололтой. Хайрын бусад илэрхийлэл нь тэдний хувьд тийм ч их утга учрыг илэрхийлдэггүй.

³⁴ Энэ хичээлийн олон санаа нь дараах номд үндэслэгдсэн болно. Gary Chapman, *The Five Love Languages: How to Express Heartfelt Commitment to Your Mate*, (Northfield Publishing, Chicago, 1995)

Хайрын таван хэл

Хүмүүс хайрыг дараах байдлаар харуулдаг:

1. Урмын үгс
2. Чанартай цаг
3. Бэлэг
4. Тусламж үзүүлэх
5. Биеэр хүрэлцэх

Үүнтэй адилаар хүмүүс хайрыг эдгээр таван аргаар таньж, хүлээн авдаг.

Хайрын үндсэн хэл

Ихэнх хүмүүс хайрыг эдгээр таван аргын аль нэг эсвэл хоёроор нь төрөлх байдлаар таньж, илэрхийлдэг. Хэрэв гэр бүлийн гишүүд хань ижил эсвэл хүүхдийнхээ үндсэн хайрын хэлээр хайраа илэрхийлэхгүй бол тухайн хүн хэдий өөр аргаар хайрлуулсан ч хайрлагдсанаа мэдрэхгүй байх боломжтой.

Зарим эмэгтэйчүүдийн хувьд ихэвчлэн хайраа дотно хүмүүстэйгээ цаг гаргах замаар илэрхийлж болно. Тэр хайртай хүмүүстэйгээ ярилцах, харилцахад бэлэн байхыг хичээдэг. Тэрээр хамтдаа үйл ажиллагаа хийхэд цаг гаргана. Үүний адил энэ нь түүний хайраа илэрхийлэх үндсэн арга учраас бусдын хайрыг өөрт нь хамгийн хялбар таниулах арга ч болдог. Хэн нэгэн түүнд цаг гаргах үед тэр хамгийн ихээр хайрлагдсанаа мэдэрдэг. Энэ эмэгтэйн хувьд нөхөр нь түүнд бэлэг авч өгөх эсвэл түүний төлөө ямар нэгэн зүйл хийх нь эмэгтэйд анхаарал хандуулж цаг гаргахаас илүү утга учиртай байж чаддаггүй.

Зарим эрэгтэйчүүдийн хувьд ихэвчлэн хайраа биеэр хүрэлцэх байдлаар илэрхийлж болно. Тэр эхнэр, хүүхдүүдээ тэвэрч, тэд түүнийг тэвэрч, ойр байхыг хүсэх үед аз жаргалыг мэдэрдэг. Тэрээр найзуудаа тэвэрч эсвэл ядаж л мөрийг нь алгадах, эсвэл тоглоомоор түлхэж, ноцолдох зэргээр хайраа илэрхийлдэг. Эрэгтэйн хувьд эхнэр нь гэр бүлийнхээ төлөө шаргуу хөдөлмөрлөж байгаад талархалтай байж болох ч эхнэрийнх нь ажил эхнэр нь түүнд хайртайг мэдрүүлж чаддаггүй. Харин эхнэр нь хажууд нь сууж, гараа түүнд өгөх, тэврэхэд эсвэл янз бүрийн байдлаар түүнд хүрэх үед тэр хайрлагдсанаа мэдэрдэг.

Машинд түлшний сав байдаг. Сав хоосон үед машин ажиллахгүй. Хүн хайрыг өөрийн танил, хэрэгцээтэй арга замаар хүлээн авах үед энэ нь сэтгэл санааных нь түлш болдог. Хүний сэтгэл санааны сав дүүрэн байх үед тэрээр бэрхшээлийн өмнө өөртөө итгэлтэй, эрч хүчтэй байж чаддаг. Тэр бусадтай хамтран ажиллаж, аливаа зөрчилдөөнийг шийдвэрлэх чадвартай болдог. Тэрээр улам бүр сайжирч, амжилтад хүрэх хүсэл тэмүүлэлтэй болдог.

Хүн өөрийн хэрэгцээтэй арга замаар хайрыг хүлээн авахгүй бол сэтгэл санаа нь түлшгүй болдог. Хүн хайрлуулж байгаага мэдэрэхгүй бол амжилтад хүрэх эсвэл сайжрах тал дээр хүчин чармайлт гаргах нь ховор болдог.

Хэрэв бид гэр бүлийн гишүүдийнхээ хайрын үндсэн хэлээр нь хайраа байнга илэрхийлэхгүй бол тэд биднийг хэр их хайрладагийг ойлгохгүй байж болно. Энэ нь бид өөрсдөө тэднийг хэр их хайрладаг гэж мэдрэхээс үл хамаарч үнэн байдаг. Бид хайраа тэдний ойлгох аргаар илэрхийлэх ёстой.

Хэрэв бид хэн нэгнийг тэдний хайрын үндсэн хэлээр нь гомдоовол энэ нь бүр ч муу юм. Жишээлбэл, хэрэв урмын үгс хүүхдийн маань хайраа илэрхийлэх хамгийн чухал арга зам байхад бид шүүмжлэн ярьсаар байвал хайрын үндсэн хэл нь өөр байснаас ч илүүгээр гомдоодог.

Нэг нэгнээ хайрлах хайраар өсөж төлөвших нь

1-р хичээлээр бид Бурхан бүх хүмүүсийг өөртэйгөө болон бусадтай харилцаатай байхаар бүтээсэн талаар сурсан. Хайрын илэрхийлэл нь харилцаа болгонд чухал хэсэг байдаг. Бидний хань ижил, хүүхдүүд болон бусад гэр бүлийн гишүүд маань хэрхэн хамгийн ихээр хайрлагдсанаа ойлгох нь чухал юм. Энэ мэдлэг нь тэдний хувьд хамгийн утга учиртай арга замаар хувьчлан хайраа илэрхийлэх боломжийг бидэнд олгодог.

Гэрлэлтийнхээ талаарх хүмүүсийн хүлээлт яв цав тохирох нь ховор. Хүмүүс өөрсдийн болон хань ижлийнхээ ялгаатай байдлаас болж ихэвчлэн урам хугардаг. Хайрын илэрхийллийн тухайд, хоёр хүн нэг ижил хайрын үндсэн хэлтэй байх нь хамгийн сайн нөхцөл мэт санагдаж болно. Хэрэв тэд энэ байдлаараа ижил төстэй байсан бол олон үл ойлголцол, бухимдлаас зайлсхийж болох байх. Хэдий тийм боловч, хэрэв хосууд гэрлэлт болон бие биенээ хайрлах хайрандаа тууштай өсч байвал энэ төрлийн ялгаа нь гэрлэлтийг бэхжүүлж чадна.

Бие биенээ ойлгохыг хичээх, бие биедээ дасан зохицох, утга учиртай байдлаар халамж анхаарал тавих үйл явц нь хүн бүрийг хөгжүүлж, жинхэнэ хайрын гайхалтай илэрхийлэл болдог. Бид гэр бүлийн гишүүдийнхээ хайрыг хүлээн авдаг арга замаар хайраа харуулах үедээ бидний зан чанар болон ойлголт маань өсөж төлөвшиж байдаг.

Эхнэр нөхөр болон бусад гэр бүлийнхэндээ хайраа илэрхийлэхдээ бид зөвхөн өөрийнхөө арга замаар хайраа илэрхийлэх, эсвэл зөвхөн хүссэн үедээ л хайраа илэрхийлэх боломжгүй гэдгийг ойлгох нь чухал юм. Хайр бол сонголт, зориулалт бөгөөд харилцааны үнэ цэнээр өдөөгддөг. Зарим тохиолдолд бид хайраа илэрхийлэх шинэ аргуудад суралцах шаардлагатай болдог. Магадгүй бид хайрыг тодорхой арга замаар илэрхийлдэг тийм гэр бүлд өсөөгүй байж болох ч, өнөөдөр гэр бүлийн гишүүн маань тэрхүү арга замаар хайрлагдах хэрэгцээтэй ч байх боломжтой. Ийм нөхцөл байдалд хайрыг танил бус аргаар

“Эзэн та нарыг хайраар бялхаан дүүргэж, бид та нарыг хайрладаг шиг та нар ч бие биеэ төдийгүй хүн бүрийг хайрлах болтугай.”

- 1 Тесалоник 3:12

илэрхийлэх нь эхэндээ хачирхалтай эсвэл таагүй санагдаж болох ч бид үүнд суралцаж чадна! Хайраа илэрхийлэхийг тааламжгүй үүрэг эсвэл тав тухгүй байдал мэтээр хэзээ ч бүү санаарай. Хэрэв бид үүргээ гүйцэтгэж байгаа мэтээр хандвал, бидний хайрын илэрхийлэл жинхэнэ хайрыг дамжуулж чадахгүй.

► Суралцагчид Ром 12:9-10, 16 ба 1 Петр 3:7-8 эшлэлийг бүлэгт уншина. Эдгээр эшлэлийг уншаад гэр бүлийн хүмүүстээ хайрыг мэдрүүлэх хамгийн тохиромжтой арга болон бид үүнд нь яагаад санаа тавих ёстой талаар хэд хэдэн шалтгааныг нэрлэнэ үү.

Хайр бол нөгөө хүнийхээ хувьд хамгийн сайн сайхан байхыг эрэлхийлж, өөрийгөө золиосолдог шийдвэр зориулалт гэдгийг санах нь чухал.

Бид төрөлхийн хувиа хичээсэн хүмүүс. Бусдыг жинхэнээр хайрлах нь бидний хэнд маань ч төрөлхийнх байгаагүй. Жинхэнэ хайр Ариун Сүнсний бидний зүрх сэтгэлд хийж буй ажлаар дамжуулан бий болдог (Ром 5:5). Итгэгчид бид Паулын Филиппой 2-р бүлэгт тайлбарласан Христийн бодол санаанд суралцах ёстой. Ингэх үедээ бид:

- Аминч хувийн ашиг сонирхлоор өдөөгдөхгүй (3-р эшлэл)
- Өөрийнхөө ач холбогдлын талаар хэтрүүлж бодохгүй (3-р эшлэл)
- Бусдыг өөрөөсөө илүү чухал гэж үзнэ (3-р эшлэл)
- Бусдын ашиг сонирхлыг хайна (4-р эшлэл)

Бид гэр бүлийн гишүүдээ хайрлахад зориулалт гаргах учиртай. Бид тэдний хэрэгцээг анзаарч, тэдгээрийг хангах арга замыг хайж сурах ёстой. Бидний зорилго бол тэднийг хамгийн их хайрлагдсанаа мэдэрдэг тийм арга замаар хайраа харуулах юм.

Бид эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүддээ ах дүү, эцэг эх, эмээ өвөө нартаа ийм байдлаар анхаарал тавихыг заах ёстой. Хүүхдүүд маань гэр бүлээ хайрлаж, үйлчлэхийг сурах хэрэгтэй. Тэд гэр бүлийнхэндээ хайраа хамгийн утга учиртай аргаар илэрхийлэхийг сурч чадна. Бид үлгэр дуурайлаар заах ёстой. Мөн бид эдгээр ойлголтуудыг тэдэнд тайлбарлахад цаг гарган, тэдгээрийг харилцаандаа хэрэгжүүлэхэд нь чиглүүлэх хэрэгтэй юм.

► Хүүхдүүдээ өөрийн гэр бүлээсээ эхлэн бусдад өөрийгөө зориулах хайрыг сурахад эцэг эхчүүд хэрхэн тусалж чадах вэ?

Хайрын хэл 1: Урмын үгс

Урмын үгс нь хайрын үндсэн хэл байдаг хүмүүс бусдаас чин сэтгэлээсээ үнэлэгдэх үгсийг сонсох үедээ хамгийн ихээр хайрлагдсанаа мэдэрдэг. Хэрэв эмэгтэй хүний хайрын үндсэн хэл нь урмын үгс бол нөхөр нь түүнтэй ярихдаа эсвэл түүний тухай ярихдаа хайраа илэрхийлж болно. Нөхөр нь эхнэртээ талархах тодорхой шалтгаануудыг дурдаж, захидал бичиж болох юм. Тэрээр бусад хүмүүстэй эхнэрийнхээ сайн зан чанар эсвэл ажлын тухай ярьж болно. Эхнэр нь нөхрийнхөө үгийг сонсох үедээ үнэлэгдэж, хайрлагдсанаа мэдэрдэг.

Бид найзуудаасаа зөвлөгөө авахдаа тэдний үнэ цэнийг нэмэгдүүлэх байдлаар асуух боломжтой. Жишээлбэл:

- “Чи үргэлж хэрэгтэй санаа хэлдэг учраас би чиний санаа бодлыг сонсмоор байна...”
- “Чи энэ асуудалд туршлагатай, би чиний зөвлөгөөг сонсохыг маш их хүсэж байна.”
- “Чи ____-ын талаар надаас илүү ихийг мэднэ, тиймээс чамд ямар нэгэн санал эсвэл зөвлөмж байвал би дуртайяа сонсоно.”

Бүх урмын үгсийг чин сэтгэлээсээ хэлэх ёстой. Үгүй бол тэдгээр нь хэрэгцээгүй эсвэл бүр хор хөнөөлтэй ч байж мэднэ. Чин сэтгэлийн бус урмын үгс нь харилцааг сулруулдаг. Тэдгээр нь үнэн дээр суурилагагүй тул сонсогч нь хэлж буй хүний сэдэлд үнэмшиж чадахгүй.

Чин сэтгэлийн урмын үгс нь бодит байдалд нийцсэн байдаг. Тэдгээр нь хуурамч эсвэл хэтрүүлэг биш. Чин сэтгэлийн урмын үгс нь зүрх сэтгэлээс илэрхийлэгддэг. Хэлж буй зүйл нь тухайн хүнийг үнэхээр мэдэрч, итгэж буй зүйл байдаг.

Урмын үгс нь сонсогчийг цаашдын өсөлт, ирээдүйн амжилтад өдөөж болох ч, хэзээ ч хуурч ашигласан байх ёсгүй. Бид бусдыг урмын үгсээр хянах гэж оролдож болохгүй.

► Нэг суралцагч Ефес 4:29 эшлэлийг бүлэгт уншина. Энд хэлэх ёсгүй зүйлсийн талаар хэрхэн тодорхойлсон бэ? Бид үгээрээ юуг гүйцэлдүүлдэг вэ? Зарим үгс нэг нөхцөл байдалд тохиромжтой ч, өөр үед тохирохгүй байх уу?

Бусдад хэлэх үгс маань үргэлж зохистой, нигүүлсэнгүй байх ёстой. Хэлж байгаа зүйлс маань бидний ярьж байгаа хүмүүсийн амьдралд Бурхан ажиллах боломжийг олгох учиртай. Бидний хэлэх зүйлс сүйтгэдэг биш, харин бүтээж байгуулдаг байх ёстой. Энэ нь эдгэрэл, эрүүл байдлыг дэмжих ёстой болохоос хор хөнөөл учруулах ёсгүй.

Урмын үгсийн төрлүүд

Урмын үгс нь олон янз байж болно. Бүх урмын үгс ижил үнэ цэнэ эсвэл ач холбогдолтой биш. Илүү өндөр түвшний урмын үгс нь тэдгээрийг хэлж буй хүнээс илүү их бодох, хүчин чармайлт шаарддаг. Заримдаа тэдгээрийг хэлэх нь эвгүй санагдаж болох ч, эдгээр үгс нь хайрыг хамгийн хүчтэй, утга учиртай байдлаар илэрхийлдэг.

Үзэгдэх байдалд чиглэгдсэн

Хэн нэгний гадаад төрхийг магтах нь урам өгөх нэг арга байж болно. Ялангуяа энэ нь тухайн хүний хүчин чармайлт эсвэл хувийн онцлог байдлаа илэрхийлж буй арга барилыг нь онцлон сайшаах тохиолдолд. Гэсэн хэдий ч, хэн нэгний гадаад төрхийг магтах нь (ялангуяа энэ нь тухайн хүний мөн чанартай холбоогүй тохиолдолд) урмын үгсийн гүехэн хэлбэр юм.

Бусдын анхаарлыг татдаг хүмүүс ихэвчлэн магтаал сонсдогоос болж өөрийн гадаад төрх байдалдаа итгэлгүй байх, өөрийнх нь үнэ цэн үүнээс хамаардаг мэтээр мэдэрч, төгс байх ёстой гэж боддог.

Хувийн үнэ цэн нь гадаад төрх байдлаар тодорхойлогдохгүй. Мөн хувь хүмүүсийн бие махбодын гоо үзэмжийг сайжруулах зүйлсэд хязгаар бий. Эдгээрээс шалтгаалан энэ төрлийн урмын үгсийг хэтрүүлэн хэрэглэх ёсгүй.

Амжилт, гүйцэтгэлд чиглэгдсэн

Хэн нэгэнд урам өгөх өөр нэг арга бол түүний амжилт, гүйцэтгэлийг магтах явдал юм. Ярьж буй хүн нөгөө хүнийхээ хийсэн үйлдлийг үл тоомсорлохын оронд түүний хийсэн зүйлийг үнэлэхэд цаг гаргах хэрэгтэй.

Жишээ:

- Эхнэр нь нөхрийгөө зорьж байсан амаргүй зорилгодоо хүрснийх нь төлөө магтаж болно.
- Нөхөр нь өөрийнх нь төслийн ажилд тусалсан эхнэрийнхээ хийсэн зүйлсийг анзаарч, талархлаа илэрхийлж болно.
- Өөрсдөд нь зориулж амттай хоол хийсэн тогоочид гэр бүлээрээ талархаж болно.

Гүйцэтгэл эсвэл амжилтыг нь үнэлэхдээ тухайн хүнийг хайрладаг хайр нь түүний гүйцэтгэлээс хамаардаг гэж бодохоос зайлсхийгээрэй. Жишээлбэл, хүүгээ шалгалтанд сайн оноо авсан учраас бахархаж байна гэж хэлснээр түүнийг оноо бага авбал та бага хайрлах болно гэж мэдрүүлж болох юм. Харин үүний оронд тухайн хүний үнэ цэнийг нэмэгдүүлэх байдлаар "Чи тэр шалгалтанд сайн оноо авсанд би баяртай байна. Суралцах хариуцлагаа үүрч, чадах бүхнээ хийсэнд чинь би бахархаж байна" гэж хэлж болно. Гэхдээ та яаж хийхээс үл хамааран, тухайн хүний хувьд чухал ач холбогдолтой амжилтыг нь үнэлж сайшаахаа битгий мартаарай.

Зан чанар, хүчин чармайлтыг онцлох байдлаар

Зөвхөн сайн гүйцэтгэлд нь урам өгөхийн оронд хүний зан чанар болон түүнийг амжилтад хүргэсэн хүчин чармайлтыг нь онцлох нь хамгийн сайн арга юм. Жишээлбэл, спортоор хичээллэдэг бага насны хүүхдийн хувьд тэмцээнд ялахаас илүү шаргуу хүчин чармайлт, түүний сайн хандлагыг нь магтах ёстой. Цөөн хүмүүс үргэлж гүйцэтгэлээрээ онцгойрч чаддаг бол зарим нь сайн зан чанарыг харуулахыг сонгож чаддаг. Зан чанар бол хамгийн чухал юм.

Хэн нэгнийг байгаагаар нь онцлон сайшаах

Хамгийн сайн урмын үгс нь тухайн хүний хувийн зан чанар, хувийн чанар, онцлог байдалд зориулагдсан байдаг. Энэ төрлийн урмын үгс нь амжилт гүйцэтгэлд өгөх урмын үгсээс илүү хүчтэй байдаг. Энэ нь өөрчлөгддөг нөхцөл байдал дээр биш, харин тухайн хүний өөрийн үнэ цэн дээр суурилдаг учраас тэр юм.

Жишээ:

- “Хүүхдүүд танд их татагддаг юм байна! Та тэдний асуултуудад маш тэвчээртэй хандаж, асуусан зүйлийг нь маш сайн тайлбарлаж өгдөг юм байна.”
- “Би танд ажлаа даатгая. Учир нь та итгэл даах хүн гэдгийг би мэдсэн.”

Энэ төрлийн урмын үгс нь Бурхан хэн нэгний амьдралд хэрхэн ажиллаж, тэднийг тодорхой арга зам болон тодорхой зүйлийг хийх боломжоор хангаж буй зэргийг олж танихтай нягт холбогддог.

Жишээ:

- “Залуу хүмүүсийг халамжлах ажилд Бурхан таныг хэрхэн ашиглаж байгааг би харахдаа баяртай байдаг. Таны амьдралыг харахдаа Есүсийн төлөө амьдрахыг хүсэж байна гэж тэдний нэг нь надад хэлсэн!”
- “Энэ хүнд хэцүү ажлыг дуусгахад Бурхан танд тусална гэдэгт би итгэж байна. Би таны төлөө залбирах болно!”

Хэн нэгэнтэй харилцаатай, хамт байгаадаа баярлаж талархсанаа илэрхийлэх нь урмын үгсийн хамгийн хүчтэй хэлбэрүүдийн нэг юм. Тэдгээр нь тухайн хүний үнэ цэнийг илэрхийлдэг.

Жишээ:

- “Таныг байхад гэр бүлийн цугларалтууд үргэлж илүү онцгой болж байдаг.”
- “Би тантай хамт байх дуртай.”
- “Та надад эрхэм нандин бөгөөд би таныг хайрладаг!”

Бидний хэлдэг үг, урмын үгстэй холбоотой тэмдэглэх чухал зүйлс

1. Хүний бие махбодын онцлогийг хэзээ ч шүүмжлэх эсвэл шоолох ёсгүй. Хүмүүс бие махбодын онцлогоо насан туршдаа тээж явах болно. Хэзээ ч хэн нэгэнд бие махбодын онцлог, ялангуяа дутагдал дээр нь үндэслэсэн нэр хоч бүү өг.
2. Давуу тал, зан чанар, сайн зан байдлыг нь сайшаан үнэлэх нь сонсогчид үүнийгээ үргэлжлүүлэн хөгжүүлэхэд урмыг өгдөг. Дутагдлыг зааж сануулах нь ихэвчлэн тус болдоггүй.
3. Зөвлөгөө нь сонсогч хүнд өөрөө алдаатай байна гэсэн агуулгаар сонсогдож болно. Харин урмын үгс нь хүнд зөвлөгөө авах үедээ илүү аюулгүй мэдрэмжийг авахад нь тусалдаг. Хэрэв та хэн нэгэнд зөвлөгөө өгөх шаардлагатай бол, зөвлөгөөний хамт хүчтэй урмын үгсийг санал болгоорой.
4. Гомдол хэлбэрийн санал нь өдөөлт болж чаддаггүй. Жишээлбэл, ямар нэгэн ажлыг аль хэдийн хийсэн байх ёстой байсан гэж хэлэх, эсвэл хэн нэгэн үүнийг хийж чадаагүйд ичгэвтэр байгаагаа илэрхийлэх нь тус болохгүй. Эдгээр үгс нь

тухайн хүнийг аль хэдийн бүтэлгүйтсэн мэтээр мэдрүүлдэг. Хэрэв тэр тухайн ажлыг хожимдуулсан байсан ч хэдийн бүтэлгүйтсэн мэтээр мэдрэх болно.

Гомдоох үгс

Урмын үгс хамгийн их хэрэгтэй байдаг хүн үүний эсрэг утгатай үгсэд хамгийн их эмзэглэдэг. Шүүмжлэл түүнийг ихээр өвтгөх бөгөөд хувь хүнийхээ үнэ цэнд эргэлзэхэд хүргэдэг. Ууртай түргэн үгс нь хүнд хэзээ ч эдгэхгүй сэтгэл санааны шарх учруулдаг. Ялангуяа ийм үг хэлсэн хүн өөрөө өвдөлтийг нь ойлгохгүй, хэзээ ч уучлалт гуйхгүй тохиолдолд энэ нь бүр ч үнэн байдаг.

Хамгийн хүчтэй урмын үгс хүний үнэ цэнтэй холбоотой байдаг шиг, хамгийн өөдгүй, гомдоох үгс хувь хүн рүү нь халдсан байдаг. Жишээлбэл, "Би тантай хэзээ ч уулзаагүй байсан бол."

Өөр өвтгөх үгс нь тухайн хүний мөн чанарт хандсан үгс байдаг: "Та ____ юм." Зан байдлын талаарх хортой үгс нь "Та үргэлж ____ хийдэг" эсвэл "Та хэзээ ч ____ хийдэггүй" гэж эхэлдэг. Эдгээр үгс нь тухайн хүний дутагдал мөн чанартай нь холбоотой бөгөөд өөрчлөгдөхгүй, сайжрах боломжгүй гэсэн утгыг агуулдаг.

Хэрэв хэн нэгэн шархадсан бол (ялангуяа хайрын үндсэн хэлээр шарх олсон бол) тэрээр дараа дараагийн гэмтлээс зугтаахыг төрөлх байдлаараа хичээх болно. Сөрөг үг хэрэглэдэг хүмүүс ихэвчлэн эерэг үг хэлдэггүй учраас сонсогч нь өөрийн зан байдлаа өөрчлөх илүү дээр аргыг олох найдвар бага байдаг. Тэрээр хайрыг олж авахын тулд зан байдлаа сайжруулах ямар ч өдөөлтгүй болдог.

Заримдаа ууртай хүмүүс бусдыг өвтгөхийг хүссэн учраас гомдоох үг хэлдэг. Заримдаа хүн сайн санаа өвөрлөж хэлсэн ч бусдыг өвтгөх үгийг хэлсэн байдаг. Өөр зарим нь сөрөг үгсийг ашиглан хэн нэгнийг илүү сайн зан байдалд авчрахыг хичээдэг ч энэ нь бараг л дэмий хоосон зүйл болдог.

► Нэг суралцагч Колоссай 3:8 эшлэлийг бүлэгт уншина. Итгэгчид Бурханы эсрэг болон бусдын эсрэг ийм байдлаар үргэлжлүүлэн нүгэл үйлдэх ёсгүй.

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Жинхэнэ хайрыг өөрийн үгээр тодорхойлно уу. Ариун Сүнс бидэнд бусдыг зохих ёсоор хайрлахад яагаад туслах ёстой вэ?
- ▶ Хэн нэгнийг болзолгүйгээр хайрлана гэдэг нь юу гэсэн үг болохыг тайлбарла. Бурханаас танд хандсан болзолгүй хайрын ач холбогдол юу вэ?
- ▶ Эхнэр эсвэл хүүхдэдээ хайраа тэдний хайрын үндсэн хэлээр илэрхийлэх нь яагаад онцгой чухал вэ?
- ▶ Урмын үгсийг хүлээн авах нь танд ямар тустай байсан бэ?
- ▶ Энэ долоо хоногт та гэр бүлийнхэндээ урмын үгсээр хайраа хэрхэн илэрхийлэв?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Жинхэнэ, болзолгүй хайрын талаар надад заасанд талархъя. Үүнийг өөрийн Үгээр тодорхойлж, надад хандсан хайраараа үлгэрлэсэнд баярлалаа.

Христ намайг хайрлаж, үйлчилсэн шиг гэр бүлээ хайрлаж, үйлчилж сурахад надад туслаач. Миний хань, хүүхдүүд, ах дүү, эцэг эхийнхээ сайн сайхан байдалд анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгооч.

Миний хэлэх үгсийн ач холбогдлыг сануулсанд талархъя. Би бусдыг гомдоосон, таныг үл хүндэтгэсэн үгсийг хэлсэндээ уучлалт гуйж байна. Миний үгс урам нэмж, босгон байгуулж, эдгээдэг байх ёстойг санаж байхад надад туслаач.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Бат бэх гэр бүлтэй хостой ярилцаж, тэдний амьдралаас суралцахын тулд асуултууд тавиарай. Ярилцлага дууссаны дараа тэдний хуваалцсан ойлголтууд болон өөрийн гэрлэлтдээ хэрэгжүүлэхийг хүсэж буй зүйлсийн талаар хоёр догол мөрөнд багтаан бичнэ үү.

Асуух асуултуудын зарим санаа:

- Та хоёрын хувийн онцлог байдлын ялгаа нь та нарын харилцаанд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Та хоёр эдгээр ялгаанаас болж хэрхэн өсөж хөгжсөн бэ?
- Та хоёр бие биенээ хүндэлж, үйлчлэхийн тулд хүлээлт, үзэл бодол, зан байдлаа хэрхэн нийцүүлэх шаардлага тулгардаг вэ?
- Та хоёрт бие биедээ хайраа илэрхийлэх ямар практик аргууд байдаг вэ?
- Таны хань юу хийх эсвэл юу хэлэх нь таныг хайрлагдсанаа мэдрэхэд тусалдаг вэ?
- Таны ханьтайгаа харилцах харилцаа таны Бурхантай харилцах харилцаанд хэрхэн нөлөөлсөн бэ?

(2) Сургаалт үгс 31:10-31 эшлэлд бичигчийн эхнэртээ зориулсан олон урмын үгсийг багтаасан байдаг. Эмэгтэйн зан байдал, үгсийг тодорхойлсон байдал нь түүний зан чанарын талаар бидэнд хэлж өгдөг. Тэр эхнэрийнхээ аль талыг сайшаан урамшуулсан бэ? Энэ эшлэлээс дараах зүйлсийг хайж олоорой:

- Түүний гадаад төрх
- Түүний үйлчлэл, ололт амжилт
- Түүний зан чанар, хүчин чармайлт
- Хувь хүнийхээ хувьд тэр хэн байв?
- Итгэгч хүнийхээ хувьд тэр хэн байв?

Энэ эшлэлд онцолсон зүйлсээс бид юу сурч чадах вэ?

9-р хичээл

Хайрын таван хэл – 2-р хэсэг

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Хайрыг илэрхийлэх таван хэлийг ойлгох.
- (2) Хайрын таван хэл тус бүрийг буруу ашиглах эсвэл үл тоомсорлох аюулын талаар хэлэлцэх.
- (3) Хүүхдийн сэтгэл санааны сав дүүрэн байх нь ямар ашиг тустай болохыг тайлбарлах.
- (4) Гэр бүл, ойр дотно хүмүүсийнхээ хайрын үндсэн хэлийг тодорхойлох.
- (5) Гэр бүлийнхээ хүн нэг бүр дээр хайрын таван хэл тус бүрээр хайраа илэрхийлэх тодорхой аргуудыг жагсаах.
- (6) Гэр бүлийнхээ хүмүүсийн хайрын үндсэн хэлээр нь хайраа харуулахыг зорих.

Танилцуулга

Өнгөрсөн хичээлээр бид өөрийгөө золиосолдог, болзолгүй хайрын тухай сурсан. Мөн хайрыг илэрхийлэх дор хаяж таван өөр арга (хэл) байдаг болохыг мэдсэн. Ихэнх хүмүүс хайрыг эдгээр таван аргын аль нэг эсвэл хоёроор нь төрөлх байдлаар таньж, илэрхийлдэг.

Бид урмын үгсийн талаар ярилцаж, гэр бүлийн хүмүүстээ хайраа илэрхийлэх практик аргуудыг олж мэдсэн. Энэ хичээлээр бид хайрын бусад дөрвөн хэлийг судалж, дараа нь хүүхдэдээ хайраа илэрхийлэх тодорхой хэрэгжүүлэлт хийх болно.

Хайрын хэл 2: Чанартай цаг

Хайрын үндсэн хэл нь чанартай цаг байдаг хүмүүс хэн нэгэн тэдэнтэй хамт байхын тулд зориуд цаг гаргах үед хамгийн ихээр хайрлагдсанаа мэдэрдэг. Энэ цаг нь хамтдаа байх, бие биедээ анхаарал хандуулахын тулд сайтар бэлдсэн цаг байдаг. Энэ бол хөгжилдөх, нөхөрлөлийн цаг юм.

Чанартай цаг нь санамсаргүй гаргасан эсвэл илүүдэл цаг биш. Хэрэв та замын түгжрэлд зогсож байгаа эсвэл уулзалтаа хүлээж байгаа бол цагийг ухаалгаар ашиглах ёстой, гэхдээ эдгээр цаг нь ихэвчлэн зориудаар гаргасан чанартай цаг байдаггүй. Та хань ижилтэйгээ эсвэл хүүхэдтэйгээ хамт ямар нэг ажил төсөл хийж болно. Мэдээж энэ цаг нь үнэ цэнтэй ч, тэдний төлөө чанартай цагийг хамт өнгөрөөх хэрэгцээг нь үргэлж хангахгүй.

Яриаг нь таслахгүй сонсох нь чанартай цагийн хамгийн сайн хэлбэрүүдийн нэг юм. Ийм ярианд хүн бүр нөгөө хүнээ анхааралтай сонсдог. Мессеж, утасны дуудлага гэх мэт саадгүйгээр ярилцдаг. Ингэснээр тухайн хүн нөгөө хүндээ болон яриандаа төвлөрч чаддаг.

Хүнийг анхааралтай сонсож байгаагаа илэрхийлэх хэд хэдэн арга бий:

- 1. Нүдээрээ харилцах.**
- 2. Идэвхтэй сонсох.** Нөгөө хүний хэлж байгаа зүйлд хариу өг. Дараа нь юу хэлэхээ бодохын оронд, нөгөө хүний юу бодож, юу хэлж байгааг үнэн зөвөөр ойлгосон эсэхээ шалгахад цаг гарга. "Хэрэв би таныг зөв сонсож байгаа бол та ийм зүйлийг мэдэрч байна уу..." гэх зэргээр хэлж зөв ойлгосон эсэхээ баталж болно.
- 3. Бүү тасал.** Сонсогч ихэвчлэн санаагаа ойлгосон гэж бодоод, дараа нь өөрийнхөө бодлыг хэлэхийн тулд хүний яриаг хурдан тасалдаг. Энэ нь сонсож буй хүн түүний яриаг үнэхээр ойлгоё гэж хичээхгүй байгаа мэт мэдрэмж төрүүлдэг.
- 4. Зөвхөн хэлж буй зүйлийг бус, мэдрэмжийг сонс.** Бид бусад хүний үзэл бодлыг ойлгохыг хичээснээрээ тэднийг үнэ цэнтэй гэж бодож байгаагаа харуулдаг. Чин сэтгэлээсээ сонссоноор бид тэдний үзэл бодол, мэдрэмж нь бидэнд чухал болохыг, мөн тэд өөрсдөө бидэнд чухал болохыг илэрхийлдэг!

Хамгийн сайн чанартай цаг бол хоорондоо харилцахдаа өөр юу ч хийхгүй байгаа үе юм. Гэхдээ хамтдаа өнгөрөөх бусад цаг хугацаа ч бас үнэ цэнтэй. Гэр бүлийнхэнтэйгээ өдөр бүр хооллох үедээ хамтдаа чанартай цагийг өнгөрөөж, хамтдаа хооллох үедээ бие биедээ зориудаар анхаарал хандуулах боломжтой.

Бага насны хүүхдүүдэд үлгэр уншиж өгөх, хамтдаа тоглох, эсвэл хамтдаа амралт зугаалга хийх нь гэр бүлтэйгээ чанартай цаг гаргах бусад аргууд юм. Сургууль, ажил, үйлчлэлд зориулагдаагүй харин зөвхөн хөгжилдөхийн тулд хамтдаа ямар нэг төсөл, урлал хийх нь мөн чанартай цаг байдаг.

Хэн нэгэн гэр бүлээсээ хол байх үед чанартай цагийг утсаар ярьж гаргах боломжтой.

Чанартай цаг гэдэг нь бие биедээ анхаарлаа төвлөрүүлж, бие биенийхээ нөхөрлөлийг таашаахын тулд тусгайлан гаргасан, өөр зүйлд сатаарахгүй, яарах зүйлгүй цаг хугацаа юм. Өдөр бүр хань ижил, хүүхдүүдтэйгээ тодорхой хэмжээний чанартай цаг гаргах нь хамгийн сайн байдаг.

Тусгайлан гаргах боломжгүй цаг

Эхнэр эсвэл эцэг эх нь үйлчлэлийн удирдагч бол гэр бүлтэйгээ чанартай цаг гаргах нь илүү хэцүү байдаг. Пасторуудын хүүхдүүдэд ийм зүйл их тохиолддог. Бусад хүмүүс аавтай нь холбогдож, анхаарлыг нь татах үед тэрээр хүүхдүүддээ хангалттай цагийг гаргаж чаддаггүй бөгөөд хүүхдүүд нь аавыгаа дэндүү завгүй, цаг гаргадаггүй гэж

мэдэрдэг. Гэр бүлийн цаг нь ихэвчлэн үйлчлэлийн төлөө золиослогддог цаг мэтээр тэдэнд санагддаг.

Үйлчлэлд байгаа хүний хувьд ийм саад тасалдуулах зүйлээс бүрэн зайлсхийх боломжгүй ч, гэр бүлдээ цаг гаргахыг хичээх ёстой. Хэрэв та ингэж хийвэл, тэд таны тогтмол үүрэг хариуцлага болон нэмэлт, хойшлуулашгүй байдлаар гарч ирдэг зүйлсийг сайн ойлгох болно.

Хайрын үндсэн хэл нь чанартай цаг байдаг хүн гэр бүлийнхэнтэйгээ зориудын, төвлөрсөн цагт байхгүй л бол хамгийн бага хайрлагдсан гэж мэдэрдэг. Тэрээр чанартай цагийг чухалчлаагүй үед, мөн энэ цагийг алдагдуулдаг саад гарч ирэхэд, чанартай цагийн төлөвлөгөө хойшлогдох зэрэгт хамгийн их гомддог. Гэр бүлийнхэн нь түүнтэй цаг өнгөрөөж амжихгүй хэт завгүй байх нь түүнд хэцүү санагддаг. Гэр бүлийн хүмүүс нь түүнийг бүрэн анхааралтай сонсохгүй байх үед тэрээр өөрийгөө үнэ цэнгүй мэтээр мэдэрдэг.

Хэрэв та хань ижил эсвэл хүүхдэдээ хувьчлан анхаарал хандуулахгүй байгаа бол, тэдний төлөө хэдий их зүйлийг хийсэн ч тэд таны хайрыг мэдрэхгүй байх боломжтой. Эрэгтэй хүн гэр бүлийнхээ төлөө шаргуу ажилладаг ч, эхнэртээ цаг гаргахгүй хэт завгүй байгаагаас болж тэр хайрлагдаагүй мэтээр мэдэрдэг.

Нэгэн бяцхан хүү аавдаа саяхан сонссон түүхээ ярихаар очжээ. Аав нь ном уншиж байсан боловч хэсэг зогсоод хүүгээ сонсож, улмаар хүү нь түүхээ ярьсаар дунд хэсэгт очих үед аав нь номоо үргэлжлүүлэн уншжээ. Энэ хүүгийн хувьд тухайн мөчид мэдэрсэн зүйлээ бүх амьдралынхаа туршид санах болно.

► Танай гэр бүлийн хувьд чанартай цаг ихэвчлэн ямар байдаг вэ? Та нар утга учиртай цагийг хамтдаа өнгөрөөхийн тулд ямар саад бэрхшээлийг даван туулах шаардлагатай болдог вэ?

Хайрын хэл 3: Бэлэг

Хайрын үндсэн хэл нь бэлэг хүлээн авах байдаг хүмүүс хэн нэгэн өөрийг нь бодож байгаагаа харуулсан зүйл өгөх үед хамгийн ихээр хайрлагдсанаа мэдэрдэг.

Хүнийг хайрлагдсан гэдгийг мэдрүүлдэг бэлэг нь бодож бэлтгэсэн бэлэг байдаг. Ийм бэлгийг тухайн хүний сонирхлыг харгалзан сонгосон байдаг. Тэдгээр нь заавал практик эсвэл хэрэгтэй бэлэг байх шаардлагагүй. Хайрын бэлгийг зөвхөн өгч байгаа хүн эдгээрийг хүсэхээ больсон учраас өгөхөө больдоггүй. Бэлгийг өгч буй хүн өөрөө үүнийг зорилготойгоор сонгож, өгдөг.

Хүнийг хайрлагдсан гэдгийг мэдрүүлдэг бэлэг нь үнэтэй байх албагүй. Энэ нь нэг удаагийн онцгой хоол эсвэл амттан зэрэг хэсэг зуур үргэлжлэх зүйл ч байж болно. Эсвэл энэ нь бэлэг өгсөн хүний харилцааг байнга сануулах харагдахуйц зүйл байж болно. Хайрын үндсэн хэл нь бэлэг хүлээн авах байдаг хүмүүсийн хувьд төрсөн өдөр, ой, баяр ёслол маш чухал юм. Эдгээр өдрүүдийг гэр бүлийн хүмүүс нь санаж, тухайн

хүнд онцгой бэлэг бэлдэх нь маш чухал байдаг. Эдгээр онцгой өдрүүдэд бэлэг хүлээн авахгүй байх нь энэ хүнд маш муухай сэтгэгдэл төрүүлдэг.

Бэлэг өгөх нь зөвхөн онцгой өдрүүдээр хязгаарлагдах ёсгүй. Энэ нь амьдралын байнгын хэв маяг байх ёстой. Хайрын үндсэн хэл нь бэлэг хүлээн авах байдаг хүний хань ижил, эцэг эх, эсвэл хүүхэд нь хайртай хүнээ бодож, хайрладаг гэдгийг сануулахад туслах бэлэг хайх зуршилтай болох ёстой.

Хайрын үндсэн хэл нь бэлэг хүлээн авах байдаг эмэгтэй хүн нөхөр нь мөнгөө хэмнэж ямар ч байсан түүнд хэрэгтэй байсан ердийн зүйлийг авч өглөө гэж бодвол хайрлагдаагүй мэдрэмж ихээр тээх болно. Магадгүй түүнд шинэ шүүр хэрэгтэй байгаад нөхөр нь түүнд нэгийг авч өглөө ч тэр бэлэг нь түүнийг хайрлагдсанаа мэдрэхэд тус болохгүй.

Бэлэг нь хүлээн авагчийг ойлгож, халамжилсныг харуулах үедээ үнэ цэнтэй болдог. Тэдгээр нь шаардлагагүй байхдаа чухал ач холбогдолтой байдаг. Бэлэг нь бодол, хүчин чармайлт, үнэ өртөг шингэсэн үедээ ач холбогдолтой байдаг.

Хайрын үндсэн хэл нь бэлэг хүлээн авах байдаг хүүхдүүдийн хувьд аав нь тэдний сургуулийн төлбөрийг төлөхөөс илүүтэйгээр (хэдийгээр сургуулийн төлбөр нь хамаагүй том, илүү чухал байсан ч гэсэн) зайрмаг авч өгөхөд нь илүү ихээр хайрлагдсанаа мэдэрдэг. Та гэр бүлийнхэндээ байнга өгдөг зүйлээ үнэлэхийг тэднээс шаардахын оронд, тэдэнд зориулж онцгой зүйл хийх арга замыг олоорой.

Зарим хүмүүс хүүхдүүд эсвэл хань ижлээрээ бүх зүйлийг гуйлгадаг. Тооцоотой, өөртөө ховорхон юм худалдаж авдаг хүний хувьд өгөөмөр байж, шаардлагагүй мэт санагдах бэлэг өгөх нь амар биш байж болно. Гэр бүлийнхэн нь бэлэг хүлээж эхлэхийг тэр хүсдэггүй. Гэхдээ түүний хань эсвэл хүүхдийнх нь хувьд бэлэг чухал бол тэр өөрийн төрөлх хандлагаа даван туулахын тулд хичээх ёстой. Тэрээр бэлгийг тэдний хардаг шиг (чухал бөгөөд үнэ цэнтэй) гэж харахыг хичээх учиртай. Бэлэг өгөхдөө, баяр хөөртэйгөөр, чөлөөтэй өгч байгаарай!

► Нэг суралцагч 2 Коринт 9:6-9 эшлэлийг бүлэгт уншина. Энэ эшлэлд Паул Коринтын итгэгчдийг хэрэгцээтэй байгаа бусад итгэгчдэд өгөөмрөөр өгөхийг уриалж байна. Эдгээр эшлэлээс өгөөмөр байх дөрөв эсвэл таван өдөөгч зүйлсийг тодорхойлно уу. Энэ эшлэлийн зарчмууд манай гэр бүл дэх өгөөмөр байдалд ямар байдлаар хамаарах вэ?

► Танай гэр бүлд бэлэг өгөх нь ямар байр суурь эзэлдэг вэ? Та бэлэг өгөх замаар хайрыг илэрхийлэхэд ямар нэгэн хүндрэлтэй тулгардаг уу? Эдгээр хүндрэлүүд юу вэ, мөн та тэдгээрийг хэрхэн даван туулж чадах вэ?

Хайрын хэл 4: Тусламж үзүүлэх

Үндсэн хайрын хэл нь тусламж үзүүлэх байдаг хүмүүс хэн нэгэн хүн тэдний төлөө ямар нэгэн зүйл хийх үед хамгийн ихээр хайрлагдсанаа мэдэрдэг.

Тусламж үзүүлэх нь практик хэрэгцээг хангадаг. Тэдгээр нь тухайн хүн өөрөө хийж чадахгүй байсан зүйл байж болно, эсвэл үгүй ч байж болно. Тусламж нь хэн нэгэнд уух зүйл аваачиж өгөх зэрэг энгийн зүйлээс эхэлнэ. Өвчтэй хүнийг асарч болно. Хэрэгцээтэй нөхцөл байдалд нь туслах гэх мэт.

Ихэнх гэр бүлийн хувьд гэр бүлийн хэн нэгэн нь удаан хугацаанд хувийн асаргаа шаарддаг тийм үеийг туулдаг. Гэр бүлийн хайр, зориулалтын ачаар тухайн хүн тогтмол олон тооны тусламжийг хүлээн авдаг. Хэдийгээр тусламж үзүүлэх нь маш их цаг хугацааг зориулж байгаа ч, гэр бүлийн гишүүд хайраа илүү утга учиртай илэрхийлэх бусад аргыг ч санах ёстой (ялангуяа тухайн хүний хайрын үндсэн хэл нь тусламж биш бол).

Зарим тусламжийг тогтмол удаан хугацаанд үзүүлснээс болоод үл тоогдох, байдаг л зүйл мэт болж орхидог. Олон эмэгтэйчүүд өдөр тутмын хоол хийх болон гэрийн ажлаараа хайраа илэрхийлдэг. Эрэгтэй хүн гэр бүлээ хангахын тулд ажилладаг байж болно. Хэрэв аль аль нь гэр бүлийнхээ төлөө өдөр тутам ийм байдлаар үйлчилж байгаа бол, ялангуяа хайрын үндсэн хэл нь тусламж үзүүлэх байдаг нэгэндээ онцгой байдлаар тусламж үзүүлэхийг эрэлхийлэх хэрэгтэй.

Эхнэр нь нөхрийнхөө жижиг хэрэгцээнд анхаарал хандуулахгүй байх үед энэхүү хайрын хэлээр ярьж чадахгүй байна гэсэн үг. Магадгүй тэрээр "Тэр өөрөө ус ууж чадна" гэж бодож болох юм. Гэхдээ эхнэр нь түүнд ус аваачиж өгсөн бол энэ нь нөхөрт нь түүний онцгой хайрыг илэрхийлэх ч байсан болов уу.

Үүнтэй адилаар, нөхөр нь анхаарал тавих ёстой. Тэрээр эхнэрийнхээ байнга хийдэг ажлыг өөрөө хийж, түүнд амралт өгөхдөө түүний үүргийг хүндэтгэж, эхнэрийнх нь ажил нь хүнд хэцүү бөгөөд чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байдаг.

Эрэгтэй хүн өөрийгөө аль хэдийн хангалттай ажилласан, ар гэрийн бүх ажлыг эхнэр нь хариуцах ёстой гэж мэдэрч болно. Нөхөр нь эхнэрээ одоо байгаагаасаа илүү үр дүнтэй байх ёстой гэж бодож ч болно. Хэрэв тэрээр ар гэрийн ажлыг өөрийн нэр хүндээс доогуур гэж үзвэл, энэ нь тухайн нөхөр эмэгтэй хүнийг дорд үзэж, бага ажил хийх ёстой гэж үздэг болохыг харуулж байна. Эмэгтэй хүн дорд биш, мөн гэрийн ажил нь гэрийн гаднах ажлаас доогуур ажил биш юм.

Эрэгтэй хүн гэртээ туслахдаа зарцын (эхнэрээсээ доогуур) үүрэг гүйцэтгэж байна гэж мэдэрч болох ч, энэ нь үнэн биш юм. Хэрэв тэр сайн дураараа ажилд нь тусалдаг бол үүгээрээ гэр бүлийн хүнийхээ үнэ цэнийг батлан харуулж байдаг. Түүний үзүүлсэн тусламж нь энэ ажлыг ердийн байдлаар хийдэг хүнийг хүндэтгэж, түүнийг үнэлж буйгаа харуулдаг. Эхнэр нь түүнийг зарц гэж бус, харин илүү хүндэтгэлтэй хүн гэж харах болно.

Хэрэв хүн дурамжхан бөгөөд дургүйцсэн хандлагаар туславал, тэр нь хүчээр туслахад хүргэж байна гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ тохиолдолд тэдний тусламж үзүүлэх нь хайрыг дамжуулахгүй. Хэрэв тэд тусламжийг баяр хөөртэйгөөр үзүүлж, чадах бүхнээ

хийвэл, энэ нь тухайн хүн сайн дураараа туслахыг сонгож байгааг харуулдаг. Учир нь хэн ч тэднийг тийнхүү үйлчлэхийг албадаж чадахгүй. Ингэж баяртайгаар тусламж үзүүлэх нь тэдний хайрыг маш тодорхой байдлаар илэрхийлдэг. Энэ нь мөн хайртай хүнийхээ хүндэтгэлийг хүлээхэд тэдэнд тусалдаг.

► Та гэр бүлдээ үйлчлэх нь хэзээ хамгийн хэцүү байдаг вэ? Тусламж үзүүлэх нь хайрын илэрхийлэл гэж бодох нь таны үзэл бодлыг хэрхэн өөрчилж байна вэ?

Хайрын хэл 5: Биеэр хүрэлцэх

Хайрын үндсэн хэл нь биеэр хүрэлцэх байдаг хүмүүс гэр бүлийнхэн нь тэдэнд хайраар хүрэх үед хайрлагдсанаа хамгийн их мэдэрдэг.

Биеэр хүрэлцэх байдлаар хайрыг илэрхийлэх олон арга бий. Зарим нь тодорхой харилцаа болон тодорхой орчинд тохиромжтой байдаг бол, өөр зарим нь ийм харилцаанд тохиромжгүй байдаг. Энд хэдэн жишээ байна:

- Бие биенээ тэврэх
- Нөгөө хүнийхээ нуруу эсвэл мөрөөр нь тэврэх
- Нөгөө хүнийхээ мөрөн дээр гараа тавих
- Нөгөө хүнийхээ нуруу эсвэл мөрийг алгадах
- Хамтдаа суух
- Бие биенийхээ гарыг атгах
- Бие биенээ үнсэх
- Нуруунд нь массаж хийж өгөх
- Хүүхдээ тэврэх
- Хүүхдийнхээ үсийг самнах эсвэл сүлжих
- Хэн нэгэн нь өвчтэй эсвэл бие нь сул байх үед эелдэг зөөлөн байдлаар халамж үзүүлэх

Хэн нэгэн хүнд хэцүү үеийг туулж явахад биеэр хүрэлцэх нь илүү утга учиртай байх боломжтой. Хайрын үндсэн хэл нь биеэр хүрэлцэх байдаг хүний хувьд гашуудал, өвдөлт, ганцаардал, эсвэл сэтгэл гутралын үед нь хүрсэн тэврэлт ямар ч үг эсвэл тусламж үзүүлэхээс илүү утга учрыг илэрхийлдэг.

Хайрын үндсэн хэл нь биеэр хүрэлцэх байдаг хүний хувьд түүнийг өвчтэй байхад нь ч (хэрэв боломжтой бол) хайраа биеэр илэрхийлэх нь чухал байдаг. Хайр бол болзолгүй бөгөөд өөрийгөө золиослодог гэдгийг санаарай. Лук 15:20-д эцэг нь гэмшсэн хүүгээ бохир заваан, муухай үнэртэй, хайр татахуйц юу ч үгүй байхад нь тэвэрч, үнссэн байдаг.

Биеэр хүрэлцэх хайрын хэл нь заавал сексийн тухай биш юм. Бэлгийн харилцаа нь хүрэлцэх нэг ангилал мөн. Хүрэх, хүрүүлэх хүсэл нь бэлгийн харилцааг өдөөж, үүнийг илэрхийлж болох ч, хайрын үндсэн хэл нь биеэр хүрэлцэх байдаг хүнд бэлгийн харилцаа нь дангаараа хангалттай байж чадахгүй.

Биеэр хүрэлцэх байдлаар хайрлагдах хүсэл нь хүнийг ёс бус бэлгийн үйл ажиллагаанд уруу татагдахад хүргэж болно. Эцэг эхчүүд хүүхдийнхээ биеэр хүрэлцэх хэрэгцээг хангахын тулд тэдэнд зохих ёсоор, бэлгийн харилцааны бус биеэр хүрэлцэх байдлаар хангалттай илэрхийлэх нь чухал юм. Хайрлагдсанаа мэдэрдэг хүүхэд уруу таталтыг эсэргүүцэх илүү хүч, урам зоригтой байдаг.

Биеэр хүрэлцэх байдлын нүгэл

Хайрын үндсэн хэл нь биеэр хүрэлцэх байдаг хүмүүс бие махбодын хувьд тэдэнтэй бүдүүлэг ширүүн харьцахад их өвдөлтийг мэдэрдэг. Уурлаж хэн нэгнийг цохих (Галат 5:20), хэн нэгний нүүрийг алгдан доромжлох (Матай 5:39) эсвэл эрх мэдлээ урвуулан ашиглаж хэн нэгнийг зодох (Матай 24:48-49) нь бузар муу үйл. Эдгээр Бичвэрээс бид эцэг эхчүүд уурласан эсвэл бухимдсан үедээ ч хүүхдүүдээ өвтгөх эрхгүй гэдгийг мэдэж болно. Түүнчлэн хүүхдүүд нь эцэг эхээ зодох нь бузар муу хэмээн Бурхан хэлсэн байдаг (Гэтлэл 21:15).

Эцэг эхчүүд хүүхдүүдээ зохистой, хяналттай байдлаар бие махбодын хувьд сахилгажуулахдаа үүнийг уян зөөлөн сүнс дотор (Колоссай 3:21) хийх учиртай. Энэ нь зөвт байдалд засаж залруулах, сургах зорилготой бол нүгэл биш юм. Сахилгажуулалт нь эцэг эхчүүдэд тавигддаг Бурханы шаардлага бөгөөд ингэснээр тэд хүүхдүүдийнхээ сэтгэлийг аврах боломжтой болдог (Сургаалт үгс 13:24, Сургаалт үгс 19:18, Сургаалт үгс 29:15, Еврей 12:5-7).

Бүх бэлгийн ёс бус үйлдэл, хүчирхийлэл, цус ойртолт (Леви 20:11-12, 14) зэрэг нь бузар муу юм.

Хайрын үндсэн хэлээ тодорхойлох нь

Хүмүүс өөрсдийн хайрын үндсэн хэлийг үргэлж таньсан байдаггүй. Тэд бусдад хайраа хэрхэн илэрхийлдэг арга замуудын талаар бодож үзээгүй ч байж болох юм. Бусдын хийдэг зүйлээс болж хайрлагдсанаа мэдэрдэг гэдгийг ч тэд мэдэхгүй байх боломжтой. Хайрын таван хэлний талаар та юу мэддэгээ эргэцүүлэхэд бага зэрэг цаг гаргаарай.

► Та бусдад төрөлх байдлаар хайраа харуулахдаа ямар хайрын хэлээр ихэвчлэн илэрхийлдэг вэ?

► Таны үндсэн болон хоёрдогч хайрын хэл юу вэ? Хэрэв танд хамгийн утга учиртай хайрын илэрхийллээ ялгаж танихад хүндрэл гарч байвал, дараах асуултууд танд тусалж мэднэ:

- Таныг баярлуулдаг зүйлсийн жишээ юу вэ?
- Таны хамгийн дуртай дурсамжууд юу вэ?
- Та юуны талаар гомдоллодог вэ (бусдад хэлэхгүй ч гэсэн)?
- Таныг юу өвтгөдөг вэ?

Хайрын таван хэл ба хүүхдүүд

Бүх хүн хайрын таван хэлээр хайрыг хүлээн авах хэрэгцээтэй байдаг ч, энэ нь ялангуяа хүүхдүүдийн хувьд бүр илүү чухал байдаг. Тэнцвэртэй, сэтгэл санааны хувьд эрүүл хүүхдүүд болохын тулд тэднийг эцэг эх нь болзолгүйгээр хайрладаг гэдгийг тогтмол, байнга хэлж, харуулж байх хэрэгтэй. Эцэг эхчүүд хүүхдэдээ өдөр бүр олон арга замаар хайраа илэрхийлэх үед энэ нь тэдний зүрх сэтгэлийн хөрсийг зөөлөн дэвтээх, тэтгэх бороо адил нөлөө үзүүлдэг.

Таны хүүхдүүд та тэдэнд хайртайг мэддэг, мэдэрдэг гэж бүү таамагла. Тэд таны хайрыг өөрсдийн хайрын үндсэн хэлээрээ болон бусад хайрын хэлээр байнга, тогтмол харах ёстой.

Хүүхдийн хайрын үндсэн хэлийг тодорхойлох нь

Гари Чапмен болон Росс Кэмпбелл нар хүүхдийнхээ хайрын үндсэн хэлийг хэрхэн илрүүлэх талаар дараах санаануудыг жагсаажээ:³⁵

1. Хүүхэд тань танд хэрхэн хайраа илэрхийлж байгааг ажигла.
2. Хүүхэд тань бусдад хэрхэн хайраа илэрхийлж байгааг ажигла.
3. Хүүхдийнхээ хамгийн олон удаа хүссэн зүйлийг сонс.
4. Хүүхдийнхээ хамгийн олон удаа гомдоллосон зүйлийг анзаар.
5. Хүүхдээрээ хоёр сонголтын аль нэгийг сонгуулаарай.

Тав хүртэлх насанд хүүхдийн хайрын үндсэн хэлийг тодорхойлох боломжгүй байж болох юм.

Хүүхдийн хайрын хэлтэй холбоотой тусгай тэмдэглэл

Бид энд хайрын хэл тус бүрийг дэлгэрэнгүй авч үзэхгүй, учир нь тэдгээрийг өмнө нь хэлэлцсэн. Үүний оронд бид хүүхдүүдэд хайрыг харуулахтай холбоотой хэд хэдэн хэрэгжүүлж болох санааг тэмдэглэх болно.

Урмын үгс

Хэн нэгнийг буруу зүйл хийсэн эсвэл сайн гүйцэтгэл үзүүлэхгүй байх үед урмын үгс хэлэх нь ихэвчлэн хэцүү байдаг. Гэхдээ хэрэв та чин сэтгэлээсээ урмын үг олж хэлж чадвал энэ нь хүүхдийг сэдэлжүүлж, тэднийг өсөн дэвжихэд их тус болдог.

Чанартай цаг

Гэр бүлүүд өдөрт дор хаяж нэг удаа хамтдаа хооллож, тэр үедээ бие биетэйгээ ярилцахад анхаарлаа хандуулах нь маш их ашиг тустай.

³⁵ Dr. Gary Chapman and Dr. Ross Campbell, *The Five Love Languages of Children*, (Northfield Publishing, Chicago, 1997), 101-103.

Олон хүүхэдтэй гэр бүл хүүхэдтэйгээ хувьчилсан чанартай цаг гаргалгүй орхигдуулах нь олон байдаг. Гэсэн хэдий ч, хүүхэдтэйгээ хувьчлан тусгай цаг гаргаж ямар нэгэн зүйл хийх нь тэдэнд таны хайрыг мэдрэхэд тусалдаг. Ганцаараа хамт байх цаг нь мөн тэдэнд ах эгч, бусад гэр бүлийнхнийхээ дэргэд яримааргүй санагддаг, хувийн бодлуудаа хуваалцах аюулгүй орчныг бүрдүүлж өгдөг.

Хүүхдүүд үе үе эцэг эхийнхээ хэн нэгэнтэй ганцаараа чанартай цаг өнгөрөөхийг гэнэт хүсэх боломжтой. Заримдаа хүүхэд унтахаасаа өмнө нээлттэй болж, зүрхэндээ дарамт болж буй зүйлийн талаар ярихыг хүсдэг. Эцэг эхчүүд энэ мөчид хүүхдүүдээ сонсоход цаг гаргах нь маш чухал юм. Хүүхдүүд сүнслэг асуудалтай олонтоо тулгарч байдаг бөгөөд ээж эсвэл аавдаа хувьчилсан байдлаар хандахдаа сүнслэг тусламж хайж байдаг. Энэ үед хүүхдүүдээ Есүс рүү хандуулах онцгой боломж эцэг эхчүүдэд олддог.

Хүүхэдтэйгээ чанартай цаг өнгөрөөхдөө тэдний хэрхэн бодож, юу мэдэрч байгааг ойлгоход туслах нээлттэй асуултууд асууж сураарай. Нээлттэй асуулт нь "Тийм" эсвэл "Үгүй" гэж хариулж болохгүй асуулт юм. Нээлттэй асуултад тодорхой хариулт байдаггүй. Нээлттэй асуулт ихэвчлэн "Яагаад...", "Хэрхэн...", эсвэл "Юу..." гэж эхэлдэг. Нээлттэй яриа нь "Надад ... энэ тухай хэлээч" эсвэл "Та ... энэ тухай юу гэж бодож байна вэ?" гэсэн хэллэгээр эхэлдэг.

Таны хүүхэд асуултад хариулах үед хариултыг нь анхааралтай сонсож, зохих ёсоор хариулахаа мартуузай. Зарим тохиолдолд та үргэлжлүүлэн асуулт асууж болно. Заримдаа та тэдний тайлбарлахыг хичээж буй зүйлийг ойлгосон эсэхээ тодруулах хэрэгтэй. Заримдаа та тэдний юу мэдэрч, юу ойлгож байгааг баталгаажуулах ёстой. Хүүхэд ярилцлага өгч байгаа юм шиг биш, харин илэн далангүй чөлөөтэй ярих нь чухал. Таны анхааралтай байдал хүүхдэд өөрийг нь сонсдог, үнэлдэг, хайрладаг гэж мэдрэхэд тусалдаг.

Хүүхдийнхээ ярих түүхийг үнэхээр сонирхон сонсох үедээ та хайраа маш утга учиртайгаар илэрхийлдэг. Хүүхдэд түүх ярих эсвэл ном уншиж өгөх нь хамтдаа чанартай цаг өнгөрөөх гайхалтай арга юм.

Хамтдаа тоглоом тоглох эсвэл хөгжилтэй төсөл дээр хамтдаа ажиллах нь хүүхэдтэйгээ чанартай цаг өнгөрөөх бусад аргууд юм.

Зарим эцэг эхчүүд хүүхдэдээ хангалттай чанартай цаг гаргадаггүй. Тэд үүний оронд хүүхдэдээ бэлэг өгөхийг хичээдэг. Бэлэг нь чанартай цагийг орлож чадахгүй. Хүүхдүүдийн хайрын үндсэн хэл нь юу байхаас үл хамааран, эцэг эхтэйгээ маш их чанартай цаг өнгөрөөх хэрэгцээтэй байдаг.

Бэлэг

Олон эцэг эхчүүд хүүхдэдээ тоглоом эсвэл сонирхолтой ном худалдан авч өгөх нь ховор байдаг. Учир нь эдгээр нь шаардлагагүй мэт санагддаг. Харин эдгээр зүйлс нь хайрын илэрхийлэл байхаас гадна, хүүхдийн хөгжилд тус болох боломжтой.

Тусламж үзүүлэх

Тусламж үзүүлэх байдлаар хүүхдэдээ хайраа илэрхийлэх зарим санаа:

- Төрсөн өдрөөр нь дуртай хоолыг нь хийж өгөх
- Өвчтэй байхад нь асарч халамжлах
- Хүүхдийнхээ сургуулийн ажил, төсөлд нь туслах
- Хүүхэдтэйгээ хамт гэрийн ажил хийж, тэдний хийсэн ажлыг үнэлэх
- Хүүхэдтэйгээ хамт гэр бүлээсээ гадуур хэн нэгэнд туслах

Биеэр хүрэлцэх

Бүх нялх хүүхдүүд болон бага насны хүүхдүүдийн хувьд биеэр хүрэлцэх байдлаар хайрыг мэдрэх ёстой. Нярай хүүхдэд хооллох, живхийг нь солих зэрэг практик хэрэгцээ байдаг ч, мөн тэврүүлэх, эрхлэх, илж, үнсүүлэх хэрэгцээ ч мөн бий. Энэхүү биеэр хүрэлцэх зөөлөн байдал нь хайрыг тэдний мэдэрдэг байдлаар дамжуулдаг бөгөөд хүүхдүүдийн сэтгэл санаа болон оюун санаа эрүүл саруул байхад зайлшгүй чухал юм.

Аав нь хөвгүүдтэйгээ ноцолдох нь хайрын илэрхийлэл байж болно. Тэдний өрсөлдөөн нь гомдоох, дарангуйлах, биеэ барихгүй байх эсвэл уур хилэн үүсгэх ёсгүй.

Эцэг эхийн үг, үйлдлээс улбаатай урт хугацааны нөлөө

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ харилцахдаа Бурханы үлгэр дуурайлыг дагах ёстой. Тэр хүүхдүүддээ үргэлж төгс, өөрийгөө золиослох, болзолгүй хайраар ханддаг. Тэрээр хүүхдүүддээ хайрладаг **учраас** тэднийг сахилгажуулж, засаж залруулж, сургадаг (Еврей 12:5-7). Эцэг эх/хүүхдийн харилцааны хүрээнд Тэрбээр итгэгчдийн амьдралд ажиллаж, тэднийг өөртэйгөө адилхан болгодог (Еврей 12:10-11).

Эцэг эхийн хүүхдээ хайрлах хайр нь хүүхдийнх нь зан байдлаас хамаарах ёсгүй. Мэдээж, зан байдлын эерэг шагнал эсвэл сөрөг үр дагавар нь хүүхэд хүмүүжүүлэхэд тохиромжтой боловч, хайрын *илэрхийллийг* зан байдлаас болж өгөх эсвэл татгалзах учиргүй.

Хэрэв хүүхэд эцэг эхийнхээ болзолгүй хайрыг тогтмол мэдэрдэг бол тэрээр Бурханы өөрт нь хандах хайрыг илүү хялбар ойлгож, итгэх болно. Гэсэн хэдий ч, хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн эсвэл үл тоомсорлогдсон хүн, насанд хүрсэн хойноо ч хайраар дүүрэн тэнгэрлэг Эцэгт итгэж ойлгох нь илүү хэцүү байдаг.

Хүүхдийн өөрийнхөө талаарх ойлголт нь (ялангуяа хувь хүний үнэ цэнэ) бараг үргэлж бусдаас сонссон, мэдэрсэн зүйлээс нь бүрэлдэн бий болдог. Эцэг эхийн үг, үйлдэл нь хамгийн их нөлөөтэй байдаг ч, хамаатан садан, найз нөхөд ч бас ихээхэн нөлөөлдөг. Хүүхэд өөртөө хэрэгцээтэй хайрын илэрхийллийг хүлээн авсан эсэх нь тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрдүүлдэг зүйлсийн нэг юм. Хүүхэд хайрыг хүлээн авахгүй байх эсвэл сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэлд өртөх үед энэ нь тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжид хохирол учруулж, бүх амьдралд нь нөлөөлдөг.

Эцэг эхийн үгс нь хүүхдийн өөрийгөө ойлгох ойлголтод нөлөөлдөг. Жишээлбэл:

- **Урмын үгс:** "Хичээл зүтгэлтэй ажиллаж байгаад чинь би бахархаж байна! Чи чадна гэдэгт би итгэж байна." Энэ нь тухайн хүүхдэд хүчин чармайлт гаргах нь үнэ цэнтэй бөгөөд түүнийг амжилтанд хүрч чадна гэдэгт та итгэдгийг хэлдэг.
- **Хортой үгс:** "Чи дэндүү залхуу. Чамд найдах юм юу ч алга!" Энэ нь хүүхдийг өөрчлөгдөх чадваргүй гэж итгэхэд хүргэж болно. Та тэднээс аль хэдийн татгалзсан учраас тэдэнд өөрчлөгдөх эсвэл таны хүндэтгэлийг хүлээх ямар ч шалтгаан байхгүй. Энэ нь хүүхдэд та түүнээс татгалзсан мэт мэдрэмж төрүүлдэг.
- **Урмын үгс:** "Зүгээр ээ. Бид бүгдээрээ заримдаа алдаа гаргадаг, дараагийн удаа илүү сайн хийхийг сурна." Энэ нь хүүхдэд алдаа гаргах нь аюулгүй гэдгийг түүнчлэн таны тэдэнд хандах хайр нь тэдний төгс гүйцэтгэлээс хамаарахгүй гэдгийг хэлж байдаг. Мөн энэ нь хүүхдэд өсөн дэвжих боломжтой гэдгийг, үргэлж хичээх шалтгаан байгааг хэлдэг.
- **Хортой үгс:** "Чи дэндүү тэнэг юм. Чи үргэлж асуудал гаргадаг." Энэ нь хүүхдийг хичээх нь найдваргүй гэж итгэхэд хүргэх боломжтой. Энэ нь тэдний үнэ цэн төгс гүйцэтгэлээс хамаардаг, мөн тэд үргэлж алддаг учраас хэзээ ч үнэ цэнтэй байж чадахгүй гэсэн утгаар төвөггүй ойлгогддог. Тэд танаар болон өөр хэн нэгнээр хэзээ ч хайрлагдах үнэ цэнгүй болж болох юм.

Хүүхдийг хэр их хайрласан эсвэл хайрлаагүйгээс түүний хувь хүн гэдгээ ойлгох ойлголт нь бүрэлдэн бий болдог. Бусадтай эрүүл харилцаа тогтоох чадвар нь эцэг эхтэйгээ харилцах харилцаанаас шалтгаалж хөгждөг эсвэл хязгаарлагддаг. Их хайрлуулсан хүүхэд бусдыг өөрийгөө золиослодог, болзолгүй хайраар хайрлахыг сурч чадна. Түүнд хэрэгтэй цагт утган өгөх хайрын нөөц ундарга байдаг.

Жинхэнэ хайр бол насанд хүрэгчидтэй адил, хүүхдийн хувьд ч сэтгэл санааных нь түлш байдаг.

Сэтгэл санааны сав дүүрэн байхын ашиг тус

Хүүхдийн сэтгэл санааны сав дүүрэн байх нь олон талын ашиг тустай. Хүүхэд хайрлагдсан гэдгээ мэдэх үедээ сорилт бэрхшээлтэй нүүр тулж, зөв хөгжихөд шаардлагатай хүч чадал, тогтвортой байдлыг олж авдаг.

Болзолгүйгээр хайрлагдсан гэдгээ мэддэг хүүхэд сэтгэл санааны хувьд аюулгүй байдаг. Үүнээс болж тэр эцэг эхээсээ залруулга, сахилгажуулалт, удирдамжийг бусдаас илүүтэйгээр хүлээн авахад бэлэн байдаг. Тэрээр үе тэнгийнхний дарамтаас үүдэлтэй уруу таталтыг эсэргүүцэх чадвартай байдаг. Учир нь тэр өөрийгөө хэн бэ гэдэгт итгэлтэй бөгөөд бусдад өөрийгөө батлах шаардлагагүй гэдгийг мэддэг.

Ерөнхийдөө хөвгүүдийн анхаарлыг татаж сээтгэнэдэг охин хөвгүүдэд таалагдахгүй, эсвэл тэд өөрт нь анхаарал хандуулахгүй байх вий гэж айдаг учраас тэгж биеэ авч явдаг байх боломжтой. Хөвгүүдтэй харилцахдаа ичдэг охин өөрийн хувийн онцлог

байдлаа үнэнээр илэрхийлбэл тэд түүнийг тоохгүй байх вий гэж айдаг байж болно. Эцгээсээ урмын үгс, хайр халамж авч өссөн охин хүүхэд хөвгүүдэд сээтэгнэх эсвэл тэднээс ичихгүйгээр эрүүл харилцаа тогтоох магадлал өндөр байдаг. Тэрээр эцгийнхээ хайраас болж өөрийнхөө хэн болох үнэ цэнд итгэлтэй байдаг.

Эцэг эхийн болзолгүй, жинхэнэ хайр нь хайрын таван хэлээр байнга илэрхийлэгдэх нь хүүхдийг олон хор хөнөөлөөс хамгаалдаг. Сайнаар хайрлуулсан хүүхэд ихэвчлэн өөрт нь муу зүйл хийхийг хүсдэг тийм хүмүүсээс хайр, аюулгүй байдлыг хайж очдоггүй.

Дүгнэж хэлэхэд, хүүхэд байхдаа сэтгэл санааны түлшний сав нь дүүрэн байх нь олон ашиг тустай юм:

- Өөрийн үнэ цэн болон түүний эх сурвалжийг зөв ойлгох
- Хүчин чармайлт, алдаа, өсөлт, болзолгүй хайрыг зөв ойлгох
- Бусдыг сайн хайрлаж сурах чадвар
- Сорилт бэрхшээлтэй нүүр тулж, зөв хөгжихөд шаардлагатай хүч чадал, тогтвортой байдал
- Сэтгэл санааны аюулгүй байдал
- Сахилгажуулалт, залруулга, удирдамжийг хүлээн авах чадвар
- Үе тэнгийнхний буруу нөлөөг эсэргүүцэх чадвар
- Ирээдүйн харилцаандаа хүчирхийлэлд өртөх магадлал бага байх

Сайн хайрлуулсан хүүхдээс өөр ямар ашиг тусыг та олж харсан бэ?

Сэтгэл санааны сав хоосон байхын сул тал

Хайрлагдсанаа мэдэрдэггүй хүүхэд ээж аавыгаа баярлуулах өдөөлт дутагдсанаас болж тэдний удирдамжийг эсэргүүцэх боломжтой. Сэтгэл санааны түлшний сав нь дүүрэн биш байх үед олон хүүхэд тэднийг чиглүүлэхийг хичээх эцэг эхдээ үнэнч, эерэг харилцаа холбоогоор дутагдаж байдаг.

Сэтгэл санааны сав нь хоосон хүүхэд гэр бүлийнхэнтэйгээ эрүүл, хайрлуулж өссөн хүүхдээс илүү хүчирхийлэлд өртөмтгий байдаг. Тэд хайрлагдсанаа мэдэрдэггүй учраас тэднийг ашиглах эсвэл хорлохыг хүссэн хүмүүсээс хайрыг хайх боломжтой.

Бат бэх гэр бүлийн чанар

Эдгээр хичээлээр бид хайрын таван үндсэн хэлний талаар сурсан. Хэдийгээр хувь хүн бүр ихэвчлэн нэг эсвэл хоёр хайрын үндсэн хэлтэй байдаг ч, хүн бүр энэхүү таван арга замаар тогтмол хайрлагдах хэрэгцээтэй байдаг. Эрүүл гэр бүл гэдэг нь хүн бүр бусадтайгаа харилцаагаа зорилготойгоор хөгжүүлж, өдөр бүр урмын үгс хэлж, чанартай цаг хамтдаа өнгөрөөж, тусламж үзүүлж, хайраар бие биедээ хүрэлцэж байдаг

гэр бүл юм. Бие биедээ бэлэг өгөх нь өдөр тутам хийх зүйл биш байж болох ч, гэр бүл доторх эрүүл харилцааны чухал хэсэг хэвээр байдаг.

► Танай гэр бүлд хайрыг хамгийн ихээр хэрхэн илэрхийлдэг вэ? Хайрыг энэхүү хайрын таван хэл бүгдээр илэрхийлдэг үү? Хайрын илэрхийллийг хэр олон удаа хуваалцдаг вэ?

14,000 гэр бүлүүдийг (шашин харгалзахгүй) хамруулсан 25 жилийн судалгаагаар өөр өөр соёлын төлөөлөл болсон эрүүл, амжилттай, тэнцвэртэй гэр бүлүүдэд зургаан нийтлэг чанар байсныг тогтоожээ.³⁶ Эдгээр чанарын зарим нь хайрын янз бүрийн хэлтэй шууд холбоотой байгаа нь хайрын янз бүрийн илэрхийллийн ач холбогдлыг онцолж буй мэт санагддаг. Стиннетт болон Бим нар эдгээр зургаан чанар болон тэдгээрийн тайлбарыг жагсаажээ:

1. **Зориулалт.** Бат бэх гэр бүлийнхэн бие биенийхээ сайн сайхан, аз жаргалыг дэмжихэд өөрсдийгөө тууштай зориулдаг. Тэд гэр бүлийн нэгдмэл байдлыг эрхэмлэдэг.
2. **Талархал ба санаа тавилт.** Бат бэх гэр бүлийнхэн бие биедээ байнга талархал илэрхийлдэг. Гэр бүл нь сайн сайхан гэж тэд мэдэрдэг.
3. **Эерэг харилцаа.** Сайн гэр бүлийн гишүүд харилцааны сайн ур чадвартай байдаг бөгөөд бие биетэйгээ ярилцахад их цаг зарцуулдаг.
4. **Хамтдаа өнгөрөөх цаг.** Бат бэх гэр бүлүүд бие биетэйгээ их хэмжээний чанартай цагийг өнгөрөөдөг.
5. **Сүнслэг сайн сайхан байдал.** Шашны үйл ажиллагаанд оролцдог эсэхээс үл хамааран, бат бэх гэр бүлүүд амьдралд агуу сайн сайхан эсвэл хүч чадал байдгийг ойлгож мэдэрсэн байдаг. Энэ итгэл нь тэдэнд хүч чадал, зорилгыг өгдөг.
6. **Стресс, хямралыг даван туулах чадвар.** Бат бэх гэр бүлийнхэн стресс эсвэл хямралыг өсөн дэвжих боломж гэж хардаг.

Хувийн хэрэгжүүлэлт

Эдгээр хоёр хичээлээр бид олон зүйлийг авч үзлээ. Бид жинхэнэ хайрын тухай хэлэлцүүлгээс эхэлж, дараа нь хайрыг илэрхийлдэг таван хэлийг таньж мэдсэн. Бид сэтгэл санааны түлшний сав болон гэр бүлийн гишүүд маань хайрыг өөрсдийн хайрын үндсэн хэлээр мэдрэх хэрэгцээтэй байдлын талаар сурсан. Гэр бүлийн хүмүүсийн маань хувийн онцлог байдал ялгаа нь биднийг хайранд өсөхөд хэрхэн нөлөөлж болох талаар ярилцсан.

Үүний дараа бид хайрын таван хэл тус бүрийг гүнзгийрүүлэн судалж, тус бүрийн жишээ болон үл тоомсорлох эсвэл буруугаар ашиглахад үүсдэг хор хохирлыг авч үзсэн.

³⁶ Dr. Nick & Nancy Stinnett and Joe & Alice Beam, *Fantastic Families: 6 Proven Steps to Building a Strong Family*, (Brentwood, TN: Howard Books, 2008)

Хүүхдийн сэтгэл санааны түлшний сав нь дүүрэн байх нь ямар ашиг тустай болох, мөн сав нь хоосорсон үед хэрхэн зовж зүдэрдэг талаар бид суралцсан. Хүүхдүүддээ хайраа илэрхийлэх талаар илүү дэлгэрэнгүй бид ярилцсан. Улмаар бид хайрын таван хэлийг хэрэглэх нь эрүүл гэр бүлийн зургаан нийтлэг чанартай хэрхэн холбогддог болохыг анзаарсан.

Эдгээр хичээлийг дүгнэж, бид таны хувийн үүрэг хариуцлагын талаар (таны юу хийж чадах талаар болон сурсан зүйлээ хэрхэн хийх тухай) ярилцах болно.

(1) Та гэр бүлээ хайрлах үүрэгтэй.

Та гэр бүлийн гишүүдээ таныг хайрлахыг хүлээлгүйгээр шаардлагатай бүх зүйлийг өөрчлөхөд бэлэн байх ёстой. Жинхэнэ хайр нөгөө хүн танд хайраа харуулахыг хүлээдэггүй. Энэ нь нөгөө хүн үүнийг хүлээн авах зохистой биш, бага мэт санагдах үед ч өөрийгөө илэрхийлдэг. Учир нь хайр бол хүлээн авагчийн зүй зохистой байдалд тулгуурладаггүй.

(2) Гэр бүлийнхэн тань бие биедээ хамгийн чухал байдлаар хайраа илэрхийлэхийн тулд та чадах бүхнээ хийх үүрэгтэй.

Та төрөлх байдлаар хийж байгаагүй нэг эсвэл хэд хэдэн хэлээр хайраа илэрхийлэхийн тулд илүү хүчин чармайлт гаргах шаардлагатай болж магадгүй. Эхэндээ, хайрын зарим илэрхийлэл танд хиймэл, эвгүй, эсвэл утгагүй санагдаж болох юм.

Гэр бүлийнхэн тань хайраа харуулах боломжуудыг анзаарч сур. Таны гэр бүлийн хүмүүст тухайн мөчид юу хэрэгтэй байж болохыг анхаар. Хайрын хэл тус бүрийн зарим жишээг эндээс харна уу:

- **Урмын үгс:** "_____ саяхан хэлсэн зүйлдээ итгэлгүй байж магадгүй. Гэхдээ тэр зөв хэлсэн. Би зарим нэг баталгааг өгөх хэрэгтэй санагдлаа" гэх мэт бодож үз.
- **Чанартай цаг:** "Энэ талаар ярилцах уу?" гэж асуугаарай. Дараа нь хийж байгаа зүйлээ зогсоож, түүнд бүрэн анхаарлаа хандуулж, үнэхээр сонсож байгаагаа биеийн хэлэмжээрээ харуул.
- **Бэлэг:** Бэлгээ өгөхдөө "Би үүнийг харахдаа чамайг бодсон" гэж хэлээрэй.
- **Тусламж үзүүлэх:** Босч очоод "Би үүнийг танд авч өгөх үү?" эсвэл "Би танд үүнийг хийхэд нь туслах уу?" гэж асуугаарай.
- **Биеэр хүрэлцэх:** Та түүн дээр очоод "Чамд тэврэлт хэрэгтэй юм шиг харагдаж байна" гэж хэлээд тэврээрэй.

(3) Та өөрийн сэтгэл хөдлөлдөө хариуцлага хүлээх үүрэгтэй.

Бурхан таныг бусадтай эрүүл харилцаанд байх хэрэгцээтэйгээр бүтээсэн. Гэхдээ энэ нь боломжтой эсэхээс үл хамааран, Бурхан өөрөө таны төгс эх сурвалж, сэтгэл хангалуун байдал юм. Таны сэтгэл санааны сайн сайхан байдалд гэр бүл тань хариуцлага

хүлээхгүй. Хэдийгээр өөр хэн ч тэгж хайрлаж чадахгүй ч, Бурхан таныг төгс хайрладаг. Түүний хайр дотор байх үед (Иохан 15:9-11) танд дутагдаж буй бүхнийг Тэр нөхөж чадна.

Таны гэр бүл хайрын үндсэн хэлээр тань таныг хайрлахгүй байж болно. Магадгүй тэд таны хайрын үндсэн хэл болон сэтгэл санааны хэрэгцээг мэдэхгүй ч байх боломжтой. Магадгүй таны хувьд хамгийн их утга учиртай байдлаар хайрлах өдөөлт тэдэнд дутагдаж байж ч болно. Та тэдэнд өөрийгөө хамгийн ихээр хайрлагдах үедээ хэрхэн мэдэрдгээ тайлбарлаж чадна. Гэхдээ та тэднээр ийм аргаар хайрлахыг сонгуулж хүчилж болохгүй.

Магадгүй гэр бүлийнхэн тань таныг бусад аргаар хайрлаж байгаа байх. Та хайрын хэлүүдийн талаар ойлголттой болох тусам, гэр бүлийнхэн нь таныг аль хэдийн хайрлаж байгааг анзаарч эхлэх болно. Та тэднийг өөрчилж чадахгүй ч, та тэдний хайрын илэрхийллийг хүлээн авч, хайрыг нь үнэлж байгаагаа харуулахыг сонгож чадна.

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Гэр бүлийг минь надад өгсөнд талархъя. Тэднийгээ хүн тус бүрчлэн зохих ёсоор үнэлж, хувьчлан сайн харилцааг хөгжүүлэхэд минь туслаач.

Гэр бүлдээ хайраа илэрхийлэх аргуудад суралцах боломж олгосонд талархъя. Есүстэй адилхан байж, суралцахад надад туслаач. Цаг зав, сэтгэл хөдлөл, бие махбодын эрч хүч, нөөц баялгаараа гэр бүлээ ерөөж, урамшуулахад өөрийгөө зориулахад туслаач. Даруу зүрх сэтгэлтэй байхад надад туслаач. Ингэснээр би өөрийн хэрэгцээнээс илүү бусдын хэрэгцээг чухалчилж чадна. Гэр бүлийн хүн нэг бүрдээ хайраа илэрхийлэх боломжийг анзаарч харахад надад туслаач.

Та надад жинхэнэ хайр юу болохыг харуулсан. Гэр бүлдээ таны надад зориулсны адил хайраар зориулахыг та надаас хүсэж байгаа. Би хань ижил, хүүхдүүдээ болзолгүй, өөрийгөө золиосолдог хайраар хайрлахыг сонгож байна. Олон удаа бүтэлгүйтсэн, миний гэм бурууг өршөөж, нигүүлслээ хайрлаач. Тэднийг зохих ёсоор хайрлах боломжийг надад олгооч.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Эхнэр/нөхөр болон хүүхдүүдийнхээ хайрын үндсэн хэлийг бодож үзээрэй. Гэр бүлийн гишүүдийнхээ нэрийг жагсаа. Дараа нь тус бүрийнх нь үндсэн нэг эсвэл хоёр хайрын хэлийг бичнэ үү.

(2) Хайрын ямар илэрхийлэл нь танаас илүү их хүчин чармайлт шаардах вэ? Тэдгээрийг тэмдэглэ. Та эдгээр арга замаар гэр бүлээ зориудаар хэрхэн хайрлаж эхлэх талаар зарим санааг бичээрэй.

(3) Ахуй соёлоо, ялангуяа өөрийн нийгмийн бүлгийг судал. Хайрын таван хэлийг жагсаа. Танай соёлд хайрын хэл тус бүрийг хэрхэн илэрхийлдэг вэ? Таван хэлний аль нь ихэвчлэн орхигддог вэ? Танай нийгмийн бүлэгт ахуй соёлын тогтсон байдлаас илүү сайн аргаар хайрыг илэрхийлэх ямар тодорхой аргууд байж болох вэ? Эдгээр асуултад хариулж, хэд хэдэн догол мөрөнд багтаан бичнэ үү.

10-р хичээл

Үр хүүхэдгүй байх

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Үр хүүхэдгүй байх талаарх Библийн үзэл баримтлалыг ойлгож, үүнд хариу үйлдэх.
- (2) Хүн бүр Бурханы дүр төрхийг агуулдгийн хувьд үнэлэх.

Бусабагийн гуниг

Бусаба Азийн нэгэн оронд төрж өсжээ. Тэрээр залуу бизнесментэй гэрлэхдээ баяртай байсан бөгөөд тэд хамтдаа аз жаргалтай амьдралыг хүлээж байв. Хэдэн жил өнгөрсөн ч Бусаба хүүхэдгүй хэвээр байв. Эмч түүнд хүүхэдтэй болох боломжгүй гэж хэлжээ. Нөхөр нь маш их гуниглаж, уурсав. Эцэст нь тэр Бусабагаас салж, өөр эмэгтэйтэй гэрлэх шийдвэр гаргасан байна. Бусаба одоо өтөлжээ. Тэрээр жижигхэн байшинд ганцаараа амьдрах бөгөөд хамаатан садан гэж түүнд байсангүй. Тэр буддын шашинтай учраас ирээдүйд хэзээ нэгэн цагт хүүхэдтэй болж, ичгүүр нь арилна гэж найдсаар байдаг.

► Хэрэв та Бусабагийн хамт олны дунд пастор байсан бол түүнд юу гэж хэлэх байсан бэ? Бусабад зориулсан христитгэлийн мэдээ сургаал нь юу байх бол?

Энэ хичээлээр бид үр хүүхэдгүй байх асуудлыг Библийн үүднээс харах болно.

Хүүхдүүд ба Бурханы ерөөлийн хөтөлбөр

Бурхан анхны эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээснийхээ дараа шууд тэдэнд хүүхэдтэй болж, хүн амын тоог олшруулж, дэлхийг дүүргэхийг тушаажээ (Эхлэл 1:28).

Хуучин гэрээнд Бурхан заримдаа ерөөлийг зөвхөн хувь хүнд төдийгүй, олон үе удам дамжин гэр бүлд амласан байдаг. Жишээлбэл, Бурхан Абрахамд хувьчилсан байдлаар бус, харин хожмын үеийнхэнд ирэх ерөөлийг амлажээ. Бурхан Абрахамд түүний үр удам далайн элс мэт олон болно хэмээн амласан юм. Абрахамын хүү Исаак гайхамшигтай арга замаар олдсон. Дараа нь гэр бүлүүд үе үеэрээ олширч, тоо нь нэмэгдсээр Бурханы амлалт биелж байгааг харуулдаг.

Гэтлэл 23:25-27-д Бурхан Израилыг шинэ газар нутагт орох үед ерөөнө хэмээн хэлжээ. Бурхан израилчуудын хоол хүнсийг ерөөж, өвчнийг арилган, үргүйдэл ба зулбалтыг тэдэнд эс зөвшөөрч, мөн дайснуудыг нь устгана гэж амласан. Эдгээр амлалт нь Израилын дуулгавартай байдлаас хамаарах байсан бөгөөд Бурхан өөрийн шаардлагуудыг (жишээлбэл, Гэтлэл 23:32-д буй тушаал) тайлбарласан байдаг. Амлалтууд нь хувь хүмүүст биш, харин үндэстэнд өгөгдсөн юм. Хувь хүмүүс нь үндэстний ерөнхий дуулгавартай байдал болон дуулгаваргүй байдлаас болж

нөлөөлөгддөг байжээ. Жишээлбэл, хүн өвчтэй байж болно, эсвэл эмэгтэй хүн хүүхэдгүй байх боломжтой. Энэ нь тэдний өөрсдийн нүглээс болсон хэрэг биш, харин тэд Бурханд итгэмжтэй байгаагүй үндэстний дор байсан учраас тэр юм. Тиймээс хүүхэдгүй эмэгтэйг зөвхөн өөрийнхөө нүглийн үр дагавраас болж зовж байгаа гэж үзэх боломжгүй юм.

Дэд хууль 7:12-15 эшлэл нь Израил үндэстэнд өгөгдсөн амлалтуудыг агуулдаг. Тэдгээр нь хөгжил цэцэглэлт, өвчин эмгэггүй байдал, хүн болон амьтад үр төлтэй байх талаар хэлжээ. 12-р эшлэлд израилчууд Бурханд дуулгавартай байвал эдгээр ерөөлийг хүлээн авна гэжээ. Учир нь Бурхан тэдний эцгүүдтэй гэрээ байгуулсан юм. Хэрэв үндэстэн Бурханд итгэмжит биш байвал Израилын дотор буй хүмүүс ядуу байж болно, эсвэл эмэгтэй хүн хүүхэдгүй байх боломжтой юм.

Хүүхдүүд Бурханы ард түмний төлөвлөгөөнд чухал ач холбогдолтой байсан. Энэ курсын бусад хэсэгт бид хүүхдүүдийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас хэрхэн үнэлэх ёстой талаар ярилцдаг. Хүүхэд бүр үнэ цэнтэй бөгөөд хайр халамжийг авах ёстой. Гэсэн хэдий ч, заримдаа хүмүүс хүүхэд зөвхөн ирээдүйд гэр бүлийг хүчтэй байлгаж чадах учраас л үнэ цэнтэй гэж боддог. Заримдаа аав нар хүүхдээ өөрийнх нь үргэлжлэх хувилбар гэж үнэлж үздэг. Бурхан хүүхдийг өөрийнхөө зорилгын төлөө өгдөг гэдгийг бид санах хэрэгтэй (Малахи 2:15).

► Нэг суралцагч Дуулал 127:3-5 эшлэлийг бүлэгт чангаар уншина уу.

Библийн энэ эшлэлд хүүхдүүд бол Бурханы ерөөл гэж хэлсэн байна. Бурхан тэднийг өв болгон ерөөсөн мэт харагддаг. Тэд Бурханаас ирсэн шагнал юм. Тэд гэр бүлийнхээ ирээдүйн хамгаалалт, аюулгүй байдал юм.

Бичвэрт заримдаа хамтдаа яригддаг хоёр ерөөл нь урт наслалт ба ач зээ нар юм. Иов ерөөгдсөн. Учир нь тэрээр арван хүүхэдтэй байсан бөгөөд дөрвөн үеэ үзэх хүртэл урт наслажээ (Иов 42:13, 16). Дуулал 128:6-ийн ерөөл нь ач зээгээ харах хүртэл амьдрах бэлэг юм.

Бурхан Ионадабын гэр бүлийг ерөөхдөө түүний удмыг тэргүүлэх хүн тасрахгүй хэмээн амласан (Иеремиа 35:19). Бурхан Давид хааны гэр бүлд үргэлж хаан ширээнд суух хүн байх болно хэмээн амлажээ (2 Самуел 7:16).

Тиймээс бид Бурханы гэр бүлд өгөх ерөөл нь ихэвчлэн хүүхдүүдийг багтаасан мөн хүүхдүүд нь Бурханы ерөөлийг ирээдүй үеийнхэнд хүргэх арга зам гэдгийг хардаг.

Үр хүүхэдгүй байх талаарх Библийн ойлголт

Үр хүүхэдгүй байх нь зарим тохиолдолд Бурхан гэр бүлийг хараасан гэсэн утгатай байж болно. Бурхан гэр бүлүүдийг үргүйдлээр хараасан тухай тохиолдлуудыг Библи бидэнд хэлдэг. Жишээлбэл, Абимелех хаан буруу зүйл хийсэн учраас Бурхан түүний гэм бурууг засах хүртэл гэрийнх нь бүх эмэгтэйчүүдийн умайг хаасан байдаг (Эхлэл 20:18). Эмэгтэйчүүдийн буруу биш байсан ч, тэд хааны нүглийн үр дагаврыг амссан.

Адам, Ева хоёр нүгэл үйлдсэний дараа тэдний нүгэл дэлхий ертөнцөд нөлөөлнө гэдгийг Бурхан айлдсан. Хараал нь хүмүүсийн харилцаа хүндрэх, хүүхэд төрүүлэх өвдөлт, гуниг харуусал, хүнд хөдөлмөр, газрын үр шимгүй байдал, эцэст нь үхэл зэргийг багтаадаг (Эхлэл 3:14-19). Адамаас хойш хүн төрөлхтөн төрсөн цагаасаа (хүн хувьчлан нүгэл үйлдээгүй байхдаа ч) энэхүү хараалыг амсаж туулдаг болсон юм. Хэдий Эзэн Есүс хүртэл огт нүгэлгүй байсан ч, хараалын нөхцөл байдлыг туулж тэсвэрлэх хүний биеэр дэлхийд ирсэн билээ. Тиймээс бид хувь хүний зовлон зүдгүүрийг өөрийнх нь нүглээс болсон гэж хэлэх ёсгүй юм. Бид бүгд хөгширч, өвчилж, олон янзаар зовж, эцэст нь нас бардаг. Энэ бүх асуудал, дээр нь хүүхэд төрүүлэхтэй холбоотой асуудал ч бүгд Адамын анхны нүглийн үр дагавар юм.

Адамын анхны нүглээс гадна, бид өвөг дээдсийнхээ нүглээр ч нөлөөлөгддөг. Учир нь тэдний хийсэн зүйл үйл нь бидний төрж өссөн нийгмийг бий болгосон юм. Бид гэр бүл, хамт олон, үндэстнийхээ нүглээр нөлөөлөгддөг. Дэлхий даяар хаа сайгүй итгэгчид хяналтгүй нийгмийн бүтээсэн нөхцөл байдлыг тэсвэрлэн амьдарч байна. Гэр бүл ядууралд өртөж болно, учир нь тэд эрх чөлөө, боломж багатай газар амьдарч байна. Хүүхэд ямар ч нүгэл хийгээгүй байсан ч бие нь согогтой төрж болно (Иохан 9:1-3).

Бурхан эцэг эхчүүдэд хүүхдийг зөвшөөрөх эсвэл хосыг хүүхэдгүй байлгах шалтгааныг бид мэдэхгүй. Заримдаа хайхрамжгүй, тэрслүү нүгэлтэй хүмүүс олон хүүхэдтэй болж, хүүхдүүдээ Бурханыг алдаршуулах замаар өсгөж хүмүүжүүлдэггүй (Дуулал 17:14). Заримдаа итгэмжтэй итгэгч хүнд үр хүүхэд заяадаггүй. Мэдээж, бид тухайн хүний нүгэл үр хүүхэдгүй байхад хүргэсэн гэж таамаглах учиргүй.

Бурхан хүссэн үедээ эдгээж, ерөөж чадна гэдгийг бид мэддэг. Гэхдээ ерөнхийдөө, итгэгчид энэ дэлхийн нөхцөл байдлыг тэсвэрлэж байгаа юм. Бурхан бүтээлээ шинэчлэх цагийг бид итгэлээр хүлээж байна (Ром 8:18-23).

Хүүхэдгүй байсных нь төлөө, түүний нүгэл хараалыг авчирсан мэтээр эмэгтэйг буруутгах нь шударга бус юм. Үүнтэй адилаар, хүүхэд төрөхөөс өмнө нас барж эндэх тохиолдолд энэ нь ихэвчлэн эхийн хийсэн зүйлээс болдоггүй. Хувь хүмүүс Адамын нүгэл, бусдын нүгэл болон дэлхийн ерөнхий нөхцөл байдлаас болж олон янзын зовлон зүдгүүрийг туулдаг. Хүн бүр нүгэл үйлдсэн учраас хүн төрөлхтөн дэлхийн нөхцөл байдлын төлөө хамтдаа гэм бурууг хуваалцдаг. Гэхдээ хувь хүмүүсийн зовлон зүдгүүр нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Бурханы гайхамшгууд

Есүс эдгээж, бусад гайхамшгуудыг үйлдэхдээ Бурханы хайрыг харуулжээ. Библид тэмдэглэгдсэн түүхээс Бурхан өөрийн хүмүүсийн төлөө хийсэн олон арван гайхамшгийн жишээг бид хардаг.

Бурхан биднийг үзэсгэлэнт дэлхий ертөнцөд аз жаргалтай, зовлон шаналалгүй амьдрахыг хүсдэг (Эхлэл 1:28, 31, 1 Тимот 6:17). Гэхдээ Бурханы нэн тэргүүнд чухалчилдаг зүйл нь биднийг нүглээс аврах бөгөөд ингэснээр бид Түүнтэй мөнхөд

харилцах боломжтой болох юм. Хүмүүс гэмшиж, итгэх шийдвэр гаргах ёстой учраас нүгэлтнүүдийг аврахад цаг хугацаа шаардагддаг. Хэрэв Бурхан яг одоо бүх зовлонг эцэслэж дуусгавал цөөхөн хүмүүс гэмших бөгөөд хүн төрөлхтөн нүглийн хор хөнөөлийг ухамсарлаж чадахгүй байсан. Тиймээс сайнмэдээ дэлхий даяар тунхаглагдах зуур одоо энэ цаг үед ч зовлон шаналал ерөнхий байдлаар үргэлжлэх ёстой юм. Хэдийгээр Бурхан заримдаа гайхамшиг үзүүлдэг ч, бидний бүх асуудлыг шийдэж, бүх зовлонгоос гэтэлгэхийг гайхамшгаар дамжуулан бид хүлээх учиргүй. Эцэстээ, Бурхантай харилцаатай болсон бүх хүмүүсийн хувьд бүх зовлон шаналалд нь төгсгөл ирэх болно. Харин энэ хооронд Бурхан бидний зовлон шаналал дунд бидэнтэй хамт гашуудаж (Иохан 11:35), мөн биднийг олон янзаар тайвшруулдаг (2 Коринт 1:3-7).

Бурханы гайхамшгуудын нэг нь хүүхэдгүй эмэгтэйг хүүхдийн ээж болгох юм (Дуулал 113:9).

Библид Бурхан хүүхэдгүй эмэгтэйд хүүхэд өгсөн талаар хамгийн багадаа зургаан тохиолдлыг тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр Бурхан энэ гайхамшигийг өөр цаг үеүдэд олон удаа хийсэн ч, энэ зургаан тохиолдол нь хүүхэд тухайн түүхэнд чухал байсан учраас тэмдэглэгдсэн юм. Исаак Сарагаас (Эхлэл 21:1-3), Иаков, Есав хоёр Ребекагаас (Эхлэл 25:21, 25-26), Иосеф Рахелаас (Эхлэл 30:22-24), Самсон Маноагийн эхнэрээс (Шүүгчид 13:2-3, 24), Самуел Ханнагаас (1 Самуел 1:20), Иохан Елизабетаас (Лук 1:13, 57) тус тус төржээ.

Эдгээр зургаан тохиолдол тус бүрд тухайн гэр бүлийн эхнэр нь хүүхэдгүй байснаас болж гунигладаг байжээ. Библид тэмдэглэгдсэнээс харвал Бурхан эмэгтэйг хүүхэдгүй байсных нь төлөө хэнийг ч буруутгаж байгаагүй. Түүнчлэн эцэг эхийн аль нэг нь Бурханд таалагдаагүй гэсэн утга санаа Библид бичигдээгүй юм. Лук 1:5-7-д Зехариа, Елизабет нар Бурханы өмнө зөвт амьдарсан, Түүний тушаалуудыг бүрэн дуулгавартай дагасан ч, хөгширтлөө үр хүүхэдгүй байсан гэж хэлсэн юм. Эдгээр зургаан түүхэнд эцэг эхийн аль нэг нь гайхамшиг хүсэн залбирахдаа нүглээ гэмшсэн эсвэл хүлээн зөвшөөрсөн талаар тэмдэглээгүй байдаг. Тэдгээр эцэг эхчүүдэд хандан ярьсан Бурханы үгэнд тэд хүүхэдгүй байсан шалтгааныг дурдаагүй. Эдгээр тохиолдлууд нь үр хүүхэдгүй байгаагийнх нь төлөө хувь хүмүүсийг буруутгах ёсгүй гэдгийг харуулж байна.

Бурхан үр хүүхдийн ерөөлийг өгөхийг бид залбирах нь зохистой боловч, эцсийн дүндээ бид Бурханы шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ёстой. Бурхан өвчин болгоныг эдгээдэггүй эсвэл зовлон шаналал бүрийг арилгадаггүй шиг, Бурхан гэр бүл болгонд үр хүүхэд өгөх нь Түүний хүсэл гэж бид таамаглах учиргүй юм.

Элч Паул бие махбодод нь өргөс мэт зүйл байсан бөгөөд түүнээс гэтэлгэхийг гурван удаа залбирч байжээ (2 Коринт 12:7-10). Бид энэ нь ямар асуудал байсныг тодорхой мэдэхгүй ч, бие махбодтой холбоотой зүйл байсан бололтой. Үүнийг нь Бурхан өөрчилнө гэж тэрээр найдаж байсан учраас гайхамшигийн төлөө залбирсан. Харин Бурхан түүний өргөсийг авахын оронд сул дорой байдлаас нь илүү агуу нигүүлслийг өгнө хэмээн хэлсэн байдаг. Түүний сул дорой байдал Бурханы хүчийг олж харахад нь

Паулд тусалсан учраас энэ нь Бурханд алдрыг авчрах болно хэмээн тэр хэлжээ. Паул үргэлжлүүлэн сул дорой байдал, зовлон шаналал дунд ч баяр хөөртэй байх болно гэж хэлсэн. Учир нь тэдгээр нь Бурханыг алдаршуулах нөхцөл боломжоор хангадаг.

Элч Паул агуу итгэлтэй хүн байсан ч, гуйж хүссэн гайхамшгуудаа үргэлж хүлээн авч байгаагүй. Тэрээр Бурханы хүслийг хүлээн зөвшөөрсөн. Хэдийгээр бид үргэлж Бурханаас ерөөлийн гайхамшгийг хүсдэг ч, Түүний шийдвэрийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Заримдаа Тэр бидний сул дорой байдлаар дамжуулан ажиллахдаа ихээр алдаршуулагддаг.

► Бурхан таны хүссэн гайхамшгийг үйлдэхгүйгээр хэрхэн танд санаа тавьж байсан талаар жишээг хуваалцаарай.

Үр хүүхэдгүй байх талаарх нийгмийн хандлага

Ахуй соёлууд нь хүүхдийг үнэлэх талаар харилцан адилгүй байдаг. Зарим оронд гэр бүлүүд олон хүүхэдтэй болохыг хүсдэг. Хүүхдүүд нь гэр бүлээ тэтгэх ажилд нь тус нэмэр болох боломжтой байдаг. Үеэл, авга ах эгч нар болон бусад хүмүүсийг багтаасан өнөр өтгөн гэр бүлүүд нь хэрэгцээтэй үед бие биенээ хамгаалж, халамж анхаарал тавьдаг. Өнөр өтгөн гэр бүлийн эхнэр бүр нь хүүхэд төрүүлж гишүүдээ нэмэхийг хүсдэг. Олон хүүхэдтэй, ялангуяа хөвгүүдтэй эрэгтэй хүн ийм өнөр өтгөн гэр бүлд чухал байр суурь эзэлдэг. Гэр бүл нь ахмад настнуудаа асран халамжлах ёстой гэж үздэг.

Бусад оронд ихэнх гэр бүлүүд хот суурин газар амьдарч, эцэг эх нь ажил хийж өрх гэрээ авч явдаг. Хот суурин газрын гэр бүлд хүүхдүүдийн дэмжлэг бага байдаг. Ийм газар хүүхэд өсгөх, боловсрол олгох нь өртөг өндөр байж болно. Цаг хугацаа өнгөрөх тусам, гэр бүлүүд хэдэн үеэр хотод амьдрахдаа цөөн хүүхэдтэй болохыг ч хүсэх боломжтой. Хот суурин газрын ихэнх гэр бүлүүд зөвхөн нэг эсвэл хоёр хүүхэдтэй байхыг илүүд үздэг.

Олон соёлд хүүхдийн үнэ цэн өндөр байдаг учраас гэр бүл болгон хүндлэгдэж, үнэлэгдэхийн тулд хүүхэдтэй байхыг чухалчилдаг. Ийм газар хүүхэдгүй эмэгтэй өөрийн хамгийн чухал үүргээ биелүүлж чадахгүй бүтэлгүйтсэн мэтээр мэдэрдэг. Хэзээ ч гэрлээгүй эмэгтэй хүүхэдгүй, хэн нэгний эхнэр болж сонгогдоогүй учраас ичиж зовдог.

Олон соёлд гэр бүлүүд удам залгах гэр бүлээ удирдаж, бэхжүүлэх хөвгүүдтэй болохыг хүсдэг. Охидыг маш бага үнэлдэг. Охидыг хэвлийд байхад нь үр хөндөх эсвэл төрөх үед нь хаяж орхих нь ч бий. Зарим улс орон төрөөгүй хүүхдийн хүйсийг тогтоохыг хууль бус болгосон байдаг. Учир нь олон гэр бүл охидыг төрөхөөс нь өмнө хөнөөдөг. Библиэс бид охид нь хөвгүүдтэй адилхан нэр төр, үнэ цэнтэй байдаг гэдгийг мэддэг. Учир нь тэд бүгд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн юм (Эхлэл 1:27). Тиймээс Христийг дагадаг гэр бүлүүд ахуй соёлд нь хэвийн тогтсон эсэхээс үл хамааран охид хөвгүүдийг адилхан үнэлэх ёстой.

Хэрэв тухайн гэр бүлд хүүхдээрээ бахархах хэрэгцээ өндөр бол, тэд бие махбодын эсвэл сэтгэцийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үгүйсгэх боломжтой. Зарим оронд

эцэг эх нь тэднийг хүсээгүй учраас хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдүүдийг асрамжийн газар руу явуулдаг. Хүүхдэд ингэж хандах нь буруу юм. Учир нь тэд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд хүүхдийн чадвар, хязгаарлагдмал байдлаас үл хамааран Түүний мэлмийд үнэ цэнтэй юм.

Зарим ахуй соёлд олон эхнэр авах ёс заншил нь хүүхдийн үнэ цэнд тулгуурласан байдаг. Эр хүн хэд хэдэн эхнэр авах замаар хүүхдүүдээ олшруулахыг хүсдэг. Библид Бурханы төлөвлөгөө нь эрэгтэй хүнд нэг эхнэр байх ёстой гэж хэлсэн байдаг (Эхлэл 2:22-24, 1 Тимот 3:2).

Хуучин гэрээнд эхнэр нь нөхөртөө эмэгтэй зарц өгч, хүүхэдтэй болсон тохиолдлууд тэмдэглэгдсэн байдаг. Эхнэр нь зарцынхаа хүүхдээр дамжуулан байр суурь олж авдаг байсан. Иаковын эхнэрүүд болох Рахел, Леа нар тус тусдаа Иаковт эмэгтэй зарц өгч, илүү олон хүүхдээр дамжуулан байр суурь олж авсан байдаг.

Хүүхэд нэмэхийн тулд зарцыг ашигласан нь төвөгтэй харилцааг үүсгэсэн. Сарай Абрахамд Хагарыг өгснөөр тэр хүүхэдтэй болоход Сарайгийн байр суурь илүү сайн болно гэж найдаж байв (Эхлэл 16:2-6). Хагар жирэмсэн болж, улмаар тэр өөрийгөө Сарайгаас илүү дээр гэж мэдэрсэн. Сарай өөрийн эрх мэдлээ тогтоохын тулд түүнд хатуу ширүүн хандсан байдаг.

Лелиа Баруун Африкийн нэгэн оронд төрсөн. Гэрлээд гурван жил болсон ч тэрээр хүүхэдгүй хэвээр байв. Лелиагийн ахуй соёлд нялх хүүхэд өргөж авах нь үр хүүхэдгүй байх ичгүүрээс нь салгадаггүй байлаа. Лелиа ядуу тосгоны нэгэн гэр бүлийн жирэмсэн эмэгтэйг олж, түүний хүүхдийг худалдаж авахаар тохиролцсон. Лелиа хэдэн сарын турш хувцасныхаа дотуур ямар нэгэн зүйл хийж, жирэмсэн мэт харагдах болсон. Хүүхэд төрөх цаг болоход Лелиа төрөх эмнэлэг рүү явж байгаа мэт дүр эсгээд, дараа нь тосгоноос хүүхдийг авч гэртээ харьжээ.

Хэрэв тухайн гэр бүл хүүхдийг зөвхөн гэр бүлд нь ашиг тустай учраас л хүсдэг бол, тэд хүүхэд нь Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүн гэж үнэлж чадахгүй байх боломжтой. Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хайрлаж, хүлээн авахаас татгалзаж магадгүй. Тэд хөвгүүдийг хүсдэг учраас охидоос татгалзаж мэднэ. Тэд хүүхэдгүй эмэгтэйг ичиж зовсон, үнэ цэнгүй хүн мэт мэдрэхэд хүргэдэг. Тэд өнчин эсвэл гэр оронгүй хүүхдүүдийг өргөж авахын үнэ цэнийг олж хардаггүй. Эдгээр бүх хандлага, үйлдэл нь хувиа хичээсэн бөгөөд буруу юм. Бид эдгээр шалтгааны аль нэгээр хувь хүмүүст муугаар хандахдаа Бүтээгчийг доромжилж байдаг (Гэтлэл 4:11, Сургаалт үгс 14:31).

Английн хаан VIII Хенри 1509-1547 онуудад хаанчилж байсан юм. Тэрээр хүүтэй болохыг маш их хүсдэг байв. Эхнэр нь охинтой байсан ч, хүү тогтдоггүй байсан учраас Хенри түүнээс салж, өөр эмэгтэйтэй гэрлэжээ. Хоёр дахь эхнэр нь мөн л хүү төрүүлж чадаагүй бөгөөд Хенри эхнэрээ эх орноосоо урвасан хэмээн буруутгаж, цаазаар авахыг тушаасан байдаг.

Анагаах ухаанд эр бэлгийн эс хүүхдийн хүйсийг тодорхойлдог болохыг баталсан. Эмэгтэй хүний бие нь хүүтэй эсвэл охинтой болох эсэхийг тодорхойлох боломжгүй юм. Гэсэн хэдий ч, олон эрчүүд охинтой болсондоо, хүүгүй байгаадаа эхнэртээ уурсдаг.

Иосеф хэмээх эр, түүний эхнэр хоёр охинтой байв. Иосефийн эхнэр гурав дахь хүүхдээ төрүүлэхээр эмнэлэгт очиход Иосеф хүүтэй болохыг хүсэж байлаа. Гурав дахь хүүхэд нь мөн л охин байв. Иосеф үүнд маш их уурлаж, эхнэрээ эмнэлэгт эргэхээс, эмнэлгийн төлбөрийг төлөхөөс татгалзжээ.

Иов 24-р бүлэгт Иов хорон муу хүний үйлсийг тодорхойлж олон зүйлийг өгүүлсэн байдаг. Энд дурдсан нэг үйл нь хорон муу хүн хүүхэдгүй эмэгтэйд муугаар ханддаг гэсэн юм (Иов 24:21). Хүүхэдгүй эмэгтэйд муугаар хандахад Бурхан дургүйцдэг.

► Танай ахуй соёлд хүүхдийг хэрхэн үнэлдэг вэ? Хүмүүс хүүхэдтэй болохыг хүсдэг зарим шалтгаан юу вэ?

► Танай ахуй соёл дахь заншлаас болж ямар шударга бус явдлууд тохиолддог вэ?

Бурхан хэлэхдээ

Библид тэмдэглэгдсэн зургаан тохиолдол бүрд Бурхан хүүхэдгүй эмэгтэйд хүүхэд өгөхдөө эцэг эхийн аль нэгийг хүүхэдгүй байсанд нь буруутгах ямар ч зүйлийг хэлээгүй. Үнэн хэрэгтээ, тэдгээр хосуудыг Бурхан онцгой хөвгүүдийн эцэг эх байлгахаар тусгайлан сонгосон байсан юм. Зехариа, Елизабет хоёрыг зөвт хүмүүс гэж нэрлэсэн (Лук 1:5-6). Бурхан таалаагүй учраас эмэгтэй хүн хүүхэдгүй байгаа гэж бид хэзээ ч таамаглах ёсгүй.

Иов 24:21-д хүүхэдгүй эмэгтэйд муугаар хандах нь бузар муу хүний үйлдэл гэж хэлсэн. Бурхан хүүхэдгүй эмэгтэйг шүүж, муугаар ханддаггүй. Бид ч мөн тэгэх ёсгүй.

Исаиа 56:4-5-д Бурхан хүүхэдтэй болох чадваргүй эрэгтэй хүнд хандан айлдсан байдаг. Хэрэв энэ хүн Бурханд дуулгавартай байж, Түүний гэрээний дагуу амьдарвал, хөвгүүд, охидтой байснаас илүү сайн байр суурь, нэр хүндтэй болно гэж хэлсэн юм.

Элч Паул өөрийгөө Тимот (1 Тимот 1:2), Тит (Тит 1:4) болон Онесимын (Филемон 10) эцэг нь хэмээн нэрлэсэн. Тэр өөрийгөө Коринтын итгэгчдийн эцэг гэж дуудаж байсан (1 Коринт 4:15). Паул тэдний биеийн эцэг биш, харин сүнслэг эцэг нь байсан юм. Тэдний сүнслэг эцэг байх нь түүнд илүү чухал байв.

Матай 12:46-50-д Есүсийг зааж байх үед түүний эх, ах дүү нар нь түүнийг үзэхээр ирсэн талаар өгүүлдэг. Есүс сонсогчдоос "Хэн Миний эх, хэн Миний дүү нар вэ?" гэж асуусан. Дараа нь Тэрээр Бурханы хүслийг биелүүлдэг хүмүүс Түүний ах, эгч, эх гэж хэлжээ. Есүс гэр бүлдээ анхаарал тавьдаг байсныг бид мэддэг. Загалмай дээр байхдаа ч Тэрээр ээжийгээ халамжлахад анхаарч үүнийг зохицуулж байсан (Иохан 19:26-27). Гэхдээ Есүс сүнслэг гэр бүл нь төрсөн гэр бүлээс ч илүү чухал хэмээн хэлсэн юм.

Итгэлийн гэр бүл нь төрсөн гэр бүлийг орлохгүй. Харин итгэлийн гэр бүлд багтсан хүний орон зай нь тэр хүн хэн болох хамгийн чухал үнэ цэнийг өгч байдаг. Чуулганы хүмүүс бие биеэ *ах, эгч* гэж дуудах нь итгэлийн гэр бүл дэх харилцаа нь ямар чухал болохыг харуулдаг (Колоссай 1:2).

Дебора нь Израилын шүүгчээр үйлчилж байсан эмэгтэй эш үзүүлэгч байв (Шүүгчид 4:4). Дебора мөн эрх чөлөөнийхөө төлөө Израилыг дарлаж байсан үндэстэнтэй хийсэн дайн тулааныг удирдсан юм. Шүүгчид 5:7-д Дебора өөрийгөө Израилын эх гэж нэрлэсэн. Библид Деборагийн төрүүлсэн хүүхдүүдийн талаар хэзээ ч дурдаж байгаагүй. Харин тэр удирдлагаараа ард түмэндээ санаа тавьсан учраас Израилын эх байсан юм.

Элч Петр Сарагийн жишээг дагадаг эмэгтэйчүүдийг түүний охид гэж хэлсэн байдаг (1 Петр 3:6). Энэ үг Сараг ямар агуу байр сууринд байгаагаар харуулсныг төсөөлөөд үз дээ! Энэ нь түүний Исаакийн эх байсан үүргийн улмаас биш, харин түүний итгэл, дуулгавартай байдлын жишээн дээр үндэслэсэн байр суурь юм.

Итгэлээр нигүүлслээр аврагдсан бүх хүмүүсийг Абрахамын хүүхдүүд гэж нэрлэдэг (Галат 3:7). Абрахам олон сая итгэгчдийн эцэг байх өндөр хүндэтгэлийг хүлээдэг. Абрахам, Сара нарын жишээнээс бид Бурхан сүнслэг эцэг эхийг ихэд өргөмжилдөг болохыг харж байна.

Элч Паул гэрлэхгүй байхын давуу талыг тайлбарласан байдаг. Гэрлээгүй хүн бусад олон үүрэг хариуцлагагүйгээр Бурханыг баярлуулахад анхаарлаа төвлөрүүлж чаддаг (1 Коринт 7:32-35). Гэрлээгүй хүн хүүхэдгүй байсан ч, Паул хэрэв хүн цэвэр ариун амьдралаар амьдарч чадвал ганц бие байх нь хамгийн сайн гэж хэлжээ. Эдгээр мэдэгдлээс болж ганц бие байх нь зарим хүмүүсийн хувьд Бурханы хүсэл мөн гэдэгт бид итгэлтэй байж болно.

Ганц бие байхтай адил үр хүүхэдгүй байхад ч давуу тал бий. Бурхан ганц бие хүмүүст онцгой боломжууд олгодог шиг, гэрлэсэн боловч хүүхэдгүй хүмүүст ч боломжууд бий. Хэдийгээр тэд хүүхэдгүй байхыг сонгоогүй ч, Бурханы төлөө чадах бүхнээ хийх ёстой.

Ганц бие байх, үр хүүхэдгүй байх болон бусад ямар ч нөхцөл байдалд Бурхан биднээр дамжуулан ажиллаж, бидэнд болон бусдад сүнслэг ашиг тусыг авчрах болно гэдэгт бид итгэж найдаж чадна (Ром 8:28).

Эцэг эх нь хайр халамж үзүүлдэггүй олон хүүхэд бий. Итгэлийн гэр бүлийн зарим хувь хүмүүс эсвэл хосууд тэдэнд хайрыг харуулахыг хичээхгүй л бол тэдний амьдралд энэ хэрэгцээг нь хангах өөр хэн ч байхгүй байж болно.

Бид өөрийн биеэ Бурханд тахил золиос болгон өргөж, Бурханд зориулан амьдрахыг уриалсан байдаг (Ром 12:1).

Гол санааны хураангуй

1. Хүүхдүүд бол Бурханы ерөөл бөгөөд хосууд тэдэнд хүүхэд өгөхийг Түүнээс залбирах нь зөв юм.
2. Гайхамшгаар үргэлж хүүхэдтэй болох нь Бурханы хүсэл гэж таамаглах нь буруу юм. Бурхан бусад бүх хэрэгцээнд үргэлж гайхамшгаар ханддаггүйн адил үргэлж хүүхэдтэй байлгахаар сонгодоггүй.
3. Үр хүүхэдгүй байгаагийнх нь улмаас эмэгтэйг эсвэл хосыг буруутгах нь буруу юм. Хүний нөхцөл байдалд Адамын нүгэл, бидний өвөг дээдсийн нүгэл болон бидний нийгмийн нүгэл нөлөөлдөг.
4. Бид хөвгүүд, охидыг адилхан хайрлаж, үнэлэх ёстой. Учир нь тэд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс юм.
5. Хүн төрүүлсэн хүүхэдгүй байсан ч, олон үед нөлөөлөх сүнслэг эцэг эх байж чадна.
6. Бурхан гэрлээгүй болон хүүхэдгүй хүмүүст онцгой үйлчлэлийн боломжуудыг олгодог.
7. Бид өөрсдийгөө Бурханд зориулж, Түүний бидэнд сонгосон нөхцөл байдлаар Түүнийг алдаршуулах ёстой.

Пасторын үйлчлэл

Харамсалтай нь, олон газар чуулганууд үр хүүхэдгүй байх асуудалд хандахдаа Бурханы Үгээс илүүтэй өөрсдийн ахуй соёлыг дагасан байдаг.

Пастор өөрийн хүмүүст үр хүүхэдгүй байх талаарх Библийн ойлголтыг, ялангуяа өмнөх хэсэгт дүгнэсэн байдлаар ойлгож хандахыг заах ёстой.

Хэрэв пастор хүүхэдгүй хосын төлөө гайхамшгийг хүсэн залбирч байгаа бол, тэрээр итгэлийн хариуцлагыг эхнэр эсвэл нөхөрт нь хүлээлгэх ёсгүй. Есүс бяцхан хүүхдийг эдгээх эсвэл үхсэн хүнийг амилуулах үед тэрхүү эдгэрсэн эсвэл амилсан хүмүүст өөрсдийн амссан гайхамшгийн төлөөх итгэл байгаагүй юм. Хэрэв тухайн пастор Бурхан гайхамшгийг үйлдэхийг хүсэж байгаад итгэлтэй байвал, пастор итгэлтэй байх ёстой бөгөөд итгэлгүй байсанд нь эхнэр эсвэл нөхрийг буруутгах ёсгүй.

Ром 12:15-д биднийг уйлж буй хүмүүстэй хамт уйлах ёстой гэж хэлсэн байдаг. Пастор чуулганыхаа хүмүүсийн гуниг харууслыг мэддэг байх ёстой. Тэрээр үр хүүхэдгүй байх эсвэл хүүхдээ алдсанаас болж гашуудаж буй хүмүүсийг зоригжуулж, тайвшруулах санаачилгыг авах ёстой. Хосууд төрөөгүй хүүхдийнхээ (зарим нь төрөх хүртлээ амьдраагүй) үхлээс болж гашууддаг. Эхнэр, нөхөр хоёул зовж байгаа ч, тэд өөр өөрөөр илэрхийлдэг гэдгийг санаарай. Пастор гашуудаж буй хүмүүс өөр дээр нь зөвлөгөө авахаар ирэхийг хүлээх учиргүй. Пастор бие биенээ зоригжуулж, дэмжихийг чуулгандаа заах ёстой.

Пастор үр хүүхэдгүй ахмад хүмүүстэй харилцаа тогтоох, тэднийг халамжлах талаар чуулганыг чиглүүлэх хэрэгтэй. Итгэлийн гэр бүлийн гишүүд тэдэнд хайраа харуулж, хамтдаа цаг өнгөрөөж, практик хэрэгцээнд нь тусалж, эцэг эх эсвэл эмээ өвөө мэт хандах учиртай.

Пастор гэрлээгүй болон хүүхэдгүй хүмүүсийг чуулган болон хамт олноо ерөөх арга замуудыг олж үйлчлэхэд нь тэдэнд туслах ёстой. Пастор итгэлийн гэр бүл дэх хүн нэг бүр чухал болохыг батлан харуулах хэрэгтэй.

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Танай ахуй соёлд хүмүүс хүүхдийг хэрхэн үнэлдэг вэ? Тэд үр хүүхэдгүй байхад хэрхэн ханддаг вэ?
- ▶ Танай ахуй соёлд итгэгчид хүүхдийг хэрхэн үнэлдэг вэ? Танай ахуй соёлд итгэгч хүн хүүхэдгүй байхад хэрхэн ханддаг вэ?
- ▶ Энэ хичээлд танилцуулсан Бичвэрийн зарчмуудыг судлах нь таны үр хүүхэдгүй байх талаарх ойлголтыг хэрхэн өөрчилсөн эсвэл бодоход хүргэсэн бэ?
- ▶ Танай чуулганы гэр бүлүүдийн дунд хүүхэдтэй болж чадахгүй байгаа хосууд бий юу? Хэрэв тийм бол, танай чуулган тэднийг хэрхэн дэмжиж, асуудлыг нь сонсох аюулгүй газар байж чадах вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Христитгэлт гэр бүлүүдийн төлөө талархъя. Таны төлөө амьдардаг нөхөр, эхнэрүүдийн төлөө, мөн таны хаанчлалд оруулж буй хувь нэмрийнх нь төлөө талархъя.

Бид үр хүүхэдгүй зовж буй хосуудын төлөө залбирч байна. Та тэдний зүрх сэтгэлийг тайвшруулж, зоригжуулаач хэмээн бид залбирч байна. Хүүхэдтэй болж чадах эсэхээс нь үл хамааран, та тэднийг тууштайгаар хайрладаг гэдгийг мэдүүлж өгөөч.

Хэрэв тэдэнд биеийн үр хүүхэд өгөх нь таны хүсэл бол, та өөрийн цагтаа энэ боломжийг олгоно гэдэгт бид итгэж байна. Та тэдэнд биеийн хүүхдийг өгөх эсэхээс үл хамааран, бусдын сүнслэг эцэг эх болоход нь тэдэнд туслаач.

Бүх итгэгчид хүн бүрийг таны дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс гэж үнэлэхэд туслаач.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Хоёр хуудас эргэцүүлэл бич. Үүнд:

- Танай нийгмийн хүүхэд болон үр хүүхэдгүй байх талаарх үзэл бодлыг тодорхойл.
- Хүүхдийн талаарх Библийн сургаалыг тайлбарла.
- Үр хүүхэдгүй байх талаарх Библийн сургаалыг тайлбарла.
- Гэрлэсэн хосыг үр хүүхэдгүй байгаагийнх нь улмаас буруутгах ёсгүй гэдгийг Библийн зарчмуудаар тайлбарла.

(2) Үр хүүхэдгүй хүмүүсийг урамшуул.

Сонголт 1: Үр хүүхэдгүйгээс болж гашуудаж буй таны таньдаг хэн нэгэнд хэрхэн энэрэл өршөөлөөр хандаж, санаа тавьж болох талаар бичнэ үү. Христ доторх ах эгч дүү нараа ерөөж болох зарим зүйлсийг тодорхой дурдаж, хийх болон тэдэнд хэлж болох зүйлсээ бич.

Сонголт 2: Үр хүүхэдгүйгээс болж гашуудаж буй таны таньдаг хэн нэгэнд зориулж богино урамшуулах захидал бич. Тэдний юу мэдэрч байгааг ойлгохыг хичээ. Та тэдний сэтгэл санаанд анхаарал хандуулж байгаагаа мэдүүлээрэй. Тэдний төлөө залбирч байгаагаа хэл. Тэдэнд захидлыг өгөхдөө тэднийг сонсоход болон зохих ёсоор санаа тавилтаа харуулахад бэлэн байгаарай.

Жирэмслэлтийг хянах

11-р хичээлийг үргэлжлүүлэн үзэхийн өмнө **Хавсралт Б**-г судалж ангидаа хэлэлцэх хэрэгтэй. Энэ нь гэрлэлт ба гэр бүлтэй холбоотой чухал сэдэв болох жирэмслэлтийг хянах талаарх товч хэлэлцүүлэг юм.

11-р хичээл

Хүүхдийн хөгжил ба хүмүүжил

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Хүн бүрийг бүтээсэн Бурханы гайхалтай ажлыг үнэлэх.
- (2) Хүний амь эрхэм нандин гэдэгт итгэх.
- (3) Хүүхэд бүрэлдсэн цагаас эхлэн хүний амийг хамгаалахад сэдэлжүүлэх.
- (4) Хүүхдийн эрүүл хөгжилд эцэг эхийн халамж чухал болохыг ойлгох.

Бяцхан ихрүүд

Марк, Мэри хоёр Энэтхэг улсад амьдардаг байжээ. Тэд гэрлээд хэдэн жилийг өнгөрүүлсэн ч хүүхэдтэй болж чадаагүй. Харин тэдэнд нэг санал ирсэн. Мэригийн хамаатны нэг хүн ихэр охид төрүүлсэн бөгөөд тэднийг өсгөх боломжгүй гэдгээ хэлжээ. Марк, Мэри хоёр бяцхан ихрийг их баяр хөөртэйгөөр хүлээн авсан ч бэрхшээлтэй тулгарчээ. Хүүхдүүд хугацаанаасаа эрт төрсөн тул ердөө 1.4 кг жинтэй байлаа. Шинэхэн эцэг эхчүүдийн хувьд бяцхан охидыг хэрхэн хооллож, асрах талаар олон зүйлийг мэдэх шаардлагатай болсон. Тэд олон шөнө нойроо хугасалж, тэднийг асарсан бөгөөд охид амьд үлдэж, хөөрхөн эрүүл хүүхдүүд болон өсөж торнижээ.

Нялх үе

Хэвлийд бүрэлдэх үеийн хүүхдийн хөгжил

► Нэг суралцагч Дуулал 139:13-18 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд Бурхан биднийг эхийн хэвлийд бүрэлдсэн цагаас төдийгүй, бидний бие дүр төрхөө олохоос ч өмнө (16-р эшлэл) мэдсэн гэж хэлсэн байдаг. Бурхан таныг төрөхөөс ч өмнө таныг мэддэг байсан бөгөөд танд зориулсан төлөвлөгөө Түүнд байжээ.

Эрэгтэй хүний эр бэлгийн эс эмэгтэй хүний өндгөн эстэй нийлэх мөчид хүүхэд бүрэлддэг. Тэр мөчөөс шинэ хүн, шинэ хүний амьдрал оршин тогтнодог! Тухайн хүний бүх генетикийн мэдээллийг агуулсан цоо шинэ эс бий болдог. Үр тогтсоноос хойш 24 цагийн дотор тухайн эс хоёр эс болон хуваагддаг. Эдгээр эс тус бүр нь дахин хоёр эс болон хуваагддаг. Эс бүр хоёр хуваагдах тусам эсийн тоо олширсоор байдаг. Ойролцоогоор нэг долоо хоног өнгөрөхөд олон эсээс бүрэлдсэн хүүхэд эхийн хэвлийн дотор бэхлэгдэж, тэндээ өсөж хөгжсөөр байдаг. Эс бүр нь тухайн хүнийг бүтээх "код" (ДНХ) агуулдаг. Эсүүд кодын зааврыг дагаж, биеийн хэсэг бүрийг бүрэлдүүлдэг.

3 долоо хоног өнгөрөхөд хүүхдийн нугас болон тархи бүрэлдэж эхэлдэг. 4 долоо хоног өнгөрөхөд хүүхдийн нүд, гар бүрэлдэж, зүрх ажиллаж эхэлдэг. 12 долоо хоног болоход хүүхдийн биеийн бүх чухал эрхтэн бүрэлдэж тогтдог.

Хүүхэд бүрэлдсэнээс 14 долоо хоног өнгөрөхөд хүүхдийн өвөрмөц хурууны хээ бүрэн бүрэлдэж тогтдог. 16-24 долоо хоног өнгөрөхөд эх нь хэвлийд байгаа хүүхдээ хөдлөхийг нь мэдэрдэг. Ойролцоогоор 26-28 долоо хоног өнгөрөхөд хүүхдийн уушги амьсгалах хэмжээнд хангалттай хөгждөг бөгөөд хүүхэд ойролцоогоор 0.9 кг жинтэй болдог. Хүүхэд хэвлийд бүрэлдсэнээс хойш 38-40 долоо хоногийн дараа төрдөг. Хүүхэд бүр бүтээгч Бурханы бүтээсэн гайхамшигтай, онцгой бүтээл юм.

► Нэг суралцагч Номлогчийн үгс 11:5 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан хүүхдийг эхийн хэвлийд хэрхэн бүтээж, бүрэлдүүлж, хөгжүүлдэг нь үнэхээр гайхамшигтай юм. Хүмүүс энэ үйл явцыг болон үүнтэй холбоотой бүхнийг хэзээ ч бүрэн ойлгож чадахгүй. Гэсэн хэдий ч, бүх тив, нийгэм, ахуй соёлыг хамруулаад хүний хөгжил яг ижил дараалал, загварыг дагадаг. Бүтээгчийн загвар төгс төгөлдөр юм!

► Нэг суралцагч Иов 10:8-12 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэлд хүүхэд эхийн хэвлийд бүрэлдэх, хөгжих үйл явцыг Иов жишээгээр тайлбарласан байдаг. Бүтээгч Бурхан амьдралын эзэн гэдгийг Иов бидэнд хэлдэг.

Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн үнэ цэн

Эхлэл 1:26-27 ба Эхлэл 9:6 эшлэлд бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдгийг хэлдэг. Бүх хүний амь эрхэм нандин билээ. Тийм учраас ямар ч хүнийг хөнөөх нь нүгэл юм (Эхлэл 9:5, Гэтлэл 20:13).

Езекиел 16:20-21, 36, 38-д Бурхан хүүхдийн амийг таслахыг хүссэн хүмүүсийн эсрэг хүчтэйгээр өгүүлсэн. Тэрээр израилчуудад хандан шүтээнүүдэд хүүхдээр тахил өргөхийг хориглож, тэднийг маш хатуу цээрлүүлэх болно гэдгийг тунхагласан.

Исаиа 46:3-4-д Бурхан хүний хөгжлийн үе шатуудад хүн төрөлхтнийг хэрхэн халамжилдаг тухайгаа ярьж байна:

Иаковын гэр ээ, Израилын гэрийн үлдэгсэд ээ, бүгд Намайг сонсогтун. Та нарыг эхийн хэвлийд байхаас Би тээсэн. Төрөхөөсөө та нар Надаар өргүүлсэн. Та нарыг өндөр настай болсон ч Би байсаар байна. Үс буурал болсон ч Би үүрч явах болно. Би бий болгосон, Би тээнэ. Би үүрнэ, аварна.

Ямар гайхалтай амлалт вэ!

Бүх хүн, үүнд төрөөгүй хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон онцгой хэрэгцээт хүмүүс, ахмад настнууд багтана. Хүний үнэ цэн нь түүний юу хийж чадах эсэхээс, эсвэл тэр ганцаараа амьд үлдэж чадах эсэхээс хамаардаггүй. Харин хүн бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас үнэ цэнтэй юм.

Библи бидэнд хүүхэд бүр бүрэлдсэн цагаас эхлэн Бурханы нүдэнд үнэ цэнтэй гэдгийг хэлдэг (Дуулал 139:13-18). Үүний улмаас хэвлийд бүрэлдсэн мөчөөс эхлэн хүн болдог гэдгээ бид мэддэг. Жирэмслэлтийг үр хөндөлтөөр санаатайгаар зогсоох нь хүнийг алах явдал юм.

Христийг дагадаг хүмүүс хэвлийд байгаа хүүхдийн амийг хамгаалж, эхчүүдэд үйлчлэхийн тулд дор хаяж дөрвөн аргаар ажиллах ёстой.

1. Тэд хэвлийд байгаа хүүхдийг хөнөөхөөс хамгаалах хууль тогтоомж, шүүхийн шийдвэр гаргахад нь улс үндэстнийхээ засгийн газар, шүүхийн тогтолцоонд нөлөөлөх ёстой.
2. Тэд үр хөндөлт нь цорын ганц сонголт гэж мэдэрч буй жирэмсэн эмэгтэйчүүдэд практик тусламж үзүүлж, хүүхдийнхээ амийг хамгаалах боломжтой гэдгээ мэдрэхэд нь туслах ёстой.
3. Тэд хүсээгүй нялх хүүхдүүдийг асрах ёстой.
4. Тэд өнгөрсөн үеийн үр хөндөлтийн гэм буруугаас болж зовж буй эмэгтэйчүүдэд нигүүлсэл, сүнслэг тусламжийг үзүүлэх ёстой.

Төрөөгүй хүүхдэд санаа тавих нь

Эхийн хэвлийд тээгдэж буй хүүхэд мөнхийн хувь тавилантай гэдгийг ойлгох нь чухал юм. Тэр хүн үүрд орших болно. Үүний улмаас эцэг эхчүүд хүүхдээ амьдралынх нь бүх талбарт буюу бие махбод, оюун санаа, нийгмийн/сэтгэл санаа, сүнслэг байдлаар халамжлах ёстой!

► Нэг суралцагч Матай 18:2, 10 эшлэлийг бүлэгт уншина.

Эрэгтэй хүний зан байдал нь хэвлийд байгаа хүүхдийнх нь эрүүл мэндэд нөлөөлж болно. Тэр ч байтугай анх удаа аав болох боломжийг ч үгүй хийж чадна. Архи, хар тамхи, эсвэл тамхи татах нь эр бэлгийн эсийг гэмтээж, үргүйдэл (үр тогтоох боломжгүй) эсвэл зулбах (жирэмслэлтийн үедээ амьгүй болох) магадлалыг нэмэгдүүлдэг.

Жирэмсэн эх хортой бодис, тухайлбал мансууруулах бодис (жороор олгодог эсвэл хууль бус), архи, тамхи зэргийг хэрэглэх нь хэвлий дэх хүүхдийг байнга гэмтээх боломжтой. Ийм бодисууд нь хүүхдийн хөгжилд саад болж, хүүхдийг бие махбодын эсвэл сэтгэцийн асуудалтай төрөхөд хүргэдэг.³⁷

Хэвлийд байгаа хүүхдийн хөгжлийн хамгийн чухал үеүүдийн нэг бол эрхтэн, эд эсүүд анх бүрэлдэж эхлэх үе буюу ялангуяа жирэмсний 3-4 долоо хоногийн хооронд юм. Энэ үедээ олон эмэгтэйчүүд хүүхэд бүрэлдсэнийг хараахан мэддэггүй!

► Нэг суралцагч 1 Коринт 10:31 эшлэлийг бүлэгт уншина.

³⁷ Greg Cook & Joan Cook, *The World of Children*, 3rd ed. (Pearson Education, 2013), 85.

Хэдийгээр эх нь хэвлийд байгаа хүүхдийнхээ эрүүл мэндийг хянаж чадахгүй ч, тэрээр сайн хооллож, хортой бодисоос зайлсхийж, хүүхдэдээ чадах чинээгээрээ туслах ёстой. Бурхан хүүхдийг үнэ цэнтэй гэж хэлсэн бөгөөд бид тэдэнд ингэж хандсанаар Бурханыг алдаршуулдаг.

Төрөх хүртлээ амьдраагүй төрөөгүй нялх хүүхдийн хувьд харамсалтай. Төрөөгүй хүүхдийн эндэл нь ихэнхдээ эхийн хийсэн зүйлээс болдоггүй. Эцэг эхчүүдийн хувьд энэ нь маш их өвдөлт гарз хохирол байдаг учраас бусад итгэгчид тэр үед тэднийг тайвшруулахыг хичээх учиртай.

Төрөх үе

Хүүхэд төрөхтэй холбоотой зарим ахуй соёлын ялгаатай ёс заншил байж болох ч, хүүхэд төрүүлэх талаарх олон зүйл дэлхийн хаа сайгүй эмэгтэйчүүдэд ижил байдаг. Эхлэл 3:16-д Бурхан: "эмэгтэйд өөрийн чинь жирэмсний бэрхшээл зүдүүрийг Би бүр ихэсгэнэ. Өвдөж зовж чи үр хүүхдээ төрүүлнэ..."

Олон зуун жил өнгөрсөн ч Бурханы үг дэлхийн хаа сайгүй үнэн хэвээр байна. Адам, Ева хоёрын анхны нүглийн үр дагавар нь төрөх үйл явцад мэдрэгдсэн хэвээр байна. Тэр ч байтугай Есүсийг төрүүлсэн эх Мариад ч энэ хамаатай байсан бөгөөд тэрээр төрөлтийн өвдөлтийг мэдэрчээ.

Бага нас

Бие бялдрын хөгжил

Хүүхэд бие бялдрын чадварыг тодорхой үе шатуудаар хөгжүүлдэг. Нялх хүүхэд эхлээд толгойгоо өргөж, дараа нь сууж, мөлхөж, улмаар алхдаг. Эдгээрийн аль нэг нь хүлээгдэж буй хугацаандаа болоогүй тохиолдолд эцэг эх нь санаа зовдог. Хүүхдүүд өсөж томрох тусам бид тэднийг 4-5 насандаа үсэрч, авирч, гүйдэг болсныг харах болно. Тэд зөвхөн сүү уудаг байсан бол удалгүй бор хоол идэх хүртэл өсөж хөгждөг. Гэр бүлийн гишүүд хүүхдийнхээ эдгээр төрөлх бие бялдрын хөгжлийг дэмжиж, урамшуулдаг.

Оюун санааны хөгжил

Асран халамжлагчид нялх хүүхдийн анхны уйлахыг сонсож, ойролцоогоор хоёр сартайд нь хүүхдийнхээ цовоо цолгиун дуу авиаг сонсохоор хүлээдэг. Дараа нь нялх хүүхэд амандаа бувтнаж, дуу авиаг давтаж эхэлдэг. Ойролцоогоор зургаан сартайдаа хүүхэд нь "Аав" эсвэл "ээж" (мама) гэж хэлэхэд нь эцэг эх нь баярладаг. Хүүхдүүд ихэвчлэн нэг настайдаа үг хэлж, хоёр настайдаа бүтэн өгүүлбэрээр ярьж эхэлдэг.

Бяцхан хүүхдүүд ой санамж, санадаг зүйлсээрээ биднийг гайхшруулдаг. Тэд олон асуулт асуудаг. Хэрэв та тэдэнтэй ямар нэгэн онцгой зүйл хийхээр амласан бол тэд үргэлж санадаг. Тэдний оюун санааны хөгжил нь Бурханы бүтээл загвар учраас явагддаг ч, эцэг эх болон бусад асран халамжлагчид хүүхдийг бүрэн чадамждаа хүртэл хөгжихөд нь их нөлөө үүрэг гүйцэтгэдэг.

Нийгмийн болон сэтгэл санааны хөгжил

Хүүхэд бие бялдрын хувьд эрүүл хөгжихийн тулд эцэг эхээсээ тусламж авах хэрэгтэй. Гэсэн хэдий ч, нийгмийн болон сэтгэл санааны хувьд хөгжихийн тулд тэдэнд илүү их урамшуулал хэрэгтэй.

Эцэг эх, багш нар болон бусад асран халамжлагчид хүүхэд бүрийг нийгмийн болон сэтгэл санааны хувьд хөгжихөд нь зориудаар туслах учиртай.

Эцэг эхчүүд дараах жагсаалтад байгаа зүйлсийг хийснээр хүүхдээ нийгмийн болон сэтгэл санааны хувьд хөгжиж, төлөвшихөд нь тусалдаг.

► Энэ жагсаалтыг уншина уу. Дараа нь жагсаалтыг хоёр дахь удаагаа уншаарай. Эцэг эхийн хувьд таны аль хэдийн сайн хийхийг хичээж буй зүйлсийг болон та үүнийг хэрхэн хийж байгаа тодорхой жишээг бичнэ үү. Та зориудаар хийж байгаагүй зүйлсийн хажууд тэмдэг тавиарай. Тэдгээрийн дэргэд та юу хийж эхэлж болохыг бич. Хэрэв та эцэг эх биш бол, та өөрийн хамаатан садан эсвэл гэр бүлийнхээ ойр дотно хүүхдүүдэд зориулж хийж болох зүйлсийг жагсаалтаас сонгох боломжтой.

Хүүхдээ төлөвшихөд нь туслах арга замууд³⁸

(1) Өөртөө санаа тавих байдлаар

- Хувийн стрессээ хянаж зохицуул.
- Гэр бүлийнхээ нөөцийг зохицуул.
- Бусад эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүл.
- Хэрэгтэй үед бусдаас дэмжлэг хүсэж, хүлээн ав.
- Өөрийн хувийн давуу байдал болон эцэг эх байхын давуу талаа таньж мэд.
- Хүүхэд өсгөх зорилтуудыг тавьснаар зорилгоо тодорхой байлгах.

(2) Ойлгох байдлаар

- Хүүхдүүдээ болон тэдний хөгжлийг ажиглаж, ойлго.
- Хүүхдүүд эргэн тойронд болж буй зүйлд хэрхэн нөлөөлж, хариу үйлдэл үзүүлж байгааг таньж мэд.

(3) Чиглүүлэх байдлаар

- Зохистой, хүсэн тэмүүлэх зан байдлыг үлгэрлэн харуул.
- Боломжтой хязгаарлалтуудыг тогтоож, хадгалж хэвших.
- Хүүхдүүдэд хариуцлагад суралцах боломжийг олго (Боломжууд нь тэдний хөгжлийн үе шатанд тохирсон байх ёстой).

³⁸ Charles A. Smith, et al., *National Extension Parent Education Model*. (Manhattan, Kansas: Kansas Cooperative Extension Service, 1994) номоос ашиглав. 2023 оны 7 сарын 31-нд дахин хандсан: <https://www.k-state.edu/wwparent/nepem/nepem.pdf>

- Асуудлыг шийдвэрлэх ур чадварт сурга.
- Хүүхдийнхээ үйл ажиллагаанд анхаарал хандуул.
- Хүүхдийнхээ бусад хүүхдүүд болон насанд хүрэгчидтэй харилцах харилцаа, туршлагыг хянаж анхаарч бай.

(4) Халамжлах байдлаар

- Хайр халамж, энэрэнгүй сэтгэлээ илэрхийл.
- Хүүхдийн өөрийгөө хүндлэх сэтгэл, найдварыг төлөвшүүл.
- Хүүхдийн мэдрэмж, санаа бодлыг сонсож, анхаар.
- Сайхан сэтгэлийг зааж сурга.
- Хүүхдийн хоол хүнс, орон байр, хувцас, эрүүл мэнд, аюулгүй байдлын хэрэгцээг ханга.
- Хүүхдүүдтэйгээ хамт амьдралын сайхныг тэмдэглэж бай.
- Хүүхдүүдэд гэр бүлийн түүх, өв уламжлалтайгаа холбогдож танин мэдэхэд нь туслаарай.

(5) Сэдэлжүүлэх байдлаар

- Хүүхдүүдэд өөрсдийнх нь, бусдын мөн тэднийг хүрээлэн буй дэлхий ертөнцийн тухай заа.
- Сониуч зан, төсөөлөл, мэдлэгийг эрэлхийлэх хүслийг өдөө.
- Ашиг тустай сургалтын нөхцлийг бүрдүүл.
- Хүүхдүүдэд мэдээллийг олж авах, боловсруулахад нь туслаарай.

(6) Өмгөөлөх байдлаар

- Өөрийн хүүхдүүдийн төлөө болон хүүхдэд ээлтэй нийгмийн төлөө хамт олны нөөц, эх сурвалжийг олж, ашиглаж, бий болго.
- Хүүхэд болон гэр бүлд дэмжлэг үзүүлэх орчныг бий болгохын тулд нийгмийн өөрчлөлтийг өдөө.
- Гэр бүл, хөрш, хамт олны бүлгүүдтэй харилцаа тогтоо.

Сүнслэг хөгжил

Бурхан биднийг сүнслэг амьдралтайгаар бүтээсэн учраас (Эхлэл 2:7) бид хүүхдүүддээ итгэлийг зааж, Бурхантай харилцах харилцаанд амьдрахад нь чиглүүлэх ёстой.

► Суралцагчид Дуулал 78:5-8 ба Дэд хууль 6:4-9 эшлэлийг бүлэг уншина. Та гэр бүлдээ хичээнгүйлэн заах Бурханы тушаалыг ямар арга замаар биелүүлж байна вэ? Та ямар талбарт хөгжих шаардлагатай байна вэ?

Бид гэр бүлдээ заах тухай Бурханы тушаалуудыг нухацтай авч үзэх ёстой. Үгүй бол, бид Бурханд дуулгавартай амьдарч чадахгүй бөгөөд бидний хүүхдүүд ч Бурханы эрх мэдлийг үгүйсгэх болно.

Хүүхдүүдэд заах олон янзын арга хэлбэрүүд бий. Үүнд: Библи унших, Есүсийн тухай дуу дуулах, Библийн эшлэл цээжлэх, залбирах, асуулт хариултаар заах, мөн өдөр бүрийн ярилцлага. Түүнчлэн чуулганд хамрагдах нь гэр бүлийнхэнд бүгдэд нь чухал юм.

Заримдаа эцэг эх нь хүүхдээ унтахаар хэвтэхэд нь тэвэрч, итгэл болон Есүс биднийг хайрладаг тухай дуу дуулж болно. Хүүхдүүд Бурханы хайр, итгэмжит байдлын тухай сонсож, эцэг эхийнхээ хайр халамжийг мэдрэх үедээ итгэл нь илүү хүчтэй болдог.

Дүгнэлт

Эцэг эх байх таны өдрүүд урт удаан үргэлжилнэ. Тэд маш завгүй; таныг ядраадаг; түүнчлэн тэд таных биш. Гэсэн хэдий ч, хүүхдийн уйлах, сүү асгах, бохир живх, хэзээ ч дуусдаггүй өдөр тутмын ажлын дунд түр зогсоод, хэтийн төлөвийг анзаарч харахад цаг гаргаарай. Та Бурханы хүүхдүүдийн нэгийг халамжилж байгаагаа сана. Тэр өөрийн мөнхийн төлөвлөгөөгөө танд итгэж даатгасан юм. Тэрээр танаас төгс байшинтай байхыг, гайхалтай төсөв төлөвлөгөөтэй байхыг, тансаг хоол, эсвэл хүүхдүүдээ үнэтэй хувцас өмсүүлэхийг шаардахгүй. Харин Тэрээр танаас дараах зүйлийг хүсэж байна:

Чи ЭЗЭН Бурханаа бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла. Өнөөдөр чамд миний тушааж буй энэ үгсийг чи зүрхэндээ байлгаж, хөвгүүдээ үүгээр хурцлан, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, хэвтэж байхдаа ч, өндийн босохдоо ч түүний тухай ярьж бай (Дэд хууль 6:5-7).

Хэлэлцүүлгийн асуултууд

- Танай нийгэмд хүүхэд асрах ямар талууд ихэвчлэн үл тоомсорлогддог вэ?
- Гэр бүлүүд ямар бэрхшээлтэй тулгардаг вэ? Энэ хичээлд дурдсан хүүхэд асарч халамжлах зүйлс нь тэдэнд яагаад хялбар биш байдаг вэ?
- Итгэгчид жирэмсэн эхчүүдэд өөрсдийгөө болон хэвлийд байгаа хүүхдээ халамжлахад нь хэрхэн тусалж чадах вэ?
- Христитгэлт гэр бүлүүд бага насны хүүхдүүд болон ээжүүдийн амьдралыг ерөөхийн тулд хэрхэн хамтран ажиллаж чадах вэ?
- Чуулган бага насны хүүхдүүдийн хэрэгцээг хангадаг үйлчлэлийг хэрхэн зохион байгуулж чадах вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Бидний гайхамшигтай Бүтээгч таныг бид мөргөн хүндэтгэж байна. Та биднийг эхийн хэвлийд бүтээж, амьдралын туршид маань халамжилдаг. Биднийг төрөхөөс ч өмнө бидний тухай бүх зүйлийг та мэддэг байсан.

Эмзэг бүлгийн хүмүүсийг, эхийнхээ хэвлийд байгаа хүүхдүүдийг хамгаалахын төлөө чадах бүхнээ хийхэд бидэнд туслаач.

Жирэмсэн эхчүүдэд үйлчилж буй хүмүүсийг ерөөгөөрэй. Бидэнд хүүхэдтэй болох, өсгөх эрхэм дээд эрх, хариуцлагыг итгэж даатгасан танд талархъя. Та бидний хүүхдүүдийг бүтээж хөгжүүлэхэд, бид тэднийг халамжилж, сургахдаа анхааралтай, хичээнгүй байхад туслаач.

Бид хүүхдүүдээ өсгөхдөө танд дуулгавартай байхыг хүсэж байна. Хүүхдүүдийнхээ өмнө таныг сайн төлөөлөхөд бидэнд туслаач. Хүүхдүүддээ таныг хайрлаж, танд дуулгавартай байхыг заахад бидэнд туслаач.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) 2 Тимот 1:3-5; 1 Коринт 4:17; Филиппой 2:19-23 эшлэлийг унш. Дараах асуултуудад хариулж нэг догол мөрөнд багтаан бичнэ үү:

- Энэ хэсэгт ямар хоёр эмэгтэйн талаар болон тэдний гэр бүл дэх үүргийн талаар юуг дурдсан бэ?
- Тэд Тимотод ямар нөлөө үзүүлсэн байж болох вэ?
- Тэдний үлгэр дуурайл эртний чуулганы амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?

(2) Энэ курсын үеэр цээжилсэн Библийн эшлэлээ дахин шалгана уу: Дэд хууль 6:4-9, Ром 6:11-14, Колоссай 3:5-7, мөн 5-р хичээлийн 4-р даалгавар дээр цээжлэхээр сонгосон эшлэлүүд. Та эдгээр эшлэлээс суралцах үед энэ нь хэрхэн нөлөөлж байна вэ?

(3) Дуулал 78:4-8 эшлэлийг цээжил. Дараагийн хичээлийн эхэнд тус эшлэлийг цээжээр уншиж эсвэл бичнэ үү.

(4) Гэр бүлийнхээ хүн тус бүрийн хувийн хэрэгцээний төлөө залбираарай. Өөрийнхөө төлөө мөн залбираарай.

12-р хичээл

Хүүхдийг зорилготойгоор хүмүүжүүлэх нь

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Бурханы эцэг эхчүүдэд өгсөн үүрэг хариуцлагыг тайлбарлах.
- (2) Бага насанд зан чанарын чухал хөгжил явагддагийг ойлгох.
- (3) Амьдралын есөн талбарт хүүхэд хөгжүүлэх зориудын төлөвлөгөөнд суралцах.
- (4) Хүүхдийн чөлөөт сонголт ба гадны нөлөөлөл хоорондын харилцааг тайлбарлах.
- (5) Хүүхдүүдийг итгэмжтэйгээр дагалдуулахад зориулах.

Жонатан Эдвардс - гэр бүлийн өвийг бүтээсэн эцэг

Жонатан Эдвардс нь 1700-аад оны үед амьдарч байсан нэр хүндтэй пастор, теологич хүн юм. Тэрээр эхнэр Сарагийнхаа хамтаар 11 хүүхдийг өсгөжээ. Сара бол гайхалтай эхнэр, ээж байсан бөгөөд хүүхдүүдийнхээ зан чанарыг төлөвшүүлэхэд асар их нөлөө үзүүлжээ. Жонатан гэр бүлдээ өөрийгөө зориулсан аав байв. Бидэнд хэлэхдээ: "Ноён Эдвардс гэртээ байхдаа орой бүр нэг цагийг гэр бүлтэйгээ ярилцаж, дараа нь хүүхэд бүрийг ерөөж залбирдаг байсан."³⁹

1800-аад оны сүүлээр амьдарч байсан сурган хүмүүжүүлэгч А. Е. Виншип Жонатан, Сара Эдвардс нарын өвийг судалж, Жонатаныг нас барснаас хойш 150 жилийн дараах тэдний үр удмаас ямар хүмүүс төрөн гарсныг танилцуулжээ. Тэрээр Эдвардсын өвд дараах хүмүүс байсныг олж тогтоосон:

- АНУ-ын дэд ерөнхийлөгч 1
- Хуулийн сургуулийн тэнхимийн эрхлэгч 1
- Анагаах ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч 1
- АНУ-ын сенатор 3
- Мужийн захирагчид 3
- Хотын дарга 3
- Коллежийн ерөнхийлөгч 13
- Шүүгч 30
- Эмч 60

³⁹ Энэ хэсгийн мэдээллийг дараах эх сурвалжаас эш татсан болно. Larry Ballard, "Multigenerational Legacies – the Story of Jonathan Edwards," YWAM Family Ministries, July 1, 2017. 2021 оны 1 сарын 11-нд дахин хандсан: <https://www.ywam-fmi.org/news/multigenerational-legacies-the-story-of-jonathan-edwards/>

- Профессор 65
- Цэргийн офицер 75
- Төрийн албан хаагчид 80
- Хуульч 100
- Пастор/Чуулганы удирдагч 100
- Дээд боловсрол эзэмшсэн 285

Ийм үр нөлөө бүхий өвийг хэрхэн бүтээх боломжтой вэ? Эдвардс 11 хүүхдийнхээ амьдралд ямар хөрөнгө оруулалт хийсэн учраас тэдний үр удам шударга, хариуцлагатай, нийгмийн зүтгэлтэн удирдагчид хэмээн алдаршсан бэ? Жонатан нь хүүхдүүдийнхээ даган дуурайх итгэмжит үлгэр дуурайл болсон бурханлаг, хичээнгүй эцэг байсан нь лавтай.

Библи бидэнд эцэг эхийн сонголт нь ирээдүйн үеийнхний Бурхантай харилцах харилцаанд нөлөөлдөг болохыг харуулдаг.

► Суралцагчид Дэд хууль 5:9-10 ба Дэд хууль 7:9 эшлэлийг бүлэгт уншина.

Эцэг эх нь ямар ч сонголт хийсэн бай, хүн бүр Эзэнд үйлчилж, өөрийн хүүхдүүдийнхээ хувьд бурханлаг эцэг эх байх боломжтой. Та болон таны үр удам Эзэнд үнэнчээр үйлчилж, Түүний ерөөл, нигүүлслийг хүлээн авч чадна. Та Бурханд итгэмжтэйгээр үйлчилж, хүүхдүүдээ ч Түүнийг танихад чиглүүлэх эцэг эх байхад бэлэн үү?

Хүүхдэд Бурханыг танилцуулах нь

Бурхан анх Иаковтай ярихдаа "Би орчлон ертөнцийн Бурхан" эсвэл "Би ертөнцийг бүтээсэн Бурхан" гэж хэлээгүй. Хэдийгээр эдгээр нь үнэн мэдэгдэл байсан ч, Тэрээр "Би бол ЭЗЭН, чиний эцэг Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан байна..." (Эхлэл 28:13) гэж хэлсэн юм. Иаков Бурханы талаар өмнө нь таньж мэдсэн мэдлэггүйгээр Түүнтэй харилцаагаа эхлүүлээгүй. Түүний аав, өвөө нь зааж сургаж байсан учраас Бурханы талаар мэдэх болсон.

Абрахам Бурханыг мөргөн хүндэтгэх уламжлалыг эхлүүлсэн. Хүмүүс өмнө нь Бурхантай хувьчлан уулзах харилцаагүй байсан ч, олон хүн Абрахамын улмаас Бурханд итгэсэн юм. Абрахамын зарц Елиезер залбирахдаа өөрийн эзэн Абрахамын Бурхан ЭЗЭНд хандан ярьжээ (Эхлэл 24:12).

Бурханыг хожим нь олон удаа "Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан" (жишээлбэл, Гэтлэл 3:15) хэмээн тодорхойлсон байдаг. Дараа үеийн төлөөлөл болох Иосеф нь Абрахам, Исаак, Иаков нарт өгөгдсөн Бурханы амлалтуудыг дурдсан байдаг (Эхлэл 50:24). Өмнөх үеийнхэнд нь өгсөн Бурханы амлалтын улмаас Иосеф гэр бүлээ Бурханд итгэмжит байна гэж хүсэн хүлээж байв.

► Бурхан өөрийгөө хэрхэн тодорхойлсон байдлаас хүмүүс Бурханыг хэрхэн таньж мэддэг талаар бид юу сурч болох вэ?

Хүмүүс ихэнхдээ Бурханы талаарх онол сургаалыг сонсоод Бурхантай харилцаатай болдоггүй. Харин ихэвчлэн хүмүүс Бурханыг Түүнтэй харилцаанд байгаа хүмүүсийн амьдралыг ажигласнаар сурч мэддэг. **Хамгийн агуу сүнслэг нөлөө нь Бурханд өөрсдийгөө зориулсан эцэг эхээс ирдэг.**

Энд анхаарал татахуйц маш чухал хувийн асуултууд байна: Таны хүүхэд таны амьдралыг ажигласнаар Бурханы тухай юу сурдаг вэ? Таны хүүхэд Бурхантай харилцаатай байгааг тань хараад Бурханд итгэмжит байхыг хүсдэг үү?

Эцэг эх байх үүрэг хариуцлага

Бурхан эцэг эхчүүдэд маш том хариуцлагыг даалгажээ. “Явах ёстой замаар нь хүүхдийг сурга өтөлсөн ч тэрээр тэр замыг орхихгүй” (Сургаалт үгс 22:6).

Эцэг эхчүүд хүүхдүүддээ Бурханыг дагах амьдралыг зориудаар зааж сургах ёстой. Эцэг эхчүүд хүүхдүүдээ удирдан чиглүүлэх, сургах хариуцлагаа ойлгох учиртай.

Хүүхдийг сургах хариуцлага нь нийгэм, сургууль, эсвэл чуулган биш, харин эхлээд эцэг эхчүүдэд хамаарна. Эцэг эх нь хүүхдээ чуулганд байгаа эсэхийг баталгаажуулах хэрэгтэй ч, чуулган таны өмнөөс хүүхдийг нь сургана гэж таамаглах ёсгүй.

► Нэг суралцагч Ефес 6:1-4 эшлэлийг бүлэгт уншина. Тэгвэл эцгүүд юу хийх ёстой вэ?

Хүүхдээ сургах нь зөвхөн ээжийн үүрэг хариуцлага биш. Эцэг нь гэр бүлийнхээ сүнслэг хамгаалалтын эцсийн хариуцлагыг хүлээнэ.

Эцэг эхчүүд хүүхдээ амьдралд бэлтгэх чухал хариуцлагатай. Амьдралд бэлтгэгдэх гэдэг нь мэргэжилд бэлтгэгдэх гэсэн үг биш. Энэ нь зөв амьдрах, Бурханы ерөөх амьдралаар амьдрахад бэлтгэгдэх гэсэн үг юм. Эцэг эхчүүд хүүхдээ нүглийг дагахыг зөвшөөрч болохгүй. Хожим нь тэд өөрчлөгдөнө гэж найдах хэрэггүй.

Библи биднийг дэлхий ертөнцийн буруу гүн ухаанд суралцахгүй байхыг анхааруулсан.

► Нэг суралцагч Колоссай 2:8 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэл биднийг буруу гүн ухаанд итгэж, буруу амьдралын хэв маягийг хүлээн авснаар дээрэмдүүлж болзошгүйг анхааруулдаг. Христийг дагахын оронд дэлхийн замыг дагахыг зааснаар дэлхий бидний хүүхдүүдийг хулгайлах боломжтой.

Хүүхдийн хүлээн авах бүх боловсрол нь христитгэлт багш, эцэг эхээс ирдэг бол хамгийн сайн юм. Христитгэлт сургуулиуд байхгүй газарт ч хүүхэд нь амьдралын зөв үзэл бодлыг сурч байгаа эсэхийг эцэг эхчүүд баталгаажуулах ёстой. Шашнаас гадуурх боловсролын тогтолцоо нь хүүхдэд бурхангүй үзэл, эволюц, хүн төвтэй үзэл онолыг заах боломжтой. Хүүхдүүд худал сургаалыг ялгах чадваргүй эмзэг байдаг (Ефес 4:14). Тиймээс эцэг эхчүүд хүүхдүүдээ хамгаалах ёстой. Пасторууд хүмүүсээ буруу гүн ухаанаас хамгаалахын тулд онол сургаалыг хэрхэн номлоход суралцах ёстой. Пасторууд, багш нар гэр бүлүүдэд хүүхдийнхээ амьдралыг үнэн дээр суурилж бэхжихэд нь туслах мэдээллээр хангах хэрэгтэй.

Бага насанд нь сургах

► Хэн нэгэн "Хүүхдүүд бол нойтон цемент" гэсэн нэртэй ном бичсэн байдаг. Энэ гарчиг юу гэсэн утгатай гэж та бодож байна?

Хүүхэд амьдралын тухай сурч, юу чухал болохыг бага наснаасаа шийддэг гэдгийг эцэг эх нь ойлгох ёстой. Хүүхдийн бага насанд зан чанар төлөвшдөг.

Ихэнх дагалдуулалт хүүхдийг насанд хүрэхээс өмнө явагддаг. Библийн ном зохиолуудын зорилго, зан чанарын зорилго, хувийн, нийгмийн, сүнслэг дадлууд зэрэг нь хүүхдийг нас биед хүрэхээс өмнө хөгжих ёстой байдаг.

Тэр ч байтугай хүүхэд 5 нас хүрэхээс өмнө хүмүүс бие биетэйгээ хэрхэн харилцах, ямар зан байдал нь хүссэн үр дүнд хүргэдэг тухай үндсийг сурсан байдаг. Тэрээр шударга байх, үгүй байх эсэх нь нэг бол шагнал, эс бөгөөс шийтгэл дагуулдаг гэдгийг мэддэг. Тэрээр хайрлагдсан эсэхээ мэддэг. Түүний мэдрэмж нь бусдад хамаатай гэдгийг тэр мэддэг. Тэрээр буруу зүйл хийхдээ уучлагдаж болох эсэхийг мэддэг. Тэрээр алдаа, нүглээ хүлээн зөвшөөрөх эсвэл нуухыг сурсан байдаг. Тэрээр эрх бүхий хүмүүс түүнийг халамжилж, амлалтаа биелүүлнэ гэдэгт итгэж болох үгүйг ч шийдэж чаддаг.

Хүүхэд эцэг эхийнхээ үг, үлгэр дуурайлаас сурдаг бөгөөд бүр эцэг эх нь тэдэнд заахыг хичээгээгүй байсан ч (Ефес 5:1) тийм байдаг. Насанд хүрэгчдийн үлгэр дуурайл нь хүүхдэд амьдралын тухай ойлголтыг өгдөг. Хүүхэд насанд хүрэгчдийн хувьд юу чухал болохыг харж юу чухал болохыг сурдаг. Хүүхэд бусадтай хэрхэн харилцах, нөхцөл байдалд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх, мөн үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлэхийг насанд хүрэгчдийг ажигласнаар сурдаг. Энэ боловсрол нь хүүхэд төрөх үеэс эхэлдэг.

Заримдаа эцэг эхчүүд хүүхдэд юу хийх ёстойг тайлбарлах үедээ л зааж байна гэж боддог. Гэсэн хэдий ч, хүүхдүүд ажиглаж байхдаа эцэг эхээсээ суралцаж байдаг.

Хүүхэд насанд хүрэгчдийг ажиглаж, стресст хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг сурдаг. Тэрээр танихгүй хүмүүст хэрхэн хандахыг сурдаг. Тэр нийгмийн өөр бүлэг давхаргын хүмүүст хэрхэн хандахыг сурдаг. Тэрбээр шүүмжлэлд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг сурдаг. Хүүхэд бусдын хэрэгцээнд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг сурдаг. Эцэг эхчүүд мэдэхгүй байсан ч тэдэнд үргэлж заасаар байдаг.

Хэрэв хүүхдийг байнга шүүмжилдэг бол, тэр алдаагаа нууж, шалтаг тоочиж, бусдыг буруутгаж сурдаг. Насанд хүрэхдээ тэрээр буруутгагч, хоёр нүүртэй, нууцлаг хүн болдог. Хэрэв гэр бүл нь байнга зөрчилддөг байсан бол тэрээр ичимхий нэг бол түрэмгий болдог. Хэрэв гэр бүлийнхэн нь түүнийг шоолдог байсан бол, тэрээр хүмүүстэй харилцахаас татгалзах эсвэл бусдыг дээрэлхэгч болдог. Хэрэв эцэг эх нь түүнийг үргэлж ичгүүрт оруулах юм бол, тэр гэм буруутайгаар амьдарч сурдаг бөгөөд Бурханаар хэзээ ч хүлээн зөвшөөрөгдөөгүй мэт мэдэрдэг. Хэрэв хүүхэд эцэг эхийнхээ шаардлагад нийцэх зан байдлын хэм хэмжээг хэзээ ч биелүүлж чадахгүй бол, эцэст нь тэднийг эсэргүүцэж, улмаар гэр бүлээ орлох өөр тэрслүү бүлэг, хүүхдүүдтэй нэгдэх ч боломжтой.

Хэрэв хүмүүс түүнд тэвчээртэй хандвал, тэр бусдад тэвчээртэй хандаж сурдаг. Хэрэв хүмүүс түүнийг зоригжуулбал, тэр улам итгэлтэйгээр хичээх болно. Хэрэв түүнийг магтвал, тэр үнэ цэнтэй болохоо мэдэрч, бусдад талархахыг хүсдэг. Хэрэв хүүхэд шударга байдлыг харвал, тэрээр шударга байхыг хүсдэг.

Хэрэв эцэг эх нь дүрмээ зөрчдөг хэрнээ хүүхдээсээ үүнийг дагахыг шаардвал хүүхэд нэг өдөр өөрөө дүрмээ зөрчих хэмжээний том хүн болно гэж боддог. Хэрэв эцэг эх нь бусдад эелдэг бус хандвал, хүүхэд нэг өдөр өөрөө ч бусдад эелдэг бус хандахаар хүчтэй болно гэж найддаг. Хэрэв эцэг эх нь хүүхдийн асуудал, хэрэгцээг чухал биш гэж боддог бол, хүүхэд нэг өдөр өөрийгөө халамжилж, бусдын хэрэгцээг үл тоомсорлодог насанд хүрэгч болно гэж боддог.

Бурханд захирагдах дуулгавартай байдлыг эцэг эхчүүд харуулах ёстой. Эцэг эх нь Бурханы Үгийг дагадаг гэдгийг таны хүүхэд мэдэх ёстой. Хэрэв эцэг эх нь өөрсдийн хүслээ Бурханы эрх мэдлээс илүү чухал гэж харуулбал, тэдний хүүхдүүд ижил аргаар амьдрахад бэлэн байх болно. Эцэг эх нь шийдвэр гаргахдаа юуг үндэслэж, яагаад ийм шийдвэр гаргаж байгаагаа хүүхдэдээ тайлбарлах хэрэгтэй юм. Энэ нь хүүхдэд шийдвэр гаргахыг заадаг.

Эцэг эх нь тэдэнтэй тоглох үед хүүхэд суралцаж байдаг. Тэд шударга байдал, бусдыг бодох, бусдад хариу үйлдэл үзүүлэхийг сурах ёстой. Тоглоом хүүхдийн ур чадварыг хөгжүүлдэг. Гэр бүлийн тоглоомын зорилго нь суралцах, хувийн хөгжил, гэр бүлийнхэнтэйгээ харилцах харилцаанаас авах таашаал байдаг. Гэр бүлийн тоглоомд өрсөлдөх нь сайн боловч, ялагч нь давуу байдлын мэдрэмжийг мэдрэхийн тулд бусдыг давамгайлах зорилготой байх ёсгүй. Тоглоомын үеэр бодолцож үзэх нэг асуулт нь "Хүн бүр энэ тоглоомыг сонирхож байна уу?" юм. Хэрэв зөвхөн ялагч нь тоглоомыг сонирхож байвал, зорилго нь буруу байна гэсэн үг. Хэрэв хүмүүс тоглоомын үеэр уурлаж, бухимдаж байвал, тоглоом нь зөв зорилгод үйлчилж чадахгүй байна.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ үйл ажиллагаанд цаг гаргаж, хүүхдийнхээ үнэ цэнийг харуулдаг. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сургуулийн ажил, төсөлд нь тусалж, тоглоом хийж эсвэл засварлаж, гэртээ хувийн орон зай бий болгож, түүний түүх, хошигнолыг сонсож, бухимдах үед нь тайвшруулах ёстой.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ сургуулийн багш нарыг мэддэг байх нь чухал. Хүүхдийнхээ сургуулийн нөхцөл байдлыг сонсохын тулд багш нартай хийх хуваарьт уулзалтуудад эцэг эх оролцох хэрэгтэй. Боломжтой бол эцэг эх хоёулаа байвал сайн. Хэрэв аав нь очихгүй бол, хүүхдийн хувьд бусад зүйлс аавд нь илүү чухал мэт санагддаг. Эцэг эхчүүд багш нараас үнэлгээ болон сургуульд болж буй зүйлсийн талаар асуудаг байх хэрэгтэй. Хэрэв эцэг эх нь сонирхож байгааг мэдэх юм бол багш нар хүүхдийн төлөө чадах бүхнээ хийж, хүүхдэд буруу хандахаас сэргийлэх магадлал өндөр байдаг.

Гэр бүлээрээ хамт амьдардаг хүмүүс бие биенээ маш сайн мэддэг. Тэд бие биенийхээ хэрэгцээ болон алдаанаас сурдаг. Тэд бие биенээ дэлхий дээрх хэнээс ч илүү хайрлаж, тэрхүү хайрыг харуулж чаддаг. Хэрэв тэд бие биенээ хайрлахгүй бол, бие биенээ өөр

хэнээс ч илүүгээр өвтгөх боломжтой. Зарим хүмүүс гэр бүлдээ үл таних хүмүүсээс ч илүү муугаар ханддаг. Христитгэлт гэр бүл нь тэвчээр, уучлал, халамж, эелдэг зан чанар илэрдэг газар байх учиртай.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Бага насны хүүхдэд өдөр бүр тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх цаг хэрэгтэй. Хүүхдэд амрах, төсөөлөн бодох, ном унших, ямар нэгэн зүйл хийх эсвэл бүтээж тоглох, байгаль дунд зугаатай байх цаг хэрэгтэй. Өдөр бүр хоол хүнсээ өөрсдөө бий болгох, эсвэл бусад ажлыг хамтдаа хийдэг орчинд хүүхдүүд гэр бүлийн ажилд оролцох нь сайн хэдий ч, эцэг эхчүүд бусад үнэт зүйлсийг ч санаж байх хэрэгтэй.

Урт удаан цагаар ажиллах нь хүүхдэд зөвхөн бие бялдрын хувьд хүндрэлтэй бус, харин хүүхдэд даалгасан ажил нь ихэвчлэн нэг хэвийн уйтгартай байдаг учраас хүндрэлтэй байдаг. Хүүхэд төсөөллөө ашиглах үйл ажиллагаанд цаг гаргахыг хүсдэг. Хэрэв тэр маш их ажиллах шаардлагатай, зөвхөн түүнд олдсон чөлөөт цаг нь идэж, унтахад зарцуулагдаад дахиад ажиллах болдог бол тун харамсалтай.

"Хүн залуу хүнийг энэрэх сэтгэлгүй болоход дэлхий дээрх түүний хэрэгцээ дуусгавар болдог."
- George MacDonald

Зарим гэр бүл эдийн засгийн хувьд бэрхшээлтэй тулгарч, хүүхдийнхээ ажил хөдөлмөрөөр орлого олох хэрэгтэй гэж үздэг. Гэсэн хэдий ч, хэрэв тэд хүүхдээ боловсролгүй орхих юм бол, гэр бүлийнх нь байдал хэзээ ч өөрчлөгдөхгүй байх боломжтой. Хэрэв хүүхэд сургуульд явахын оронд ажиллах юм бол, тэр бүх амьдралынхаа туршид бага цалингаар ажиллаж өнгөрөөх магадлалтай. Ихэнх карьер, бизнесийн боломжууд түүнд хүртээмжгүй байх болно.

Зарим хүмүүс өөрсдийн хүүхдэд боловсрол олгодог боловч ядуу гэр бүлийн хүүхдүүдийг (тэд боловсролгүй байгааг мэдсээр байсан ч) талбай дээр, эсвэл гэрийн ажилд, түүнчлэн гудамжинд худалдаа хийлгэхээр урт цагаар ажиллуулах зэргээр буруугаар ашиглахад бэлэн байдаг. Христитгэлт хүмүүс хамтдаа ажиллаж, орон нутгийнхаа гэр бүлүүдэд илүү сайн шийдлийг олоход нь туслах хэрэгтэй.

Хүүхэд амжилттай ахиц дэвшиж байгаага мэдэрх боломжтой тийм ажлыг хийх үедээ урамтай ажилладаг. Эцэг эх нь хүүхдээ урамшуулдаг бол тэд эцэг эхтэйгээ хамт ажиллахдаа баяртай байдаг. Хүүхэд нь юу хийж чадах талаарх хүлээлтэндээ эцэг эхчүүд бодитой хандаж, хүүхдээ үргэлжлүүлэн сурч, өсөн торниход нь сэдэлжүүлэхийн тулд эерэг байдлаар бүтээлч санал санаачлагыг гаргах хэрэгтэй юм.

Хүүхдийг өдөр бүр хариуцлагатай, найдвартай, нягт нямбай байхад зааж сургах нь тустай. Хүүхдийнхээ ажиллах үед нь илэрч буй зан чанаруудыг, тухайлбал санаачлага, хичээл зүтгэл, нямбай байдал, тууштай байдал зэргийг эцэг эхчүүд нь урамшуулан хэлдэг байх учиртай. Бурханы Үгэнд заасан ажлын зарчмуудыг хүүхэддээ заах ёстой.

Хүүхэд өөртөө зарцуулж болохуйц мөнгө олдог боломжтой байх нь сайн. Тэд өөрсдийн ажлын үнэ цэнийг сурч, мөнгөө хэрхэн сайн үр ашигтай ашиглахаа сурдаг. Мөнгө олохын тулд ажил хийдэг хүүхэд олсон бүх мөнгөө амтанд зарцуулах ёсгүй гэдгийг ойлгосон байх болов уу. Тийм хүүхэд өөртөө хадгалах ямар нэгэн зүйл худалдаж авахыг хүсдэг. Хүүхэд мөнгийг ашиглах талаар Бурханлаг ойлголттой байхад эцэг эхчүүд зааж сургах хэрэгтэй.

Хүүхэд, өсвөр насныхан чадвараа хөгжүүлэх олон төрлийн ажилтай танилцах нь тустай байдаг. Залуу хүн суралцахын тулд янз бүрийн ур чадвартай хүмүүстэй хамт ажиллах боломжтой байвал тун сайн.

► Танай нийгэмд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт ямар нөхцөл байдалтай байна вэ? Эцэг эхчүүд юу хийх ёстой вэ? Чуулган юу хийх ёстой вэ?

Хүүхдийг зорилготойгоор хөгжүүлэх нь

Эцэг эхчүүд хүүхдийнхээ зан чанарыг хөгжүүлэх үүрэгтэй. Нэгэн христитгэлт гэр бүл болох Мэтт, Мэри Фрийдман нар хүүхдэдээ хөгжүүлэхийг хүссэн зан чанаруудыг жагсаажээ. Жагсаалт гаргасныхаа дараа тэд үүнийг хянаж, хүүхдүүддээ эдгээр чанаруудыг хөгжүүлэхэд туслах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна. Энэ үйл явц мэдээж хурдан явагдахгүй. Эдгээр чанарууд гэнэт бий болохгүй. Эцэг эхчүүд хүүхдээ өсгөх он жилүүдийн туршид зорилготой, тууштай байх учиртай. Доорх жагсаалтад Фрийдман нарын нэрлэсэн зарим чанар багтсан байна.⁴⁰ Бусад чанаруудыг жагсаалтад нэмсэн болно.

Ангилал	18 нас хүрэхэд байх ёстой чанарууд
Сүнслэг байдал	<ul style="list-style-type: none"> • Бурханы дүр төрхийг тээсэн, мөнхийн үнэ цэнтэй гэдгээ мэдсэн • Аврагч хэрэгтэй нүгэлтэн гэдгээ мэдсэн • Христийг дагах шийдвэр гаргасан • Өдөр бүр Бурханд цаг гаргадаг • Сүнслэг бэлгүүдээ ашигладаг • Христийн үйлчлэлд бэлтгэгдсэн байх • Гэрлэх хүртлээ бэлгийн цэвэр ариун байдлаа хадгалсан
Библийн мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Христитгэлийн үндсэн онол сургаалуудыг ойлгосон • Бичвэрийн гол эшлэлүүдийг цээжилсэн (300 эшлэл) • Библийн түүхүүдийг мэддэг • Библийн номуудыг мэддэг

⁴⁰ Matt Friedeman, *Discipleship in the Home*, (Wilmore: Francis Asbury Society, 2010), 31-33.

	<ul style="list-style-type: none"> • 10 тушаал болон Уулан дээрх сургаалыг мэддэг • Библийг бүхэлд нь хамарсан нүгэл ба авралын талаарх сайнмэдээний сэдвүүдийг олж харсан
Библийн дагуух ертөнцийг үзэх үзэл	<ul style="list-style-type: none"> • Өөрийн итгэлийг хэрхэн хамгаалахыг мэддэг • Амьдралын том асуултуудад Библийн ойлголтоор хариулж чаддаг • Христитгэл нь дэлхийн бусад шашин, гаж урсгалуудаас өвөрмөц онцлогтой болохыг ойлгосон
Оюун ухаан (Боловсрол)	<ul style="list-style-type: none"> • Христитгэлт боловсролыг боломжоороо эзэмшсэн • Ном унших, подкаст эсвэл сургамжтай видео үзэх дадлыг өөртөө суулгасан. • Өөрийн билэг авьяас, дуудлагатай холбоотой коллеж эсвэл мэргэшүүлэх сургалтад хамрагдсан
Зан чанар	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө хянах чадварыг эзэмшсэн • Даруу байх—уучлалт гуйж чаддаг • Эрх мэдэлд хүндэтгэл үзүүлдэг • Эелдэг ярих • Цагийг ухаалаг ашиглаж сурсан (нийгмийн мэдээллийн хэрэгсэл, зугаа цэнгээн болон бусад зүйлсэд өөрийгөө сахилга баттай байлгадаг)
Мөнгө ба үйлчлэл	<ul style="list-style-type: none"> • Бурхан ядууст санаа тавьдаг гэдгийг ойлгосон • Өгөөмөр байдал болон ядууст үйлчлэх дадал • Аравны нэгийг өргөх болон хуримтлал үүсгэх дадал • Санхүүгийн төсвөө хэрхэн ашиглахад суралцсан
Харилцаа	<ul style="list-style-type: none"> • Ах дүүс, хамаатан саднаа хайрлаж, эв эетэй байдаг • Нийгмийн орчинд нийтлэг ёс зүйг харуулдаг • Үнэнч найз байхыг сурсан • Насанд хүрэгчидтэй хүндэтгэлтэй, итгэлтэйгээр ярьж чаддаг
Эрүүл мэнд	<ul style="list-style-type: none"> • Ариун цэврийг сахьдаг • Тогтмол дасгал хөдөлгөөн хийдэг • Хоол хүнс голдоггүй • Боломжтой бол эрүүл хоол хүнс сонгодог
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Бурханы өгсөн билэг авьяасуудыг хөгжүүлдэг • Тогтмол дасгал сургуулилалтаар ур чадвараа хөгжүүлдэг

Мэтт Фрийдман эхнэрийнхээ хамтаар эдгээр чанарыг жагсаагаад дараах байдлаар тайлбарлажээ.

Бид дээрх [чанаруудыг] нэг хуудсан дээр бичээд, хуудасны дундуур шугам татаж, "Одоо бид [хүүхдэдээ эдгээр чанаруудыг хөгжүүлэхэд өөрсдийн үүргээ гүйцэтгэхийн тулд] юу хийх ёстой вэ?" гэж асуусан. Хуудасны зүүн талд бид эцэг эхийнхээ үүрэг хариуцлагыг бичсэн.⁴¹

Хэрэв энэ нь их хариуцлага мэт санагдаж байвал, Бурхан бидэнд хүүхдүүдээ дагалдуулахад 16-18 жил өгсөн гэдгийг санаарай. Дараах зүйлс чухал юм:

1. Дагалдуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх.
2. Гэр бүлийнхээ заншил, хийх зүйлсийг тогтоох (өдөр тутмын хоол, цөөн минутын төлөвлөсөн сургалт, зааварчилгаа гэх мэт)
3. Дагалдуулалтыг өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болгож, заах, сургах олон боломжуудыг ашиглах.
4. Бурханы Үгээр амьдрахын тулд үргэлж залбирах.
5. Бүтэлгүйтэх үедээ ч хэзээ ч бууж өгөхгүй байх

► Дээрх хүснэгтээс хэд хэдэн зүйлийг сонгож, эцэг эхчүүд эдгээр зорилгуудад зориудаар хүрэхийн тулд юу хийж чадахыг тайлбарлана уу.

Хүний хүсэлтэй холбоотой хүчин зүйлс

► Заримдаа хүн "Миний туршлагауд намайг одоогийн хүн болгосон" гэж хэлдэг. Үүнтэй төстэй нэгэн мэдэгдэл бол "Хүн бол өөрийн орчны бүтээгдэхүүн" юм. Эдгээр мэдэгдлүүд үнэн үү?

Хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Хүмүүс бодит сонголт хийдэг бөгөөд инстинкт эсвэл орчноор хянагддаггүй. Библид бүхэлдээ Бурхан хүмүүсийг зөвийг хийхийг сонгож, хорон мууг эсэргүүцэхийг уриалдаг.⁴² Бурхан хүмүүсийг гаргасан шийдвэрийнх нь дагуу шүүдэг.

Бидний өссөн орчин ба туршлагауд бидэнд нөлөөлж болох ч, тэдгээр нь биднийг хянадаггүй. Учир нь бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүсийн хувьд бодит сонголтыг хийдэг. Энэ нь хүүхэд эцэстээ өссөн гэр орон, орчинтойгоо зөрчилдсөн сонголт хийж болно гэсэн үг юм. Нүгэлт амьдрал нь хэвийн зүйл байсан харь итгэл үнэмшилтэй гэр бүлээс гаралтай хүүхэд ч гэмшээд Бурханы төлөө амьдрах боломжтой. Христитгэлт гэр бүлээс гаралтай хүүхэд ч Бурханыг дагахгүй байх сонголтыг хийх боломжтой.

⁴¹ Matt Friedeman, *Discipleship in the Home*, 33.

⁴² Иошуа 24:14-15, Езекиел 33:10-11, Илчлэл 22:17

Хэдийгээр хүмүүс бодит сонголт хийдэг ч, тэдгээр нь бүрэн чөлөөтэй биш юм. Библи биднийг нүгэл үйлдэх хандлагатай мөн чанартай төрдөг гэж хэлдэг (Дуулал 51:5, Дуулал 58:3). Хүмүүс эрх мэдлийг эсэргүүцэх, өөрийн явах чиглэлийг сонгох, уруу таталтад бууж өгөх, бусдыг хуурах, хувиа хичээх төрөлх хандлагатай байдаг (Ефес 2:1-3). Хүүхдүүд аль аль талыг харьцуулж ялгагдаггүй бөгөөд ямар ч чиглэлд дагуулахад бэлэн байдаг. Хүүхдүүд хүссэн зүйлээ авахын тулд худал хэлж, дуулгаваргүй байх шаардлагатай байсан ч өөрсдийн хүслийг биелүүлэх арга замыг хурдан хайж олдог. Үүнээс гадна, Сатан тэднийг хуурч, уруу татахыг хичээдэг гэдгийг бид мэднэ (Ефес 2:2, Илчлэл 12:9).

Зөвхөн зааварчилгаа нь хүүхдэд зөвийг хийхэд хангалтгүй гэдгийг эцэг эх ойлгох ёстой. Сүнслэг тэмцэл тулаан гэж бий (Галат 5:17). Бурханы Сүнс хүүхдэд нь нөлөөлж, удирдан чиглүүлэхийн төлөө эцэг эхчүүд залбирах ёстой. Эцэг эхчүүд мэргэн ухаан, сайн сүнслэг үлгэр дуурайлтай байх хүчийг Бурханаас хайх учиртай. Эцэг эхчүүд хүүхэд нь бага насандаа гэмшиж, сүнсээр дахин төрөхийн төлөө хичээнгүйлэн залбирах ёстой.

Хэдийгээр хүүхэд итгэлд ирсэн ч, эцэг эх нь хүүхдээ төлөвшсөн христитгэлт хүн болсон гэж хүлээх ёсгүй. Түүний хандлага, мэдрэмж нь тогтвортой биш байж болно. Тэрээр заримдаа уруу таталтад бууж өгч болно. Хүүхэд зөвийг хийх хүсэлтэй байгаа л бол, эцэг эх нь түүнийг итгэгч хүн шиг амьдрахгүй байна гэж хэлж урмыг нь бүү мохоо. Үүний оронд эцэг эх нь хүүхдийнхээ сайн зан байдлыг магтаж, тэмцэлдэж байгаа талбартаа Бурханы тусламжийг асуун залбирахыг урамшуулах ёстой.

Хэдийгээр хүн бүр нүгэл үйлдэх хандлагатай төрдөг ч, хүн бүрд Бурхан хэрэгтэй. Ариун Сүнс хүн бүртэй ярилцаж, Бурхантай харилцах хүслийг өгдөг. Бид хүүхдэдээ Бурханы Үгийг заахад Бурхан тусалдаг гэдгийг мэддэг. Бурханы Сүнс хүүхдийн доторх өмгөөлөгч мэт, үнэнийг баталж, Бурхантай харилцах хүслийг өгдөг.

Бурханд зориулсан гэр бүлийн цаг

Гэр бүлүүд өдөр бүр хэдэн минут Библи унших, ярилцах, залбирах зорилгоор цаг гаргах хэрэгтэй. Эцэг эх хоёулаа байх хэрэгтэй бөгөөд гэрт байгаа бүх хүүхдүүдээ оролцуулах ёстой. Эцэг нь удирдах ёстой боловч гэр бүлийн гишүүдээс Библийн эшлэл уншиж, янз бүрийн аргаар оролцохыг хүсэх боломжтой.

Бурханд зориулсан энэхүү цаг нь үргэлж нэг ижил загвараар явагдах албагүй. Энэ цаг нь янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд үүнд Библийн түүх, христитгэлийн болон илгээлтийн түүх, асуулт хариултын хэлэлцүүлэг, онол сургаалын үнэнүүдийг заах цээжилсэн асуулт хариултыг ашиглах, христитгэлийн ном зохиол унших, дуу дуулах, Библи цээжлэх, жүжигчилсэн тоглолт, янз бүрийн аргаар залбирах зэрэг багтаж болно.

Бурханд зориулсан цагийн үйл ажиллагааны нэг жишээ нь: Библийн түүхийг сонгож, гэр бүлийн гишүүдээр жүжигчилсэн тоглолт хийлгэх.

Пасторууд чуулгандаа гэр бүлээрээ Бурханд зориулсан цаг гаргах талаар зааж сургах хэрэгтэй. Эцэг эхчүүдийн хувьд Бурхан тэдэнд хүүхдэдээ Бурханы Үгийг заах үүрэг хариуцлагыг өгсөн гэдгийг санах учиртай (Дэд хууль 6:5-7).

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Энэ хичээлээс таны хувьд шинэлэг санагдсан зарим ойлголтууд юу вэ? Та сурсан үнэнээ хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?
- ▶ Чуулган гэр бүлүүдийг бэхжүүлж, эцэг эхчүүдэд хүүхдээ өсгөхөд нь туслахын тулд юу хийж чадах вэ?
- ▶ Чуулганы хүмүүс хүүхдүүдээ дагалдуулах амаргүй талбарт хэрхэн хамтран ажиллаж чадах вэ?
- ▶ Гэр бүлдээ өдөр бүр дагаж мөрдөх ёстой зарим зүйлийн жишээ юу вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Гэр бүлийг бүтээж, хүмүүст эцэг эх байх агуу аз завшааныг олгосонд талархъя. Та биднийг хайрладаг шиг хүүхдүүдээ хайрлахад бидэнд туслаач.

Тэд таныг таньж, үйлчлэхийн тулд бүтээгдсэн гэдгийг үргэлж санахад бидэнд туслаач.

Хүүхдээ таныг дагахад сургаж, нөлөөлөхөд бидэнд хэрэгтэй хайр, тэвчээр, ойлголтыг өгөөч.

Манай чуулганы итгэгчид гэр бүл, залуучууд, хүүхдүүдийг итгэл, дуулгавартай байдалд хүчирхэгжүүлэхэд туслаач.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Дараах эшлэл тус бүрийг судлаарай. Эдгээр эшлэлийг ашиглан эцэг эхийн үүрэг хариуцлагын талаар Библи юу заадаг тухай гурван хуудас эргэцүүлэл бичнэ үү:

- Эхлэл 18:17-19
- Дэд хууль 6:4-9
- Дуулал 78:1-8
- Колоссай 3:21
- Ефес 6:4
- 1 Тимот 3:4-5, 12
- 2 Тимот 3:14-17
- Матай 18:5-6

(2) Та эцэг эх эсэхээс үл хамааран, энэ хичээл дээр хүснэгтээр өгөгдсөн хөгжүүлэх чанаруудаас тавыг сонгоно уу. Сонгосон таван чанарын зорилгод хүүхдүүдээ хүрэхэд нь туслах гурван практик аргыг бичээрэй.

(3) Хэрэв та эцэг эх бол Бурханд зориулах цагийг хүүхдүүдтэйгээ гаргах шийдвэр төлөвлөгөөгөө бичнэ үү. Өөрийн гаргасан шийдвэр төлөвлөгөөгөө хэн нэгэнд танилцуулж хариуцлагатай хандаарай.

13-р хичээл

Хүүхэд хүмүүжүүлэхэд тулгардаг асуудлууд

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Хүүхдийг Бурханы зарчмаар сахилгажуулж, засаж залруулах.
- (2) Хүүхдийг дагалдуулахын тулд гэр бүлийн таатай орчинг бүрдүүлэх.
- (3) Хүүхдийнхээ Бурханы өмнө хүлээх хариуцлагыг ойлгох.
- (4) Өдөр тутмын эцэг эхийн үүрэг ажилд зориулсан практик зүйлсэд бэлтгэгдсэн байх

Зорилготой ээж Сузанна Весли

Сузанна Весли 19 хүүхэд төрүүлсэн боловч тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан ес нь урт наслаагүй. Түүний өсгөсөн 10 хүүхдийн дунд Жон болон Чарльз Весли нар байв. Түүний хүү Жон насанд хүрснийхээ дараа ээжээсээ хүүхдүүдээ өсгөсөн арга барилаа бичиж өгөхийг хүссэн бөгөөд ээж нь энэ талаар захидалдаа дурдсан байдаг.⁴³

Хүүхдүүд ярьж чаддаг болмогцоо Эзэний заасан залбирлыг заалгаж, өглөө, орой бүр давтдаг байв. Хүүхдүүд өдөр бүр хамтдаа Библийн нэг бүлгийг уншдаг. Тухайн үед ихэнх эмэгтэйчүүд боловсрол багатай байсан ч Сузанна бүх хүүхдүүд уншиж сурах ёстой гэж шаарддаг байжээ. Тэрээр ажил хөдөлмөрт сурахаас илүүтэйгээр бичиг үсэгт тайлагдахыг чухалд тооцож байлаа.

Сузанна “Дураараа авирлах бол бүх нүгэл, зовлонгийн үндэс” гэж хэлсэн. Тэр хүүхдүүддээ өөрсдийн дур хүслийг хянаж, эрх мэдэлд захирагдахыг заасан. Хэдий төгс биш байсан ч гэсэн дуулгавартай байдлын үйлдэл бүрийг сайшааж урамшуулах ёстой гэж тэрээр хэлжээ. Алдааг тэвчиж болох ч, зориуд дуулгаваргүй байгаа тэрслэл бүрийг шийтгэх ёстой гэж тэр мөн хэлсэн.

Тэд гэр бүлээрээ үргэлж хамтдаа хооллодог байсан бөгөөд хүүхдүүд нь өгсөн хоолыг гомдоллохгүйгээр идэж сурсан.

Засах ба сахилгажуулах

Библи бидэнд "Саваагүй мунхаглал хүүхдийн зүрхэнд уяатай..." (Сургаалт үгс 22:15) гэж хэлдэг. Дууллыг бичсэн хүн хүүхдүүд төрөхөөсөө л худал ярьдаг гэж хэлсэн,

⁴³ Eliza Clark, *Susanna Wesley*, (London: W. H. Allen & Co, 1886), 30-36.
<https://archive.org/details/susannawesley00clariala/page/30/> вебсайтаас харах боломжтой.

"...Төрөлхөөсөө төөрөлдсөн тэд худал ярьдаг" (Дуулал 58:3). Энэ нь үнэн учраас эцэг эхчүүд хүүхдүүдээ засах үүрэгтэй.

3 настай хүүхдэд одоо нэг ширхэг зайрмаг идэх эсвэл нэг жилийн дараа зайрмагны үйлдвэртэй болох хоёр сонголтыг санал болгож байна гэж төсөөлөөд үз дээ. Эцэг эх нь хүүхдэд сонголтуудыг тайлбарласан ч гэсэн, ихэнх хүүхдүүд нэг ширхэг зайрмагийг тэр даруй идэхийг сонгох болно. Энэ жишээ нь *тайлбарлах* нь хүүхдийг засахад хангалтгүй болохыг харуулж байна.

Зөв, бурууг тайлбарлах нь хүүхдийг засахад хангалтгүй. Учир нь:

1. Хүүхэд төлөвшсөн сэтгэлгээг ойлгох чадваргүй (1 Коринт 13:11).
2. Хүүхэд үйлдлийнхээ бүрэн, урт хугацааны үр дагаврыг харж чадахгүй.
3. Хүүхэд өөрийн дур хүслийг ухаалгаар хянах хэмжээнд хангалттай төлөвшөөгүй.

Магадгүй хүүхдэд бие махбодын өвдөлт учруулах нь харгис мэт санагдаж болох ч, хайртай эцэг эх нь үүнээс ч илүү муу хохирлоос урьдчилан сэргийлэхийн тулд үүнийг хийдэг: "Хүүгээ саваанаасаа хэлтрүүлэгч нь түүнийг үзэн ядагч юм. Хүүгээ хичээнгүй сахилгажуулагч нь түүнийг хайрлагч юм" (Сургаалт үгс 13:24). Жишээлбэл, ил галын ойролцоо тоглож буй бяцхан хүүхэд аюулыг ойлгохгүй учраас түүнд унаж, их хохирол амсаж болно. Гэхдээ эх нь түүнийг галд хэт ойртлоо гэж алганы амт үзүүлэхэд бяцхан өвдөлт нь том өвдөлтөөс урьдчилан сэргийлдэг.

Зарим хүмүүс өөрсдийг нь хайрладаггүй хүмүүсээс бие махбодын хүчирхийлэл амссан байдаг. Тэдний амссан туршлага нь хүүхдийг бие махбодын хувьд шийтгэх тухай санааг үзэн ядахад хүргэдэг. Гэсэн хэдий ч, *зөвөөр* засаж залруулахыг үл тоомсорлодог эцэг эх хожим нь хүүхдэдээ ихээхэн асуудал үүсгэдэг.

► Суралцагчид Сургаалт үгс 19:18 ба Сургаалт үгс 29:17 эшлэлийг бүлэгт уншина.

Засаж залруулах нь хүүхэд эцэг эхээ эсэргүүцэж байгаага ойлгох хангалттай насанд хүрэх үед эхлэх ёстой. Бүр маш бага хүүхэд ч хамтран ажиллахаас татгалзаж байгаага мэддэг.

Ихэнх засах ажлыг хүүхэд бага, зөөлөн байх үед хийх хэрэгтэй (Сургаалт үгс 22:15). Шавар цаг хугацаа өнгөрөх тусам хатуурч, хүссэн хэлбэрт оруулахад улам хэцүү болдог шиг, хүүхдийн зан чанар ч цаг хугацаа өнгөрөх тусам төлөвшүүлэхэд улам хэцүү болдог. Хэрэв хүүхэд 10 наснаас хойш эцэг эхдээ дуулгаваргүй байх нь тогтмолжоод эхлэвэл эцэг эхийн засах залруулах ажил амжилт олоогүй гэсэн үг бөгөөд эцэстээ амжилттай байх магадлал маш бага болж байна. Бие махбодын хувьд засаж залруулах нь хүүхэд томрох тусам үр дүн багатай болдог. Эцэг эхчүүд хүүхэд нь том болох үед засаж залруулах нь илүү хялбар болно гэж бодох нь алдаа юм. Энэ нь илүү хэцүү болж, эцэстээ боломжгүй болдог.

Хүүхэд өсвөр насанд хүрэх үед түүнийг бага насных шиг нь бие махбодын хувьд засах боломжгүй болдог. Залуу эрэгтэй эсвэл эмэгтэйг хэдийгээр зан байдал нь төлөвшөөгүй

байсан ч хүндэтгэх хэрэгтэй юм. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хийдэг зугаатай зүйлс, утас үздэг цаг эсвэл нийгмийн үйл ажиллагааг нь хязгаарлах зэрэг бусад засах залруулах хэлбэрийг ашиглаж болно. Гэхдээ хайрлаж, санаа тавьдаг харилцаа хамгийн чухал байх болно. Эцэг эх нь залуу хүн бодит шийдвэр гаргаж байгааг ойлгох ёстой. Түүнчлэн хэдий эцэг эх нөлөөтэй ч гэсэн залуу хүнийг хувийн хүслээ илэрхийлэх, шийдвэрийнхээ үр дагаврыг амсахаас урьдчилан сэргийлж чадахгүй юм.

Зарим эцэг эхчүүд хүүхдэд бие махбодын шийтгэл өгөхдөө хэр зэрэг хатуу байх ёстойгоо мэддэггүй. Хэрэв хүүхэд засах залруулах ажлын дараа ч ууртай, дуулгаваргүй байдалтай байвал, шийтгэл нь хангалттай хатуу байгаагүй (энэ зарчим нь бие махбодын шийтгэлээр үр дүнтэй засагдах нас хэтэрсэн хүүхдийн хувьд хамаарахгүй) байх боломжтой. Засаж залруулах нь хүүхдийг дуулгаваргүй байдалдаа харамсаж, эрх мэдэлд захирагдахыг сонгох хэмжээнд хангалттай хатуу байх ёстой. Засаж залруулах нь гэмтэл учруулж болохгүй. Хэдхэн минутаас илүү хугацаанд үлдэх хөхрөлт эсвэл арьсан дээр үл мөр үүсгэх сахилгажуулалт нь хэт хатуудсан байх боломжтой.

Библид Бурхан өөрийн хүүхдүүдтэй хэрхэн харилцдаг болохыг тайлбарлахын тулд бие махбодын шийтгэлийн жишээг дүрсэлсэн байдаг.

► Суралцагчид Сургаалт үгс 3:11-12 ба Еврей 12:5-8 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэлд Бурхан өөрийн хүүхдүүдийг хайрладаг учраас сахилгажуулдаг гэдгийг хэлсэн. Үүнтэй адил, эцэг нь хүүгээ хайрладаг учраас сахилгажуулдаг. Зөв сахилгажуулалт нь хайрын тэмдэг юм. Сахилгажуулахгүй байгаа нь хайргүй байна гэсэн үг.

Бие махбодын сахилгажуулалт нь хүүхдэд өөрийгөө хянах чадварыг зааж сургадаг. Учир нь тэр буруу зүйл хийвэл шийтгүүлэхийг мэдэж, уруу таталтыг эсэргүүцэж сурдаг. Тэрээр буруу зүйл хийх уруу таталтыг эсэргүүцэх тусам, илүү хүчтэй зан чанарыг хөгжүүлдэг. Тэрбээр төлөвшсөн үедээ уруу таталтыг эсэргүүцэх болно. Учир нь тэр бие махбодын шийтгэлээс болж биш, харин үр дагаврыг нь ойлгосон учраас тэр юм. Гэсэн хэдий ч, хүүхдийг тогтмол засаж залруулаагүй тохиолдолд тухайн хүүхэд өөрт нь муу гэдгийг мэдэж байсан ч уруу таталтыг эсэргүүцэх чадваргүй сул дорой насанд хүрэгч болдог.

Хүүхэд нь зөвхөн чихэр идэхийг л хүсдэг учраас эцэг эх нь түүнийг зөвхөн чихрээр хооллодог гэж төсөөлөөд үз дээ. Тийм эцэг эх хүүхдээ аз жаргалгүй байлгахыг хүсэхгүй байгаа ч, хүүхдэдээ хор хохирол учруулж байгаа юм. Үүнтэй адил, хүүхдийнхээ зан авирт үргэлж буулт хийдэг эцэг эх нь түүний зан чанар, ирээдүйн нөхцөл байдалд хор хөнөөл учруулдаг. Тэр ч байтугай, эцэг эх нь хүүхдээ засахгүй бол түүнийг үзэн ядах болно гэж Библид хэлсэн (Сургаалт үгс 13:24).

Хил хязгааргүй гэрт амьдардаг хүүхэд жаргалтай байдаггүй. Хязгаарлалтууд аюулгүй байдлыг авчирдаг. Хэрэв хүүхэд маргаж, цухалдсанаар хүссэн зүйлээ авч болохыг сурвал, тэрээр үүнийг үргэлж хийдэг болно. Гэхдээ тэр жаргалтай байхгүй. Хүүхдүүд

аюулгүй, хязгаарлагдмал байдалтай байхдаа жаргалтай байдаг. Ямар нэг зүйлийг өөртөө байлгахын тулд тэмцэлдэж, хяналтыг эсэргүүцэх шаардлагагүй гэж мэдэрдэг. Сахилгажуулагдаагүй хүүхэд жаргалтай байх нь ховор юм.

Хүүхдийг насанд хүрэх үед нь дэлхий түүнд хүссэн бүхнийг нь өгөхгүй. Хэрэв тэрээр бүдүүлэг, хувиа хичээсэн, хариуцлагагүй байвал түүнийг хүндлэх, дэмжих хүн олдохгүй. Эцэг эх нь хүүхдээ амьдралд бэлтгэгдэх байдлаар өсгөх ёстой. Эцэг эхчүүд хүүхэд өсгөж байгаа бус, харин насанд хүрэгчдийг өсгөж байгаа гэдгээ санах ёстой.

Хүүхдээ засаж залруулах нь хүүхдийг итгэл даасан, хүндлэл хүлээсэн сайн зан чанартай хүн болгох зорилготой гэдгийг эцэг эхчүүд тайлбарлаж, харуулах учиртай.

► Суралцагчид Сургаалт үгс 22:15, Сургаалт үгс 23:13-14, ба Сургаалт үгс 29:15 эшлэлийг бүлэгт уншина.

Засаж залруулахын зорилго нь хүүхдийг хөгжүүлэх гэдгийг санаарай. Хүүхэд өөрийн хийсэн буруу зүйлээ ойлгож, аль хэдийн харамссан бол, бие махбодын сахилгажуулалт шаардлагагүй ч байж болно. Зорилго нь шударга байх биш, харин засаж залруулах юм. Тиймээс эцэг эхчүүд хүүхэд нь зохих шийтгэлээ авсан эсэхийг баталгаажуулах шаардлагагүй юм.

► Эцэг эхийн сахилгажуулалт нь хүмүүсийг өөрийн хүссэнээрээ байлгахын тулд дээрэлхэж, бие махбодын хохирол учруулна гэж заналхийлдэг хүний үйлдлээс юугаараа ялгаатай вэ?

Хүчирхийлэгч хүн өөрийн хүссэн зүйлээ авахын тулд бусад хүмүүст хор хохирол учруулахад бэлэн байдаг. Эцэг эх бол хүүхдээ хайрладаг. Бие махбодын сахилгажуулалт нь хүүхдийн сайн сайхны төлөө байдаг. Хайрладаг эцэг эх хүүхдэдээ хор хохирол учруулахыг хүсдэггүй. Хүн дээрэлхдэг эсвэл дарангуйлагч хүнээс хайрыг мэдэрч чадахгүй, харин хүүхэд сахилгажуулагдаж байхдаа ч өөрийг нь хайрлаж байгааг мэдэрч чаддаг. Хүүхэд эцэг эхийнхээ эрх мэдлээс болж амьдрал нь илүү дээр байгааг ухаардаг.

Зарим эцэг эхчүүд уур хилэн эсвэл харгис хэрцгий байдлаасаа болж хатуу, тогтмол биш шийтгэл оногдуулдаг. Тэд хүүхдэдээ бие махбодын болон сэтгэл санааны гэмтэл учруулдаг. Тийм хүмүүс хүүхдээ өөрсдийн стресс, амьдралын бухимдлаа тайлах арга болгон шийтгэдэг. Энэ нь үүнийг харж ажигласан хүмүүсийн хувьд чимээгүй өнгөрч, тэвчээртэй хандах ёсгүй ноцтой асуудал юм. Найз нөхөд, хөршүүд, хамаатан садан нь хүүхдийг хүчирхийлж буй хүнтэй нүүр тулах ёстой. Хүчирхийлэгч гэр бүлийн хань ижил нь хамаатан садан, найз нөхөд эсвэл пастораас тусламж хайх хэрэгтэй. Хүүхдийг хамгаалах нь чухал юм.

► Зарим эцэг эхчүүд хүүхдээ буруу зүйл хийхэд нь олон нийтийн өмнө ичгүүртэй байдалд оруулдаг. Энэ нь засаж залруулах сайн арга мөн үү?

► Нэг суралцагч Ефес 6:4 эшлэлийг бүлэгт уншина.

Хүүхэд эцэг эх нь түүнийг хайрладаг, мөн тэдний сахилгажуулалт нь түүний сайн сайхны төлөө гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй. Хүүхэд эцэг эхээрээ гутаан доромжлогдох үедээ хайрлагдсанаа мэдэрч чадахгүй. Харин тэр хорсож, эцэг эхийн эрх мэдэл нь түүнийг зугтаах шаардлагатай аймшигтай зүйл гэж мэдрүүлэх боломжтой. Эцэг эхчүүд хүүхдээ хувьчилсан байдлаар засаж, бусад хүмүүсийн дэргэд тэднийг ичээхээс зайлсхийх ёстой. Эцэг эхчүүд хүүхдэдээ зөөлөн, тэвчээртэйгээр зааж, засах ёстой.⁴⁴ Сургаалт үгс 16:21б эшлэлд "... Үг амтат бол ятгалга хүчтэй байна" гэж хэлсэн байдаг.

► Та гэрийнхээ амьтдад санаа тавь гэж хүүхдэдээ хэлсэн гэж төсөөлье. Орой нь таныг гэртээ ирэхэд амьтдыг хооллоогүй байж. Та өдөржин ажиллаад ядарсан ч, хүүхэд тань дуулгаваргүй байсан учраас амрахаасаа өмнө амьтдаа хооллох ёстой болов. Та уурлах ёстой юу? Эцэг эх нь хүүхдэдээ уурлах нь буруу юу?

Эцэг эхийн засах залруулга хүүхдэд ашиг тустай байх ёстой гэдгийг санах хэрэгтэй. Эцэг эх өөрсдийгөө үл хүндэтгэсэн мэт мэдэрсэн, эсвэл хүүхдийн дуулгаваргүй байдал нь түүнд таагүй байдал үүсгэсэн учраас уурласан бол, тэдний уур уцаар нь ямар ч сайн зүйлд хүргэхгүй (Иаков 1:20). Тэр нь хувиа хичээсэн уур уцаар юм.

Эцэг эхчүүд уураа ийнхүү зөвөөр илэрхийлж болно: "Хүү минь, чи миний хэлсэн шиг амьтдыг хооллосонгүй. Амьтад өлсгөлөн байсан, хэрэв би тэднийг хооллоогүй бол тэд бүтэн шөнөжин өлсгөлөн байх байлаа. Би өдөржин ажиллаад ядарсан ч тэднийг хооллох шаардлагатай болсон. Би чамайг хариуцлагаа үл тоомсорлож, бусдын хэрэгцээг анхаардаггүй хүн байгаасай гэж хүсэхгүй байгаа учраас уурлаж байна. Сургаалт үгс 12:10 эшлэлд 'Зөвт хүн малынхаа амийг ч хэрэгсэнэ буруу санаатан энэрэхдээ ч харгисална' гэж заасан байдаг."

Ребекка хүүхдүүддээ шинэ хивстэй өрөөнд хоол, унд авч орохгүй гэж хэлжээ. Маргааш нь хүүхдийн нэг нь тэр өрөөнд юм идэж байхыг хараад тэр түүнийг загнав. Дараа нь өөр нэг хүүхэд нь хивсэн дээр ундаа барьж явахыг хараад тэр мөн л загнажээ. Харин дараагийн хэдэн өдөр хүүхдүүд нь зарим үед ундаагаа бариад тэр өрөөнд орж ирдэг байсан ч Ребекка завгүй байснаасаа болоод тэднийг зассангүй. Тэгтэл нэг өдөр түүний хүү хивсэн дээр кока-кола асгачихав. Ребекка уурлаж, түүнийг алгадаж орхив.

► Ребеккагийн хүүхдүүдээ засаж залруулах арга барилд ямар алдаа байна вэ?

Ребеккагийн дүрэм нь хүүхдүүд хивстэй өрөөнд хоол, ундаа оруулахгүй байх ёстой байсан ч, энэ нь тохиолдох хүртэл хүүхдүүд нь тухайн дүрмийг зөрчихөд тэрээр хүлцэнгүй хандсан. Тэр дүрмийг зөрчсөн үйлдлийг бус аль хэдийн болоод өнгөрсөн хойно шийтгэжээ. Энэ нь хүүхдүүдэд муу үр дагаварт өртөхгүй хамгаалагдаж л байвал дүрмийг зөрчиж болно гэдгийг зааж байна. Энэ санаа нь бүх дүрмийг зөрчих үндэс болдог учраас муу зан чанарыг хөгжүүлдэг. Хүн хүссэн үр дүндээ хүрч, муу үр

⁴⁴ Хэдийгээр 2 Тимот 2:24-25 болон Галат 6:1 эшлэл нь чуулган дахь нүглийн асуудалд хандсан заавар боловч засаж залруулахдаа тэвчээртэй, эелдэг байх энэхүү зааварчилгаа нь гэр бүлийн хүрээнд хүүхэд хүмүүжүүлэхэд ч хамаатай юм.

дагавраас зайлсхийж чадна гэж боддог учраас дүрмийг зөрчдөг. Эцэг эхчүүд болоод өнгөрсөн зүйлийн төлөө хүүхдээ шийтгэхээс илүүтэйгээр дуулгаваргүй байдлыг нь засах ёстой юм.

Майкл хөвгүүддээ орой бүр унадаг дугуйгаа үргэлж байранд нь тавихыг хэлдэг байж. Долоо хоногийн турш Майклыг гэртээ ирэх болгонд унадаг дугуйнууд гадаа байсаар байлаа. Тэгтэл нэг өдөр ажил дээрээ Майкл нэг багажаа гэж, санамсаргүйгээр хуруугаа гэмтээн, гэртээ харих замд нь машиных нь дугуйн хий гарчихав. Тэгээд гэртээ иртэл унадаг дугуйнууд гадаа байсаар байсан тул тэр хөвгүүдээ шийтгэв.

► Майклын хөвгүүдээ засах арга барилд ямар алдаа байна вэ?

Олон эцэг эхчүүд сэтгэл санаа нь давгүй байхдаа дуулгаваргүй байдлыг тэвчиж өнгөрөөгөөд амьдралын нөхцөл байдлаас болж уурлах үедээ дуулгаваргүй байдлыг шийтгэдэг. Эцэг эхчүүд тогтмол засахгүй бол хүүхэд дуулгавартай байхад суралцдаггүй.

► Дараах зүйлсийг хараад, тус бүр яагаад чухал болохыг тайлбарлана уу. Хэрэв эцэг эх нь эдгээр зааврыг дагаж мөрдөхгүй бол юу болдог вэ?

- Шаардлага нь хүүхдийн чадвар, төлөвшилд тохирсон байх ёстой.
- Зөвхөн санаатайгаар дуулгаваргүй байгаа байдлыг шийтгэх (тохиолдлын зүйлсийг биш)
- Дүрэм, шаардлага нь тодорхой, ойлгомжтой байх ёстой.
- Хүүхдийг дуулгаваргүй байх үед нь эцэг эх нь түүнд юу хийх ёстой байсныг тайлбарлах ёстой.
- Өөрийнх нь хянаж чадахгүй зүйлийнх нь төлөө хүүхдийг хэзээ ч бүү шийтгэ.

Хүүхдүүдийн практик зөвлөмж, заавар

Олон жилийн өмнө Британийн сэтгэл судлаач, доктор Р.Ф. Херц нэгэн судалгааны төсөл хэрэгжүүлжээ. Тэрээр 24 орны 8-14 насны 100,000 хүүхдээс эцэг эхдээ зориулж биеэ авч явах талаарх дүрэм гаргахыг хүссэн байна. Энэ судалгаа нь Бурханы Үгийн эрх мэдлийг агуулаагүй хэдий ч, хүүхдүүдийн мэдэрдэг зарим хэрэгцээг харуулдаг. Хамгийн түгээмэл хариултуудын зарим нь энд байна:

- Хүүхдийнхээ дэргэд бүү хэрэлд.
- Хүүхдэдээ бүү худал хэл.
- Үргэлж хүүхдийнхээ асуултад хариулж байгаарай.
- Бүх хүүхдүүддээ ижилхэн хайр халамжаар хандаарай.
- Эцэг эх, хүүхдийн хооронд [нөхөрлөл] байх ёстой.

- Хүүхдийнхээ найзуудад зочлон ирсэн хүн шиг хандаарай.
- Хүүхдээ найзуудынх нь дэргэд бүү буруутгаж, шийтгээрэй.
- Хүүхдийнхээ сайн талуудад анхаарлаа хандуулж, алдаа дутагдлыг нь хэт онцлохгүй байх.
- Хайр халамж, сэтгэл санааныхаа байдалд тогтвортой байгаарай.

Нэг эцэг эх нөгөө эцэг эхийг хүүхдийнхээ дэргэд байнга шүүмжлэх үед хүүхэд нь ч бас тэрхүү үл хүндлэгдсэн эцэг эхтэй санал зөрөлдөж, алдааг нь олж харах ёстой гэж таамаглаж болох юм.⁴⁵ Эцэг эхчүүд өөрсдийн санал зөрөлдсөн асуудлаа хувьчилсан байдлаар ярилцаж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийг хичээх хэрэгтэй юм.

Эцэг эхчүүд хүүхдэдээ худал хэлэх ёсгүй (Колоссай 3:9). Ингэхдээ тэдний санааг зовоосон зүйлийг тайлахын тулд эсвэл тэдэнтэй хамтрахын тулд ямар нэг шалтгаан болгож ч бүү худал хэл. Эцэг эх нь өөрт нь худал хэлдгийг ойлгож мэдэхдээ хүүхэд аюулгүй байдлыг мэдрэхээ больдог. Зарим эцэг эхчүүд хүүхдээ айх үед нь тайвшруулж, чиглүүлж чаддаггүй, учир нь эцэг эхийнхээ хэлсэн үгэнд хүүхэд нь итгэдэггүй.

► Дээрх хэсэгт байгаа нэг зааврыг сонгож, хэрэв эцэг эх нь тэр зааврыг дагаж мөрдөхгүй бол үүсэх асуудлуудыг тайлбарлана уу.

Христитгэлт хүний гэр орон

► Гэрт тань танихгүй хүн ирвэл, танайхыг христитгэлт хүн амьдардаг гэр орон байна гэж харах болов уу? Тийм бол яагаад тэр вэ?

► Нэг суралцагч Дэд хууль 6:6-9 эшлэлийг бүлэгт уншина.

Израилчууд хүүхдүүдийнхээ зан чанарыг төлөвшүүлэх замаар ирээдүйгээ цогцлооход анхаарах ёстой байв. Тэд үүнийг хэрхэн хийх ёстой байсан бэ? Хүүхдүүдээ Библийн зарчмуудаар сургахад зориулсан хамгаалагдсан орчныг тэд бүрдүүлэх ёстой байж. Тэд Библийн эшлэлийг хаа сайгүй байрлуулж ("түүнийг гэрийнхээ хатавчин дээр ч, хаалган дээр ч бич") харуулах ёстой байлаа. Библийн эшлэлийг гэртээ бичээд зогсохгүй, хамгийн чухал нь гэрт байгаа бүх зүйл Библийн эшлэлтэй нийцэх ёстой байжээ.

Эдгээр гэр бүлүүд нь нэг ханан дээрээ Арван тушаалыг өлгөчихөөд нөгөө ханан дээрээ дэлхийн зугаа цэнгэлийг төлөөлөх нүгэлт хүний зургийг өлгөхгүй байх байсан. Энэ нь хүүхдийн үнэт зүйлсийн талаарх ойлголтод маш их төөрөгдөл үүсгэх байв.

Хүүхдүүд өдөр бүр харж, сонсдог зүйлээсээ ухамсаргүйгээр нөлөөлөгддөг. Хэрэв хүүхдийн гэрт үргэлж радио асаалттай байвал, тэд тухайн сонсдог хөгжмийнхөө зарим философийг өөртөө шингээдэг.

⁴⁵ Ефес 4:29-32, Ефес 5:33; 1 Петр 3:7-12 эдгээр эшлэлийн заавар, зарчмууд нь бүгд хэрэгжүүлэхэд тустай.

Эцэг эхчүүд хүүхдээ хорон муу философи, дэлхийн нөлөөнөөс бүрэн хамгаалах боломжгүй ч, христитгэлт эцэг эхчүүд хүүхдэдээ сонссон, харсан бүх зүйлээ Бурханы Үгийн үүднээс үнэлж дүгнэхийг заах ёстой. Есүс “тэднийг Та ертөнцөөс аваач гэж Би гуйхгүй, харин муу нэгнээс хамгаалахыг гуйж байна... Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг үнэн мөн” (Иохан 17:15, 17) хэмээн залбирчээ.

Хүүхдүүд эцэг эх нь хэнийг баатар мэт биширдгийг анзаардаг. Эцэг эх нь хэнийг хүндэлдгийг тэд мэддэг. Эцэг эхчүүд өөрсдөө дэлхийн болон ёс суртахуунгүй хүмүүсийг биширч байхдаа хүүхдэдээ Христийн үнэнийг заах нь зүйд нийцэхгүй. Үүнийг хийдэг эцэг эхчүүд өөрийн хүүхдэд Христийг дагадаг итгэмжит хүн байхаас илүүтэй амжилттай зугаацагч байвал илүү жаргалтай байх болно гэсэн утга санааг дамжуулдаг.

Зарим эцэг эхчүүд хүүхдэдээ тухайн зүйл яагаад буруу болохыг тайлбарлахдаа нүгэлт зүйлстэй харьцаж, тэдгээрийг мэдэж авах нь зүгээр хэвийн зүйл мэтээр боддог. Гэсэн хэдий ч, үүнийг бодож үзээрэй. Хэрэв та хүүхдэдээ зөв эрүүл хоол өгөхийг хичээдэг бол түүний өмнө чихэр, бялуу овоолж тавиад, идсэнийх нь дараа яагаад ногоо идэх хэрэгтэй талаар тайлбарлахгүй байсан. Амттаныг хараад идэхийг хүсдэг төрөлх дур хүсэл нь амин дэмийн талаарх бүх дэлгэрэнгүй мэдээллээс ч илүү хүчтэй байх болно.

Зарим эцэг эхчүүд хүүхэд нь юу үзэж байгаад огт санаа зовохгүйгээр телевизороо үргэлж асаалттай байлгадаг. Үр дүнг нь хянаж чадаж л байвал нүгэл бол зүгээр гэж заадаг нийгэмд бид амьдардгийг итгэгчид санах ёстой. Телевизийн нэвтрүүлгүүд нь нүгэлд амьдарч буй хүмүүсийг үр дагаваргүйгээр харуулдаг. Гэхдээ энэ нь бодит амьдралын үнэн зөв дүрслэл биш юм. Телевизор хүүхдийг эцэг эх нь түүнийг амьдралаас таашаал авах зүйлээс нь холдуулж байна гэж бодоход хүргэдэг бөгөөд улмаар тэр хүссэнээ хийх цагийг хүлээдэг.

Олон итгэгч хүмүүс итгэгч бус хамаатан садантайгаа хамт амьдардаг. Энэ тохиолдолд гэр орон нь буруу нөлөөнөөс хамгаалагдсан орчин байж чаддаггүй. Христитгэлт эцэг эх нь хайр, итгэмжит байдал, цэвэр ариун байдал, баяр хөөрийн талаарх үлгэр дуурайлыг харуулж, амьдралдаа зөв чиглэлийг сонгоход нь Ариун Сүнс хүүхдэд нь туслахын төлөө залбирах нь чухал юм.

Төгс бус гэр бүлүүд

Гэр бүлүүд төгс бус учраас харилцаанд ихэвчлэн өмнөх алдаа, шийдэгдээгүй зөрчилдөөний түүх байсаар байдаг.

Итгэгч эцэг эхчүүд ч төгс бус. Тэд дүрэм тогтоож, хэрэгжүүлэхдээ үргэлж тогтвортой байдаггүй. Тэд өсвөр насны хүүхдийнхээ нөхцөл байдлыг үргэлж ойлгодоггүй (шинэ үеийнхний хувьд бүх зүйл нь өөр байдаг). Тэд хүүхдийнхээ бодит асуудлуудад уужуу сэтгэлээр энэрч хандах нь бага байдаг. Тэд үргэлж хамгийн сайн хандлагатай байж чаддаггүй бөгөөд гомдоох үг хэлдэг.

Бурхан анхны хүмүүсийг бүтээж, гэр бүлийг загварчилсан. Тэр эрэгтэй хүнийг бүтээж, түүнд эхнэрийг өгсөн бөгөөд тэдэнд өсгөн хүмүүжүүлэх хүүхдүүдийг өгчээ. Бурхан бүх

зүйлийг мэднэ. Эцэг эхчүүд алдаа гаргахыг Тэр мэдэж байсан ч, эцэг эхийн үүргийг хэвээр үлдээсэн. Хүмүүст олон дутагдал байсан ч энэ нь хамгийн сайн арга гэдгийг тэр харж байсан. Энэ нь гэр бүл цааш урагшлахын тулд заавал арга зам байх ёстой гэсэн үг юм. Гэр бүлийн систем төгс бус байсан ч, энэ нь олон ашиг тусыг агуулдаг.

Бурхан эцэг эхийн үүргийг санаачилсан нь хүүхдийн хувьд чухал ач холбогдолтой. Энэ нь хүүхдүүд эцэг эхээ эсэргүүцэх үедээ Бурханы тогтоосон системийг үгүйсгэж байна гэсэн үг юм. Бурхан "Хүүхдүүд ээ... эцэг эхдээ дуулгавартай бай" (Ефес 6:1) гэж хэлсэн юм. Эцэг эхчүүд Бурханы өгсөн үүрэг хариуцлагаа үл тоомсорлох үедээ Бурханы төлөвлөгөөний эсрэг тэрсэлдэг. Бурханы төлөвлөгөөг үгүйсгэх нь Бурханы эсрэг тэрслэх явдал юм.

Хүүхэд хүмүүжүүлэхэд хүлээх хариуцлага

Эцэг эх байх энэхүү хариуцлага нь гурван хүрээг хамардаг. Хүүхдийн хүлээх хариуцлага. Эцэг эхийн хүлээх хариуцлага. Бурханы хүлээх хариуцлага. Бид эцэг эхийн хүлээх хариуцлагыг сүүлийн хоёр хичээлээр нарийвчлан үзсэн. Одоо бид хүүхдийн амьдралд болон хүүхдийн хүлээх хариуцлагад Бурханы оролцоо ямар байдгийг авч үзэх болно.

Хүүхдүүдийн амьдрал дахь Бурханы ажил

1. Бурхан хүүхдүүдийг Есүст итгэх итгэлээр дамжуулан өөртэй нь хувийн харилцаатай болохыг хүсдэг (Матай 18:1-6 ба Матай 19:13-15 эшлэлийг унш).
2. Бурхан хүүхдүүдийг өөртэй нь харилцаатай байхаар ойртуулахдаа итгэмжтэй ханддаг (Иохан 6:44 эшлэлийг унш).
3. Бурхан хүүхдүүдтэй өөрийн Үгээр дамжуулан ярьдаг (2 Тимот 3:14-15 эшлэлийг унш).

Хүүхдийн Бурхантай харилцах харилцаа

1. Хүүхдүүд нүглээ уучлуулж чадна (1 Иохан 2:12).
2. Хүүхдүүд Бурханыг таньж чадна (1 Иохан 2:13).
3. Хүүхдүүд Бурхантай харилцаагаа хөгжүүлж чадна (1 Самуел 2:26).
4. Хүүхдүүд Бурханыг мөргөн хүндэлж чадна (Матай 21:15-16).
5. Хүүхдүүд болон залуучуудыг Бурхан өөрийн зорилгын төлөө ашиглаж чадна (Иоел 2:28).

Библид Самуел, Нааманы эхнэрийн шивэгчин охин, Есүс цугласан олныг хооллохын тулд өдрийн хоолыг нь ашигласан хүү, Даниел, Иосеф, Давид, Мариа гэх мэт Бурханы зорилгыг биелүүлэхэд ашиглагдсан хүүхэд, залуучуудын олон жишээ бий.

Хүүхдийн хүлээх хариуцлага

Бурханы Үгийн дагуу хүүхдийн хүлээх хариуцлага нь эцэг эхдээ дуулгавартай байх явдал юм (Ефес 6:1-3). Хэрэв эцэг эх нь заримдаа буруу байвал яах вэ? Хүүхэд өөрийн

хариуцлагаа биелүүлэх ёстой бөгөөд энэ нь эцэг эхийн гүйцэтгэлээс хамаарах ёсгүй. Хүүхэд эцэг эхийнхээ зан байдлын төлөө хариуцлага хүлээхгүй. Хүүхэд дуулгавартай байх үүрэгтэй.

Хэрэв хүүхэд зөвхөн эцэг эхээ зөв гэж бодсон үедээ л дуулгавартай байхаар шийдэж чаддаг байсан бол, эцэг эх нь ямар ч эрх мэдэлгүй байх байсан. Энэ нь Бурханы хүссэн зүйл байж чадахгүй. Учир нь энэ нь эцэг эх байх талаарх бүх системийг сүйтгэх байсан.

Хүүхэд эцэг эх нь эрх мэдлээ хэрхэн ашиглах талаар хариуцлага хүлээхгүй. Түүний өөрийн хариуцлагын хүрээ нь дуулгавартай байх явдал юм. Хэрэв эцэг эх нь хүүхдэд буруу зүйл хийхийг, жишээлбэл, хөргөгчнөөс пиво авчир гэж хэлвэл яах вэ? Хүүхэд эцэг эхийн зөв эсвэл буруу эсэхийг шийдэх хариуцлага хүлээхгүй. Тэрээр өөрийн үзэл бодлоо хүндэтгэлтэйгээр илэрхийлж болно, гэхдээ тэр дуулгавартай байх ёстой.⁴⁶

Хүүхдүүд эцэг эхтэйгээ асуудалтай байгаа нь ихэвчлэн эцэг эхийн тэдэнд тушаасан зүйл Христийн зарчмуудтай нийцэж байгаа эсэхэд эргэлзэж байгаагаас биш юм. Тэрслүү хүүхэд ихэвчлэн өдөр тутмын асуудлууд болох өрөөгөө цэвэрлэх, гэрийн ажил хийх, тодорхой цагт гэртээ байх, зугаацах зүйлсийг нь хязгаарлах зэрэгт эцэг эхээ эсэргүүцдэг.

Тэрслүү хүүхэд эцэг эхийнхээ тушаасан зүйл буруу байх үед өөрийн шийдэх эрхээ шаардаж, эцэг эхийнхээ эрх мэдлийн талаарх үзэл баримтлалыг эсэргүүцдэг. Түүний эсэргүүцэл нь тусгаар тогтнох, өөрөө бүгдийг мэдэх, бие даан шийдвэр гаргах үндсэн хүслээс үүдэлтэй байдаг. Хүн хэдэн насандаа үүнийг олж авдаг вэ? Хэзээ ч үгүй.

Ийм бие даасан байдлын үзэл баримтлал бол хуурмаг зүйл юм. Бусад хүмүүсийг харгалзан үзэхээс үүдэлтэй хариуцлагууд танд үргэлж байх болно. Ээж тань дэргэд нь байж хэлэхгүй байсан ч танд хийх ёстой гэдгийг мэддэг ажлууд үргэлж байсаар байх болно. Бусдын өмнө ямар ч үүрэг хүлээхгүйгээр амьдрах гэж оролддог хүн өвдөлт, сүйрлийн зам мөрийг үлдээх бөгөөд түүнд итгэдэг, түүнээс хамаарал бүхий хүмүүсийг зовоодог.

Заримдаа хүүхэд эцэг эхийнхээ санаа зовнилд гомдож, эцэг эх нь түүнд илүү итгэх ёстой байсан гэж мэдэрдэг. Хэрэв хүүхэд эцэг эхийнхээ санаа зовнилыг ойлгож, хүндлэхийг хичээвэл, эцэг эх нь түүнд илүү итгэж, хязгаарласан зүйлс дээрээ тохиролцоход бэлэн байх боломжтой. Хүүхэд эцэг эхийнхээ санаа зовнилыг үгүйсгэх үед, эцэг эх нь түүнийг илүү их хязгаарлах хэрэгтэй гэж мэдэрдэг.

Алдаагаа хүлээн зөвшөөрөх нь

Олон хүн харилцаандаа алдаагаа хүлээн зөвшөөрөхөөс айдаг. Учир нь энэ нь ирээдүйн зөрчилдөөнд тэднийг сулруулна гэж айдагтай холбоотой байдаг. Бодит байдал дээр

⁴⁶ Хэрэв хүүхэд эцэг эх эсвэл хэн нэгний бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол хүүхдийг хамгаалахын тулд хэн нэгэн хөндлөнгөөс оролцох ёстой. Хүүхэд ихэвчлэн ийм нөхцөлд хэрхэн тусламж хайхаа мэддэггүй.

үнэнч, зөвийг хийхэд бэлэн байх нь хамгийн хүчтэй байр суурь юм. Энэ байр сууринд байх, мөн үүндээ үлдэх цорын ганц арга бол өөрийн хийсэн буруу зүйлээ хүлээн зөвшөөрч, зөвийг хийж эхлэх, мөн алдаа гаргасан үедээ засахад бэлэн байх явдал юм.

Заримдаа эрх мэдэлтэй хүн өөрийн дор байгаа хүмүүсээсээ алдаагаа хүлээн зөвшөөрөхийг хүсдэг боловч өөрийн алдаагаа хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Учир нь энэ нь түүний эрх мэдлийг бууруулна гэж тэр боддог. Энэ нь буруу юм. Хэрэв эрх мэдэлтэй хүн алдаагаа хүлээн зөвшөөрч чадахгүй бол, түүний дор байгаа хүмүүс түүнд итгэхээ больдог. Энэ зарчим нь эцэг эхийн эрх мэдлийг оролцуулаад бүх эрх мэдлийн байр сууринд хамаардаг.

Эцэг эхчүүд ээ, хэрэв та хүүхэдтэйгээ зөрчилдсөн бол, та магадгүй зарим алдааг гаргасан байж болох бөгөөд үүнийгээ хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Хүүхэд таны алдаагаар өөрийн буруу үйлдлээ зөвтгөж байж ч болох юм. Өөрийн хатуу үг, яаруу хариу үйлдэл, нөхцөл байдлыг ойлгож чадаагүйдээ уучлалт гуйгаарай. Та үүнийг хийхгүй бол зөрчилдөөнийг дуусгах тал дээр ахиц гарахгүй байж магадгүй. Учир нь "... Бурхан бардмыг эсэргүүцэж дарууд нигүүлсэл өгдөг" (Иаков 4:6).

Та эцэг эх ч бай, хүүхэд ч бай, өөрийн буруугаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэмшил, уучлалт гуйх, Бурханы өгсөн эрх мэдэлд тууштай захирагдах байдлаар ихэвчлэн бусдаас илүү их дэмжлэг хамтын ажиллагааг олж авч болох ч энэ нь та үүнийг хийх шалтгаан биш юм. Та үүнийг Бурханыг баярлуулахын тулд хийх ёстой.

Та өөрийн хийсэн буруу зүйлээ хүлээн зөвшөөрөхдөө нөгөө хүнийг ч бас өөрийнхөө хийсэн буруу зүйлдээ буруутай гэж нотлох хэрэггүй юм. Бусдын алдааг өөрийн буруу үйлдлийг зөвтгөх шалтгаан болгон бүү ашигла.

Харилцаа шууд сайжирч болох ч, цаг хугацаа шаардагдаж ч болно. Заримдаа хүмүүс өөрчлөгдөхөөсөө өмнө өөрчлөлт бодитой гэдгийг харах хэрэгтэй байдаг. Гэхдээ таны зөвийг үйлдэх шалтгаан нь өөр хэн нэгнийг өөрчлөх биш юм. Та Бурханы хүссэн зүйлийг хийх ёстой. Магадгүй нөгөө хүн өөрчлөгдөхгүй байж болох ч, та цэвэр мөс чанартай, Бурханаар ерөөгдсөн байх болно. Учир нь та өөрийн хариуцлагаа биелүүлж байна. Бурхан өөрийн хариуцлагыг биелүүлнэ гэдэгт ч итгээрэй.

Амьдралынхаа бүх талбарыг Бурханы эрх мэдэлд захируулахын ач холбогдол

Зивиа хэмээх жижиг арлын улсыг төсөөлөөд үз дээ. Грекиа хэмээх ойролцоох арлын улс Зивиаг эзлэн авахыг хүссэн гэж бодъё. Грекиагийн захирагч Зивиагийн засгийн газарт хэрэв танайх арлынхаа дунд хэсэгт ердөө 0.4 км газрыг Грекиад өгөх юм бол хоёр улс энх тайван харилцаатай байж болно гэж амлав. Энэ нь энх тайван байдлын төлөөх сайн шийдэл байх болов уу? Хэрэв Зивиа дайсандаа нутаг дэвсгэрийнхээ дунд хэсэгт газар өгөх юм бол дайсан нь тухайн хэсгээс бусад хэсгийг эзлэхээр тархаж болно.

Та өөрийн амьдралыг янз бүрийн бүс нутагтай улс орон гэж төсөөлөөд үз дээ. Нэг бүс нутаг нь ажил эрхлэлт эсвэл сургууль байж болно. Өөр нэг бүс нутаг нь таны зугаацдаг

зүйлс байх боломжтой. Өөр нэг бүс нь гэр бүлийнхэнтэйгээ харилцах харилцаа гэх мэт. Өөр олон бүс нутаг байх боломжтой.

Амьдралын тань бүх бүс нутаг, улс орон тань бүхэлдээ Бурханы эрх мэдэлд байх ёстой. Хэрэв нэг бүс нутаг болох гэр бүлийнхэнтэйгээ харилцах харилцаа тань Бурханы эрх мэдэлд байхгүй бол юу болох вэ? Та Сатаныг тэр бүс нутагт орохыг зөвшөөрсөн гэсэн үг юм. Тэрхүү бүс нутгаас Сатан таны амьдралын бусад бүс нутгийг эзэлж эхлэх болно. Үүнтэй адил, хэрэв хүн зугаацдаг зүйлсээ бузар байлгавал түүний амьдралын бусад бүс нутаг Сатанд эзлэгдэх болно. Итгэгч хүн амьдралынхаа бүх бүс нутгийг Бурханы эрх мэдэлд авчрах ёстой.

Эцэг эхчүүдэд зориулсан зарим зөвлөмж

► Суралцагчид Ефес 6:4, Колоссай 3:21, 1 Коринт 13:11, ба Колоссай 3:8 эшлэлийг бүлэгт уншина.

Хэрэв таны хүүхэд сэтгэл хөдлөл ихтэй, уур эсвэл бухимдлаа илэрхийлж байвал, та түүнийг ойлгохгүй байна гэж тэр боддог. Тэрээр таныг сонсож, ойлгохыг хичээж хангалттай санаа тавихгүй байна гэж боддог байх магадлалтай.

Та сонсож, ойлгохыг хичээгээрэй. Хэрэв та түүний асуудлуудыг үргэлж өчүүхэн эсвэл утгагүй гэж үл тоомсорлодог бол түүнд тулгарч буй зүйлийг та үнэхээр ойлгохгүй байна. Хэрэв энэ нь түүнд том асуудал мэт санагдаж байгаа бол энэ нь түүний итгэл, зан чанарт нөлөөлөх болно. Тэр яагаад ийм хүчтэй хариу үйлдэл үзүүлж байгааг та ойлгохгүй байвал энэ нөхцөл байдал ямар ээдрээтэй том болсныг та ойлгохгүй байна гэсэн үг.

Хүүхдийнхээ асуудалд хэзээ ч бүү бууж өг. Түүнчлэн бууж өгсөн мэт сонсогдох зүйлийг ч та бүү хэл.

Таны бүх хүүхдүүд адилхан гэж битгий бодоорой.

► Нэг суралцагч Ефес 4:30-32 эшлэлийг бүлэгт уншина.

Асуудал гарч ирэх үед бүтэлгүйтлийн түүхээ бүү сөх. Хүүхэд өөрийн өнгөрсөн дэх бүтэлгүйтлээ одоогийн нөхцөл байдалд хамааралгүй гэж бодохыг хүсдэг. Тэрээр одоо өөр болсон, мөн та түүнд өнгөрсөн алдааг нь сануулах нь шударга бус гэж бодох болно. Гэсэн хэдий ч, тэр тантай тийм эелдэг байна гэж битгий хүлээгээрэй.

Хэлэлцүүлгийн асуултууд

► Энэ хичээлээс танд шинэлэг санагдсан зарим ойлголтууд юу байв? Та өөрийн хийдэг зүйлсдээ юуг өөрчлөхөөр төлөвлөж байгаагаа хуваалцаж болох уу?

► Танай чуулганы гэр бүлүүд гэртээ сайжруулах зүйлс болон чуулганыхаа хүүхдүүдэд туслахын тулд цаашид хэрхэн хамтран ажиллах талаар ярилцана уу.

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Бид гэр орноо хайр, аюулгүй байдал, ерөөлийн газар байгаасай гэж хүсэж байна. Тэнд хийх бүх зүйлдээ цэвэр ариун, хайраар хандахад бидэнд туслаач.

Биднийг Христийн сургаал, зан байдал дотор тогтвортой байхад туслаач. Хүүхдүүдэд маань таныг дагах хүслийг өгөөч.

Бидний хүүхэд бүрд итгэмжит ханддагт баярлалаа. Таны Сүнс тэдний сэтгэл зүрхэнд ажиллаж байгааг бид мэднэ.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Гэр бүлд зориулсан Библийн долоон чиглэлийг жагсаана уу. Дараа нь бодит амьдралын нөхцөл байдалд тохирсон тодорхой хэрэгжүүлэх зүйлсийг бич. Хэрэгжүүлэлт бүрийг тайлбарлаж нэг догол мөрөнд багтаан бичнэ үү (нийт долоон догол мөр).

(2) Доорх сэдвүүдээс нэгийг сонго. Сургаалт үгс номыг нээж, тухайн сэдвийг хөндсөн Сургаалт үгсийн эшлэлийн жагсаалтыг гаргана уу. Сургаалт үгс энэ сэдвийн талаар юу хэлсэн талаар хоёр догол мөрөнд нэгтгэн дүгнээрэй. Дараа нь эцэг эхчүүд хүүхэд эсвэл өсвөр насныханд эдгээр зарчмыг хэрхэн зааж болох талаар гурван догол мөрөнд бичнэ үү. Сэдвүүд:

- Үнэнийг хэлэх
- Санхүү
- Мэргэн ухаан болон мөнгөний үнэ цэнийн ялгаа
- Итгэл хүлээсэн байдал
- Бэлгийн цэвэр ариун байдал
- Даруу байдал
- Засаж залруулах болон зааврыг хүлээн авах
- Хичээл зүтгэлтэй байх/санаачлагатай байх
- Таашаалын талаар Бурхан юу хэлдэг вэ?
- Үг яриа
- Бусадтай харилцах харилцаа
- Өгөөмөр байдал

14-р хичээл

Өсвөр насны хүүхдийг хүмүүжүүлэх нь

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Өсвөр насны хүүхдийн хувьд Бурханы нэн тэргүүнд тавьдаг зүйлсийг ойлгох.
- (2) Өсвөр насны хүүхдийг нас биед хүрэхэд нь бэлтгэх, тэдэнд нөлөөлж, сургах хариуцлагыг хүлээх.
- (3) Өсвөр насны хүүхэдтэй эрүүл, үр бүтээлтэй харилцааг хөгжүүлэхэд сэдэлжүүлэх.
- (4) Өсвөр насны үед тулгардаг асуудлуудыг Библийн зарчмын дагуу даван туулахад сургагдах.

Гэр бүлийнхээ сургагч Марта

Марта орой бүр хоёр хүүхэдтэйгээ залбирч, Библи уншихад цаг гаргадаг байв. Тэрээр Библийн хэдэн эшлэлийг уншиж, эшлэл бүрийн төгсгөлд амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилцдаг байжээ. Тэднийг өсвөр насанд хүрэхэд Марта Библийн хэсгүүдийг уншиж, тайлбарлах ээлжийг хүүхдүүддээ шилжүүлжээ. Тэд ээжийнхээ үлгэр дуурайлаас сурсан учраас Библийг сайн тайлбарлаж чаддаг байв. Тэд ээжээсээ сурсан амьдралын зарчмуудаа өөрсдийн үгээр илэрхийлж чаддаг болжээ.

Өсвөр насны үе

Хүүхэд наснаас насанд хүрэх хоорондын үеийг нэрлэдэг бөгөөд энэ үеийг нийгэм болгон янз бүрээр нэрлэх нь бий. Энэ нь залуу хүн бэлгийн харилцаа гэх мэт насанд хүрэгчдийн зүйлсийг сонирхож эхлэх хэдий ч насанд хүрэгчдийн адил хариуцлага хүлээх хэмжээнд хараахан хүрээгүй үе юм. Зарим улс оронд хүн 18 насандаа хууль ёсоор насанд хүрэгч болдог. Эдгээр улс оронд 18-аас доош насны хүн эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр гэрлэх, цэргийн алба хаах эсвэл хууль ёсны гэрээ хэлцэл хийх боломжгүй байдаг.

Өсвөр үеийн насны хязгаар нь газар орон бүрд харилцан адилгүй байдаг. Зарим нийгэмд тухайн хүн насанд хүрэгчдийн хийдэг ажлыг хийж сурсан л бол 18 нас хүрээгүй байсан ч насанд хүрэгч адил амьдрахад бэлэн байж болох юм. Бусад нийгэмд хүн 18 нас хүрсэн ч үүнээс хойш хэдэн жилийн турш эцэг эхээсээ хамааралтай хэвээр байж, боловсролоо үргэлжлүүлэн эзэмшдэг ч байх боломжтой.

► Танай нийгэмд хүүхэд наснаас насанд хүрэгчдийн хоорондох үе шатанд байгаа залуучуудыг тодорхойлохдоо ямар нэр томъёо ашигладаг вэ?

► Насанд хүрэгч гэж хэн бэ?

Насанд хүрэгчдийн талаарх нэг тодорхойлолт нь хүн болон амьтан дээр хоёуланд нь хэрэглэдэг `бие махбодын хувьд төлөвшсөн бүтээл (амьтан)' гэсэн нэр томъёо юм. Гэсэн хэдий ч, хүний насанд хүрэх нь бие махбодын төлөвлөөс илүү гүнзгий утга агуулгатай. Залуу хүн насанд хүрэгчтэй адил хэмжээ, тэнхээ чадалтай байж болох ч, насанд хүрэгчийн хариуцлагыг хүлээхэд бэлэн биш байж болно.

► Бие махбодын төлөвлөөс гадна насанд хүрэгчийг ямар шинж чанар тодорхойлж болох вэ?

Ерөнхийдөө насанд хүрэгч гэдэг нь өөрийгөө удирдан чиглүүлж, шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай хүн юм. Энэ тодорхойлолт нь яг оновчтой байж чадахгүй, учир нь хувийн хариуцлагын түвшин маш их ялгаатай байдаг. Бүрэн тусгаарлагдаагүй л бол хүн бүр бусад хүмүүсээр нөлөөлөгдөж байдаг бөгөөд насанд хүрэгчид ч гэсэн шийдвэр бүрийг бүрэн эрх чөлөөтэйгөөр гаргадаггүй. Гэсэн хэдий ч, насанд хүрэх нь ерөнхийдөө өөрийн шийдвэр гаргалт, хариуцлага хүлээх чадвараар тодорхойлогддог. Өсвөр насны үеийн төгсгөлд хүн өөрөө шийдвэр гаргахад бэлэн байх ёстой. Эцэг эхийн зорилго бол өсвөр насны хүүхдийг тэр хариуцлагад бэлтгэх явдал юм.

Есүсийн сургаалт зүйрлэлд амьд байсан эцгээсээ өв хөрөнгөө нэхсэн хүүгийн түүхийг өгүүлдэг (Лук 15:11-32). Хүү мөнгөө аваад бүгдийг үрж орхисон. Энэ бол өсвөр насны үеийг дуусгаад насанд хүрсэн боловч, ухаалаг шийдвэр гаргахад бэлэн биш байсан хүний жишээ юм. Насанд хүрсэн хүнд байх эрх чөлөө, хариуцлагыг хүлээн авахаасаа өмнө сайн хөгжүүлээгүйн улмаас буруу шийдвэр гаргаж, хохирол амсаж буй олон залуус байдаг.

Хүний хөгжлийн чухал үе болох өсвөр насанд зориулагдсан олон мэргэн ухааныг Бурханы Үг агуулдаг.

Бие махбодын болон оюун санааны хөгжил

► Нэг суралцагч Лук 2:40, 52 эшлэлийг бүлэгт уншина.

Есүс өсвөр насандаа, бие махбодын болон оюун санааны хувьд өссөн. Эдгээр хоёр эшлэлийн хооронд Есүс багш нартай ярилцахаар Сүмд зочилсон тухай өгүүлдэг. Тэр зөвхөн бие махбодын хувьд өсөөд зогсохгүй, илүү биеэ даах чадвартай болсноо ойлгосон. Тэрээр мөн гэр бүл, найз нөхдөөсөө гадна бусад хүмүүстэй санаа бодлоо хуваалцахад бэлэн болжээ.

Мариа, Иосеф хоёр багш нартай ярилцаж буй Түүнийг сонсоод гайхсан боловч, дараа нь Мариа нөхөртэйгөө хамт гурван өдөр Түүнд санаа зовсон тухайгаа Есүст хэлсэн байдаг (Лук 2:46-48). Есүс тэднийг санаа зовох ёсгүй байсан, учир нь тэрээр Эцэгийнхээ ажлыг эхлүүлж байсан гэж хэлжээ (Лук 2:49). Өсвөр насандаа тэрээр амьдралынхаа хүсэл тэмүүллийг дагаж эхлэх ердийн хүсэл сонирхлоо мэдэрч байсан.

Гэсэн хэдий ч, тэрээр гэртээ буцаж ирээд, өсвөр насны үлдсэн он жилүүдэд эцэг эхийнхээ эрх мэдэлд захирагдсан юм (Лук 2:51).

Өсвөр насны эхэн үед хүүхдийн бие насанд хүрэгчийнхтэй илүү төстэй болж өөрчлөгддөг. Хүүхдийн биеийн өндөр хурдан нэмэгдэж болно. Биеийн хэд хэдэн хэсэгт үс ургаж эхэлдэг. Дуу хоолойны өнгө өөрчлөгддөг. Эдгээр өөрчлөлтүүд нь хэвийн зүйл гэдгийг хүүхэд нь ойлгосон эсэхийг эцэг эхчүүд баталгаажуулах хэрэгтэй. Бурхан хүнд ийм хэвийн байдлаар бие махбод болон оюун санаагаар хөгжих хөгжлийг төлөвлөжээ.

Хүүхэдтэйгээ сайн харилцаатай байх нь амьдралын энэ үед тантай нээлттэй ярилцах чадвартай, тийм мэдрэмжтэй байхад түүнд тусалдаг. Эдгээр зүйлсийн талаар эцэг эхтэйгээ ярилцахдаа тав түхгүй байдлыг мэдэрдэг хүүхэд нууц айдастай байх, найз нөхөд эсвэл онлайнаас мэдээлэл хайж болох юм.

Сэтгэл санааны хөгжил

Өсвөр нас бол хүүхдийн өмнөх амьдралын үргэлжлэл төдий биш юм. Эцэг эхчүүд өсвөр насны хүүхдийг бага хүүхдийг удирдан чиглүүлж, заадаг шигээ үргэлжлүүлэн удирдан чиглүүлж болно гэж бодох нь буруу юм. Өсвөр насны хүүхдийн оюун ухаан, сонирхол нь өөрчлөгдөж байдаг. Тэд насанд хүрсэн хүний эрх чөлөө, амжилт, хүндлэлийг хүсэж байдаг. Өсвөр насныхантай бага хүүхэд адил харьцах үед тэд бухимддаг.

Библийн хаа сайгүй Есүс шиг ухаалаг шийдвэр гаргасан, эсвэл Есүсийн ярьсан түүхэнд гардаг шиг (Лук 15:11-32) муу шийдвэр гаргасан залуусын жишээ олон байдаг. Эцэг эхчүүд хүү, охин нь сэтгэл санааны хувьд хэрхэн хөгжиж байгааг ойлгох хэрэгтэй. Эцэг эхийн зорилго бол залуу хүнд сэтгэл санааг оролцуулаад бүх талбарт өөрийгөө хянах чадварыг хөгжүүлэхэд нь туслах явдал бөгөөд ингэснээр эцэг эхийн хяналт шаардлагагүй болдог.

► Ефес 6:1-4 эшлэлийг унших. Энэ эшлэлээс бид ямар тодорхой зааварчилгаа авдаг вэ?

Хүүхэд эцэг эх хоёуланд нь дуулгавартай байх ёстой бөгөөд энэ нь эцэг, эх хоёр хамтран ажиллах ёстой гэсэн үг юм. Энэ эшлэлд эцэг эхдээ дуулгавартай байхыг Бурханд дуулгавартай байх үүрэгтэй нягт холбосон байдаг. Хүүхэддээ дуулгавартай байхыг заадаггүй эцэг эхчүүд тэднийг Бурханд дуулгавартай байхад бэлтгэхгүй байна. Хүүхдээ эцэг эхийнхээ эсрэг тэрслэхийг зөвшөөрөх нь тэднийг Бурханы эсрэг тэрслэхэд бэлтгэж байна гэсэн үг.

Энэ эшлэл эцгүүдэд тусгай зааварчилгаа өгдөг. Эцгүүд хүүхдээ зөв зүйл хийдэг болгохын тулд тэднийг бухимдуулах эсвэл урмыг нь хугалахгүйгээр сахилгажуулах ёстой. Шийтгэл болон засаж залруулах нь зайлшгүй бөгөөд тэдгээр нь хүүхдийг шууд жаргалтай болгодоггүй ч, эцэг нь үүнийг хайраар, тогтмол хийх хэрэгтэй. Энэ нь эцэг хүн хүүхдийнхээ сэтгэл санааны хөгжлийн талаар зарим зүйлийг ойлгох ёстой гэсэн үг юм.

Эцэг нь зөвхөн засаж залруулахаас гадна, Эзэнээс ирдэг сүнслэг халамж, сургаалыг ч дамжуулах ёстой. Бид хүүхдийнхээ зөвхөн алдааг нь шүүмжилж хөгжүүлдэггүй. Бид хүүхдээ ойлгож, урамшуулахад хичээх ёстой. Ингэхдээ бид зөвхөн өөрийн шаардлагыг бус, Бурханы үнэнийг хэрэглэдэг. Бид өөрсдөө ч Бурханд дуулгавартай амьдарч байгаагаа харуулах ёстой.

Хүүхэд бага насандаа хүндэтгэх, дуулгавартай байхыг сурсан бол, өсвөр насанд нь сургах нь илүү хялбар болдог! Эцэг эх хүүхдээ бага байхад нь тогтоосон харилцаа хүүхэд өсвөр насанд хүрч бие махбодын, сэтгэл санааны, сүнслэг өөрчлөлтүүд гарах үед нь тус болдог. Эцэг эхийн үүргийг хялбар болгох заавар байхгүй ч, хүүхэдтэйгээ эртнээс сайн харилцаа тогтоох нь өсвөр насыг дуустал харилцаатай байх боломжийг олгодог.

Эцэг эхчүүд хүүхдээ сонсохыг хүсдэг ч, ихэнх тохиолдолд эцэг эх нь эхлээд сонсох хэрэгтэй байаг. Та бүгдээс гуйя, өөрийнхөө төлөө болон тэдний төлөө утас, ном, ажил эсвэл хийж буй бусад зүйлээ хойш тавиад, хүүхдүүдээ ярих хэрэгцээтэй үед нь анхаарлаа хандуулаарай. Өөр юу ч түүнээс илүү чухал биш мэт түүнийг сонсоорой. Тэдний алдааг засахгүйгээр, тэд юу хэлэхийг хүсэж байгааг үнэхээр ойлгох хүртлээ сонсоорой. Та тэднийг болон тэдний үзэл бодлыг үнэхээр үнэлдэг, мөн та тэднийг хүн гэдэг утгаар нь хүндэлдэг гэдгийг хүүхдүүд тань мэдрэх хэрэгтэй. Хэдийгээр тэд таны зөвлөгөөнд дургүй байсан ч, таныг үнэхээр сонсож байгааг мэдээд дараа нь илүү их хүндлэх болно.

Залуу хүн бухимдал, уур уцаар, эсвэл өөрийгөө тусгаарлах байдлыг илэрхийлэх үед тэднийг сонсох нь хэцүү санагдаж болно. Залуу хүн өөрийн мэдрэмжийг бүрэн ойлгодоггүй гэдгийг санаарай. Заримдаа тэдний сэтгэл хөдлөл нь нөхцөл байдал, харилцаа, бие махбодын нөлөөнд автсан учраас л залуу хүмүүс хэлж байгаа зүйлээ хэлдэг. Өсвөр насны хүүхдийн сэтгэл санаанд: сургуулийн стресс, найз нөхөддөө хүлээн зөвшөөрөгдөх дарамт, бие махбодын өөрчлөлтөөс үүдэлтэй санаа зовнил, үнэлэгдэх эсвэл хүндлэгдэхгүй байгаагаас үүдэлтэй хорсол, дааврын үйл ажиллагаа, тогтворгүй нойрны хэвшлээс үүдэлтэй ядрал гэх мэт эдгээр бүх зүйлс нөлөөлж болно.

Сүнслэг хөгжил

► Номлогчийн үгс 11:9-12:1, 13 эшлэлийг унших. Эдгээр тушаалыг залуу хүнд хэрхэн тайлбарлах вэ?

Дэлхий залуу хүмүүсийн хайхрамжгүй, ёс суртахуунгүй үйлдлийг зөвтгөж болох ч, эдгээр эшлэл залуу хүн үйлдлийнхээ төлөө Бурханы өмнө хариуцлага хүлээх ёстойг сануулдаг. Тэрээр тэдний шүүгч юм.

Амьдралын янз бүрийн үйл ажиллагааны үеэр Бурханы Үгийг заах нь амьдралын энэ үе шатанд ч маш чухал хэвээр байдаг (Дэд хууль 6:6-7). Гэсэн хэдий ч, энэ нь илүү хэцүү юм. Учир нь өсвөр насныхан гэр бүлээс гадуурх олон үйл ажиллагаанд оролцдог учраас завгүй байдаг. Тэд өөрсдийн сонирхол, боловсролын үйл ажиллагаа, спортын үйл

ажиллагаа, найз нөхдийн бүлгүүдэд хамрагддаг. Эцэг эх нь тэдэнтэй үргэлж хамт байх боломжгүй ч, Бурхан хамт байдаг бөгөөд эцэг эхчүүд тэдний төлөө итгэмжтэйгээр залбирах ёстой юм. Тэдэнтэй онцгой яриа хийхийн тулд эцэг эхчүүд Бурханаас мэргэн ухааныг эрэлхийлэх хэрэгтэй. Залуу хүний амьдралын янз бүрийн талбарт оролцож, мэдээлэлтэй байх нь эцэг эхчүүдэд маш чухал юм.

► 1 Тесалоник 2:11-12 эшлэлийг хамтдаа унших. Бурхан эцгүүдэд өсч буй хүүхдүүдтэйгээ харилцах харилцаанд нь ямар хариуцлага өгсөн бэ?

Эцэг эхчүүд ээ, асуудал илэрхий биш байгаа учраас бүх зүйл зүгээр гэж битгий бодоорой. Хүү, охин тань уруу таталттай тулгарч, сул талуудаа мэдэрнэ гэж хараарай. Учир нь тэд тийм байх болно! Тэдэнд санхүүгийнхээ төлөө, цагаа хэрхэн өнгөрөөж байгаа, амьдралын сонголт хийж байгаа, бэлгийн цэвэр ариун байдлынхаа төлөө хариуцлага хүлээх боломжийг олгоорой. Бусдаас мэргэн ухаан, зөвлөгөөг асуугаарай. Багш нар болон санаа бодлоо илэрхийлсэн бусад хүмүүсийг сонсоорой. Хэдийгээр та бусад хүний хүүхдийнхээ талаарх үзэл бодолтой санал нийлэхгүй байсан ч, та сонсож, хүүхдийнхээ хэрэгцээг ойлгохыг хичээх ёстой.

Өсвөр насны хүүхдийнхээ төлөө залбирч, түүний төлөө залбирч байгаагаа хэлээрэй. Түүний төлөө залбирч байгаагаа түүнд сонсгоорой. Түүний төлөө залбирч байгаа тодорхой залбирлуудаа хуваалцаарай. Жишээлбэл, та хүүхдэдээ: " ... зөвт байдлын төлөө өлсөж, цангаасай (Матай 5:6); мөн буга ус руу тэмүүлдэг шиг Бурханыг хүсээсэй (Дуулал 42:1) гэж би залбирч байна. Бурхан чамайг өөрийн Сүнсээр дүүргэхийг би хүсэж байна (Ефес 5:18). Ингэснээр чи Түүнийг бүх зүрх сэтгэл, сүнс, оюун ухаанаараа болон хөршөө [эсвэл ах дүүгээ] өөр шигээ хайрлах болно (Матай 22:37-39)" гэж хэлж болно."

► Өсвөр насны хүүхдийнхээ төлөө залбирч болох Библийн өөр ямар эшлэлүүд байдаг вэ?

Эцэст нь, өсвөр насны хүүхэдтэйгээ хийх энэхүү сүнслэг аялалд Бурханы Үгийг тэдэнтэй хамт ашиглаарай:

- Үлгэр дуурайл байгаарай: Өөрийн Библи судлах хувийн цагийг тогтмол гаргаарай. Хүү, охинтойгоо Бурхан танд юу зааж байгаа, мөн та Бурханы Үгийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар ярилцаарай. Хэдийгээр тэд урам зоригтой хариу үйлдэл үзүүлэхгүй эсвэл яриаг үргэлжлүүлэхгүй байсан ч, тэд сонсож, Үгийн нөлөөг хүлээн авч байгаа!
- Библийн эшлэлийг гэр бүлээрээ хамтдаа цээжилж, өдөр тутмын хоолны цаг эсвэл орой унтахын өмнө уншаарай.
- Сургаалт үгс номыг хамтдаа нэг эшлэлээр ээлжлэн уншиж, ярилцаарай. Сургаалт үгс нь Бурханы тухай ярилцах богино цагт зориулсан гайхалтай ном бөгөөд өдөр тутмын амьдралд хэрэгтэй практик мэргэн ухааныг агуулдаг. Энэ нь олон яриа хийх боломжийг олгож, асар их нөлөө үзүүлдэг.

- Библид хаа сайгүй байгаа заавар, зарчим, жишээнүүд нь амьдралын бүх үе шатанд хамааралтай тул Бурханы бүх Үгийг хүү, охинтойгоо судлаарай.

Нийгмийн хөгжил

Лук 2:52, Есүсийн өсвөр насны талаар дүрсэлсэн энэ эшлэлд тэр мөн бусад хүмүүстэй харилцах харилцаандаа ч өссөн гэдгийг өгүүлсэн. Бидний харилцаанд Бурхан маш их анхаарал хандуулдаг. Тэр биднийг хүмүүстэй харилцаж, нөхөрлөхөөр бүтээсэн.

Гэр бүлийнхнээс гадна бидэнд анги, хөрш, чуулганы бүлгүүд, ажил олгогчид, багш нар болон бусад удирдагчид, мөн хэвлэл мэдээлэл нөлөөлдөг. Үе тэнгийнхэн нь ихэвчлэн сайн эсвэл муугаар хамгийн их нөлөөлдөг. Христитгэлт эцэг эхчүүд хүүхэд, залуусынхаа нийгмийн харилцаанд хяналт тавих хэрэгтэй.

Залуучууд насанд хүрэх үйл явцаа хэр хэмжээгээр зохицуулж чадахыг анхааралтай, залбиралтайгаар авч үзэж хандаарай. Гэрийн компьютерууд болон гар утасны төхөөрөмжүүд дээр нууц үг, тодорхой апп ашиглан гэр бүлээ хорон муу контент руу нэвтрэхээс хамгаалаарай. Төхөөрөмж ашиглах цагийг хязгаарлаж болно. Вебсайт, кино, телевизийн нэвтрүүлэг, олон нийтийн мэдээллийн платформуудад хяналт тавиарай. Та өсвөр насны хүүхдээ танихгүй хүмүүстэй цагийг өнгөрөөхийг зөвшөөрдөггүй шигээ, тэднийг цахим орчинд буруу хүмүүсийг дагах эсвэл холбогдохыг бүү зөвшөөр.

► Залуусыг зөвхөн хамгаалах нь хангалтгүй. Өсвөр насанд нь та өөрийн хүүхдүүдийг Бурханыг хүндэлж, сэтгэлээ хамгаалах ухаалаг шийдвэрийг өөрсдөө гаргадаг тийм хариуцлагыг хүлээхэд бэлтгэж байна. Технологи болон нийгмийн ертөнцөд хариуцлагатай байхыг өсвөр насны хүүхдэдээ заах зарим арга зам юу вэ?

Залуу хүмүүс ихэвчлэн хамтдаа их цагийг өнгөрөөдөг найз нөхдийн бүлгүүдийг үүсгэдэг. Тэд ижил төрлийн зугаатай зүйлсээс таашаал авах болон сонирхдог зүйлсээ хуваалцсанаар суралцдаг. Тэд чуулган, эцэг эх, сургууль, бусад байгууллагуудын талаар ижил хандлага, бодолтой болж эхэлдэг. Эцэг эхчүүд өсвөр насны хүүхдийнхээ хандлагад гарсан өөрчлөлтөд ихэнхдээ гайхдаг. Залуу хүмүүс заримдаа гэнэтийн сэтгэгдэл, шүүмжлэл хэлж, найз нөхдөөсөө сурсан үг хэллэгийг ашигладаг. Найз нөхдийн бүлэг нь тэдний хувьд хоёр дахь гэр бүл болох бөгөөд тэндээ тэд хүлээн зөвшөөрөгдөхийг илүүд үздэг. Хэрэв өөрийн гэр бүл нь түүнд үнэ цэн, өөрөө хэн болох, хүлээн зөвшөөрөгдсөн мэдрэмжийг өгөхгүй бол, залуу хүн хоёр дахь гэр бүлдээ хүчтэй татагддаг.

Эцэг эх нь өсвөр насны хүүхдээ найз нөхдийн бүлгээс гаргах эсвэл бүлгийн нөлөөг хязгаарлах нь маш хэцүү байдаг. Эцэг эх нь тухайн бүлгийг эсвэл хувь хүмүүсийг шүүмжлэх үед хүүхэд тэднийг хамгаалахыг хүсэж, эцэг эх нь ойлгохгүй байна гэж мэдэрдэг. Эцэг эхчүүд халамж, сонирхол, хайрыг үзүүлж, өсвөр насны хүүхдэдээ тусалж чадна. Эцэг эхчүүд залуу хүний сэтгэл санааны хэрэгцээг хангаж байвал, тэд хоёр дахь гэр бүл болох найз нөхдөөсөө хамааралгүй болдог.

► Хэд хэдэн гэр бүлийн эцэг эхчүүд өсвөр насны хүүхдүүддээ туслахын тулд хэрхэн хамтран ажиллаж болох вэ?

► Танай чуулган өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдүүд нь Бурханыг хүндэлдэг эрүүл, нийгмийн амьдралтай байхад нь хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ?

Насанд хүрэх шилжилтийн үеийн хүндрэлүүд

Хүүхэд яг нэг тодорхой цаг хугацаанд л насанд хүрэгч болдоггүй. Хүүхэд хэд хэдэн жил үргэлжлэх шилжилтийн үеийг дамждаг.

Бүх Бичвэрээс, тэр тусмаа Сургаалт үгс ном нь залуучуудад илүү тохирдог. Сургаалт үгс номыг Соломон хаан амьдралд суралцаж, ертөнцийг үзэх үзлээ хөгжүүлж байсан хүүдээ хандан бичжээ. Соломон хүүтэйгээ амьдралын бүх талбар, Бурханы замыг сонгохын үр шим, Бурханы замыг үгүйсгэхийн аюулын талаар ярилцсан байдаг.

Хүүхэд насанд болон өсвөр насанд үүссэн итгэл үнэмшил, мөн тэр үед гаргасан сонголтууд нь хүний амьдралд маш чухал байдаг. Бид насанд хүрэх шилжилтийн үеийн хэд хэдэн сорилтыг авч үзэхдээ, Бурханы Үг бидэнд залуусынхаа өсвөр насны үеийг даван туулахад хэрхэн тусалж чадах талаар эргэцүүлэх болно.

Сорилт 1: Өсвөр насны хүүхэд өөрт нь заасан бүхнийг үнэлж, юунд итгэхээ шийддэг.

Өсвөр насны хүүхэд өөрийн итгэл үнэмшлийг оюун санаандаа тодорхой байлгахыг хүсдэг тул өөрт нь заасан зүйлийг үнэлж, асуудаг. Тэрээр эцэг эхийнхээ заасан бүх зүйлийг хүлээн авахгүй байх магадлалтай. Эцэг эхчүүд энэ эрсдэлээс айдаг. Хэрэв тэд өөрийнх нь бодож буй асуудлуудыг ойлгоход нь тусалж чадахгүй гэж залуу мэдэрвэл, түүнд дахин хүүхэд шиг хандалгүй, ямар ч асуух зүйлгүйгээр эргэлт буцалтгүйгээр өөрийн итгэл үнэмшлийг хүлээн авахад нь хандуулдаг. Энэ нь өсвөр насны хүүхдэд өөрийгөө бодох боломж олгохгүй байна гэсэн мэдрэмжийг төрүүлдэг.

Эцэг эх нь итгэл үнэмшлийн шалтгааныг тэвчээртэйгээр тайлбарлаж, тайлбарлахад тусалж чадах бусад хүмүүстэй хамт ярилцах боломжийг хүүхдэдээ олгох хэрэгтэй юм.

► Сургаалт үгс 23:22-23 эшлэлийг хамтдаа унших.

Эдгээр эшлэлд залуу хүн эцэг эхийнхээ мэргэн ухааныг сонсохыг сонгох ёстой гэж Бурхан хэлсэн. Эцэг эх нь өсвөр насны хүүхдийнхээ төлөө энэ сонголтыг хийж чадахгүй ч, тэд сайн харилцааг хөгжүүлж чадна. Хэрэв эцэг эх нь хүү, охинтойгоо нээлттэй, хүндэтгэлтэй харилцвал, энэ нь өсвөр насны хүүхдүүдийг энэ сонголтыг хийхэд урамшуулдаг.

Сорилт 2: Өсвөр насны хүүхэд шийдвэр гаргах хариуцлагыг авч эхэлдэг.

Өсвөр насны хүүхэд шийдвэрийг хэрхэн гаргадгийг ойлгож эхэлдэг бөгөөд өөрөө шийдвэр гаргах чадвартай гэж мэдэрдэг ч, эцэг эх болон бусад хүмүүс түүний сонголтыг нь хязгаарладаг. Тэд түүний чадамжийг ойлгохгүй байна гэж тэр боддог учраас бусад

хүмүүсийн эрх мэдлийг эсэргүүцдэг. Хэрэв тэр эсэргүүцвэл эцэг эх нь түүнийг илүү их хязгаарлах хандлагатай байдаг.

Эцэг эхчүүд хүүхдээ бага байхад нь амьдралын энэ үе шатанд хүрэх сайн суурь тавих ёстой. Бурханы сахилгажуулалт нь бидний сайн сайхны төлөө байдаг шиг (Еврей 12:9-10) хүүхдээсээ шаардаж буй зүйл нь хүүхдийн өөрийнх нь сайн сайхны төлөө гэдгийг эцэг эхчүүд харуулж чадна. Эцэг эхчүүд өөртөө тав тухтай байдлыг авчрах дүрэм тогтоож байгаа биш гэдгээ харуулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, эцэг эхчүүд хүүхдэдээ хүүхэд нас болон өсвөр насыг бүхэлд нь хамарсан илүү том, чухал шийдвэр гаргах хариуцлагыг аажмаар шилжүүлэн өгдөг. Энэ нь залуус хариуцлагаа хэрэгжүүлэх, итгэл үнэмшлээ батлах, насанд хүрэхэд бэлтгэгдэх боломжийг олгодог.

Эцэг эхчүүд өсвөр насны хүүхдэдээ хязгаар тогтоох хариуцлагаа Бурханы өмнө хүлээсээр байдаг (1 Тимот 3:4). Харин өсвөр нас нь залуу хүн өөрийн сонголтын төлөө Бурханы өмнө бүрэн хариуцлага хүлээх насанд хүрэхэд бэлтгэх үе байдаг. Эцэг эхчүүд өсвөр насны хүүхдээ энэхүү дараагийн үед бэлтгэх ёстой. Сургаалт үгс нь хүүгээсээ мэргэн ухаантай шийдвэр гаргахыг хүсэж буй эцэг хүний бичсэн ном юм. Соломон эцгийн хувьд хүүгийнхээ төлөө сонголт хийж чадахгүй ч, зөв сонголтыг түүний өмнө хамгийн сонирхолтой байдлаар харуулж чадна гэдгийг мэдэж байсан.

Сорилт 3: Өсвөр насны хүүхдэд насанд хүрсэн хүнийх шиг төлөвшил байдаггүй.

Өсвөр насныхан эцэг эхийнх нь санаа зовоосон аюул, эрсдлийг ойлгохгүй байж болно. Өсвөр насныхан ихэвчлэн зорилгодоо хүрч, аюулаас зайлсхийж чадна гэж мэдэрдэг. Эцэг эх нь өөрсдийнх нь чадвар, ялгах чадварт нь итгэхгүй байгаад тэд ихэвчлэн бухимддаг.

Сургаалт үгс ном нь эцэг эхчүүд өсвөр насны хүүхдэдээ юу зөв, юу бурууг хэлэх эсвэл зүгээр л хязгаар тогтоох нь хангалтгүй, харин сонголт бүрийн үр дагаврын талаар тэдэнтэй ярилцах нь чухал болохыг харуулдаг. Энэ зааврыг сонсох нь залуу хүнд төлөвшсөн байдлаар бодож сурахад нь тусалдаг.

► 1 Петр 5:5 эшлэлийг хамтдаа унших.

Залуу хүн хийж чадах хамгийн ухаалаг зүйл бол бурханлаг эцэг эхийнхээ эрх мэдэлд захирагдаж, тэдний мэргэн зөвлөгөөг сонсох явдал юм. 1 Петр 5:5-д харуулснаар, үүнийг үйлдсэн залуу хүн Бурханы онцгой ивээлийг хүртдэг.

Сорилт 4: Өсвөр насны хүүхдэд насанд хүрсэн хүнийх шиг дур хүсэл байж болох ч түүнд насанд хүрсэн хүний эдлэх эрх завшаан байдаггүй.

Насанд хүрэгчид гэрлэлт, өмч хөрөнгө эзэмших, удирдах албан тушаал, шийдвэр гаргах эрх чөлөө зэрэг олон эрх завшааныг эдэлдэг. Өсвөр насныхан эдгээр эрх завшааныг хараахан эдэлж чадахгүй ч, эдгээр зүйлсийг төрөлхийн хүсэж тэмүүлдэг учраас

бухимддаг. Тэдний дур хүсэл нь хүчтэй уруу таталтыг үүсгэдэг. 2 Тимот 2:22 нь залуучуудад энэ бэрхшээлийг хэрхэн даван туулахыг мэдэхэд тусалдаг.

► 2 Тимот 2:22 эшлэлийг хамтдаа унших.

Өөрт нь дуулгавартай байхыг хүссэн залуучуудын төлөө Бурхан нигүүлслээ бэлддэг. Тэр тэдэнд эрх мэдэлд нь захирагдах болон Түүний цаг хугацаа, хүслээс гадуурх өөрсдийн дур хүслээсээ татгалзахад нь тусалдаг. Тэрээр христитгэлт өсвөр насныханд эдгээр дур хүслээ ойлголт, зан чанар, амьдралын ур чадварыг хөгжүүлэх замаар насанд хүрэхэд бэлтгэх урам зориг болгон хувиргахад нь тусалдаг.

Сорилт 5: Өсвөр насны хүүхэд бусдын үг үйлдэл нь өөр нийцэхгүй байгаа байдлыг харахдаа гомддог.

Олон залуу хүмүүс тэдний хувьд илүү сайн үлгэр дуурайл, илүү сайн сүнслэг удирдагч нь байх ёстой хүмүүс тийм байж чадаагүйд урам хугардаг. Ийм зүйл тохиолдоход өсвөр насны хүүхэд хэнд ч итгэж чадахгүй хандлагатай болдог. Ийм учраас чуулганы удирдагч, эцэг эхийн хувьд та бүхэн тогтвортой, бурханлаг амьдралаар амьдрах нь нэн чухал юм. Таны амьдралаас харагдах үл нийцэх зүйлс олон залуусыг мөнхөд тамд байхад хүргэж болзошгүй. Хэдийгээр Есүс өсвөр насныхны талаар яриагүй ч, Матай 18:6 эшлэл нь энд хамаатай бөгөөд хүүхдүүдийн талаар өгүүлсэн байдаг.

► Матай 18:6 эшлэлийг хамтдаа унших.

Христитгэлт залуу хүн бусдаас үлгэр дуурайлыг харахгүй байсан ч бурханлаг байдлын үлгэр дуурайл болж чадна. Хуучин гэрээн дэх Самуелын амьдрал бол үүний жишээ юм. Самуел бурханлаг бус, олон талаараа завхарч гажуудсан тахилчийн гэр бүлд өссөн ч, тэр бага наснаасаа Бурханы төлөө амьдрахаар шийдсэн (1 Самуел 1:20; 1 Самуел 2:11-18, 22-26). Бүр хүүхэд, өсвөр насандаа ч тэрээр цэвэр ариун амьдралаар амьдарсан юм (1 Самуел 3:19, 21).

► 1 Тимот 4:12 эшлэлийг хамтдаа унших.

Сорилт 6: Өсвөр насны хүүхэд олон шийдвэр, боломжийн өмнө баяр хөөртэйгөөр нүүр тулдаг.

Өсвөр насныхан боломжоор дүүрэн ертөнцийг хардаг. Тэд амьдралынхаа чиглэлийг олоход бэрхшээлтэй байж болно. Тэдэнд янз бүрийн хүмүүсээс хоорондоо зөрчилдсөн зөвлөгөө ирэх боломжтой.

Хэн нэгэн тэдэнд боломжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлийг өгөх ёстой гэж өсвөр насныхан боддог. Өсвөр насны хүүхдийн хувьд жижиг зүйлд итгэмжит байснаар Бурхан өөрийнхөө төгс цагт илүү олон боломжийг нээж өгнө гэж итгэж үйлдэж сурах нь маш чухал байдаг.

► Лук 16:10 эшлэлийг хамтдаа унших.

Өсвөр насны хүүхэд бурханлаг зөвлөгөөг сонсохыг сонгох нь чухал юм.

► Сургаалт үгс 11:14 эшлэлийг хамтдаа унших.

Бурханы мэргэн ухааны замыг дагахад ерөөл, эрх чөлөө байдгийг залуу хүмүүс олж мэдэх болно.

Хэлэлцүүлгийн асуултууд

► Энэ хичээлээс танд хамгийн их тус болсон санаанууд юу вэ? Эдгээр нь танд болон таны гэр бүл, хамт олон, эсвэл чуулганд хэрхэн нөлөөлөх вэ?

► Хэрэв та өсвөр насны хүү, охинтой эцэг эх байсан бол амьдралын энэ үе шатанд хүүхэдтэйгээ нээлттэй, хүндэтгэлтэй харилцааг хөгжүүлэх талаар ямар зөвлөгөө өгөх вэ? Өөрийн алдааны талаар шударгаар ярина уу.

► Залуучуудад мэргэн ухаантай байж, зөв шийдвэр гаргахад нь туслахын тулд та ямар практик зүйлс хийж чадах вэ?

► Эцэг эхийн хувьд таны хүүхдийн эрх дураараа байдал нь өсөн нэмэгдэж байна уу эсвэл хариуцлагатай байдал нь нэмэгдэж байна уу гэдгийг хэрхэн мэдэж болох вэ?

► Өсвөр насны үед эцэг эхийн үндсэн хариуцлага болон хүүхдийн үндсэн хариуцлагын талаар дүгнэж үзнэ үү.

► Хүүхдээ өсөж томрох үед нь эцэг хүн амьдралын аль талбарт түүнийг урамшуулж, анхааруулж, чиглүүлэх ёстой вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Хүүхдийг төлөвшиж насанд хүртэл нь өсгөх хариуцлагыг бидэнд даатгасанд талархъя. Энэ хариуцлага олон талаараа төвөгтэй бөгөөд бидэнд таны мэдлэг ойлголт хэрэгтэй билээ.

Таны Үгээс бид хүүхдэдээ мэргэн ухаан, өөрийгөө хянах чадвар, танд дуулгавартай байхыг заах хариуцлагаа олж хардаг. Бид өсвөрийн хүүхдүүдтэйгээ харилцахдаа эдгээр нэн тэргүүнд тавих зүйлсэд анхаарлаа хандуулж чадаагүйнхээ төлөө уучлалт гуйж байна.

Таны Үгийг уншиж, дуулгавартай дагах үед хүүхдийн маань хэрэгцээнд зориулсан тодорхой мэргэн ухааныг бидэнд өгөөч хэмээн хүсэж байна. Тэд амьдралынхаа бүх өдрүүдэд таныг үнэнчээр дагах нь бидний хамгийн агуу хүсэл билээ.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) Гэр бүлийнхээ эсвэл таны халамжинд байгаа өсвөр насны хүүхдийн төлөө залбирахад ашиглаж болох дор хаяж гурван Библийн эшлэл эсвэл багцлалыг олоорой. Дараах зүйлстэй холбоотой эшлэлийг хайгаарай:

- Тэдний сүнслэг хэрэгцээ
- Тэдний зан чанарын хөгжил
- Тэдэнд нөлөөлдөг зүйлс болон хүмүүс
- Тэдний өсч хөгжих хэрэгцээтэй арга замууд

Эдгээр эшлэлийг байнга харагдахуйц газарт бичээрэй. Өдөр бүр эдгээр эшлэлийг ашиглан залуучуудынхаа төлөө залбирч эхлээрэй.

(2) Хичээлийн төгсгөлд дурдсан бүлгийн хэлэлцүүлгийн асуултуудаас хоёрыг сонгоно уу. Сонгосон асуулт тус бүрд дор хаяж нэг догол мөрөнд багтаан хариулж бичнэ үү.

(3) Дараах Библийн эшлэлээс нэгийг сонгож унших:

- Сургаалт үгс 4-5-р бүлэг
- Сургаалт үгс 6-р бүлэг
- Сургаалт үгс 23-р бүлэг
- Сургаалт үгс 24-р бүлэг

Унших явцдаа дараах асуултуудыг бодож үзээрэй. Энэ эшлэлээс...

- Өсвөр насны хүүхэдтэй эцэг эхийн хувьд нэн тэргүүнд тавих ёстой зүйл юу вэ?
- Өсвөр насны хүүхдийн хувьд нэн тэргүүнд тавих ёстой зүйл юу вэ?
- Өсвөр насны хүүхэдтэй эцэг эх ямар хандлагатай байх ёстой вэ?
- Өсвөр насны хүүхэд ямар хандлагатай байх ёстой вэ?
- Өсвөр насны хүүхэдтэй эцэг эх юу хийдэг вэ?
- Өсвөр насны хүүхэд юу хийдэг вэ?
- Амьдралын ямар талбаруудын талаар эцэг эх, өсвөр насны хүүхэд хоорондоо ярилцах ёстой вэ?

Өсвөр насны хүүхэдтэй эцэг эхэд хандсан эшлэл дэх сургамжийг нэгтгэж, жагсаан бич. Мөн өсвөр насны хүүхдэд хандсан эшлэл дэх сургамжийг нэгтгэн, хоёр дахь жагсаалтыг гаргана уу.

15-р хичээл

Залуу нас

Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах чадварт суралцсан байна:

- (1) Залуу насанд тулгардаг чухал хариуцлага, асуудлын талаарх Бурханы үзэл баримтлалыг ойлгох.
- (2) Залуучуудыг ухаалаг шийдвэр гаргаж, Бурханы зааврыг дагахад нөлөөлөх чадвартай байх.

Шаргуу дайчин залуу Езра

Езраг бага байхад эцэг эх нь түүнд сайн ажиллахыг зааж сургажээ. Тэр ажиллаж, мөнгө олох боломж олдвол үргэлж баяртай байдаг байв. Хэн нэгэн түүнийг ажилд авах л юм бол тэр үргэлж бэлэн байдаг. Өсвөр насандаа тэрээр хашаа талбай цэвэрлэж, сонин хүргэж, дугуй засдаг байв. Езра бизнесмен болох сонирхолтой байсан ч, Бурхан түүнийг үйлчлэлд дуудаж байгааг мэдсэн. Улмаар тэр Езра Библийн сургуульд суралцжээ. Сургалтын төлбөрөө төлөхийн тулд тэрээр оффис цэвэрлэж, ресторанд ажиллаж, хашаа талбайн ажил хийдэг байв. Тэрээр төгсөөд үйлчлэлээ эхлүүлсэн боловч, үйлчлэл нь түүнийг бүрэн дэмжих боломжгүй байсан учраас заримдаа байшин будаж, барилгын засвар хийдэг байсан. Эхнэр хүүхдээ тэжээх хэрэгцээтэй байсан ч, тэр үргэлж ашиг олохыг бус, харин үйлчлэлийн хариуцлага болон хувийн хөгжлийг нэн тэргүүнд тавихыг хичээсэн. Эцэст нь түүний үйлчлэл Езраг бүрэн дэмжих цаг ирсэн.

Төлөвшил ба зан чанар

► Суралцагчид 1 Тимот 4:12 ба Гашуудал 3:27 эшлэлийг бүлэгт уншина.

1 Тимот ном нь хэд хэдэн чуулганыг харгалзаж байсан залуу хүнд зориулж бичигдсэн юм. 1 Тимот 4:12 эшлэлээс Бурхан итгэгч залуучуудаас зан чанар, биеэ авч явах байдлаараа үлгэр дуурайл болохыг хүсдэг гэдгийг бид хардаг. Тэд Христийн онол сургаалын сайн үндэс суурьтай байхыг чухалчлах ёстой юм. Тэд бусадтай харилцах бүрдээ цэвэр ариун байдал, хувиа хичээдэггүй хайрыг харуулах хэрэгтэй. Тэдний зан байдал, үг яриа нь Бурханыг өргөмжилж, Түүнийг алдаршуулсан байх учиртай.

Итгэгч залуучууд хянамгай, зорилготой амьдрах ёстой. Бурхан тэдний амьдралын энэ үе шатанд өгсөн хүч чадлыг буруугаар ашиглах ёсгүй. Тэд сурах, үр чадвараа хөгжүүлэх, бусдад үйлчлэх, хариуцлага хүлээх боломжийг дэмий үрэх учиргүй. Өсвөр нас болон залуу насны эхэн үеийг хувиа хичээсэн амбицад зарцуулж болохгүй. Эдгээр

нь өсөлт, үйлчлэлийн хамгийн чухал он жилүүд юм. Бурхан залуу итгэгчдийг өөрийгөө хянах чадвартай болгож, улмаар Түүний төлөө үр жимстэй байлгаж чадна.⁴⁷

Ажил

Ажлын талаарх үзэл баримтлал

Зарим соёлд хүмүүс, тэр ч байтугай залуу, эрүүл чийрэг хүн хүртэл суугаад ажил хийхгүй байх нь түгээмэл байдаг. Хэдийгээр тэдэнд хэрэгцээ байгаа, мөн бусдын төлөө хариуцлага хүлээсэн ч гэсэн тэдэнд ажиллах урам зориг байдаггүй. Тэд сайн цалинтай ажилд орвол л ажиллана гэж хэлдэг. Тэд бага цалинтай ажил хийх эсвэл доод түвшний ажил мэт санагдах ажил хийхийг хүсдэггүй. Хэрэв хувьдаа ашиг олохгүй л бол орчноо сайжруулахын тулд ажиллахыг хүсдэггүй.

Заримдаа ажилд орсон хүмүүс ажилтай болсондоо баяртай байдаг. Магадгүй тэдний хувьд ихэнх хүмүүс сайн ажил олж чаддаггүй тийм оронд амьдардаг байж болно. Тэд компанийнхаа дүрэмт хувцсыг өмсөж, ажлынхаа байр сууриар бахархах дуртай байдаг. Гэвч тэд өөрсдийн байр суурийг эдэлж байхдаа ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчдэд хэрхэн үйлчлэх талаар бодолцож үздэггүй. Тэд компанийн нэг хэсэг болсондоо бахархдаг ч, яагаад ажилд орсон болохоо ухаардаггүй.

Ажиллахаас татгалздаг хүмүүсээс ялгаатай нь зарим хүмүүс карьер эсвэл мөнгө олоход хэт их анхаардаг. Магадгүй тэд өөрсдийн амьдарч байсан нөхцөлтэйгээ харьцуулбал хамаагүй өндөр цалинтай ажилд шилжсэн байж болно. Тэд аль болох их ажиллаж, мөнгө олохыг хүсдэг. Тэд Бурхан болон гэр бүлтэйгээ харилцаагаа хөгжүүлэх гэх мэт амьдралын бусад чухал талбаруудыг үл тоомсорлодог.

Нийгэм дэх хүмүүс эдгээр зүйлсийг хийж болох ч, итгэгчид өөрсдийн ахуй соёлд хэвийн зүйлсийг зүгээр л хийдэг байж таарахгүй. Үүний оронд тэд Бурхан юу гэж хэлснийг олж мэдээд, Түүнд дуулгавартай байх ёстой. Библид ажил, хичээл зүтгэл, үр бүтээлтэй байдлын талаар их зүйлийг өгүүлдэг.⁴⁸

Ажлын үүсэл

Бурхан бүтээлч (Дуулал 104:24) бөгөөд үр бүтээмжтэй (Дуулал 104). Бурхан үргэлж ажиллаж, хувь хүний амьдрал болон бүх цаг үеийн туршид дэлхийн үйл хэрэгт оролцсоор байдаг (Иохан 5:17). Бурхан хүмүүсийг бүтээхдээ тэднийг өөрийн дүр төрхөөр, өөрийгөө тусган харуулах байдлаар бүтээжээ. Тэр хүмүүсийг бүтээлийнхээ бүтээлч, үр бүтээмжтэй менежер байхыг хүссэн. Бурхан хүн төрөлхтөнд газар, далай,

⁴⁷ Энэ сэдвийн талаар дэлгэрүүлж дараах хичээлийг үзнэ үү. *Spiritual Formation*, 12-р хичээл, Shepherds Global Classroom.

⁴⁸ Энэ сэдвийн талаар дэлгэрүүлж дараах хичээлийг үзнэ үү. *Practical Christian Living*, 3-р хичээл, Shepherds Global Classroom.

тэнгэрийн бүх амьтдын дээгүүрх эрх мэдлийг өгчээ (Эхлэл 1:26). Тэр хүмүүсийг дэлхийн нөөцийн менежер, итгэмжлэгдсэн хүмүүс болгосон (Эхлэл 1:28-30).

Ажил бол хүний амьдралд зориулсан Бурханы загвар төлөвлөгөөний нэг хэсэг юм. Эхнээсээ л Бурхан хүмүүст өндөр хариуцлага өгчээ. Түүний бидэнд өгсөн ажлыг итгэмжтэйгээр хийсэн эсэхээ бид Түүнд тайлагнах болно.

Сургаалт үгс номын зарчмууд

Сургаалт үгс ном нь тусгайлан залуу хүмүүст зориулагдан бичигдсэн бөгөөд тэднийг мэргэн ухаантай байж, зөв зан байдалд явахыг сургадаг. Сургаалт үгс номд ажлын талаар их зүйлийг өгүүлдэг.

► Суралцагчид Библийн эшлэл бүрийг бүлэгт уншина.

Сургаалт үгс 6:6-11, Сургаалт үгс 10:5. Шоргоолж нь хүмүүсийн хувьд сайн жишээ юм.

- **Тэд хэн нэгэн тэднийг ажиллахад албадахгүй байсан ч хичээл зүтгэлтэй ажилладаг.** Хэн ч тэдэнд юу хийх, хэрхэн хийхийг хэлдэггүй ч, тэд бүтээмж өндөр байдаг. Албадуулахгүйгээр ажиллах ёстой гэдгийг бид шоргоолжноос сурдаг. Бурхан бидний хэрэгцээг ийнхүү хангадаг учраас бид ажиллахыг хүсэх ёстой.
- **Тэд ажиллах цаг болоход ажилладаг.** Ажиллах цаг, бусад зүйлийг хийх, амрах цаг гэж бий. "Би яг одоо юу хийх ёстой вэ?" гэж асуух нь тустай байж болно.
- **Тэд ажиллах боломж байхад ажилладаг.** Улирал солигдож, нөөц хуримтлуулах боломж өнгөрөн одож болно. Бидний боломжууд ч ирж, мөн оддог. Бид одоо байгаа боломжоо ашиглах ёстой, эс тэгвээс энэ нь дэмий үрэгдэнэ.
- **Тэд өөртөө хэрэгтэй хоол хүнсээ дараа идэхийн тулд ажилладаг.** Ажиллах цаг болоход бид унтаж эсвэл амрах ёсгүй. Хэрэв бид сайн ажил хийх ёстой үедээ залхуурвал, ирээдүйн хэрэгцээгээ хангаж чадахгүй. Бид **маргаашийн** хэрэгцээг хангахын тулд **өнөөдөр** ажиллах ёстой.

Сургаалт үгс 19:15, Сургаалт үгс 20:4, Сургаалт үгс 12:24. Бурхан энэ дэлхий дээр бидний сонголтууд бодит үр дагавартай байхаар тогтоожээ (Галат 6:7).

Хэрэв бид биеийн хувьд үргэлж залхуу байхыг сонговол, бид биеийн хувьд сул дорой болно. Хэрэв бид бодол санаандаа үргэлж залхуу байхыг сонговол, сурах, бодох, шүүн тунгаах чадвар маань буурна.

Хэрэв бид ажиллах боломжтой үедээ ажиллахаас татгалзвал, Бурхан биднийг хоолгүй байх ёстой гэж хэлдэг (2 Тесалоник 3:6-12 эшлэлийг унш).

Хэрэв бид хичээл зүтгэлтэй байвал, Бурхан бидний боломжуудыг нэмэгдүүлж, илүү том хариуцлагаар ихэвчлэн шагнадаг.

Бурхан бидний сонголтын ерөнхий үр дагаврыг тогтоосон. Бид үр дагаврыг сонгодоггүй, харин юу хийхээ сонгодог!

Сургаалт үгс 14:23, Сургаалт үгс 20:6. Зарим хүмүүс өөрсдийгөө маш ухаалаг гэж боддог ч, ажиллахаас татгалздаг. Тэд хэрхэн хийх ёстой талаар мөрөөдөж, ярих дуртай ч, өөрсдөө юу ч хийдэггүй. Бурхан биднийг зүгээр л ярихаас илүүтэйгээр бодитоор ажиллахыг хүсдэг. Тэр биднийг хариуцлага хүлээж, хэлсэн зүйлээ итгэмжтэйгээр биелүүлэхийг хүсдэг.

Сургаалт үгс 15:19. Заримдаа хүмүүс аливаа зүйлийг **хэрхэн** хийх тал дээрээ залхуу ханддаг. Хэдийгээр тухайн арга сайн үр дүнд хүргэхгүй байсан ч, тэд хялбар аргыг сонгодог. Магадгүй тэд бага зардалтайгаар ямар нэгэн зүйл хийж байгаа ч, хийж байгаа зүйл нь цаг хугацааны туршид тогтвортой байж чадахгүй. Магадгүй тэдний аргачлал бага хүчин чармайлт шаардаж болох ч, эцсийн бүтээгдэхүүн нь чанар муутай байх боломжтой. Магадгүй тэд бэрхшээлүүдийг даван туулж, зөвийг хийх хүсэлтэй байхын оронд бусад хүмүүсийн шахалтад бууж өгдөг ч байх боломжтой.

► Хүмүүс ямар нэгэн зүйлийг хийх аргачлалдаа залхуу ханддаг жишээг та санаж байна уу?

Энэхүү сургаалт үг нь бид хийдэг зүйлдээ болон хэрхэн хийх тал дээрээ залхуу хандах нь хожим бидэнд болон бусад хүмүүст асуудал үүсгэдэг гэдгийг сургамжилдаг. Харин бид зөвийг хийх үед сайн үр дүнгээр шагнагддаг. Бид одоо хянамгай, гүнзгийрүүлэн хийх ёстой бөгөөд ингэснээр хожим хамгийн сайн үр дүнг эдлэх болно.

► Залхуурал нь хожим бэрхшээл, зовлонд хүргэсэн жишээг та санаж байна уу? Итгэмжит байдал, хичээл зүтгэл сайн үр дүнд хүргэсэн жишээг та санаж байна уу?

Сургаалт үгс 12:11, Сургаалт үгс 21:20, Сургаалт үгс 28:19. Залуучууд аа, Бурхан та нарт хүч чадал, эрүүл мэндийг өгөхдөө эдгээрийг үнэ цэнгүй зүйлд үрэхийн тулд өгөөгүй юм. Тэр та нарт биеийн болон оюун ухааны чадамжуудаа сайн удирдахыг итгэж даалгасан. Тэрээр та нарт Түүнд үйлчлэх боломжуудыг олгосон. Итгэмжит үйлчлэгч байх нь өөрийгөө хянахыг шаарддаг. Та зугаацах таашаал авах хүсэл бүрийг биелүүлж чадахгүй. Та Бурханы зорилгыг биелүүлэхийн тулд эрч хүч, нөөц, цаг хугацаандаа төвлөрөх хэрэгтэй болно.

Бурхан танаас өөрийн хэрэгцээ, гэр бүлийнхээ хэрэгцээ (1 Тимот 5:8) мөн тусламж авах зохистой боловч өөр хэн ч байхгүй хүмүүсийн хэрэгцээг хангахыг хүсэж хүлээдэг (1 Тимот 5:3-16, Ефес 4:28, Иаков 1:27, Иаков 2:15-16).

1 Тесалоник 4:11-12-д хэлэхдээ,

Бидний тушаасанчлан, төвшин амьдрахыг хичээж, өөрийн ажилд анхаарч, [өөрийн] гараар ажиллахыг эрмэлз. Ингэснээр та нар гаднынхны өмнө зохистой явах бөгөөд ямар ч юмаар дутахгүй.

Энэ бол итгэгчдэд зориулсан Бурханы хүсэл юм.

► Итгэгчид ямар төрлийн ажил хийхэд бэлэн байх ёстой вэ? Байр суурь чухал уу? Хэрэв тийм бол, ямар байдлаар эсвэл аль хүртэл?

Бид ажлын тухай сэдвийг санхүүгийн талаар ярилцахдаа үргэлжлүүлэх болно. Энд Бурхан биднээс ажиллахыг хүсдэг хамгийн чухал шалтгаануудын талаар, үүнд өөрийн болон бусдын хэрэгцээг хангах талаар ярилцлаа. Ажил бол хоол хүнс, хувцаслах зэрэг үндсэн хэрэгцээг хангахын тулд Бурханаас өгөгдсөн ердийн арга зам юм (1 Тимот 6:8). Олон газар оронд хүмүүс ажиллаж мөнгө олдог бөгөөд үүнийгээ материаллаг хэрэгцээндээ зарцуулдаг. Зарим газарт хүмүүс мөнгөний оронд хоол хүнс, эд хөрөнгө, эсвэл үйлчилгээ зэргээр цалинждаг. Аль ч тохиолдолд Бурхан хүмүүсийн хэрэгцээг тэдний ажил хөдөлмөрөөр хангаж байна.

Санхүү

Олон Библийн эшлэл мөнгөний талаарх сэдвийг хөнддөг. Бид мөнгөний талаар хэрхэн бодох, үүнтэй харьцах нь Бурхан болон бусад хүмүүстэй харилцах харилцаанд маш их нөлөөлдөг. Энэ нь маш чухал учраас Бурхан биднийг мөнгө болон түүний хэрэглээний талаар зөв ойлголттой байхыг хүсдэг.⁴⁹

Сургаалт үгс номын зарчмууд

► Суралцагчид Библийн эшлэл бүрийг бүлэгт уншина.

Бидний аюулгүй байдлын эх сурвалж юу вэ?

1. Бурхан бол зөв шударга хүмүүсийн туйлын хангагч нь юм (Сургаалт үгс 10:3).
2. Эд баялаг нь түр зуурын бөгөөд хүч нь хязгаарлагдмал тул бид үүнийг хайрлаж, итгэл найдвараа тавих ёсгүй (Сургаалт үгс 11:4, 28).

► Бурхан хангагч, аюулгүй байдлынх нь эх сурвалж гэдэгт итгэж буй хүний бодол, хандлага, үйлдэл нь ямар байдаг вэ?

Баян байхаас илүү чухал олон зүйл бий. Жишээлбэл:

1. Бусадтай сайн харилцаатай байх (Сургаалт үгс 15:17).
2. Мэдлэг, мэргэн ухаантай байх (Сургаалт үгс 8:10-11).

⁴⁹ Энэ сэдвийн талаар дэлгэрүүлж дараах хичээлийг үзнэ үү. *Practical Christian Living*, 9-р хичээл, Shepherds Global Classroom. Нэрийг нь байдалны хамгийн дотноог зүйлсийнандлага, үйлдэл нь ямар байдаг

3. Бурханаас эмээж, Түүнтэй зөв харилцаатай байх (Сургаалт үгс 15:16).
4. Сайн зан чанарын улмаас хүндлэл хүлээсэн байх (Сургаалт үгс 11:16).
5. Итгэмжит, шударга, эелдэг байх (Сургаалт үгс 19:22).

► Эдгээрийн аль нь таны нөхцөл байдлаас шалтгаалаад их бэрхшээлтэй байдаг вэ?

Мөнгийг зөв удирдах зарчмууд:

1. Хичээл зүтгэлтэй, үнэнч ажлаар мөнгө олох (Сургаалт үгс 10:4).
2. Цаг хугацааны туршид тэвчээртэйгээр мөнгө хуримтлуулах (Сургаалт үгс 13:11).
3. Орлогынхоо дээжийг Бурханд өгч Түүнийг дээдлэх (Сургаалт үгс 3:9-10).
4. Ядууст өгөөмөр байх (Сургаалт үгс 11:24-25, Сургаалт үгс 14:21, Сургаалт үгс 19:17, Сургаалт үгс 21:13).

► Эдгээрийн аль нь танд хамгийн их бэрхшээл болдог вэ?

Мөнгийг буруугаар ашиглахаас сэргийлэх:

1. Мөнгө олохын тулд Бурханы Үгийг хэзээ ч бүү зөрч (Сургаалт үгс 10:2, Сургаалт үгс 15:27).
2. Яаруу эсвэл хайхрамжгүй шийдвэр бүү гарга (Сургаалт үгс 21:5).
3. Бусдын өрийг төлөх амлалт бүү өг (Сургаалт үгс 6:1-5; Сургаалт үгс 17:18)

► Сургаалт үгс номын эдгээр зарчмуудын аль нь танай ахуй соёлд хамгийн их үл тоомсорлогддог вэ?

Дотно найзууд

► Суралцагчид Сургаалт үгс 13:20 ба 1 Коринт 15:33 эшлэлийг бүлэгт уншина.

Дотно нөхөрлөл бол залуучуудын амьдралд хамгийн хүчтэй нөлөөг үзүүлдэг зүйлсийн нэг юм. Хүмүүс ихэвчлэн үнэт зүйлээ хуваалцдаг хүмүүстэй дотно найзууд болдог. Гэвч нөхөрлөл нь тухайн нөхөрлөлд байгаа хүн бүрийг нэг бол илүү сайн эсвэл бүр муу болгож өөрчилдөг. Хэн нэгэнтэй цаг хугацааны туршид дотно найз хэвээр байх нь танд *нөлөөлнө*. Таны үзэл бодол, философи, чухалчлах зүйлс, зан байдал, сонголт, зан чанарт нөлөөлнө. Таны хамгийн дотно найзууд өөрсдийн жишээгээр, мөн таны сонголтыг зөвшөөрөх эсвэл үл зөвшөөрөх байдлаар, мөн итгүүлэн үнэмшүүлэх үгсээр танд нөлөөлнө.

► Суралцагч бүр дараах асуултуудад хариулж, 1-5 тодорхой хүний нэрийг бич:

- Би ихэвчлэн хэнийг зөвшөөрч, дэмжихийг хүсдэг вэ?
- Би амьдралынхаа асуудлуудын талаар хэнтэй ярилцдаг вэ?
- Би шийдвэр гаргах үедээ хэний зөвлөгөөг хайдаг вэ?
- Хэний зан байдал надад нөлөөлж байна вэ?
- Би хэний философийг хуваалцдаг вэ?

Нэрийг нь бичсэн хүмүүсийн талаар бодож үзээрэй. Тэдний зан чанар ямар вэ? Тэд хэрхэн биеэ авч явдаг вэ? Тэдний үг яриа ямар вэ? Хэрэв та тэдний жишээг дагавал, та Христийг дагасаар байх уу? (1 Коринт 11:1). Тэд дараах шинж чанартай хүмүүс мөн үү:

- Тэд Эзэнээс эмээдэг (Дэд хууль 10:12, 20, Дуулал 112:1).
- Тэд Бурханы Үгээс бүрэн хамааралтай амьдардаг (Иохан 17:14-17).
- Тэд бүх зүйлд Эзэнийг баярлуулж, дуулгавартай байхыг нэн тэргүүнд тавьдаг (2 Коринт 5:9-10).

Тэд таныг Бурхантай дотно, дуулгавартай харилцаатай болоход нөлөөлж байна уу? Тэд танд үнэнийг (Бурханы Үгтэй нийцдэг зүйлийг) хэлдэг үү, эсвэл сонсоход хялбар зүйлийг хэлдэг үү? Та хийхийг хүсэж байгаа зүйлээ хийхэд тэд таныг урамшуулдаг уу, эсвэл хэцүү байсан ч, Бурханы мэлмийд зөв зүйлийг хийхэд урамшуулдаг уу?

Нэгэн нөлөө бүхий залуу байжээ. Бусад залуучууд өөрсдийн зан авираа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд түүнийг харж дуурайдаг байв. Тэд ямар нэгэн ёстой эсвэл бүдүүлэг зүйл хэлэхдээ, нөгөө залууг инээж байгаа эсэхийг хардаг байжээ. Тэд ямар нэгэн тэрслүү зүйл хийхдээ, өнөөх залууг нүд ирмэж, зөвшөөрч байгаа эсэхийг хардаг байв. Тэд өнөөх залууг баярлуулахыг хүссэн. Гэвч тэдний хэн нь ч дараах асуултуудыг бодож үзээгүй: Би яагаад **түүгээр** хүлээн зөвшөөрүүлэхийг хүсдэг вэ? Тэр миний баярлуулахыг хичээх ёстой хүн мөн үү? Түүний зан чанар, зан авир нь надад сайн үлгэр жишээ мөн үү?

Эдгээр асуудлуудын талаар бодох нь хүчин чармайлт шаарддаг. Итгэгчид өөрсдийн хамгийн дотнын найзууд болон хамгийн том нөлөөлөгчдийг сонгохдоо зорилготой байх учиртай. Мэдээж, Бурхан өөрийн хүмүүсээр сүнслэг төлөвшилд хүрээгүй болон эсвэл үл итгэгч хүмүүст нөлөөлөхийг хүсдэг. Гэхдээ тэдгээр хүмүүс бидний хамгийн дотнын хамтрагч, зөвлөгч, нөлөөлөгч байх шаардлагыг хангадаггүй. Бид тэднээс хүлээн зөвшөөрлийг хайх ёсгүй юм.

► Нэг суралцагч Дуулал 101 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ Дууллыг Давид хаан бичжээ. Тэр Эзэнээс эмээдэг хүн байсан. Тэрээр үнэнч амьдралаар амьдарна хэмээн Эзэнд өөрийгөө зориулж байсан. Өөрт нь нөлөөлдөг хүмүүс түүний энэхүү амлалт зориулалтад туслах нэг бол үүнээс нь хойш татна гэдгийг тэрээр мэдэж байсан. Ийм учраас тэрээр зөвхөн итгэмжит, бурханлаг хүмүүсийг өөрийн нөлөөлөгчөөр сонгохоор шийдсэн.

Бид Давидын адил хаан хүмүүс биш бөгөөд ихэвчлэн Давид шиг бузар муу хүмүүсийг шийтгэх эрх мэдэл, хариуцлага бидэнд байдаггүй. Гэсэн хэдий ч, бид Давидын жишээг бусад арга замаар дагах боломжтой. Бид үнэнч амьдралаар амьдрахад өөрсдийгөө зориулах ёстой. Бид зөвхөн бурханлаг хүмүүсийг хамгийн дотнын найзууд болон хамгийн агуу нөлөөлөгчөөр өөртөө сонгох учиртай.

Шийдвэр гаргах нь

Залуу хүн нас биед хүрэхэд олон шийдвэр гаргах хэрэгтэй болдог бөгөөд тэдгээрийн зарим нь насан туршийн (эсвэл бүр **мөнхийн**) үр дагавартай байх болно.⁵⁰ Бид сонголтуудаа авч үзэхдээ дараах хэдэн асуултыг анхаарах ёстой:

- **Энэ үйлдэл Бурхан намайг ямар хүн байгаасай гэж хүсэж байгаатай нийцэж байна уу?** Нийгэм бидэнд "Өөрөөрөө бай." "Өөртөө үнэнч бай." "Зүрхээ дага" гэж хэлдэг. Гэвч бид өөрсдөдөө бус, харин Христэд үнэнч байхаар дуудагдсан. Үнэн хэрэгтээ, бидний өөрийн хүсэл Түүнд дуулгавартай байхтай зөрчилдөх үед Тэр "үгүй" гэж хэлэхийг бидэнд сануулдаг (Матай 16:24-26). Бурхан биднийг өөрийн зөвт байдлын хэм хэмжээнд амьдруулахаар дууддаг. Тэр ерөөгдсөн хүмүүсийг өөрөөс нь эмээдэг, бүх зүйлд Түүнд дуулгавартай байдаг хүмүүс хэмээн тодорхойлдог (Дуулал 15, Дуулал 112, Матай 5:3-11). Бид Түүнийг итгэмжтэйгээр дагах үедээ Бурханы хүссэн хүмүүс болдог.
- **Энэ үйлдэл миний нэр хүндэд хэрхэн нөлөөлөх вэ?** Бид гаргасан сонголт бүрээрээ өөрсдийн нэр хүндийг бүтээдэг (Сургаалт үгс 20:11). Бурхан бидний талаар юу гэж боддог нь хамгийн чухал бөгөөд үнэн юм. Гэвч бид бусдад үнэнч хүмүүс хэмээн танигдах үед, бусдад зөвөөр нөлөөлж, Христийг гэрчлэх гэрчлэл маань итгэл үнэмшилтэй болдог. Сургаалт үгс 22:1 эшлэл нь материаллаг эд баялгаас илүү сайн нэр хүндтэй байх нь чухал гэдгийг бидэнд хэлдэг.
- **Энэ сонголтын дараа ямар үр дагавар гарах вэ?** Сургаалт үгс 22:3 эшлэл нь бид өнөөдөр сайн сонголт хийж, ирээдүйд бэлдэх ёстойг харуулдаг. Бид сонголтынхоо талаар бодохдоо, сонголт тус бүрийн дараа гарч болох үр дүнг анхаарах учиртай. Бидний сонголт бидний амьдрал болон бусдын амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?

Сургаалт үгс 4:23 эшлэлд бидний сонголт, зан байдал нь зүрхний маань сэдлээс үүдэлтэй гэдгийг хэлдэг. Хэрэв бид Бурханыг баярлуулах сайн сонголт хийхийг хүсвэл, бид Түүнд үнэнч байгаа эсэхээ нягтлах хэрэгтэй (Дэд хууль 6:2, 5-6, Дэд хууль 13:4).

Бие бялдрын эрүүл мэнд

Залуу хүн өөрийн сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг бөгөөд үүнд хоол хүнс, биеийн тамирын идэвхтэй байдал, дасгал хөдөлгөөн, нойрны зуршил зэрэг багтдаг. Эдгээр бүх талбарт өөрийгөө хянах чадвар чухал юм (1 Коринт 9:27). Итгэгч хүний бие нь Ариун Сүнсний орших сүм бөгөөд Христийн цусаар золин авагдсан гэдгийг санах ёстой (1 Коринт 6:19-20). Бид Бурханы үйлчлэгчид учраас өөрсдийн биеэ арчилж, хийх

⁵⁰ Энэ сэдвийн талаар дэлгэрүүлж дараах хичээлийг үзнэ үү. *Practical Christian Living*, 5-р хичээл, Shepherds Global Classroom.

зүйл бүрдээ зөв сонголт хийхэд өөрсдийгөө сахилгажуулах хэрэгтэй. Ингэснээр бид Түүний төлөө хамгийн сайнаараа байж чадна.⁵¹

► Суралцагчид 1 Коринт 6:12-13, 19-20 ба 1 Коринт 10:31 эшлэлийг бүлэгт уншина.

Өнгөрсөн долоо хоногийнхоо хоолны сонголт, хэмжээг бодож үзээрэй. Магадгүй та идэж болох олон сонголттой, элбэг дэлбэг хоолтой байсан байж болно. Магадгүй танд идэх хоол бага, сонголт цөөн байсан ч байж болно. Аль ч тохиолдолд таны идэх, уух нь Бурханыг алдаршуулах учиртай. Хэрэв та Есүстэй хамт сууж, хооллохоор уригдсан гэж бодвол ердийн үед иддэг хоол эсвэл хэмжээгээ сонгох байсан уу? Энэ нь утгагүй асуулт мэт санагдаж болох ч, магадгүй хооллох үедээ бодолтой, талархаж, өөрийгөө хянах талаар танд сануулга болж мэдэх юм.

Нойр бол итгэгч хүн өөрийгөө хянах чадварыг харуулах ёстой өөр нэг талбар юм. Бид залхуурч, хэт их унтах ёсгүй (Сургаалт үгс 6:10-11, Сургаалт үгс 20:13). Хэдий тийм боловч, Бурхан бидний биеийг тогтмол бөгөөд хангалттай амрах хэрэгцээтэйгээр бүтээсэн (Дуулал 3:5). Эрүүл насанд хүрсэн хүн ихэвчлэн шөнөдөө 6-8 цаг унтах хэрэгтэй байдаг.

Номлогчийн үгс 5:12 эшлэл нь хичээл зүтгэлтэй ажилладаг хүмүүсийн шагнал нь нойр гэж хэлсэн байдаг. Сургаалт үгс 3:24 ба Дуулал 4:8 эшлэл нь Бурхан хүүхдүүддээ өгдөг ханасан, амар тайван нойрны талаар өгүүлдэг. Энэ бол бидний биеийг сэргээдэг нойрны төрөл юм. Бурханы амар тайвнаар бид өдөр тутмын санаа зовнил, зовлонгоос ангид байж, итгэмжит Бурхан биднийг харж хандаж байгааг мэдэрдэг. Амраадаг нойр нь бие, оюун санааг сэргээж, дараа дараагийн хийх ажил болон үйлчлэлд биднийг бэлддэг.

Сургаалт үгс 3:24 эшлэл нь Сургаалт үгс номын мэргэн ухаан, ойлголт, хэрсүү байдлаар дүүрэн амьдралд хэрэгтэй зааварчилгааг багтаасан хэсэг юм. Хэрэв та ханасан нойртой байхыг хүсвэл, телевизор эсвэл кино үзэх, интернетээр аялах эсвэл ухаалаг утас ашиглах, найз нөхөдтэйгөө цаг өнгөрөөх зэрэг амьдралынхаа бусад талбарт ухаалаг сонголт хийх хэрэгтэй болно.

Таны нойрны чанарт өдрийн турш идсэн хоолны сонголт, хэмжээ, дасгал хөдөлгөөний хэмжээ, хэцүү нөхцөл байдлыг хэрхэн зохицуулсан, эсвэл мөнгөө хэрхэн зарцуулсан зэрэг нь нөлөөлөх боломжтой. Галат 5:22-23 эшлэлд жагсаасан Сүнсний үр жимсээр (шинж чанаруудаар) бусадтай харилцах харилцаа маань дүүрсэн үед ханасан нойртой унтаж чадна.

► Дээрх хэсэгт дурдагдсан эшлэлийг уншихад цаг гаргаарай. Эдгээр эшлэлээс олж харсан зарчмуудын дагуу нойроо үнэлээрэй. Бурхан таны биеийг зөв ажиллахад хэрэгтэй байхаар төлөвлөж бүтээсэн тэрхүү амралтыг та биедээ зориулж байна уу?

⁵¹ Энэ сэдвийн талаар дэлгэрүүлж дараах хичээлийг үзнэ үү. *Practical Christian Living*, 13-р хичээл, Shepherds Global Classroom.

Дуулалд өгүүлсэн утга санааг анзаараарай: Давид эдгээрийг маш их стресстэй нөхцөл байдалд бичиж байгаа ч, түүний биеийг нойроор сэргээдэг Бурханы итгэмжит байдлыг гэрчлэн өгүүлжээ.

Стрессийг шийдвэрлэх

Бурханы загвар төлөвлөгөөний дагуу, нас биед хүрэх эхэн үе нь анхаарал тавих, стресс үүсгэх (Гашуудал 3:27) олон үүрэг хариуцлага давхацсан үе байдаг. Хүн боловсролын зэрэг цол авах, бизнес эхлүүлэх, нэг эсвэл хэд хэдэн ажил хийхийг энэ үед хичээж байх боломжтой. Залуу насанд зориудаар анхаарал хандуулах шаардлагатай олон харилцаа бий. Санхүү, унаа тээвэр, гэр орны хэрэгцээ бүгд анхаарал шаарддаг төдийгүй мөн стресс үүсгэдэг.

Стресс нь "биднийг дарамталж эсвэл сорьж буй үйл явдалд бидний бие болон сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл юм" хэмээн тодорхойлогдсон байдаг.⁵² Та өөрийн нөхцөл байдлуудаа хэрхэн хардаг талаараа бодож үзээрэй. Тулгарч байгаа нөхцөл байдлын улмаас таны оюун бодол хэрхэн ажилладаг вэ?

Таны ирээдүйтэй холбоотой ямар нэг зүйлийн талаар та хэрхэн боддог вэ? Боломжуудын талаар ямар сэтгэл хөдлөлийг өөртөө мэдрүүлэхийг зөвшөөрдөг вэ? Ямар үзэл баримтлал тухайн нөхцөл байдлыг шийдвэрлэхэд танд нөлөөлдөг вэ? Таны ерөнхий зан төлөв (темперамент) болон хувийн онцлог шинж юу вэ? (Сургаалт үгс 15:15)

Таны үзэл баримтлал, зан төлөв, хувийн онцлог шинж бүгд амьдралын нөхцөл байдалд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх, мөн ямар хэмжээний стресс мэдрэхэд тань нөлөөлдөг. Стресс нь амьдралын хэвийн нэг хэсэг боловч, стрессийг хэрхэн зохицуулах нь хувийн асуудал юм. Сэтгэл түгших нь заримдаа толгой өвдөх, булчин өвдөх, өвчин тусах, цусны даралт ихсэх, ходоодны шарх, болон бусад олон сэтгэц, сэтгэл хөдлөл, бие махбодтой холбоотой саатал хүндрэлүүдийг үүсгэдэг (Сургаалт үгс 12:25). Стресст муу хариу үйлдэл үзүүлэх нь Христэд үйлчлэх таны үйлчлэлд ихээхэн саад болох боломжтой. Ийм учраас Бурханы Үг бидэнд санаа зовниж, түгшихгүй байх талаар хэлсэн нь гайхах зүйл биш юм.

► Суралцагчид Матай 6:34, 1 Петр 5:7 ба Дуулал 105:4 эшлэлийг бүлэгт уншина.

Бид дарамттай нөхцөл байдалтай тулгарах үедээ Бурханд найдаж, Түүнээс хамааралтай байхыг сонгох ёстой. Зөвхөн Түүнд ямар ч хязгаарлалт үгүй. Тэр хүч чадал, мэргэн ухаан, сайн сайхан байдалдаа төгс төгөлдөр билээ. Тэрээр хүүхдүүддээ төгс халамжийг үзүүлдэг. Бурхан биднийг Түүнээс хамаарч байгаагаа ухаарч, санаа зовоосон бүх зүйлээ Түүнд авчирч, Түүний хүч чадлыг эрэлхийлэхийг хүсдэг. Бид үүнийг хийх үед, Тэр бидэнд амар тайван, амралт болон бидэнд хэрэгтэй бүх зүйлийг өгч чадна. Залуу

⁵² Robert S. Feldman, *Discovering the Lifespan*, 2nd ed. (Upper Saddle River, NJ: Pearson, 2012), 317.

байхдаа бид Бурханы өмнө тайван, чимээгүй байдлыг хадгалж, Түүний удирдамжийг хүлээж сурах учиртай (Дуулал 46:10, Гашуудал 3:25-27).

► Таны одоо мэдэрч буй стресстэй нөхцөл байдлуудыг жагсаана уу. Бурханы Үгэнд үндэслэн таны хариу үйлдэл ямар байх ёстой вэ?

Хэлэлцүүлгийн асуултууд

► Энэ хичээлийн ямар санаа эсвэл зарчим танд шинэлэг байсан бэ? Залуу хүний амьдралын эдгээр талбартай холбоотой өөр ямар Библийн зарчмыг та бодож үзсэн бэ?

► Энэ хичээлээр судалсан зүйлс таны хувийн амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?

► Танай чуулганд эдгээр сэдвийн аль нь итгэгч залуучуудын дунд хамгийн их хөндөх шаардлагатай байна вэ?

► Таны мэддэг христитгэлт залуучууд амьдралынхаа эдгээр талбарт Библийн дагуу бодож, үйлдэхэд нь та хэрхэн нөлөөлж чадах вэ?

Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Таны Үг амьдралын үе шат бүрд таны төлөө хэрхэн амьдрахыг бидэнд заадагт талархъя. Бидний залуу насанд үр жимстэй, үр бүтээмжтэй амьдралд бэлдсэнд талархъя.

Таны өгсөн хүч чадал, нөөц, боломжуудад итгэмжит нярав байж, таныг алдаршуулахад бидэнд туслаач. Бусдад бурханлаг нөлөө үзүүлж, бурханлаг найз нөхөд, зөвлөгчдийг сонгоход бидэнд туслаач.

Бид ухаалаг шийдвэр гаргаж, бие, оюун санаа, сүнс сэтгэлээрээ таныг дээдлэх болтугай.

Амен

Хичээлийн даалгаврууд

(1) 1 Тимот 4:12 эшлэлд Паул Тимотод тодорхой талбаруудад үлгэр дуурайл байхыг сургасан байдаг. Бичгээр, эдгээр талбар тус бүрийг тодорхойл. Эдгээр нь залуу хүний амьдралд хэрхэн биелэгдэж болохыг тайлбарлана уу. Талбар тус бүрд дор хаяж нэг практик жишээ өгнө үү.

(2) Энэ хичээлээс нэг сэдвийг сонгоно уу:

- Төлөвшил ба зан чанар
- Ажил
- Санхүү
- Дотно найзууд
- Шийдвэр гаргах
- Бие бялдрын эрүүл мэнд
- Стресс

Сонгосон сэдвийнхээ талаар дор хаяж гурван догол мөрөнд багтаан бичээрэй:

- Тухайн сэдэвтэй холбоотой Библийн зарчмуудыг нэгтгэн дүгнэх.
- Эдгээр зарчимд дуулгавартай байснаар ирэх зарим эерэг үр дүнг тайлбарлах.
- Эдгээр зарчмыг үл тоомсорлоход гарах зарим сөрөг үр дагаврыг тодорхойлох.

Эерэг болон сөрөг үр дагаврын талаар бичихдээ тухайн хүний сонголт бусад олон хүмүүст (тухайн хүнд, түүний гэр бүл, хамт олон болон түүний чуулганд) үзүүлэх нөлөөг бодож тунгаагаарай.

Хавсралт А

Эмэгтэйчүүдийг хүндлэх нь

Эмэгтэйчүүдийг хүндэлсэн Есүсийн үлгэр дуурайл

Нэгдүгээр зууны үеийн Ромын ертөнц болон иудеизмд эмэгтэйчүүдийг эрчүүдээс дорд үздэг байжээ. Эмэгтэйчүүдийг дорд үзэх явдал дэлхийн олон соёл, гэр бүлүүдэд түгээмэл хэвээр байна. Эмэгтэйчүүдийг үл хүндэтгэх, бэлгийн хэрэгсэл болгон ашиглах, хүчирхийлэл үйлдэгдсээр ирсэн. Харин Есүс эмэгтэйчүүдийг хүндэлж байсан нь бидний хувьд үлгэр дуурайл болох ёстой.

Христ эмэгтэйчүүдийн нэр төр, үнэ цэнийг эрчүүдтэй ижил тэгш гэж үздэг байсан. Есүс "Бүтээгч анхнаас нь тэднийг эр эмээр нь бүтээснийг" (Матай 19:4, Эхлэл 1:27) хэмээн айлджээ. Эмэгтэй хүн эрэгтэйн адил Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Эрчүүдийн адил өөрийгөө ойлгох, тодорхойлох, эрх чөлөөтэй байх, хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай юм. Есүс эмэгтэйчүүдийг эрэгтэй хүний хүслийг хангах хэрэгсэл гэж үзээгүй, харин жинхэнэ хүмүүс гэж үздэг байв. Тэрээр эмэгтэйчүүдийг хүн хэмээн үзэж, тэдний төлөө дэлхийд ирсэн гэж хэлсэн байдаг (Лук 8:1-3).

Жеймс Борланд, Жон Пайпер, Вейн Грудем нар Сайнмэдээний дөрвөн номд тэмдэглэгдсэн, Есүс эмэгтэйчүүдийг өндрөөр үнэлж, хүндэтгэсэн тодорхой жишээнүүдийг дараах байдлаар тайлбарлажээ:

(1) Есүс олон нийтийн газар эмэгтэйчүүдтэй шууд байдлаар харилцдаг байсан.

Есүсийн цаг үед эрчүүд эмэгтэй хүнд ийнхүү хандах нь энгийн зүйл байгаагүй (Иохан 4:27). Дагалдагч нар нь Есүсийг Сухар худгийн дэргэд самари эмэгтэйтэй ярилцаж байхыг хараад гайхсан (Иохан 4:7-26). Тэрээр завхайрсан эмэгтэйтэй чөлөөтэй ярилцжээ (Иохан 8:10-11). Есүс Наин хотын бэлэвсэн эмэгтэйтэй (Лук 7:12-13), цус алддаг өвчтэй эмэгтэйтэй (Лук 8:48, Матай 9:22, Марк 5:34) болон цугласан олны дундаас Түүнийг дуудсан эмэгтэйтэй (Лук 11:27-28) олон нийтийн газар ярилцсан талаар Лук тэмдэглэсэн. Есүс 18 жилийн турш бөгтөр байсан эмэгтэй (Лук 13:12) болон загалмай руу явах замдаа бүлэг эмэгтэйчүүдтэй (Лук 23:27-31) хандан өгүүлсэн байдаг.

(2) Есүс эмэгтэйчүүдтэй ярилцаж буй байдлаараа тэднийг хүндэтгэж, өндрөөр үнэлдэг байснаа харуулсан.

Тэрээр ухаалаг, санаа тавьсан байдлаар тэдэнтэй ярилцдаг байсан. Матай, Марк, Лук нь Есүс цус алддаг өвчтэй эмэгтэйтэй "охин" гэж дуудсан, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйд "Абрахамын охин" (Лук 13:16) хэмээн хандсан талаар дурдсан байдаг. Есүс тэднийг "Абрахамын охид" гэж дуудсанаараа "Абрахамын хөвгүүд"-тэй адил сүнслэг хэмжээнд өргөмжилж буй юм.

(3) Тэд өөрсдийн нүглийн төлөө хувийн хариуцлага хүлээхийг сануулахдаа Есүс тэдний төрөлх үнэ цэнийг харуулсан юм.

Энэ нь худгийн дэргэдэх эмэгтэй (Иохан 4:16-18), завхайрсан эмэгтэй (Иохан 8:10-11) болон Түүний хөлийг тосолсон нүгэлт эмэгтэйтэй (Лук 7:44-50) харилцсан байдлаас харагддаг. Есүс тэдний нүгэлд тоомжиргүй хандаагүй, харин нүүр тулсан юм. Түүний үйлдэл нь эмэгтэй хүн бүр хувийн эрх чөлөөтэй, сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг, нүгэл, гэмшил, уучлалын асуудлыг өөрөө шийдвэрлэх ёстойг илэрхийлсэн.

Эмэгтэйчүүдийг үнэлсэн Есүсийн хандлагыг өнөөгийн чуулган хэрхэн дагах вэ?

Эмэгтэйчүүдийн үйлчлэл болон гэр бүл дэх Библийн дагуух үүрэг хариуцлагын талаар чуулганууд, урсгал чиглэлүүдийн дунд байнга яригдаж байгаа ч, Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүсийнх нь хувьд тэдний үнэ цэн, тэгш эрх **хэзээ ч** эргэлзээтэй байх ёсгүй. Есүс эмэгтэйчүүдийг үнэ цэн, нэр төртэй хүмүүс гэдгийг байнга илэрхийлж байсан. Есүс эмэгтэйчүүдийг амиллынхаа анхны гэрч нар байхаар дуудсан (Иохан 20:17). Тэрбээр тэдний нөхөрлөл, залбирал, итгэлийн үйлчлэл, санхүүгийн дэмжлэг, гэрчлэлийг нь үнэлдэг байсан. Есүс эмэгтэйчүүдийг хүндэлж, тэдэнд зааж, ухаалгаар үйлчилж байв.

Шинэ гэрээнд эмэгтэйчүүдийг хүндэлсэн талаар

Есүс эмэгтэйчүүдийг хүндэлсэн үлгэр дуурайлыг Ариун Сүнсний амьдралаас харж болно. Пентэкостын өдөр Ариун Сүнс хөвгүүд, охид, эрэгтэй, эмэгтэй зарц нар дээр асгарсан (Үйлс 2:17-18). Ариун Сүнс хэнийг ч ялгаварлаагүй.

Ром 16-р бүлэгт Паул Фойбе хэмээх эмэгтэйд чуулганы үйлчлэгчээр (1-р эшлэл), Приска болон Акул хоёрыг Христ Есүсийн хамтран зүтгэгч буюу түүний амь насны төлөө өөрсдийгөө эрсдэлд оруулсан хүмүүс (3-4-р эшлэл), Мариаг шаргуу хөдөлмөрлөсөн (6-р эшлэл), Иуниаг элч нарт сайн танигдсан хүн (7-р эшлэл), мөн бусад эмэгтэйчүүдийг ч сайшаан бичжээ.

1 Тесалоник номд Паул Бурханы бүтээсэн энхрий зөөлөн, эхийн хайрыг "бид та нарын дунд эх хүн хүүхдүүдээ асрах мэт зөөлөн байсан" (1 Тесалоник 2:7) хэмээн бичсэнээр эмэгтэйчүүдийг сайшаажээ. Ефес номд тэрээр нөхрүүдэд хандан эхнэрээ "Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил", мөн өөрийн бие шиг (Ефес 5:25, 28) хайрлахыг тушаасан юм. Петр нөхрүүдэд "эхнэр чинь эмэгтэй хүн тул... эхнэртэйгээ ойлголцож амьдар... түүнийг хүндэтгэ" (1 Петр 3:7) хэмээн уриалсан байдаг.

Эртнээс чуулганд эмэгтэйчүүдийг үнэ цэнтэй гэж үздэг байсан нь тодорхой харагддаг бөгөөд эрчүүдэд эмэгтэйчүүдийг хүндэтгэхийг заадаг байсан. Сүнслэг удирдагчид эдүгээ цагт эмэгтэйчүүдийн төлөө зогсож, тэднийг хүчирхийлэхийн эсрэг зогсох цаг болжээ. Эмэгтэйчүүдийг Бүтээгчийн онцгой дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс гэж үзэх цаг болжээ. Чуулганд болон гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн ялгааг заахдаа

энэхүү байр сууринаас хандах ёстой бөгөөд, эс тэгвээс бидний зааж буй сургаал хүчирхийллийг авчрах боломжтой.

Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Таны амьдарч буй нийгэмд тогтсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааг тодорхойлно уу. Эдгээр ялгааг Библийн үнэнд суурилсан мэдлэгээр дамжуулан хэрхэн шинэчилж болох вэ?
- ▶ Танай улсад буй чуулганууд эмэгтэйчүүдэд ялгаатай ханддаг уу? Чуулган болон нийгмийн хандлагын хооронд ялгаа бий юу?
- ▶ Есүсийн харуулсан үлгэр дуурайлыг үндэслэн өөрчлөгдөх шаардлагатай ямар нэгэн ёс заншил байна уу?

Хавсралт Б

Жирэмслэлтээс хамгаалах

Жирэмслэлтээс хамгаалах аргууд

Анагаах ухаан нь бэлгийн хавьталд орох боловч хүүхэдтэй болохыг хүсэхгүй байгаа хүмүүст зориулсан жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх аргуудыг боловсруулсан байдаг. Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх аргуудыг "жирэмслэлтээс хамгаалах" гэж нэрлэдэг. Жирэмслэлтээс хамгаалах хэд хэдэн арга бий:

1. Эмэгтэй хүний бие өндгөн эс ялгаруулахаас сэргийлдэг эм
2. Үр тогтсоны дараа өндгөн эсийг үхүүлэх эм
3. Эр бэлгийн эс эмэгтэй хүний биед орохоос сэргийлдэг биет төхөөрөмж

Эмэгтэй хүний бие сард хэдхэн хоног үр тогтоох чадвартай байдаг. Хосууд эмэгтэй хүний биеийн үр тогтох хуваарийг мэдсэнээр, жирэмслэх магадлалтай үед бэлгийн хавьталд орохоос зайлсхийх боломжтой. Энэ дөрөв дэх аргыг жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх аргад тооцдоггүй.

Хүмүүс яагаад жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэдэг вэ?

Зарим байгууллагууд бэлгийн харилцааг зөвхөн гэр бүлийн харилцаагаар хязгаарладаггүй хүмүүст зориулан, өвчин тарахаас сэргийлж, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлгэвч хэрэглэхийг зөвлөдөг. Гэрлэлтээс гадуурх жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн тухай энд яригдаагүй. Библи гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцааг буруушаадаг. Христэд итгэгчдийн хувьд өвчнөөс зайлсхийх, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх зөв арга бол зөвхөн гэр бүлийн хүрээнд бэлгийн харилцаанд орох гэж үздэг.

Зарим гэрлэсэн хосууд жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэдэг хэд хэдэн шалтгаан бий:

- Олон хүүхэд өсгөх боломжгүй ядуу айл өрхүүдэд жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэхийг эмнэлгийн байгууллагууд уриалснаар, төрөх хүүхдийг тоог цөөрүүлдэг.
- Хосууд гэрлэснийхээ дараа мөнгө хуримтлуулах, амьдралын нөхцлөө сайжруулах шаардлагатай болдог тул хүүхэдтэй болохоо хойшлуулдаг.
- Хосууд хүүхдүүдийнхээ хоорондох төрөлтийн хугацааг хол байлгах зорилгоор жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэдэг.

- Зарим тохиолдолд хосууд хүссэн тооны хүүхэдтэй болсон хэмээн үзэж жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэдэг.
- Зарим эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн асуудал тулгардаг бөгөөд эмч жирэмслэлтийг тэдэнд болон хүүхдэд аюултай хэмээн үзэж, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэхийг зөвлөдөг.

Чуулгануудын дундах жирэмслэлтээс хамгаалах аргын талаарх маргаан

Библид жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх нь зөв эсэх талаар тодорхой бичигдээгүй. Ромын Католик сүм жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэхийг буруушаадаг боловч хуваарьт аргыг зөвшөөрдөг. Зүүний Ортодокс сүм бүгдээрээ биш ч, зарим удирдагчид жирэмслэлтээс урьдчилан сэргийлэхийг эсэргүүцдэг. Протестант болон эвангелийн чуулгануудын дунд ч янз бүрийн байр суурь бий.

Дараах санааг үндэслэн зарим чуулганууд жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг хориглох шалтгааныг тайлбарладаг. Тус бүрд нь нэмэлт тайлбар өгөгдсөн.

(1) Хүүхэд бол Бурханы ерөөл, гэрлэлтийн зорилго юм.

Хүүхэдгүй байх талаарх хичээл дээр Бурханаас ирдэг хүүхдүүдийн ерөөлийг тайлбарласан. Зарим чуулганууд Бурхан хүүхдүүдийг үнэ цэнтэй хэмээн үзэж буй учир жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэж болохгүй хэмээн үздэг. Харин зарим нь үзэхдээ хэрэв аль хэдийн хүүхэдтэй болсон бол эрүүл мэндийн асуудал болон санхүүгийн бэрхшээлээс үүдэн дахин жирэмслэлтээс хамгаалах нь буруу биш гэж үздэг.

(2) Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг ёс бус бэлгийн хавьтал болон түүний үр дагавараас сэргийлэхэд ашигладаг.

Тэд ёс бус үйлдэлдээ ашиглаж болох ч, энэ нь гэрлэсэн хосуудын ашиглах асуудалд хамааралгүй юм.

(3) Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл нь бэлгийн хавьтлаар хүүхэдтэй болох хууль ёсны зорилгыг үгүй хийж, хувиа хичээсэн, цэвэр бус болгож буй явдал.

Бэлгийн харилцаа нь өөрийнхөө төлөө эсвэл цэвэр бус байдлаар хийгдэж болох хэдий ч, энэ нь зөвхөн хүүхэдтэй болох зорилго биш бөгөөд гэрлэлтийн харилцааны нэг хэсэг юм (1 Коринт 7:3-5). Библи бидэнд нөхөр, эхнэр хоёр ийнхүү бие биедээ үйлчлэх ёстой гэж хэлдэг.

(4) Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл нь жирэмслэлтийг Бурханы сонголт бус, харин хүний сонголт болгодог.

Зарим чуулганууд хосууд хүүхдийн тоо, хугацааг хязгаарлахгүйгээр Бурхан тэдэнд хүүхдүүдийг өгнө гэдэгт итгэх ёстой гэж үздэг. Харин зарим итгэгчдийн хувьд бид амьдралынхаа бүхий л талбарт шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд Библийн дагуух үндсэн зүйлсээ дагахыг хичээж л байгаа бол жирэмслэлтээс сэргийлэх тал дээр ч шийдвэр гаргах үүрэгтэй гэж үздэг.

Мөс чанарын асуудал

Учир нь (1) Библи жирэмслэлтээс хамгаалах аргын талаар тодорхой мэдэгдэл хийгээгүй бөгөөд (2) эвангелийн итгэгч нар энэ асуудалд янз бүрийн үзэл бодолтой байдаг тул нэг нэгнийхээ шийдвэрийг хүндэтгэх ёстой. Хосууд Бурханд захирагдаж, Библийн үндсэн сургаалуудыг дагаж байгаа эсэхээ баталгаажуулсны дараа энэ шийдвэрийг гаргаж, ингэхдээ Бурханаас мэргэн ухаан гуйн залбирах ёстой.

Жирэмсэн болсон үедээ хүүхэдтэй болох эсэх талаар шийдвэр гаргах нь боломжгүй. Библид төрөөгүй хүүхдийн амийг таслах нь буруу гэдгийг тодорхой хэлдэг. Хүний амь үр тогтохоос эхэлдэг тул үр тогтсон өндгөн эсийг амьдруулахаас сэргийлдэг эмийг хэрэглэх нь буруу юм. Жирэмслэлтээс хамгаалах аргыг сонгосон хосууд жирэмслэлтээс хамгаалах зүйлийг ашиглаж байхдаа үр тогтсон өндгөн эсийг үхэлд хүргэх зүйл биш гэдгийг баталгаажуулах ёстой.

Санал болгох эх сурвалжууд

Гэрлэлтэд бэлтгэх

Drescher, John. *For Better, For Worse*. Morgantown, PA: Masthof Press, 2012.

Thomas, Gary. *Sacred Marriage*. Grand Rapids: Zondervan, 2000.

Гэрлэлт

Eggerichs, Emerson. *Love and Respect*. Nashville: Thomas Nelson, 2004.

Thomas, Gary. *Sacred Search*. Colorado Springs: David C Cook, 2013.

Бэлгийн харилцаа

Ferrer, Hillary. *Mama Bear Apologetics Guide to Sexuality: Empowering Your Kids to Understand and Live Out God's Design*. Eugene: Harvest House Publishers, 2021.

Sprinkle, Preston. *People to Be Loved: Why Homosexuality is not Just an Issue*. Grand Rapids: Zondervan, 2015.

Yuan, Christopher. *Holy Sexuality and the Gospel: Sex, Desire, and Relationships Shaped by God's Grand Story*. New York: Multnomah, 2018.

Shimer, Ted. *The Freedom Fight: The New Drug and the Truths That Set Us Free*. Houston: High Bridge Books, 2020.

Хүүхэд хүмүүжүүлэх

Brown, Nadine M. *How to Have Kids with Character (Even if Your Kids are Characters)*. Wheaton: Tyndale House Publishers, Inc., 1990.

Chapman, Gary and Ross Campbell. *The Five Love Languages of Children*. Chicago: Northfield Publishing, 1997.

Dobson, James. *Bringing up Boys*. Wheaton: Tyndale House Publishers, Inc., 2001.

Friedeman, Matt. *Discipleship in the Home: Teaching Children. Changing Lives*. Wilmore: Francis Asbury Society, 2010.

Hubbard, Ginger. *Don't Make Me Count to Three!* Wapwallopen, PA: Shepherd Press, 2003.

Mulvihill, Josh. *Biblical Worldview: What It Is, Why It Matters, and How to Shape the Worldview of the Next Generation*. Roanoke: Renewanation, 2019.

Tripp, Tedd. *Shepherding a Child's Heart*. Wapwallopen: Shepherd Press, 1995.

Гэр бүл

Гэр Бүлээрээ Суралцах Зааварчилгаа. Shepherds Global Classroom, 2023. дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://shepherdsglobal.org/courses/>

Garland, David and Diana Garland. *Flawed Families of the Bible*. Grand Rapids, MI: Brazos Press, 2007.

Mally, Sarah and Stephen Mally and Grace Mally. *Making Brothers and Sisters Best Friends*. Marion, IA: Tomorrow's Forefathers Inc, 2002.

Даалгаврын тэмдэглэл

Суралцагчийн нэр _____

Дараах хүснэгтэд даалгавар бүрийг бүрэн хийж дуусгасан өдрөө тэмдэглээрэй. Сорилд 70% эсвэл түүнээс дээш оноо авсан суралцагчийн даалгаврыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно. Shepherds Global Classroom байгууллагаас гэрчилгээ авахын тулд бүх даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн байх ёстой.

Хичээл	Даалгавар 1	Даалгавар 2	Даалгавар 3	Даалгавар 4
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				

Shepherds Global Classroom байгууллагаас төгсөлтийн гэрчилгээ авах өргөдлийг манай www.shepherdsglobal.org вебсайтаар орж бөглөх боломжтой. Суралцагчдынхаа өмнөөс өргөдөл илгээсэн багш, сургагч багш нарт SGC-ийн ерөнхийлөгч төгсөлтийн гэрчилгээг цахим хэлбэрээр илгээх болно.